БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

“ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТООН СИСТЕМД ОРУУЛАН ХАДГАЛАХ ХӨТӨЛБӨР”

/ СУРГАЛТ СЕМИНАР /
2007.06.11-14

УЛААНБААТАР
2007 он

“ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТООН СИСТЕМД ОРУУЛАН ХАДГАЛАХ ХӨТӨЛБӨР “-ИЙН ТАНИЛЦУУЛГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Танилцуулга

2005 оны 12-р сарын 07-ны өдрийн Засгийн газрын 244-р тогтоолоор “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг 2006-2008 онд хэрэгжүүлэхээр баталсан юм.

Энэ хөтөлбөр нь түүх, соёлын дурсгалт зүйл хадгалагдаж буй 35 байгууллагыг (хавсралт.1) өндөр хүчин чадал бүхий компьютер, гэрэл зургийн тоног төхөөрөмжөөр ханган, тусгай зохиосон бүртгэлийн програмаар интернет сүлжээ ашиглан түүх, соёлын дурсгал зүйлийн (ТСДЗ) талаарх бүхий л мэдээллийг цуглуулж, тоон системд оруулан, анхан шатны бүртгэл мэдээллийн сан, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд тус тус цуглуулан бүртгэж, архивлан хадгалах зорилготой.

“Соёлын өвийг хамгаалах тухай” хуулинд 1994-1995 оноос ТСДЗ-ийг бүртгэх, бүртгэл-мэдээллийн сангийг тогтолцоо, бүртгэн баримтжуулах ажлыг хийх тухай тусгайлсан заалт нэмэгдэж орсон юм. Үүний дагуу сум, аймаг, улсын бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог үүсгэж Соёлын өвийн төвийн дэргэд Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бий болгон, энэхүү сан нь монгол улсын хэмжээнд байгаа ТСДЗ-ийг бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг дагнан эрхлэх болсон билээ.

Соёлын өвийн УНБМСангаас музей болон бусад байгууллагад хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн авах, баримтжуулах ажлыг хийхдээ 2005 он хүртэл тусгайлан бэлдсэн асуулга, бөглөх Маягт.1-ийг А3 цаасан дээр үйлдэж хийж байсан ба бүртгэлийг гараар болон бичгийн машин ашиглан хийж байсан юм.

Сүүлийн жилүүдэд компьютер, техник тоног төхөөрөмж ашиглах болноос бэлэн өгөгдөл бүхий хуучин Маягт.1 нь техникийн шинэчлэлтэнд гологдох, мөн утга болоод найруулгын зарим өөрчлөлтөнд орж Маягт.2 болж өөрчлөгдсөн.

Соёлын өвийн УНБМСангийн мэргэжилтнүүд сүүлийн 10 орчим жилд дийлэнх аймгийн музейнүүдээр явж ТСДЗ-ийг бүртгэн баримтжуулах ажлыг хийж, музейнүүдийг бүртгэл хийх арга зүй, удирдамжаар ханган ажиллаж бага ч болов амжилтанд хүрсэн ч нийтлэг нэгэн бэрхшээл бүх музейд байгааг тогтоосон юм. Энэ нь тухайн байгууллага бүртгэл-мэдээллийн сангийн ажилд зориулагдсан техник, тоног төхөөрөмжөөр огт хангагдаагүй, байгууллагын удирдлага (музейн захирал), эрдэм шинжилгээний ажилтнууд бүртгэл-мэдээллийн сан, бүртгэл бүрдүүлэлтийн ажлын ач холбогдлыг ойлгодоггүй, эрдэм шинжилгээний тодорхойлолт бүртгэлийг дутуу дулимаг буюу огт хийдэггүй, музейнүүд интернет шугам сүлжээнд холбогдоогүй, орчин үеийн техник технолог, мэдээллийн хурдаас маш хол хоцорсон байснаар илэрхийлэгдэж байна.

Цаасан бүртгэлээр бичигдэж ирсэн ТСДЗ-ийн талаарх бүртгэл мэдээлэл хагас дутуу хийгддэг, бүртгэлийг үнэн зөв хийх хариуцлагын тогтолцоо байхгүй, нэгдсэн нэг ижил төрлийн өгөгдөл, стандарт, бүртгэлийн журамд ороогүй, бүртгэлийн систем комьютертэй холбогдоогүй, түргэн шуурхай мэдээлэл цуглуулах, мэдээлэл боловсруулах боломж байхгүй зэргээс шалтгаалан мэдээллийн шинэ дэвшилт технологид орох цаг үеийн шаардлага гарч ирсэн юм.

Иймд монгол улсын хэмжээнд байгаа бүх түүх, соёлын дурсгалт зүйлийн талаарх эрдэм шинжилгээний үнэн зөв бодит мэдээллийг цуглуулан авахад зориулж, тусгайлан боловсруулсан өгөгдөл бүхий бүртгэн баримтжуулах програм хангамж зохиох, бүртгэл хийх байгууллагыг зөвхөн энэ ажилд зориулан өндөр хүчин чадалтай компьютер, гэрэл зургийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, интернет шугам сүлжээ үүсгэх, ТСДЗ-ийн анхан шатны болон улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан, сүлжээ, электрон архив үүсгэн бий болгох, мэдээлэл нэгтгэх, боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхээр энэ хөтөлбөрт ТСДЗ-ийг хадгалж хамгаалж буй 35 улсын болон аймаг, байгууллагын харъяаны музей, номын сан, эрдэм шинжилгээний хүрээлэн, шашны байгууллагыг (Гандантэгчинлэн хийд) хамруулан оролцуулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй бүртгэл хийх програмын үзүүлэлт

Бичигдсэн технологи: Microsoft.NET 2005
Програмчлалын хэл: VB,C#,ASP.NET
Өгөгдлийн бааз: Sql 2000
Microsoft framework: version 2.0

Програм ажиллах системийн шаардлага

Operation system:	Windows XP SP2
CPU:	1.5Ghz санал болгож байгаа нь 2.0Ghz

RAM:	256 Mb болон түүнээс дээш
Hard disk free space:	40GB
Display resolution:	840x600 болон түүнээс дээш
CDROM:	rewitable drive
Internet speed:	52Kbps болон түүнээс дээш

RCH буюу Registration of Cultural Heritage бүртгэлийн програмыг ТСДЗ-ийг бүртгэхэд зориулан 2006 оны 2-р сард БСШУ-ны сайдын 56-р тушаалаар баталсан Маягт.2-ыг ашиглан гол чиглэлээ болгож, зохих өөрчлөлт шинэчлэлтийг хийлээ.

Бүртгэл хийхэд зориулж тусгайлан бэлдсэн өгөгдөл, музейн стандарт журамд заасан бүртгэлийн ангилалт, улсын хэмжээнд мөрдөж буй шинэчилсэн бүс нутгийн код индексийг програм хангамжинд өргөн ашигласнаар монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн гэж үзэж байна.

Програмын бодлогын даалгаврыг СӨТ-ийн мэргэжилтнүүд бусад музей, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран боловсруулллаа.

ТСДЗ нь маш олон төрөл зүйл, ангилалтай байдаг ба энэхүү төрөл зүйл, ангилалтыг мөн музейн эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж ерөнхий байдлаар бүгдийг хамруулахыг зорьсон юм.

Энэ програм нь улсын хэмжээнд ТСДЗ-ийг бүртгэх нэг стандарт бий болгох зорилготой ба бусад байгууллага өөрийн онцлогт тохирсон бүртгэлийн нарийн төрөлжсөн системтэй (database) байж болно.

Соёлын өвийн төв нь энэ хөтөлбөрийн хүрээнд 3 төрлийн програм хангамж зохионо.

1-рт: Хөтөлбөрт хамрагдаж буй 35 нэгж байгууллагад зориулсан хөдлөх дурсгалыг бүртгэх сүлжээнд ашиглах “RCH” програм

2-рт: Соёлын өвийн УНБМСанд бүх 35 байгууллагаас цуглагдан ирсэн бүртгэл мэдээллийг нэгтгэн боловсруулалт хийх сервер буюу “Мэдээлэл боловсруулах програм- CCH”

3-рт: Хээр, хөдөө орших хадны зураг, булш бунхан, хүн чулуу, байшин барилга гэх мэт түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэхэд зориулсан “Үл хөдлөх дурсгал програм” юм.

- Програм нь интернет сүлжээ ашиглан мэдээлэл дамжуулах тул тодорхой нууцлалтай. Бүртгэлийн мэдээллийг зөвхөн тухайн байгууллага болон Соёлын өвийн УНБМСан хоёр тодорхой график хугацааны дагуу нууцлалтай илгээх, хүлээн авах үйл ажиллагааг хийнэ. Бусад хэрэглэгч тухайн үед энэ ажиллагаанд оролцохгүй, хаагдмал байдалтай байна.
- Програм нь зөвхөн ТСДЗ-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж бичихээс гадна цуглагдсан бүртгэл мэдээллийг дотор нь нэгтгэх, хайх, боловсруулах системийн үйлдэл хийнэ.
- Програм нь ТСДЗ-ийг бүртгэн баримтжуулах үндсэн чухал ажил болох гэрэл зургийн өгөгдөлтэй хамт уялдаж ажиллана. Мэргэжлийн дижитал гэрэл зургийн аппаратаар авсан зургийн нягтаршил автоматаар бүртгэлийн програмд нэг хэмжээнд шилжиж орно.
- Програмын текст бичилтэнд урьд өмнө Microsoft WORD програм дээр бичигдсэн файлыг шууд зөөж хуулах боломжтой ба англи монгол хэлээр компьютерийн гар солигдоно. (ARIAL MON үсгийн шрифтийг ашиглана.)
- Бичигдсэн бүртгэл мэдээллийг бүхий л төрлөөр хэвлэнэ. Үүнд хүссэн мэдээлэл, хайлт хийсэн нөхцлөөрөө хэрэглэгч өөрөө хүснэгт зохиож боловсруулан, мэдээллээ хэвлэж гаргах боломжтой.

Хөтөлбөрт хамрагдаж буй байгууллагууд бусад музей, судалгааны байгууллагатай хамтран ажиллах бөгөөд энэ бүхнийг www.monheritage.mn домайн нэрийн дор үүсгэсэн интернет хаягаар та бүхэн чөлөөтэй мэдээлэл солилцоно.

Мөн www.monheritage.mn вэб сайтыг интернет орчинд байршуулж байгаа ба энэ сайтанд 35 байгууллагын танилцуулга, зарим мэдээллийг нэгтгэн тодорхой хязгаарлалттайгаар судлаач, сонирхогч нийтэд түгээх үйл ажиллагаа хийгдэнэ.

Гурав. Хөтөлбөрт оролцогч байгууллагын үүрэг

- Музей болон бусад байгууллагын удирдлага энэхүү ажлыг хийхэд зориулсан хөдөлмөрийн хуваарь, мэргэжилтэн, зарцуулах цагийг (хүн, цагийг) түлхүү тавьж өгч, анхаарах, дэмжиж туслах хэрэгтэй
- Захиргааны зүгээс танай байгууллагад данс бүртгэлтэй бүх үзмэр, бүтээл, эд өлгийн зүйлсийн бүртгэлийг хийж, мэдээллийг СӨТ-д дамжуулж дуусах үе хүртэлх хугацаанд харъяа дээд шатны байгууллагатай “Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ” төлөвлөгөөнд энэхүү ажлыг төлөвлөн оруулах
- Энэ ажилд зориулсан эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтэнг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах

- Хөтөлбөрийн хүрээнд хэрэглэх техник тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдсон гэрээ болон түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулах, бүртгэл хийх, бүртгэлийг Соёлын өвийн төв рүү дамжуулахтай холбогдсон 2 төрлийн хамтын гэрээ байгуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамаар батлуулан ажиллана.
- "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.Дөрөв. Хөтөлбөрийн ач холбогдол

- Хөтөлбөрийн хүрээнд ашиглах програмыг хэрэглэснээр монгол улсын хэмжээнд ТСДЗ-ийг бүртгэх бүртэлийн нэгдсэн систем бий болон сүлжээнд орж, бүх музей интернетэд холбогдоно.
- 35 байгууллагад анхан шатны БМСан идэвхтэй үйл ажиллагаа явуулна.
- Нэгдсэн стандарт хэв загварт орсноор улсын хэмжээнд байгаа ТСДЗ-ийн талаарх бүртгэл мэдээллийг нэгтгэх, боловсруулах, статистик тоо баримтыг төрөл бүрээр үнэн зөв гаргах, мэдээлэх боломжоор хангагдана.
- ТСДЗ-ийг хадгалж хамгаалж буй бүх музей, байгууллага бүртгэлийн ажилд зориулсан өндөр хүчин чадалтай компьютер, мэргэжлийн гэрэл зургийг тоног төхөөрөмжөөр хангагдана.
- ТСДЗ-ийг хэрхэн бүртгэх, програм хангамж дээр ажиллах, гэрэл зургийг үнэн зөв баримтжуулж авах тухай сургалт, дадлага хичээл зохиож, тухайн байгууллагын ажилтанг мэргэшүүлнэ.
- Соёлын өвийн УНБМСанд монгол улсын хэмжээнд байгаа бүх ТСДЗ бүртгэгдэж, архив үүснэ.
- Соёлын өвийн төвд цаасан баримтын болон электрон мэдээллийн архивын сан бүрдэж, тоног төхөөрөмжөөр хангагдана.
- ТСДЗ гэнэтийн тохиолдлоор устах, алга болох эвдэрч гэмтсэн үед түүнийг сэргээн засварлах, шинээр хийхэд шаардлагатай бүхий л баримт мэдээлэл, тал бүрээс нь болон онцлог шинжийг бодитой авсан гэрэл зураг зэрэг нь энэхүү бүртгэлийн програмаар дамжигдан хадгалагдан үлдэх ач холбогдолтой.
- Компьютерийн програмд бичигдсэн бүртгэл нь байгууллагад 1 хувь, СӨТ-ийн УНБМСанд 1 хувь байх ба компьютерийн хард дискэнд болон CD-ROM-д, мөн цаасан хэлбэрээр тус бүр хадгалагдана. Мөн 3 дахь хувийг Улсын төв архивт хадгалуулах төлөвлөгөөтэй байна.

Тав. Хүлээгдэж буй үр дүн

Аймгийн музей дунджаар 3,000 гаруй үзмэртэй, улсын музей дунджаар 10,000 гаруй үзмэртэй гэсэн судалгаа байдаг.

Хөтөлбөрт хамрагдсан байгууллага нь ТСДЗ-ийн эрдэм шинжилгээний тодорхойлолт бүртгэлийг хийж СӨТ рүү мэдээллийг заасан цаг хугацааны дагуу улиралд 1 удаа буюу жилд 4 удаа интернет шугам ашиглан илгээнэ.

1 удаагийн илгээх багц бүртгэлд дунджаар аймгийн болон шашин, эрдэм шинжилгээний байгууллага 100-150 орчим ширхэг түүх, соёлын дурсгал, улсын музей дунджаар 250-300 орчим ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлийг хамруулж байх төлөвлөлт байна.

ТСДЗ-ийг бүртгэх эрдэм шинжилгээний тодорхойлолт нь програм хангамжийн туслалцаатайгаар бичигдэж, интернет шугам ашиглагдан Соёлын өвийн төв рүү заагдсан хуваарийн дагуу ирэх ба харин гэрэл зураг нь мөн хуваарын дагуу CD-ROM-д дижитал хэлбэрээр бичигдэж, баталгаат шуудан болон бие төлөөлөгчөөр дамжигдаж ирнэ.

Иймд энэ хөтөлбөрийн үр дүнд 2015 он гэхэд 35 байгууллагын түүх, соёлын дурсгалт зүйл, үзмэр, бүтээл, эд өлгийн зүйлс, олдворын бүртгэл, эрдэм шинжилгээний тодорхойлолт, гэрэл зургийн хамт баримтжуулагдан бүртгэгдэж, архивлагдсан байх зорилт тавьж ажиллана.

Энэ ажлыг хийхийн тулд нэгж байгууллагатай холбогдох дээд шатны байгууллага "Үр дүнгийн гэрээ" байгуулах, нэгж байгууллага өөрсдийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай уялдаж ажиллах, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, шинэчлэлтийг хийж байх зэрэг олон нөхцөл бүрдэж нэгдэн хамтран ажиллах шаардлага гарч ирж байна.

2007 онд танай байгууллагын 4 сарын хугацаанд интернет ашигласны зардлыг Соёлын өвийн төвөөр дамжуулан танай байгууллага руу шилжүүлсэн ба энэхүү зардлын дагуу танай байгууллага ирэх жилийн 2008 оны урсгал зардалдаа тухайн зардлыг суулгаж авна.

Мөн Засгийн газрын тогтоол, хөтөлбөрт ТСДЗ-ийг бүртгэн баримтжуулахад зориулсан 420,000 төгрөгийг жил бүр улсын төсөвдөө суулгаж авч байх талаар заалт орсон байгаа болно.

Энэ хөтөлбөр нь 2009 онд явцын байдлаа засгийн газарт тайлагнах бөгөөд цаашид хөтөлбөр бус музейн үйл ажиллагааны үндсэн ажил үүрэг болгож үргэлжлүүлэн хийгдэнэ.

Цаашид жил бүр энэ хөтөлбөр-үйл ажиллаганы явцын тайланг Боловсрол, соёл, шинжлэх, ухааны яам болон холбогдох газарт өгч дүгнэлт, үнэлгээ шинжилгээ хийнэ.

Соёлын өвийн төв

Хөтөлбөр хамрагдсан 35 байгууллагын Соёлын өвийн төв рүү мэдээллээ дамжуулах хуваарь

/Эрчим хүчний хязгаарлалттай аймаг болон хотын музейнүүдийн ачаалал, жуулчны улирлыг харгалзан үзэв/

д/д	Байгууллагын нэрс	2007 он												2008 оноос эхлэн цаашид жил бүр											
	сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Зүүн болон говийн бүс																								
1	Хэнтий										■				■			■			■			■	
2	Дорнод										■				■			■			■			■	
3	Сүхбаатар										■				■			■			■			■	
4	Дорноговь											■			■			■			■			■	
5	Говьсүмбэр											■			■			■			■			■	
6	Дундговь											■			■			■			■			■	
7	Өмнөговь											■			■			■			■			■	
	Төвийн бүс																								
8	Төв											■				■			■			■			■
9	Өвөрхангай											■				■			■			■			■
10	Эрдэнэ-зуу											■				■			■			■			■
11	Архангай											■				■			■			■			■
12	Булган												■			■			■			■			■
13	Эрдэнэт												■			■			■			■			■
14	Сэлэнгэ												■			■			■			■			■
15	Дархан-Уул												■			■			■			■			■
	Баруун бүс																								
16	Хөвсгөл													■			■			■			■		
17	Завхан													■			■			■			■		
18	Увс													■			■			■			■		
19	Баян-Өлгий													■			■			■			■		
20	Ховд													■			■			■			■		
21	Говь-Алтай													■			■			■			■		
22	Баянхонгор													■			■			■			■		
	Улаанбаатар хот																								
23	Богд хааны ордон музей											■			■			■				■			■
24	Чойжин ламын сүм музей											■			■			■				■			■
25	Дүрслэх урлагийн музей											■			■			■				■			■
26	Археологийн хүрээлэн											■			■			■				■			■
27	Үндэсний түүхийн музей											■			■			■				■			■
28	Байгалийн түүхийн музей											■			■			■				■			■
29	Уран зургийн галарей											■		■		■			■				■		
30	Үндэсний номын сан											■		■		■			■				■		
31	Гандантэгчэнлин хийд											■		■		■			■				■		
32	Театрын музей											■		■		■			■				■		
33	Монгол цэргийн музей											■		■		■			■				■		
34	Палеонтологийн хүрээлэн											■		■		■			■				■		
35	Улаанбаатар хотын музей											■													

“Үндэсний соёлын өвийн мэдээлийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд www.monheritage.mn домэйн дээр тулгуурлан 35 байгууллагын харилцах хаяг

Соёлын өвийн төвийн УНБМСангийн имэйл хаяг
cch_fund@monheritage.mn

1. Монголын үндэсний түүхийн музей	history_mus@monheritage.mn
2. Дүрслэх урлагийн музей	finearts_mus@monheritage.mn
3. Богд хааны ордон музей	bogd_mus@monheritage.mn
4. Чойжин ламын сүм музей	choijin_mus@monheritage.mn
5. Монголын уран зургийн галерей	artgallery@monheritage.mn
6. Монголын театрын музей	theatre_mus@monheritage.mn
7. Эдэнэзуу музей	erdenezuu_mus@monheritage.mn
8. Монголын үндэсний номын сан	library@monheritage.mn
9. ШУА-ын Археологийн хүрээлэн	archeology@monheritage.mn
10.ШУА-ын Палентологийн төв	palentalogy@monheritage.mn
11 .БХЯ-ны харъяа Монгол цэргийн музей	military_mus@monheritage.mn
12.Гандантэгчилэн хийд	gandan@monheritage.mn
13.Архангай аймгийн музей	arkhangai_mus@monheritage.mn
14.Баян-Өлгий аймгийн музей	bayanulgii_mus@monheritage.mn
15.Баянхонгор аймгийн музей	bayankhongor_mus@monheritage.mn
16.Булган аймгийн музей	bulgan_mus@monheritage.mn
17.Говь-Алтай аймгийн музей	gobialtai_mus@monheritage.mn
18.Говьсүмбэр аймгийн музей	gobisumber_mus@monheritage.mn
19.Дархан Уул аймгийн музей	darkhan_mus@monheritage.mn
20.Дорноговь аймгийн музей	dornogobi_mus@monheritage.mn
21.Дорнод аймгийн музей	dornod_mus@monheritage.mn
22.Дундговь аймгийн музей	dundgobi_mus@monheritage.mn
23.Завхан аймгийн музей	zavkhan_mus@monheritage.mn
24.Орхон аймгийн музей	orkhon_mus@monheritage.mn
25.Өвөрхангай аймгийн музей	uvurkhangai_mus@monheritage.mn
26.Өмнөговь аймгийн музей	umnugobi_mus@monheritage.mn
27.Сүхбаатар аймгийн музей	sukhbaatar_mus@monheritage.mn
28.Сэлэнгэ аймгийн музей	selenge_mus@monheritage.mn
29.Төв аймгийн музей	tuv_mus@monheritage.mn
30.Увс аймгийн музей	uvs_mus@monheritage.mn
31.Ховд аймгийн музей	khovd_mus@monheritage.mn
32.Хөвсгөл аймгийн музей	khuvsgul_mus@monheritage.mn
33.Хэнтий аймгийн музей	khentii_mus@monheritage.mn
34.Улаанбаатар хотын музей	ulaanbaatar_mus@monheritage.mn
35.Байгалийн түүхийн музей	natural_mus@monheritage.mn

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 03 сарын 05 өдөр — Дугаар 55 — Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 244 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хөтөлбөрт хамрагдсан (хавсралтад заасан) байгууллагууд 2007 оны интернэт суурилуулах зардлыг байгууллагынхаа 2007 оны төсвөөс, ашиглах зардлыг Соёлын өвийн төвөөс гаргах, 2008 оноос эхлэн интернэт ашиглах зардлаа байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгаж байхыг Соёлын өвийн төв, улс, аймгийн музейн захирал нарт тус тус даалгасугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын гэрээ хийх, соёлын өвийн бүртгэл-мэдээллийг улирал бүр Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд ирүүлж байх талаар жил бүрийн Үр дүнгийн гэрээндээ тусгаж ажиллахыг Соёлын өвийн төв, улс, аймгийн музейн захирал нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Соёл, урлагийн газар /Г.Эрдэнэбат/, хөтөлбөрийн явцыг цаг тухайд нь тайлагнаж байхыг Соёлын өвийн төв /Г.Энхбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД Ө. ЭНХТҮВШИН

90 171

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 55 дугаар тушаалын хавсралт

Соёлын Өвийн Төвийн **www.monheritage.mn** домэйн дээр тулгуурлан 35 байгууллагын 2007 онд интернэт ашиглах зардал

1	Монголын үндэсний түүхийн музей	history_mus@monheritage.mn	839000₮
2	Дүрслэх урлагийн музей	finearts_mus@monheritage.mn	839000₮
3	Богд хааны ордон музей	bogd_mus@monheritage.mn	839000₮
4	Чойжин ламын сүм музей	choijin_mus@monheritage.mn	839000₮
5	Монголын уран зургийн галерей	artgallery@monheritage.mn	839000₮
6	Монголын театрын музей	theatre_mus@monheritage.mn	839000₮
7	Эрдэнэзуу музей	erdenezuu_mus@monheritage.mn	839000₮
8	Монголын үндэсний номын сан	library@monheritage.mn	839000₮
9	ШУА-ын Археологийн хүрээлэн	archeology@monheritage.mn	839000₮
10	ШУА-ын Палентологийн төв	palentalogy@monheritage.mn	839000₮
11	БХЯ-ны харьяа Монгол цэргийн музей	military_mus@monheritage.mn	839000₮
12	Гандантэгчилэн хийд	gandan@monheritage.mn	839000₮
13	Архангай аймгийн музей	arkhangai_mus@monheritage.mn	600000₮
14	Баян-Өлгий аймгийн музей	bayanulgii_mus@monheritage.mn	600000₮
15	Баянхонгор аймгийн музей	bayankhongor_mus@monheritage.mn	600000₮
16	Булган аймгийн музей	bulgan_mus@monheritage.mn	600000₮
17	Говь-Алтай аймгийн музей	gobialtai_mus@monheritage.mn	600000₮
18	Говьсүмбэр аймгийн музей	gobisumber_mus@monheritage.mn	600000₮
19	Дархан Уул аймгийн музей	darkhan_mus@monheritage.mn	600000₮
20	Дорноговь аймгийн музей	dornogobi_mus@monheritage.mn	600000₮
21	Дорнод аймгийн музей	dornod_mus@monheritage.mn	600000₮
22	Дундговь аймгийн музей	dundgobi_mus@monheritage.mn	600000₮
23	Завхан аймгийн музей	zavkhan_mus@monheritage.mn	600000₮
24	Орхон аймгийн музей	orkhon_mus@monheritage.mn	600000₮
25	Өвөрхангай аймгийн музей	uvurkhangai_mus@monheritage.mn	600000₮
26	Өмнөговь аймгийн музей	umnugobi_mus@monheritage.mn	600000₮
27	Сүхбаатар аймгийн музей	sukhbaatar_mus@monheritage.mn	600000₮
28	Сэлэнгэ аймгийн музей	selenge_mus@monheritage.mn	600000₮
29	Төв аймгийн музей	tuv_mus@monheritage.mn	600000₮
30	Увс аймгийн музей	uvs_mus@monheritage.mn	600000₮
31	Ховд аймгийн музей	khovd_mus@monheritage.mn	600000₮
32	Хөвсгөл аймгийн музей	khuvsgul_mus@monheritage.mn	600000₮
33	Хэнтий аймгийн музей	khentii_mus@monheritage.mn	600000₮
34	Улаанбаатар хотын музей	ulaanbaatar_mus@monheritage.mn	839000₮
35	Байгалийн түүхийн музей	natural_mus@monheritage.mn	839000₮

Нийт дүн: 24'346'000₮

www.monheritage.mn

Музейн Үзмэр тодорхойлох арга зҮйн зарим асуудал

Музейн олон талт үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь үзмэрийг судлан, бүртгэн баримтжуулах ажил буюу үзмэр нэг бүрт тодорхойлолт хийх арга зүйн асуудал юм. Үзмэрийн тодорхойлолт нь шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой дэс дараалал, нарийн мэдлэг, дадлага шаардана.

Үзмэрийн тодорхойлолт (Опредление музейных предметов
буюу **Object ID)** хийх арга зүйн асуудал

Үзмэрийн тодорхойлолтын стандартыг хаана, хэзээ боловсруулсан бэ?

Олон улсын хэмжээнд мөрдөх Үзмэрийн тодорхойлолтын стандарт боловсруулах асуудлыг анхлан Гетти мэдээллийн хүрээлэн (АНУ, Лос Анжелес) сэдэж тусгай төсөл боловсруулах замаар хэрэгжүүлжээ. Жеан Паул Гетти нь АНУ-ын газрын тосны эзэн, тэрбумтан байсан бөгөөд урлагийн бүтээл, хуучны эдлэлийн нэртэй цуглуулагч байжээ. Геттигийн нэрэмжит музей, хүрээлэн, ивээх сан зэрэг олон газар, байгууллагууд бий.

1993 онд Парис хотноо тус хүрээлэн соёлын дурсгал тодорхойлох баримт бичгийн стандарт боловсруулах төслийн асуудлаар уулзалт зохион байгуулсан.

Уулзалтанд Европын хамтын ажиллагаа, аюулгүй байдлын байгууллага, Европын зөвлөл, Олон улсын музейн зөвлөл, Интерпол, Юнеско зэрэг байгууллагууд оролцжээ. Оролцогчид соёлын дурсгалыг тодорхойлоход шаардагдах мэдээллийг бүрдүүлэх, холбогдох жишгийг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх механизм хэрэгтэй байгаа талаар нэгдсэн зөвшилд хүрсэн байна. Төсөлд дараах 6 байгууллага хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

- Соёлын өвийн байгууллагууд /музей, үнэлгээний газрууд, археологийн хүрээлэн, байгууллагууд/
- Хууль хэрэгжүүлэгч агентууд
- Гаалийн байгууллагууд
- Урлагийн бүтээл худалдаалдаг газрууд
- Үнэлгээний газрууд
- Даатгалын байгууллагууд

Боловсруулахаар төлөвлөсөн баримт бичгийн жишгийг тогтооход юуны өмнө мэдээлэл бүрдүүлэхэд шаардлагатай асуултуудыг дээрх байгууллага бүрээс авч тодорхой болгох, тэдгээрийг харьцуулж үзэх явдал чухал гэж тооцсон бөгөөд энэ ажлыг олон улсын чанартай асуулт хариултын судалгаагаар хэрэгжүүлсэн ба судалгаанд 44 орон оролцож, эдгээр оронд байгаа холбогдох байгууллагууд хариултаа ирүүлсэн. Энэ судалгааны дүнг 1994-1996 оны хооронд дээр дурьдсан байгууллагуудын мэргэжлийн шинжээчид оролцсон 5 удаагийн уулзалтаар шүүн хэлэлцэж нягталжээ. Ингэж олон улсад мөрдөж болохуйц үзмэр тодорхойлох баримт бичгийн стандартийг боловсруулсан байна.

Үзмэрийн тодорхойлолт гэж чухам юуг хэлэх вэ?

Үзмэрийн тодорхойлолт гэдэг нь урлагийн бүтээл, эртний эдлэлийг тодорхойлоход хэрэгтэй хамгийн наад захын мэдээллийг агуулсан олон улсын стандарт бичиг баримт юм. Уг стандартыг музей, цагдаа, гааль, урлагийн бүтээлийг худалдаалдаг байгууллага, даатгал, урлагийн бүтээл-хуучны эдлэлийг үнэлдэг үнэлгээний байгууллагуудын оролцоотойгоор боловсруулсан. Энэхүү стандарт нь дараах бичиг баримтын байдлаар ашиглагдана. Үүнд:

- Хулгайлагдсан болон алдагдсан үзмэрийг тодруулахад шаардлагатай мэдээллийг шалгаж гэрчлэх баримтын үүргээр
- Үзмэр тодорхойлоход хэрэгтэй наад захын мэдээллийг бүрэлдүүлж байгаа стандарт баримт бичгийн үүргээр
- Олон улсын байгууллагууд үзмэрийн тодорхойлолтыг богино хугацаанд солилцох мэдээллийн сүлжээг боловсруулахад үндсэн баримт бичиг болгох
- Урлагийн бүтээл, эртний эдлэлийг хэрхэн баримтжуулах тухай аливаа сургалтын хөтөлбөрт гол хэрэглэгдэхүүн болгож ашиглах

Үзмэрийн тодорхойлолтын стандарт яагаад хэрэгтэй болсон бэ?

Өнөөдөр урлагийн бүтээл, эртний эдлэл хийгээд соёлын бусад эд зүйлсийг хууль бусаар худалдаалах нь олон улсын хэмжээнд өргөн дэлгэрээд байгаа гэмт хэргийн нэгэн төрөл болоод байна. Соёлын дурсгалыг хамгаалахад баримт бичгийн стандарт маш чухал зүйл бөгөөд сайн тодорхойлолт хийгдээгүй, зурагжуулаагүй үзмэр нь алга болох, эвдрэх гэмтэх тохиолдолд сэргээн засварлах боломцоогүй байдаг. Зарим үзмэрийн хувьд хулгайлагдсан тохиолдолд зөвхөн эд материалын хувьд дахин сэргээж болохоор баримтжуулсан байдаг, мөн хэдийгээр баримт бичгийг бүрэлдүүлсэн ч холбогдох мэдээлэл нь нэг хэвийн бус, янз бүрийн байдлаар хийгдсэн байдаг. Тийм учраас үзмэрийн тодорхойлолт нь шаардлага хангахуйц, стандарт байх нь чухал юм.

Тодорхойлолтыг сайн хийх нь гэмт хэргийн илрүүлэлт, алдагдсан үзмэрийг сэргээхэд туслаад зогсохгүй гэмт хэргийн гаралтыг зогсоох бодлогын хэмжээнд чухал болно. Хулгайлагдсан болон хууль бусаар хилийн чанадад гарч байгаа үзмэрийн мэдээлэл нь маш хурдан дамжуулагдаж байх учиртай, өөрөөр хэлбэл, олон улсын хил болон зохих байгууллагуудад хүргэгдэж байх хэрэгтэй гэсэн үг юм. Цахим сүлжээний өнөөгийн хөгжил нь энэ боломжийг бүрэн хангаж байна.

Үзмэрийн тодорхойлолт буюу Object ID стандартыг ашиглан урлагийн бүтээл, эртний эдлэлийг тодорхойлох тухай

Үзмэрийн тодорхойлолтын стандартыг боловсруулахдаа 2 үндсэн баримт бичгийг боловсруулж гаргасан. Нэгдэх нь Үзмэр тодорхойлох стандарт, нөгөө нь Үзмэрийн гэрэл зураг авах аргачлал-ын тухай баримт бичиг юм, Үзмэр тодорхойлох стандартад үзмэрт бичгээр тодорхойлолт хийхдээ 9 төрөлд хамаарах мэдээллийг оруулах нь зүйтэй гэж тогтсон. Үүнд:

- Үзмэрийн төрөл,
- Материал ба арга техник,
- Хэмжилт,
- Бичээс болон тэмдэгтүүд,
- Содон шинжүүд,
- Нэр,
- Сэдэв /тухайн үзмэр чухам юун тухай болох/
- Он цаг,
- Хийсэн бүтээлч. Үзмэрийг тодорхойлох талаар хэдийгээр нэгдсэн саналд

хүрээгүй хэдий ч дээрх 9 зүйл дээр бас нэмэлт 5 зүйл мэдээллийг оруулах нь зүйтэй гэж үзсэн байна. Үүнд: Дансны дугаар, Холбогдох бичмэл хэрэглэгдэхүүн, Нээж олсон газар, Холбогдох лавлагаа, Баримтжуулсан огноо.

Угсаатны зүйн үзмэрүүдийг тодорхойлоход анхаарах зарим арга зүйн асуудал

Үзмэрийн тодорхойлолтыг зөв, оновчтой хийж гүйцэтгэх нь тухайн дурсгал буюу үзмэр нь соёлын дурсгалт зүйлсийн чухам ямар төрөлд хамаарч байна гэдгээс ихээхэн шалтгаална. Байгаль, түүх, археологи, угсаатны зүй, урлагийн төрөл зүйлд хамаарах үзмэрүүд нь өөр өөрийн өвөрмөц онцлогыг хадгалж байдаг. Угсаатны зүйн холбогдолтой үзмэрийн хувьд ихээхэн хам шинжтэй, тухайн угсаатан, ард түмний амьдралын олон талыг тусгаж байдаг онцлогтой. Тухайлбал, уламжлалт аж ахуй, тээврийн хэрэгсэл, гар урлал, гэр орон сууц, дээл хувцас, гоёл чимэглэл, хоол унд, тоглоом наадгай зэрэг соёлын олон арван дурсгалуудыг багтаадаг бөгөөд эдгээр нь байгалийн ухаан, урлаг, шашин шүтлэг, зан заншил, зан үйлийн ойлголт төсөөлөл, өвөрмөц талуудыг өөртөө агуулж байдаг. Мөн эдгээр соёлын олон зуун дурсгалууд нь янз бүрийн бүс нутгийн гаралтай, янз бүрийн түүхэн он цагт байсан эд материалаар хийгдсэн, хийж урлахдаа өвөрмөц олон төрлийн арга техник ашигласан байдаг онцлогтой. Нийгэм ямагт урагшаа явдаг тул 50 жилийн дараа гэхэд л бүх юм өөрчлөгдөн мэдэх хүн бараг байхгүй болдог байна. 100 жилийн өмнөх зүйлийг асуух, мэдэх гэдэг нь бүрч бэрхшээлтэй нь тодорхой.

Угсаатны зүйн холбогдолтой үзмэрт тодорхойлолт хийхэд тухайн үзмэрийг ямар эд материалаар хийсэн, үзмэрийг ямар арга техник хэрэглэж бүтээсэн, уг үзмэр ямар хийц загвар /стиль/-д хамаарч байгаа, үзмэрт хэрхэн хэмжилт хийх, үзмэр-дурсгалын он цагийг хэрхэн тодорхойлох зэрэг нь маш чухал юм. Ялангуяа угсаатны зүйн үзмэрийн хувьд угсаатны хамаарлыг зөв тодорхойлох явдал ихээхэн ач холбогдолтой зүйл юм. Мөн үзмэрийн өнгө, хэлбэр, жин зэрэг ч чухалд тооцогдоно. Дүрслэх урлагийн бүтээл, бичгийн болон гэрэл зураг, кино зэрэг дурсгалуудын хувьд сюжет буюу өгүүлэмж, сэдэв, агуулга ихээхэн үнэ цэнэтэй юм. Эдгээр нь тухайн үзмэрийн гол шинж чанар, онцлогыг илэрхийлдэг.

Үзмэрийн материалыг тодорхойлох. Үзмэр хийсэн эд материал олон янз байх, түүнийг таньж ялгахад бэрхшээлтэй байх нь тухайн орны хөгжлийн хандлагатай ихээхэн уялдаатай, монголын орны хувьд энэ асуудал харьцангуй амар дөхөм гэж хэлж болно. Гэхдээ хөрш орнуудаас дамжиж ирсэн зээлдмэл соёлын дурсгалуудын хувьд асуудал өөр юм. Тухайлбал, олон зуун жилийн соёлын баялаг уламжлалттай, олон соёл солигдож өөрчдлөгдсөн, мөн соёлын дурсгалыг эрт дээр үеэс хуурамчаар хийж орлуулдаг байсан хятад гаралтай үзмэр-дурсгалуудын материалыг үнэн зөв тодорхойлоход нарийн төвөгтэй байх нь эргэлзээгүй.

Үзмэрийн материалыг тодорхойлоход нэг анхаарах зүйл бол тухайн үзмэрийг хийсэн материал нь байгальд байсан байдлаараа ашиглагдаж уу, эсвэл хэд дахин боловсруулагдсан байна уу гэдгийг ажиглаж мэдэх нь ихээхэн чухал. Үүнийг мод, чулуу, зарим металл эд материалаар хийсэн эд өлгийн дурсгалууд дээр харж болно. Эхний хэсэгт эдгээр материалын зөвхөн төрөл зүйлийг зааж тодорхойлоход л хангалттай.

Холимог материалын хувьд нарийн мэргэжил, олон жилийн дадлага туршлага, цаашлаад хими, физикийн мэдлэг, лабораторийн нарийн шинжилгээ шаардах юм. Нарийн мэргэжил тэр бүр шаардаад байхгүй ч хэд хэдэн материал орсон үзмэр-дурсгалууд ч байдаг. Алтаар, гуулиар шарсан, цайрдсан, мөнгө, алт, зэс, гуулиар жийжүүдсэн эдлэл хэрэглэл өдий төдий буй. Эдгээрийг тодорхойлолтондсайн тэмдэглэж бичиглэх ёстой. Цайр, цас, пойлоос зэрэг материалаар хийсэн эд өлгийн зүйлсүүд нь ямар шинж тэмдгээр өөр хоорондоо ялгарах вэ гэдгийг нарийн сайн мэдэх, үүнийхээ үндсэн дээр бид зөв тодорхойлолт хийх бололцоотой. Үзмэрийг материал нь лавтай сайн танигдаж тогтоогдоогүй үед шууд алт, мөнгө гэж бичих нь буруу бөгөөд мөнгө шиг цагаан өнгөтэй эсвэл алт шиг алтан шаргал өнгөтэй гэх мэтчилэн өнгө, хэлбэр дүрсийг нь тодорхой сайн бичиж бүртгэх нь зүйтэй. Таниж мэдэхэд хэцүү нарийн төвөгтэй холимог эд материалын хувьд метал судлалын мэргэжилтэнд хандахаас өөр аргагүй юм. Мөн дүрслэх урлагийн бүтээлүүд, ахуй хэрэглээний эдлэл хэрэглэлийн будаг шунх, тэдгээрийн төрөл зүйлийг таньж мэдэх нь ихээхэн төвөгтэй байдаг.

Монголын угсаатны зүй, дүрслэх урлагийн олон арван дурсгалууд торго, бөс даавуу зэрэг зөөлөн материалыг ашиглаж бүтээгдсэн байдаг. Эдгээр материалыг ихэнхдээ хөрш зэргэлдээх орнуудаас худалдаагаар авчирдаг байсан. Тийм учраас тухайн орнуудын ямар бүс нутгуудад хэдий үед торго, даавууны ямар төрлийг хийж үйлдвэрлэдэг байсан, мөн монголд хэдий үеэс тэдгээр эд барааг оруулж ирэх болсон, хэдий үед зогссон зэргийг мэдэх шаардлагатай бөгөөд энэ мэдлэгийг бид холбогдох судалгаануудаас олж болох юм. Энэ нь үзмэрийн материалыг зөв тодорхойлоод зогсохгүй тухайн дурсгалын хийсэн он цагийг тогтоох бололцоог олгох ач холбогдолтой.

Үзмэрийг хийсэн арга техник, түүнийг тодорхойлох. Үзмэрийг хийж бүтээсэн арга техник нь тухайн дурсгалыг тодорхойлох чухал шинж тэмдгийн нэг болдог. Хийсэн аргыг тодорхойлох гэдэг нь тухайн үзмэрийг хийж урласан гол арга техник, уг үзмэрийн хээ гоёл, будаг шунх зэргийг хэрхэн бүтээв гэдгийг товч тэмдэглэж бичихэд л оршино. Юуны өмнө тухайн үзмэрийг гараар, эсвэл ямар нэг механикжсан техник ашиглаж хийсэн эсэх, эсвэл бүр үйлдвэрийн аргаар хийж урласан уу гэдгийг эхлээд тогтоох нь зүйтэй юм. Үүний дараа тухайн дурсгалыг тодорхой ямар арга техникээр хийснийг тодруулах, тухайлбал, барих, эсвэл цутгуурын арга, эсвэл хөөмлийн арга ашигласан уу гэдгийг тодорхойлвол зохино. Нэг дурсгалыг хосолмол аргаар хийх тохиолдол ч цөөнгүй. Гараар хийж бүтээсэн эд өлгийн дурсгалууд нь хэдий уран чадварлаг хийсэн байлаа ч аль нэг хэмжээгээр зарим хэсэгтээ тодорхой хэмнэл алдагдсан байдаг нь олонтоо, мөн уг дурсгалын өнгөн хэсгээр ямар нэг ор мөр ажиглагддаг байна. Тиймээс эдгээрийг сайн нягталж үзэх явдал чухал юм. Машин, үйлдвэрийн аргаар хийсэн эд өлгийн дурсгалуудын деталь хэсгүүд нь хэмнэлийн хувьд ижил давталттай, өнгөн тал нь жигд, гөлгөр байх жишээтэй, мөн олон тоогоор үйлдвэрлэгдсэн байдаг онцлогтой.

Үзмэрийн хэмжээ /үзмэрийг хэрхэн хэмжих/. Аливаа үзмэрийн хэмжээ нь бас л тодорхой мэдээллийг өөртөө агуулж байдаг онцлогтой. Тухайлбал, монголчуудын эдлэж хэрэглэж ирсэн олон арван эд өлгийн зүйлс нь хэмжээгээр тийм том биш байдаг. Энэ нь үргэлж хөдөлгөөнтэй, нүүж сууж явдаг нүүдлийн ахуйтай гүнээ шүтэлцээтэй уламжилсан нь эргэлзээгүй. Гэтэл суурьшмал орнуудын ард түмнүүдийн эдлэж хэрэглэж ирсэн зарим эд өлгийн жишээн дээр авч үзэхэд ихээхэн өөр, харьцангуй том хэмжээтэй байдаг онцлогтой. Үзмэрийн хэмжээг олон улсын стандартад тохируулж нэгдсэн нэг маягаар хэмжилт гаргана гэдэг нь арга зүйн хувьд ихээхэн чухал ажил, тэгээд ч янз бүрийн төрөлд хамаарах олон зуун хэлбэр төрх бүхий үзмэр-дурсгалуудыг хэмжих гэдэг нь тийм ч хялбар бус. Юуны өмнө хэмжих нэгж ижил байх, ямар үзмэрт 2 хэмжээст хэмжилт хийх, ямар үзмэрт 3 хэмжээст хэмжилт хийх вэ? гэдэг талаар нэгдсэн нэг ойлголт, нэг журам заавар мөрдөх ёстой юм. Уран зураг, фото зураг зэрэг зөвхөн ганц хавтгай гадаргуутай үзмэрийг голдуу өндөр /height/, өргөн /width/ гэсэн 2 хэмжээст байдлаар, авдар, хайрцаг зэрэг олон талтай, зөв тэгш хэмтэй эд өлгийн дурсгалуудыг өндөр /heigth/, өргөн /width/, зузаан /debth/ зэрэг 3 хэмжээст хэмжилтээр хэмждэг байна. Харин дээл хувцас, том жижиг янз бүрийн өвөрмөц дүрс хэлбэртэй бүтээлүүдэд хэмжилт хийхэд багагүй бэрхшээлтэй болно. Эдгээрийг бас л ихэнхдээ өндөр /heigth/, өргөн /width/, эсвэл зөвхөн өндөр /heigth/, эсвэл зөвхөн урт /Length/, дугуй хэлбэрийн үзмэрийг голч / diameter/ зэрэг 2 эсвэл 1 төрлийн хэмжилтээр хэмждэг байна.

Үзмэрийн хэмжээ гэдэг ойлголтонд мөн жин чухал байртай, гэхдээ энэ бол ихэнх ном зохиолд тэмдэглэснээр голдуу ховор үнэт үзмэрүүд-д хамаарах юм.

Угсаатны зарим үзмэрүүдийн хэмжээс, нэр томъёоны тухай. Угсаатны үзмэрүүдийн хэмжээ, жин, хийсэн матариал, загвар, зориулалт, нэршил, цаг үеийг тодорхойлох асуудал үзмэрийг бүртгэн баримтжуулахад чухал байдаг.

Аймаг орон нутагт олноор байх үзмэрийн тоонд хувцас, гоёл чимэглэлийн эд зүйлс ихээхэн байдаг. Гэтэл эдгээр нь олон эсгэвэртэй, 2-оос дээш материалаар хийгдсэн, олон хэсгээс бүтсэн байх нь элбэг. Эдгээрийг тодорхойлоход нэлээд бэрхшээлтэй. Ялангуяа тэдгээрийн хэмжээсний асуудлыг нэг тал болгон шийдвэрлэх нь чухал. Нэгдсэн арга зүй одоогоор үгүй учир бүртгэл, эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж байгаа хүмүүс өөр өөрийнхөөрөө буруу зөрүү хэмжээс, нэр томъёог ашиглан тайлбарлах нь бий.

Монголчуудын өмсөж байсан хувцас нь тухайн угсаатныхаа уламжлалт соёл, эрхлэх аж ахуй, зан заншил түүхэн уламжлал зэргийг өөртөө тусгасан онцлог шинжүүдтэй.

Дээлний загвар, эсгүүр, хэмжээс

Музейд голчлон халх, буриад, баруун монгол дээлийн 3 янзын хийц загвартай дээл тэрлэг бий бөгөөд эдгээр нь өөр хоорондоо нэлээд ялгаатай. Эрэгтэй дээлний ерөнхий эсгүүр, хэмжээ нь уламжлалт байдлаа хадгалсаар өнөө хүрсэн байна.

а.Халх эхнэр дээл тэрлэг: Ар хэсэг, хормой, энгэр, дотоод энгэр, ханцуй, нударга гэсэн хэсгээс бүрдсэн эсгүүртэй.

б.Баруун монгол эмэгтэй дээл тэрлэг: Ханцуй, цээж, гадаад энгэр, хормой, нудрам гэсэн үндсэн эсгүүртэй.

в.Буриад эхнэр дээл: Цээж, хормой, ханцуйн уг, бүдүүн ханцуй, нударга, энгэр зэрэг үндсэн 8 эсгэвэртэй. Гэвч эдгээрийн хэмжээг авахад нэлээд анхаарах хэрэгтэй.

Эхнэр дээл, тэрлэгийн үндсэн хэмжээс

1. Урт /length/ - дээлийн ар голоос хормой хүртэл
2. Өргөн /Width/ - ар голоос ханцуйн үзүүр хүртэл гэж авдаг.

Дээрх хэмжээ нь үзмэрийн хэмжээсийг гаргаж тодорхойлолт бичихэд учир дутагдалтай. Иймд монголчуудын дээл, тэрлэг эсгэхдээ хэрэглэгддэг үндсэн хэмжээсүүдийг ашиглах нь зүйтэй. Дээлний бусад нэмэлт хэмжээсүүдийг зайлшгүй бичих шаардлага гардаг. Нэмэлт хэмжээс:



а. Захны урт
б. Цээжний өргөн
в. Суганы өргөн
г. Ханцуйн өргөн
д. Хормойн өргөн гэж авах ба эхнэр дээлэн дээр нэмж

- Түнтгэр мөрний өндөр
- Хормойн онооны өндөр
- Цэзгэр энгэрийн өндөр зэрэг орно.

Малгайн хэмжээс: Монголчууд цаг агаар, зэрэг дэв, эрхэлж байгаа албан тушаал, хүйс, угсаатны онцлог байдлаасаа хамаарч олон төрлийн малгай хийж өмсдөг байжээ. Гэвч эдгээр малгайнууд нь нийтлэг 5-8 талт эсгүүртэй пөмбөгөр болон шовх оройтой, хар хилэн хүрээтэй, улаан торгон залаатай, зарим нь 16-32 ширээстэй байдаг. Малгай үндсэн хэмжээсийг олон улсын жишигт

1. Өндөр /heigth/ - малгайн оройноос суурь хүртэл
2. Тойрог /diameter/ - толгойн оройд тавигдах суурийн голчоор хэмжинэ.

Нэмэлт хэмжээс:

- Хэвсэг /хүрээ/-ний өндөр
- Малгайн оройны өндөр
- Бүчний урт, өргөн
- Залааны урт, өргөн
- Тажид /чимэглэл/-ийн өндөр
- Жинс /сампин/-ний өндөр зэрэг.

Гутлын хэмжээс: Монголчууд олон янзын хэв маягтай гутал өмсөж байсан боловч эдгээр нь эсгүүр хийцийнхээ хувьд 3 янз байсан хэмээн үзэж болно.

1. Ойрад гутал буюу хөмөн гутал. Энэ гутал нь түрий зулаг үргэлж эсгэн ширээр уллана. Хөлийн шагай орчим гарах цүлхэнг хагалан дотроос нь танаж оёдог.
2. Зүүн монголчуудын гутал. Барга, үзэмчин, буриад нарын өмсөх мухар хоншоортой, хоншоор нь улнаасаа бага зэрэг илүү гарсан онцлог эсгүүртэй гутал.
3. Халх гутал. Олноор өнөө болтол өмсөх монгол гутлын загвар улам боловсронгүй болж түрий, зулаг, ул, зуузай, хавчаар гэсэн үндсэн эсгүүртэй болжээ. Гутлын хэмжээсийг олон улсад:

1. Өндөр /heigth/ - гутлын түрийнээс ул хүртэл
2. өргөн /width/ - хамрын ээтгэр үзүүрээс арын зуузай хүртэл гэж авдаг бол,

Нэмэлт хэмжээсэнд

- Түрийний өргөн
- Улны өргөн

Улны урт /хамрын ээтгэр улнаас өсгий хүртэл/ хэмжээг авдаг.

Үзмэрийн хийц загвар /стиль/-ыг тодорхойлох. Хийц загвар гэдэг ойлголт нь түүхэн тодорхой үед бүрэлдэж буй болсон дүрслэл, уран сайхны өвөрмөц, арга ажиллагаа, арга техникийн хам цогц юм Бид монгол дахь буддийн урлагийн тухайд Занабазарын хийц, мөнгөний дарханы урлалд Дарьгангын хийц, эсвэл дэлхийн хэмжээнд Готийн стиль, хийцийн уран барилга гэхчлэн ярьдаг. Хийц загвар нь нэг тодорхой үед буй болж, аажмаар шинэ, дараа үеийн загвар хийцээр солигдож байдаг түүхэн үйл явц, энэ утгаараа ч тодорхой түүхэн үеийн соёлын дурсгалуудын шинж, онцлогыг илэрхийлдэг ажээ. Загвар хийц нь тодорхой үндэстэн, угсаатны онцлогыг нэгэн адил илэрхийлнэ. Нөгөө талаар ард түмнүүдийн соёлын харилцаа, тэдгээрийн харилцан нөлөөллийн онцлогыг ч тусгана. Хийц загвар нь бүхэл үе, улс орон, бүс нутгийн хэмжээнд онцлог байдлаа хадгалахын зэрэгцээ тодорхой нэг бүтээлчийн уран бүтээлийн хувьд ч нэгэн адил юм.

Загвар хийц нь тухайн дурсгалын он цаг, хаана бүтээсэн, тэрчлэн хийж урласан эзнийг нь тодруулахад дөхөм үзүүлнэ. Загвар хийцийг тодорхойлохын тулд тухайн үзмэрийн хэлбэр төрх, уг дурсгалын хээ гоёл, зохиомж, уран сайхны шийдэл зэргийг нарийн нягталж судлах хэрэгтэй юм. Жишээ нь зүүн монгол, дарьганга эмээлийн мөнгөн чимэглэлийн хийц загвар ямар онцлогтой байсан бэ?, хэлбэр төрх нь ихэнхдээ дугариг, зуйван, эсвэл гурвалжин байсан эсэх, ямар аргаар голдуу урладаг байсан, гоёл чимэглэлийнхээ хувьд ямар төрлийн хээ угалзыг хэрхэн зохиомжилж урладаг байсан бэ зэрэг нь хийц загварыг тодруулах гол хэмжүүр болох талтай. Аливаа үзмэрийн загвар хийцийг тодорхойлоход холбогдох бичгийн болон судалгааны хэрэглэгдэхүүнтэй уйгагүй танилцах хэрэгтэй юм. Мөн тодорхой сэдэв, чиглэлээр судалгааг зохион явуулах нь илүү үр дүнтэй болно.

Үзмэрийн он цаг, хийсэн газар нутгийг тодорхойлох. Энд юуны өмнө тухайн дурсгалыг хийсэн арга техник, материалыг нарийвчлан судлах нь он цаг, хаана хийснийг тогтоох боломжуудын нэг болдог байна. Тодорхой арга техник чухам хэдий үед ямар бүс нутаг, ямар угсаатан ястанд нийтлэг байсан, хэдий үеэс өөр арга техник давамгайлах болсон зэргийг харгалзаж үзэх нь зүйтэй юм. Мөн тодорхой бүс нутагт дахь байгалийн өвөрмөц материалуудыг ашиглаж ирсэн түүхэн уламжлалыг харгалзаж үзэх нь үзмэрийн хийсэн газрыг тодорхойлж мэдэхэд арга зүйн хувьд чухал болдог байна. Цаашилбал тухайн дурсгалын үүрэг ач холбогдол, бүтэц зохион байгуулалтыг анхааралдаа авах нь чухал юм. Энгийн жишээн дээр ярихад сагсан тулга, шалдан тулганы хувьд үүрэг зориулалт нэг боловч өөр өөр бүс нутгийнхны хэрэглэдэг бүтэц хэлбэр төрхийн ялгаатай зүйл. Тиймээс хийж бүтээсэн нутаг газрыг энэ шинж байдлаар нь тоймлож мэдэж болох талтай.

Үзмэрийн угсаатны хамаарлыг тодорхойлох Энэ нь ялангуяа угсаатны зүйн музей, мөн бусад музейнуудын хувьд бас чухал юм. Угсаатны өвөрмөц онцлог нь аливаа дурсгалыг бүтээж хийсэн материал, зориулалт, хийсэн арга техник, хийц загварын шийдэл зэрэгт тусгалаа олж байдаг байна. Өөрөөр хэлбэл, угсаатны хамаарлын мэдээллийг аль нэг хэмжээгээр өөртөө агуулж байдаг зүй тогтолтой. Тухайлбал, хувцас, гоёл чимэглэл, гэр орон сууц, хоол унд зэрэгт хамаарах олон арван дурсгал нь тухайн угсаатны уламжлалт соёлын онцлогыг хадгалсаар явдаг байна. Бид аливаа үзмэрийн гарал хамаарлыг зөв тодорхойлоход юуны өмнө угсаатны зүйн баялаг мэдлэгтэй байх, холбогдох судалгааны ном бүтээлийг гүнзгий судалсан байвал зохих юм. Жишээ нь баруун монгол, хамниган, буриад нарын уламжлалт гутлын төрөл зүйлийг ялгаж тодорхойлоход ямар онцлог шинжүүдийг онцгойлж үзэх вэ гэдэг нь арга зүйн хувьд ихээхэн чухал юм. Бидний дээр дурьдсан хийц загвар, хийдэг арга техник зэрэг шинжээр нь нягтлах шаардлагатай.

Монголын үндэсний түүхийн музей
Ц. Аюуш.
Монголын үндэсний түүхийн музей
Ж.Туулцэцэг.
Соёлын өвийн төв
Д.Нарантуяа.

Энэхүү зөвлөмжийг боловсруулахад “Музееведение /Музеи исторического профиля/. М, 1988, Музееведение / Учебник для высшей школы/, М, 2003, Introduction to Object ID, Guidelines for Marking Records that Describe Art, Antiques, and Antiquities.1999. The Asian Art Museum of San Francisco, 1994, Seattle & London, Mongolia, The Legacy of Chinggis khan /Цомог/ зэрэг эх сурвалжуудыг ашиглав.

МАЯГТ № 2

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2006 оны 56 дугаар тушаалаар батлав.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМСангийн дугаар: 1125YTM00001

Зэрэглэл: **шийдвэр:**

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Монголын үндэсний түүхийн музей	**РД:** 9081569
Дурсгалын оршин байгаа хаяг: Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Худалдааны гудамж-1	

Дурсгалын нэр: Мөнгөн хэт хутга	
Орон нутаг, олон улс (шинжлэх ухаан) –ын нэр:	
Бүртгэлийн дугаар:	**Хувийн дугаар:** Ү84ц-2-37
Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл	
Ашиглалтын байдал: Музейн үнэт эдлэлийн сан хөмрөгт	
Төрөл зүйл: Дээл хувцас, гоёл чимэглэл	
Он цаг: XIX зуун - сүүлч үе	
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Тодорхойгүй	
Материал: Мөнгө, шүр, эвэр, паалан, төмөр, гууль, хаш, савхи, булигаар	

Хэмжээ	өндөр/~~урт~~	өргөн ~~(зузаан)~~	~~урт~~ зузаан	диаметр	жин
	20	10	32.5 см 5		1780 гр
	54	26			
	300	20			

Гэрэл зураг: 4 ширхэг зурагтай

		[Зураггүй]	
өмнө тал	ар тал	хажуу тал	бусад

Иж бүрдэл: Том, жижиг хутга -2 ширхэг. Төмөр, эвэр иш, мөнгө, Том хутганы урт-27 см. өргөн -2,7 см, Жижиг хутганы урт -21,7 см, өргөн-2,4 см
Савх -2 ширхэг, Гууль, мөнгө, Савхны урт-21,5 см, өргөн-0,5 см...

Үргэлжлэл хуудас-1

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1984 онд Ховд, Баян-Өлгий аймагт явуулсан үзмэр цуглуулгаар цуглуулсан.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: Үзмэр худалдан авах зөвлөлийн 1984 оны 2-р хурлын протоколыг үндэслэн музейд авч, ерөнхий бүртгэлд бүртгэжээ.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлагдаж байгаагүй.	**Хуулбар хийгдсэн байдал:** Хуулбар хийгдэж байгаагүй.
СЗБ №	

Тодорхойлолт: Том, жижиг хутга нь эвэр иштэй, тольтондоо цэцгэн хээтэй мөнгөн дугтуй чимэгтэй. Том хутганы төмөр ир эдэлгээний явцад нэлээн мөлийн элэгдсэн. Хутганы хуй нь хар савхин бүрээстэй, дээд, доод амсарт ямар нэгэн хээ чимэглэлгүй цулгуй мөнгөн дугтуйтай. 6 ширхэг мөнгөн бүстэй. Гинж оосорлох мөнгөн гархи бүхий мөнгөн дэл чимэгтэй.
Хос гуулин савхны хойд үзүүрт 2,5 см өргөн мөнгөн бөгжилгөөтэй.
Хэтний төмөр цахиурын 2 талыг бага зэрэг ухаж цэнхэр, ногоон өнгө хосолсон паалан чимэг хадсан. Дөрвөн булан нь хос гөрөөс болон хос лууны хөөмөл мөнгөн чимэгтэй. Нурууны голд сэнжний 2 талаар өөд өөдөөсөө харсан хос лууны мөнгөн чимэгтэй. Хэтний 2 талын нүүрэнд зээбадын толгойн хөөмөл мөнгөн жижиг чимэгтэй. Хэтний гадна хүрээг мөнгөөр хүрээлж хээлсэн.
Хавтгай дугуй хэлбэртэй, цайвар ногоовтор өнгийн хаш чулуун тээгний голд нүхлэн мөнгөөр тавлан сэнж хийжээ. Хаш тээг нь хэттэйгээ 5,5 см урт мөнгөн гинжээр холбоотой.
Мөнгөн хос бэл нь хагас дугариг эвэр угалз хэлбэртэй ба хоорондоо мөнгөн нугасаар холбоотой бэлний дөрвөлжин хэлбэрийн тархи буюу толгой нь голдоо шүрэн шигтгээтэй, гадна талаараа цохимол хээтэй. Бэл нь хүрэн булигаар оосортой. Хос булигаар оосор нь 12,9x4,3 см болон 11,3x4 см хэмжээтэй. Хос бэл нь хутганы хуй болон хэттэйгээ мөнгөн гинжээр холбогдсон. Хуй болон бэлийг холбосон мөнгөн гинжний урт-14 см. Хэт болон бэлийг холбосон мөнгөн гинжний урт 19,5 см.

Гэмтэл өө сэв: Хадгалалтын байдал "дунд" зэрэг.
Хэтний нүүрний чимэг нь 3 хугарсан. Нэг талынх хаягдсан. Нөгөөг нь утсаар даруулсан. Арын чимэг нь сууринаасаа ханзарсан. Хэтний арын өрөөсөн булангийн мөнгөн чимэг хаягдсан.
Хуйны савхин бүрээс 2 газар ховхорч урагдсан. Хуйны аман талын мөнгөн дугтуй холхиж суларсан.
Жижиг хутга ишнээсээ салсан. Том, жижиг хутганы эвэр иш зарим хэсэгтээ эмтэрсэн. Хутга, бэлний гинж 2 газар тасарсан. Хэтийг бэлтэй холбох гинжний мөнгөн цагираг хаягдсан.

Зориулалт: Монгол эрчүүдийн өдөр тутмын ахуйдаа хэрэглэх, хутга, хоолны савх, гал асаах хэт зэрэг нэгэн иж бүрэн, үнэт металлаар чимэглэн урласан хэрэглээний эд зүйл.

Ховор, түгээмэл байдал: Элбэг байдаг.

Товч түүх: Ховд аймгийн Булган сумын иргэн Дамирангийн эцэг нь хэрэглэж байгаад өөрийн хүүдээ өвлүүлэн үлдээсэн байна. Дамиран нь өөрийн эцгээс уламжлагдан ирсэн энэхүү хэт хутгаа 1984 онд музейд худалджээ.

Гарал үүсэл: Баруун монгол (Торгууд)

Шилжилт хөдөлгөөн: 1988 онд Улаанбаатар хотод зохиогдсон "Ардын урлаг" үзэсгэлэнд тавигдаж байсан.

Судлагдсан байдал: "Ардын урлаг" үзэсгэлэнгийн танилцуулга , УБ хот. 1988 он

Хавсралт материалын тэмдэглэл: Өнгөт гэрэл зураг 1 хуудас, "Иж бүрдэл"-ийн үргэлжлэл 1 хуудас

Эзэмшигч /өмчлөгч/-д хадгалагдаж байгаа

Негатив № 01-25 слайд № 0 CD № 07-02 дүрс бичлэгийн хуурцаг № 0

УНБМСанд хадгалагдаж байгаа

Негатив № ______ слайд № ______ CD № ______ дүрс бичлэгийн хуурцаг № ______

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: Ц.Аюуш, Эрдэм шинжилгээний ажилтан 2007 он 6 сар 7 өдөр

УНБМСанд хүлээн авсан: ______ ...... он ...... сар ...... өдөр

Хэмжилтийн зураг



Иж бүрдэл:
Дурсгалын нэр: Мөнгөн хэт хутга
УНБМСангийн дугаар: 1125YTM00001
Хувийн дугаар: Y84ц-2-37

Хутганы хуй -1 ширхэг, Мод, савхи, мөнгө. Хуйны хэмжээ 22,3х4,5 см
Хэт -1 ширхэг. Төмөр, мөнгө, паалан чимэг, савхи, Хэтний хэмжээ 15,2х7,5х1,2 см
Тээг - 1 ширхэг, Хаш чулуу, мөнгө, Хаш чулууны голч -5,3 см
Бэл -2 ширхэг, Мөнгө, шүр, булигаар, Бэлний хэмжээ 8х.5,4 см
Мөнгөн гинж -3 ширхэг
Том, жижиг мөнгөн цагираг- 6 ширхэг

Мөнгөн хэт хутга. БД: Ү84ц-2-37.
Монголын Үндэсний Түүхийн Музей

ЧУЛУУ, ЧУЛУУН ӨВ СОЁЛ

Монгол орны соёлын үл хөдлөх хийгээд хөдлөх өвийн үлэмж хэсэг чулуун дурсгал, уран барилга, угсаатны холбогдолтой эд өлөг, багаж зэвсэг, эдлэл хэрэгсэл, онго шүтээн, зүүлт чимэглэлийн зэрэг зүйлст холбогддог. Тэгвэл чулуу гэж юу вэ?

Чулуу буюу чулуулгийн талаархи мэдлэгтэй байхын өмнө түүнийг бүрдүүлэгч эрдсийн тухай ойлголттой байх хэрэгтэй. Тэгвэл эрдэс гэж юу вэ? Өнө урт удаан түүхэн хугацаанд үүсч бий болж тогтсон, байгалийн хад чулуу буюу чулуулгийг бүрдүүлэгч найрлага бүтцийн хувьд жигд талст байгуулалттай тогтцыг эрдэс гэнэ. Нэг юмуу хэд хэдэн эрдэс нийлж чулуулаг, хүдэр, ашигт малтмалыг бүрдүүлдэг. Эрдсийн наад захын жишээ гэхэд бидний хамгийн сайн мэдэх харандаа адил зургаан талт, гурамсан өнцөгт тогтолцоот болор болой. Байгальд ус адил тунгалагаар оршдгийг нь усан болор, бараавтар туяатайг нь утаат болор, тас харыг нь морион буюу хар болор, ягааныг аметист гэгчлэн нэрлэнэ. Эдгээр нь найрлага дахь химийн өчүүхэн хольцоос болж тийм янз бүрийн өнгө үүсгэх боловч цөм ижил талст үүсгэж, үндсэн найрлага нь цахиур хэмээх мах бодиос тогтсон байдаг.

Эрдэс тус бүр өөрийн тодорхой хэлбэр бусад өвөрмөц онцлогуудтай. Бид болорын хэлбэр төрхийг дээр ярьсан. Өөр жишээ гэвэл хоолны давс, дүши чулуу мэт нь шоо дөрвөлжин тогтолцоотой байх жишээтэй. /Зураг 1, 2, 3/ Эрдсүүд нь хэлбэрээс гадна өнгө, гялбаа, хатуулаг, цуурал, зураасны өнгө, соронзон чанар, талстын дээрх зураасын зэрэг олон шинжүүдээрээ ялгаатай. Эрдсийг хатуулгаар нь "Моосын" гэгдэх 10 шаталбарт хуваадаг. Моос гэж эрдсийн хатуулгийг ийнхүү 10 бүлэг болгосон Германы эрдэмтний нэр болно. Моосын тэрхүү шаталбарыг жагсаан танилцуулбал:

1. Тэнэгэр (тальк)
2. Гөлтгөнө
3. Кальцит (шохойн жонш)
4. Хайлуур жонш
5. Апатит (сүүмэгжин)
6. Хээрийн жонш
7. Болор
8. Молор
9. Корунд (бадмаараг)
10. Алмаас

Эдгээрээс бие биен дээр нь зурж үзэхэд зураас гаргаж байвал зөөлөн, зураас гаргахгүй байвал хатуу гэнэ. Бас ердийн нөхцөлд:

- зөөлөн балтай харандаа 1,
- хумс 2,5
- хөнгөн цагаан 3
- шил 5
- ган (хутга) 5,5-6
- болор 7… гэх мэт тодорхойлж болдог байна.

Үүний ялдамд манай ард түмний хэрэглэж ирсэн уламжлалт аргууд ч бий. Жишээ нь баритийг хүнд жинтэй учир хүнд жонш гэж нэрлэж ирсэн. Имэрч таньдаг байв, Жишээ нь тосон хужир байна. Хазаж таньдаг байв. Жишээ нь цайр хазахад чахарч дуу гардаг, шөрмөсөн чулуу шөрмөс хазсан мэт санагдуулна. Амталж мэддэг, жишээ нь зарим байвангуудыг хэлж болно. Үнэрлэж мэднэ. Жишээ нь хүхрийг шатааж үнэрлэж таньдаг. Тэр ч бүү хэл чагнаж таних арга ч байдаг. Жишээ нь мөнгөний цэвэр цэвэр бусыг үлээж чихэндээ барьж чагнаж таньдаг.

Энэчилэн эрдсүүдийн шинж чанар, тодорхойлох аргуудын талаар олныг өгүүлж болох боловч үүгээр хязгаарлая.

Орон нутгийн музейн үзмэрт бидний дээр ярьсан усан болор, утаат болороос өгсүүлээд хайлуур жонш, гөлтгөнө, анар гэх мэтчилэн эрдсүүд зүйл зүйлээр тавигддаг учраас эрдсийн гүнзгий ойлголтой байх шаардлага музейн ажилтнуудад зүй ёсоор тавигддаг билээ.

Одоо чулуу буюу чулуулгийн талаархи ойлголтод шилжье. Байгаль дахь эрдсүүдийн нэгдлийг чулуу буюу чулуулаг гэж бүдүүн тоймоор хэлж болох юм. Жишээ нь бидний сайн мэдэх боржин чулуу байна. Боржин чулуу бол үндсэндээ болор, хээрийн жонш, гялтгануураас бүрддэг. Чулуулгийг гарал үүслээр нь маагмын чулуулаг, тунамал чулуулаг, хувирмал чулуулаг гэж ерөнхийд нь гурав ангилдаг.

Гүний халуун хайлмаг маагм дэлхийн гүнд болон гадрага дээр ил гарч талсжих явцад үүссэн чулуулгийг маагмын чулуулаг гэдэг. Наад захын жишээ нь боржин болон хүрмэн чулуу. Найрлага дахь цахиурын ислэлийн агуулгаар нь маагмын чулуулгийг хэт суурьлаг, суурьлаг, дундлаг, хүчиллэг, шүлтлэг гэхчлэн ангилдаг.

Тунамал чулуулаг гэж хөдөлгөөнт уусмал орчинд үүсч тогтсон чулуулгийг хэлнэ. Голдуу хэмхдэс үйрмэг, элс, шавранцраас бүрддэг. Тунамал чулуулгийг 1) хэмхдэст чулуулаг, 2) хемоген буюу химийн, 3) органоген чулуулаг гэж ангилдаг. Хэмхдэст чулуулгийн жишээ нь бул чулуу, үхэр чулуу, хайрга, элс, шаварлаг чулуу, занар чулуу гэх мэт болно. Химийн чулуулагт зарим шохойн чулуу, чулуун давс, доломит зэргийг нэрлэж болно. Органоген чулуулагт ургамал, амьд амьтнаас үүссэн чулуулаг багтана. Жишээ нь шохойн чулуу, чулуун нүүрс, занар гэх мэт.

Музейн үзмэрт тодорхой байр эзэлдэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал хөшөө чулуу, хүн чулуу, буган чулуу, эртний хот балгадын туурийн чулуун довжоо, багана, чулуун яст мэлхий, чулуун арслан барс тэргүүтэн цөм энд яригдсан гурван төрлийн гарал үүслийн чулуулгийн аль нэгээр цогцлогдон бүтээгдсэн байдаг билээ.

Чулуужмагийн талаар энд ярилгүй өнгөрч боломгүй. Эрт галавын ургамал, амьтны чулуужсан үлдэгдлийг чулуужмал гэдэг. Чулуужмагаар хурдас чулуулгийн насыг тогтоодог. Чулуужмагийн наад захын жишээ нь цэрдийн галавын чулуужсан мод, 200 сая жилийн өмнөх Мезозойн үеийн мөлхөгч амьтан динозаврын чулуужсан яс, өндөг зэрэг болно. /Зураг 4, 5/

Музейн үзмэрт үнэт эрдэнийн чулуун эд өлөг, гоёл чимэглэлийн зүйл ихээхэн тавигддаг. Өвөрмөц, гоц гойд өнгийн, голдуу талст байдлаар тохиолддог, гоёл чимэгт зориулагдсан эрдэс чулуулгийг үнэт эрдэнийн чулуу гэдэг. Эрдэнийн чулуу нь ховор олддог, өндөр үнэтэйгээрээ онцлог. Дотор нь үнэт эрдэнийн, хагас үнэт эрдэнийн, өнгөт буюу өнгөлгөөний чулуу гэж ангилна.

Ангилал	Зэрэглэл	Чулууны нэр
Үнэт эрдэнийн	1	Бадмаараг, маргад, алмааз, хөх индранил
	2	Александрит (хувилгаан чулуу), ягаан, хөх, ногоон индранил, хар опал (ууpаг чулуу), эрдэнийн бөөр хаш, буюу жадейт
	3	Гэрэлт эрдэнэ (шпинель), демантоид, эрдэнийн болон галт опал, усан биндэръяа, молор эрдэнэ, улаан анар (родолит), саран чулуу, улаан халтмар
	4	Хөх, ногоон, ягаан олон өнгөт халтмар, кунцит, хатаан (циркон), шар, ногоон, алтлаг, ягаан биндэръяа, оюу, адур чулуу (хризолит), ягаан болор (ягар), ногоон мана, ринчинням анар (пироп), ягаан анар (альмандин), шар болор
Өнгөт эрдэнийн	1	Утаат болор, часалжин буюу улаан гүр, хув, усан болор, хаш, номин, ногоолин, ундрам
	2	Өнгийн мана, гартаам, чүнчигноров, сувдан упаалаа буюу чингирчимид (кахолонг), амозон чулуу (амозонит), шижил чулуу (родонит), нов мана буюу улаан толбот ногоон мана (гелиотроп), ягаан болор, солонгот гашил, (галт уулын шил) (обсидиан), уураг чулуу (опал), аливуу чулуу (лабрадор), беломорит (нэгэн зүйл саран чулуу), тунгалаг болон олон өнгийн туяа солонгот жонш
Өнгөт чулуу	1	Хас, бичигт боржин, чулуужсан мод, гантигжсан гартаам, мана, шугас чулуу буюу лиственит, галт уулын шил, лүнтэн, хайлуур жонш, толигор, цахиур, өнгийн гантиг

Ангилал Зэрэглэл Чулууны нэр

Үнэт эрдэнийн 1 Бадмаараг, маргад, алмааз, хөх индранил

2 Александрит (хувилгаан чулуу), ягаан, хөх, ногоон индранил, хар опал (уураг чулуу), эрдэнийн бөөр хаш, буюу жадейт

3 Гэрэлт эрдэнэ (шпинель), демантоид, эрдэнийн болон галт опал, усан биндэръяа, молор эрдэнэ, улаан анар (родолит), саран чулуу, улаан халтмар

4 Хөх, ногоон, ягаан олон өнгөт халтмар, кунцит, хатаан (циркон), шар, ногоон, алтлаг, ягаан биндэръяа, оюу, адур чулуу (хризолит), ягаан болор (ягар), ногоон мана, ринчинням анар (пироп), ягаан анар (альмандин), шар болор

Өнгөт эрдэнийн 1 Утаат болор, часалжин буюу улаан гүр, хув, усан болор, хаш, номин, ногоолин, ундрам

2 Өнгийн мана, гартаам, чүнчигноров, сувдан упаалаа буюу чингирчимид (кахолонг), амозон чулуу (амозонит), шижил чулуу (родонит), нов мана буюу улаан толбот ногоон мана (гелиотроп), ягаан болор, солонгот гашил, (галт уулын шил) (обсидиан), уураг чулуу (опал), аливуу чулуу (лабрадор), беломорит (нэгэн зүйл саран чулуу), тунгалаг болон олон өнгийн туяа солонгот жонш

Өнгөт чулуу 1 Хас, бичигт боржин, чулуужсан мод, гантигжсан гартаам, мана, шугас чулуу буюу лиственит, галт уулын шил, лүнтэн, хайлуур жонш, толигор, цахиур, өнгийн гантиг

Манай ард түмэн олон янзын эрдэс чулуулаг түүний дотор үнэт, өнгөт эрдэнийн чулууг өргөн хэрэглэж ирсэн өнө эртний уламжлалтай. Эртний чулуун зэвсгийн олдворуудыг ажиглахад мана, гартаам, чүнчигноров, уураг чулуу, хасаар хийгдсэн зэвсгийн зүйл цөөнгүй тохиолддог. Монголчууд Хүннүгийн үеэс эхлээд эзэн Чингэсийн үеийг дамжин Богд хааны үе хүртэл төрийн тамгаа хашаар үйлдэж иржээ. Манай улсын банкны үнэт эрдэнийн зүйлийн цуглуулга, Үндэсний түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Богд хааны музей, Чойжин ламын музей болон аймаг орон нутгийн музейд үнэт, өнгөт, эрдэнийн чулуун ховор нандин үзмэрүүд их байдаг.

Эдгээрийн дотор янз бүрийн үнэт чулуун хөөрөг тодорхой байр эзэлнэ. Тэр бүхний дунд хаш, пийсүү, мана, гартаамаас гадна ундрам, чүнчигноров, лүнтэн, цагаан шүр, сүйжин гэхчилэнгийн содон сонин нэртэй чулуун хөөргүүд цөөнгүй. Үүнтэй холбогдуулж чулууны нэр түүний дотор үнэт эрдэнийн чулууны уламжлалт нэр, тэдгээрийн онцлог шинжүүдийн талаар музейн ажилтан бүрд тодорхой мэдлэгтэй байх шаардлага тавигддаг.

1. Дорнын буюу Монгол, Хятад, Төвд, Энэтхэгийн соёлын эртний харилцаагаар уламжлагдсан нэр гэж байна. Чүнчигноров гэж төвд үг бөгөөд монголоор гарьдын бөөлжис гэдэг. Гартаам гэж гартамэ гэсэн төвд үг, оюу мана ч ялгаагүй төвд үг, бадмаараг гэж санскрит үг, маргад мөн адил, сүйжин гэж хятад нэр байх жишээтэй.
2. Өнгө тогтцоор нь эрдэс чулууг нэрлэж ирсэн уламжлал их бий. Жишээ нь чүнчигноров буюу гарьдын бөөлжис, тархи мана, халтар мана гэх мэт
3. Арилжааны нэр гэж байна. Жишээ нь цагаан шүр, үзмэн мана
4. Орон нутгийн нэр. Жишээ нь эрднийн долгор буюу толигор
5. Орчин үед үнэт, эрднийн чулууг хиймлээр гаргах болсонтой холбогдуулаад монголчууд чулууны нэрний өмнө “таримал” гэдэг тодотгол хэрэглэх нь бий.
6. Эрдэс чулуунд бас шинжлэх ухааны болон олдсон газры нь нэр ихээхэн хэрэглэгддэг. Жишээ нь Монголит, Онгонит, Армастронгит, Баянханит, Чароит гэх мэт.

Тодруулга:

1. Алмас эрдэнэ. Усан болороос 1000 дахин хатуу. Засмалыг нь нийтээр брилиант гэдэг. Манай музейн үзмэр дэх энэ эрднийн чулуун зарим зүйлийн жишээ гэвэл: мөнгөн хуудсан дээр алтаар цутгаж урласан “Сундуйн жүд” (222 хуудас) судрын бурхны хөрөгт очир алмаас шигтэн урласан байдаг. Архангай аймгийн Тариат сум болон бусад нутгаас алмаас эрднийн илрэл олдсон. /Зураг 6/
2. Бадмаараг. Нийтээр рубин гэдэг. Бадмаараг шигтгээт үзмэр Богд хааны музейд бий. Баруун монголоос бадмаараг эрднийн илэрц олдсон. /Зураг 7/
3. Индранил. Богд хааны эрднэсийн санд энэ эрднийн шигтгээт гоёл чимэглэлийн зүйлүүд үзсэнээ Оссендовский мэдээлсэн байдаг. Монголд хэд хэдэн газраас илрэл нь олдсон.
4. Анар. (хүрэн анар) Ерөнхийлөгчийн ёслолын малгай, бүс ийм эрднийн шигтгээтэй. Анараар хийсэн хөөрөг тааралддаг. Монголд Шаврын царамд бий. Монгол оронд хүрэн анар (пирот)-аас гадна хар, ягаан, ногоон гэх мэт олон төрлийн анар бий. /Зураг 8/
5. Биндэръяа. Ногоон биндэръяа монголд цөөнгүй газар бий. Усан биндэръяа буюу аквамарины сайхан талст Политехникийн их сургуулийн эрдэс баялагийн музей, хувь хүний цуглуулгад ч нэлээд бий. /Зураг 9/
6. Молор эрдэнэ. Байгалийн түүхийн музей, Политехникийн их сургуулийн эрдэс баялагийн музей, хувь хүний цуглуулгад энэ эрдсийн сонирхолтой талстууд хадгалагддаг. Морин толгойн чинээ молор эрднийн тухай монгол ардын үлгэр домогт олонтаа өгүүлэгддэг билээ. /Зураг 10/
7. Ягаан болор. (аметист) Төв орон нутгийн хэд хэдэн музейд энэ эрдсийн дээжүүд бий. Голдуу зүүлт шигтээнд хэрэглэж иржээ. /Зураг 11/
8. Хаш. Боржингоос 9 дахин илүү даралт тэсвэрлэдэг. Бат бэх энэ чулуугаар хийсэн эд өлгийн зүйл төв орон нутгийн музейд ихээр тавигдсан байдаг. Тэдгээрийн дотроос Богд хааны музейн хаш тамга, хаш хул, хаш хөөрөг, хаш сийлбэр зэрэг гойд үзмэрүүдийг онцлъё. Үүний сацуу андуурч ташаарсан хаш үзмэр ч хаа нэг тааралддагт сайн нягтлал хийгүүштэй.
9. Хас. Цахиуржсан тунамал чулуулаг. Ялангуяа төрөл бүрийн хасаар хийгдсэн чулуун зэвсгийн олдвор музейнүүдэд элбэг байдгийн дотор задын чулуу гэгддэг шовх үлдцийг онцолъё. /Зураг 12/
10. Мана. Монголчууд 30 гаруй төрлийн маныг нэрлэж чаддаг. Халтар мана, сүй мана, замагт мана гэхчлэнгийн үнэ цэнэтэй, сонин тогтоцтой манан хөөргүүдийг музейн үзмэрүүдээс олныг үзэж болно. /Зураг 13/
11. Гартаам Чигжүү судалтай мана. Музейн үзмэрт манан хөөргийн зэрэгцээ гартааман хөөрөг цөөнгүй тавигдсан байдаг. /Зураг 13/
12. Ундрам. Хайрслаг гялтгануур, төмрийн элдэв эрдэс зэргийг агуулсан цахиурлаг чулуулаг. Найрлагад нь шил оруулж, зэс хийгээд төмөр хромын исэл хольсон “дууриамал” ундраман эдлэл ч байдаг. /Зураг 14 г/

13. Лүнтэн. Цэрдийн галавын нүүрсэнд тохиолддог модожсон нүүрс. Шатдаг. Тас хар өнгөтэй. Харах нүднийн нь хар цагаан

Хаш чулуунд шигтгэсэн лүнтэн мэт…. гэж энэ эрднийн гойд онцлог хар өнгийн талаар Д.Нацагдорж шүлэглэсэн байдаг. Урлагийн олон гайхамшигт бүтээлд лүнтэнг ашиглаж, бас эрхи хийж байжээ. Дүрслэх урлагийн музейн нэгэн арслангийн нүдийг лүнтэнгээр хийсэн буй. /Зураг 14 а/

14. Чүнчигноров. Цахиурын төрлийн өвөрмөц тогтоцот чулуулаг. Өнөө хэр орос, англи нэргүй. Чүнчигноров хөөрөг музейн үзмэрт цөөнгүй таардаг. /Зураг 15/

15. Богхед. (Зүүрс) Замгийн нүүрс. Шатдаг. Хүннү булшнаас зүүрсэн олдвор цөөнгүй олдсон нь Үндэсний түүхийн музей, Археологийн музейд хадгалагдаж буй

16. Толигор (серпентин). Ногоовтор голдуу өнгөтэй, нягт, зөөлөн (хатуулаг нь 2.4-4) энэ чулуулгийг манай ард түмэн эрт дээр үеэс элдэв хэв цутгуурын ажил болон жижиг баримал, сийлбэрийн урлалд өргөн ашиглаж ирсэн. Өмнөговь аймгийн Говь Гурвансайхан уулын толигорыг нутгийхан эрднийн долгор чулуу ч гэж нэрлэх нь бий. /Зураг 16/

Эцэст нь түүх, соёлын үл хөдлөх өв-хөшөө дурсгал, хүн чулуу, буган чулуу, хөшөө чулуу, эртний уран барилгын олдворын гол хэрэглэгдэхүүн болж байсан зарим чулуулгийн зүйлээс тоймчлон тодотгоё. Дээрх дурсгалуудыг голдуу тухайн орон нутгийн боржин, гантиг, шохойн чулуу, бөсөл, асмалжин, хүрмэн чулуу, занар, элсэн чулуугаар үйлдсэн байдаг.

1. Боржин. Голдуу ягаандуу, ягаавтар саарал, цайвар саарал, заримдаа бараавтар өнгөтэй хөшөө дурсгалд тааралдана. Жижиг дунд, том мөхлөг (ширхэг)-тэй гэж ялгана. Голдуу Түрэг, Уйгарын үеийн хөшөө дурсгал, тэрчилэн эртний уран барилгын үлдэгдэл, гэрэлт хөшөөдийг боржингоор үйлдсэн байдаг. Басхүү эртний газар тариаланд хэрэглэж байсан уур, нүдүүр, тээрмийн боржин чулуун дурсгалууд олддогийг төв орон нутгийн музейнүүдээс үзэж болно.

2. Хүрмэн чулуу (Базальт) Хар өнгөтэй, нягт, шигтгээлэг бүтэцтэй маагмын чулуулаг. Голдуу Түрэгийн үеийн хүн чулуу, эртний шинэ чулуун зэвсгийн үеийн газар тариалангийн хэрэгсэл энэхүү чулуугаар хийгдсэн байх нь бий. Баян-Өлгий аймгийн Шивэрт уул, Чойбалсан хотын орчим, Халхгол, Дундговийн Цагаан Олом, Дорноговийн Цахиурт зэрэг газраас хүрмэн чулуун хянгар, хусуур, чоппер, чоппинг зэвсэг цөөнгүй олдсон.

3. Бөсөл чулуу. (Туф) Цайвар шаргалдуу сүвэрхэг чулуулаг. Галт уулсын халуун уусмалаас үүсэлтэй. Эртний галт уулын үлдэгдэлт Дарьгангын Монголын үеийн зарим хүн чулууг ийм чулуугаар урласан байхаас гадна Дорнод аймгийн олон газрын шинэ чулуун зэвсгийн олдворуудын дотор цахиурлаг бөсөл чулуун цавчуур, хусуур, хянгар зэвүүд олддог.

4. Асмалжин. (Диорит) Сааралдуу өнгөтэй маагмын чулуулаг. Цул нягт чулуу юм. Өмнөговь аймгийн нутаг Оюу толгойгоос зэс чулууны үед холбогдох цутгуурын асмалжин шанага олдсон.

5. Гантиг. Шохойнцор, доломит зэрэг шохойлог чулуулаг дахин талсжихад үүссэн, ихэвчлэн кальцигаас бүрддэг зөөлөн чулуулаг. Янз бүрийн өнгө судалтай тохиолддог бөгөөд Үндэсний түүхийн музейд тавигдаад байгаа Дорнод аймгийн Халхгол сумын Шонх таван толгойн хүн чулуу, Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн хүн чулуу зэрэг дурсгалууд цагаан болон хөх судалт гантигаар урлагдсан.

6. Шохойн чулуу. Ихэнх хэсэг нь кальци, доломит, элслэг шаварлагаас бүрдсэн тунамал чулуулаг. Цайвар голдуу өнгөтэй. Завхан аймгийн Яруугийн голын хүн чулууд зэрэг шохойн чулуун дурсгал манай оронд цөөнгүй.

7. Элсэн чулуу. Барьцалдан нягтарч хатуурсан элснээс тогтсон тунамал чулуулаг. Хэврэг. Булган аймгийн Ингэт толгойн Киданы үеийн хүн чулуу мэтийн элсэн чулуун дурсгал энд тэнд тохиолддог. Элсэн чулуу нэн өгөршимтгий, хэврэг учраас зарим нь хүн чулуу гэж хэлэхэд хэцүүхэн болтлоо элэгдсэн нь ч бий. Өвөрхангай аймгийн Бүрд болон Баруунбаян-Улаан сумын Таримлын өвөлжөөний хүн чулууг ийм жишээнд оруулж болно. Нягт ширхэгт элсэн чулуун гампанз, ганжин, голдоо нүхтэй эдлэл зэрэг шинэ чулуун зэвсгийн дурсгал Дорнод, Баянхонгор, Өмнөговь, Сүхбаатар болон Улаанбаатар хотын музейнүүдэд цөөнгүй бий.

8. Занар чулуу. Нимгэн ялтас болон салдаг шинж чанар бүхий тунамал чулуулаг. Зарим хөшөө, буган чулуу, ялангуяа эртний барилга байгууламтад занар чулуу өргөн хэрэглэгддэг байсан тал ажиглагддаг. Зарим аймаг орон нутгийн музейд занарлаг чулуун зээтүү, бусад эдлэлүүд тавигдсан байдаг. Мөн занарлаг чулуун хөшөө дурсгал ч цөөн бус таарлдана. Алдарт Ямаан усны хадны зураг, Дэл уулын хадны зураг зэрэг эртний хадны зураг дурсгалууд занар чулуун дээр сийлэгдэж зурагдсан байдаг билээ.

Уламжлалт чулуун цоолбор, сийлбэр бүтээлүүдийг:

1. Гурван орон зайд дүрсэлсэн ээлхүүнт цоолбор (Түрэг, Уйгар, Киданы үеийн зарим хүн чулууд, монголын үеийн хүн чулууд гэх мэт)
2. Хүрээлбэр цоолбор (Хадны зураг, зарим буган болон хүн чулуунд ажиглагдана)
3. Товгор сийлбэр (Буган чулуу, сүм дуганы чуулбарт харагдана)
4. Хавтгай сийлбэр (Дэвсгэр, дүрс хоёрыг нэг түвшинд дүрсэлсэн бүтээлүүд орно)
5. Хотгор сийлбэр гэж ангилж болно. Дорнод аймгийн Норовлин уулын неолитын булшнаасгарсан чулуун онгоноос аваад Дүрслэх урлагийн музей болон Ховд аймгийн музейн хуцын толгойн дүрст чулуун эдлэл ардын урлалын элдэв мал амьтны дүрс, шатар, гоёл чимэглэл, ахуйн хэрэглэл, хөөрөг, соруулын зэрэг овор бага ч гэлээ түүх, соёлын дурсгалт ховор нандин чулуун урлалын бүтээлүүдээрээ манай музейн үзмэрийн танхимууд үнэхээр нүд баясган, сэтгэл бадраадаг билээ.

Химич, эрдэс судлаач, сэтгүүлч проф
Г.Гонгоржав

Холбогдох ном бүтээл

1. Gemstones. BY. G.F. Herbert SMITH. London., 1972
2. А.Г.Бетехтин. Курс минерологии. Москва., 1963
3. Ричард.С.Митчелл. Названия минералов. 1982
4. Геология Монгольской Народной Республики. УБ., I-II
5. Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал. УБ., 1999
6. Г.Гонгоржав. Монголчуудын чулуун өв соёл. УБ., 2006



1. Усан болорын талст

2. Утаат болорын талст

3. Шоо чулуу

4. Эртний дун хэлбэртний чулуужмал

5. "Лууны соёо" чулуужмал



6. Очир алмаазын талст

7. Бадмааргийн талст

8. Анарын талстууд

9. Усан биндэръягийн талст

10. Молорын талст

11. Ягаан болорын талстууд

12. Чулуун зэвсгийн үеийн хас хутга

13. а.Лүнтэн, б.сувд, в.оюу, г.ундрам

14. Гартаам, мана гартааман хөөрөг



15. Чинчигноров хөөрөг

16. Хүрэл хутганы чулуун хэв

ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОР ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ҮНДЭСЛЭЛ

1. Палеонтологийн олдворын тухай ерөнхий ойлголт

Палеонтологи (Эртний шим судлал буюу эртний амьтан ургамал судлал)-ийн олдвор, цуглуулга гэдэгт дэлхийн шим ертөнцийн түүхийн олон эрин галавын туршид үүсэн хөгжиж, удамшин хувьсаж, мөхөж сөнөж байсан амьтан болоод ургамлын чулуужсан үлдэгдэл, түүнтэй холбоотой бусад зүйлс багтана. Эртний амьтан ургамлын судалгаа бодит баримт буюу тэдгээрийн чулуужиж хадгалагдсан олдвор цуглуулгад үндэслэн хийгддэг нь ойлгомжтой. Хэдийгээр эртний шим судлал өнгөрсөн зууны туршид маш эрчимтэй хөгжсөөр ирсэн боловч бидний амьдарч буй эх дэлхийн түүх, түүн дээрх амьд организмын хувьсал хөгжлийн талаар таньж мэдэгдээгүй, учир нь олдоогүй өдий төдий нууц байсаар байна.

Шим ертөнцийн түүхийн туршид үүсэн хөгжиж, удамшин хувьсаж, мөхөж сөнөж байсан амьтан, ургамлын тун багахан хэсэг нь үлдэж хоцорсныг нь нээн олж, эх дэлхийнхээ түүх, түүний нууцыг тайлах, танин мэдэхийн тулд бодит баримт болгон тив тивийн эрдэмтэн судлаачид махран оролдсоор байдаг билээ. Харамсалтай нь ийм олдвор манай дэлхий дээр тэр бүр элбэг тохиолддоггүй, шим ертөнцийн түүхийн хэлхээ нь байнга тасалдалтай байдаг нь энэ ажлыг үргэлж хүндрүүлж байдаг бөгөөд эртний амьтан ургамлын зарим олдворын өчүүхэн хэсэг нь ч судлаачдад чухал байдаг. Гэхдээ тэдгээрийг илэрсэн газарт нь судалгаа явуулж, гарал үүслийн холбогдох мэдээллийг баримтжуулж авснаар ач холбогдол нь өсөх болохоос хэн хэзээ хаанаас олж, хэрхэн яаж малтлагын ажлыг явуулсан нь тодорхойгүй, хууль бус аргаар цуглуулсан зүйлсийг олдвор гэж тооцох боломжгүй байдаг.

Эртний амьтан ургамлын олдвор нь өөр хоорондоо шүтэлцээтэй маш нарийн тохироонууд бүрдснээр бий болдог. Тухайлбал:

- тухайн газар нутагт балар эрт цагт тухайн амьтан ургамал өргөн тархан амьдрах нэн таатай нөхцөл нь бүрдсэн байх,
- мөхөж сөнөсөн амьтдад хадгалагдах орчны маш нарийн зохилдолгоо бүрдэн богино хугацаанд гадаад орчноос тусгаарлагдан булагдсан байх,
- олон арван сая жилийн дараа түүнийг агуулсан хурдас, чулуулаг нь газрын гадаргууд илрэх нөхцөл бүрдэх,
- илэрсэн газарт нь амьтан ургамлын олдвор хадгалагдсан байх,
- хадгалагдсан олдвор нь судалгаа шинжилгээ, танин мэдэхүйд хэрэг болохуйц бүрэн бүтэн, хадгалалт сайн байх,
- тэдгээрийг судлахад бэлтгэгдсэн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагатай байх зэрэг өөр хоорондоо уялдаатай олон тохироо бүрдсэний эцэст үр дүн гардаг.

Дээрх олон тохироо нэг дор бүрэлдэх нь маш ховор байдаг. Иймээс ч дэлхий дээр ийм төрлийн баялагтай орон цөөн байдаг билээ.

Бидний амьдарч байгаа эх дэлхий маань 4,6 тэр бум жилийн тэртээгээс үүсэн бий болж, түүн дээр амьдралын үүслийн анхны төлөөлөгчид болох маш бяцхан бактери маягийн бичил биетнийг хадгалсан чулуулгийн нас 3,1 тэр бумаар тогтоогдсон байдаг. Нилээд тод томруун амьдралын ул мөр болох бичил биетний олдвор одоогоос 2,5 тэр бум жилийн өмнөх настай. Эдгээр нь Австралийн Эдиакарийн занарын үеэс олдсон усан орчинд амьдардаг өт хэлбэрийн амьтад, медуз хэлбэртэн, бүдүүлэг шүрийн олдворууд юм. Монгол орноос хамгийн эртний амьд биетний үлдэгдэл Кембрийн өмнөх цаг үе буюу одоогоос 600 гаруй сая жилийн тэртээх үе давхаргаас олдсон байна.

Эх нутаг маань ийнхүү далай тэнгисийн усаар бүрхэгдэн олон зуун сая жил болж, олон төрлийн усны сээр нуруугүй амьтад үүсэн хөгжиж, хувьсан өөрчлөгдсөөр одоогоос 200 гаруй сая жилийн өмнөөс эх газар бүрэлдэн тогтож, түүн дээр нь эх газрын амьтан ургамал цэцэглэн хөгжиж байсны нэг томоохон төлөөлөгч нь динозавр буюу үлэг гүрвэл билээ. Үлэг гүрвэл нь Хожуу Триасын карниан үеэс Хожуу цэрдийн Маастрихтын үеийг дуустал 160 гаруй сая жилийн турш хувьсан өөрчлөгдөж, өргөнөөр тархаж байсан эх газрын амьтад болно. Монгол орноос олдож байгаа үлэг гүрвэлийн олдворууд нь үлэг гүрвэлийн хөгжлийн сүүлчийн үе шатанд хамаарагдана. Судлаачдын үзэж байгаагаар дэлхийд 280 гаруй төрөл, 330 гаруй зүйл үлэг гүрвэлийн олдвор бичиж тэмдэглэгдсэнээс Монгол орноос 60- аад төрөл зүйлийн үлэг гүрвэл олж тогтоогдоод байна. (Хүснэгт.1)

Монгол орон эртний шим ертөнцийн чулуужсан олдвороороо дэлхийд дээгүүр байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд ялангуяа үлэг гүрвэлийн судалгааны үр дүнгээр шинжлэх ухааны салбарт ч, нийт сонирхогчдын дунд ч олон улсын түвшинд сонирхол төрүүлж байдаг юм.

Хэдийгээр үлэг гүрвэлийн чулуужсан олдвор нь бүх тивээр олдож байдаг боловч одоогийн байдлаар уг эртний амьтны аймгийн үүсэл хөгжилтэй шууд холбогдсон гурван үндсэн томоохон төв манай дэлхий дээр ялгарах болсон юм. Тухайлбал, Умард Америк /АНУ, Канад/, Төв Ази /Монгол улс/, Зүүн Өмнөд Ази /БНХАУ/. Сүүлийн арваад жилийн судалгааны үр дүнг авч үзвэл Монгол улс, БНХАУ-ын нутгаас онцгой ховор олдворуудыг олж, дэлхийн шинжлэх ухааны сан хөмрөгийг баяжуулсан байдаг. Эдгээр нь өвөрмөц, онцлог шинж байдлаараа шинжлэх ухаанд анх бичигдэж тодорхойлогдсон, эртний амьтны талаарх хүн төрөлхтний олж авсан мэдлэгийн хамгийн тайлагдаагүй шинжүүдийг хадгалсан, эртний шим ертөнцийн олдворын цуглуулгын хувьд дэлхийн түвшинд хосгүй, олон эрдэмтэн мэргэдийн судалгаанд анхаарагдаж байгаа, шинжлэх ухааны ихээхэн ач холбогдолтой, музейн үзмэрийн хувьд буюу танин мэдэхүйн хүрээнд гайхал төрүүлж, үзэгч сонирхогчдын анхаарлыг татсаар байгаа нэн ховор олдворууд юм.

2. Палеонтологийн олдворын нас, он цаг тоолол, ангилал

Палеонтологи-д олон улсын болон бүс нутгийн геологийн цаг тооллын ангилал, хуваарийг өргөнөөр хэрэглэдэг. Дэлхийн сайн судлагдсан бүс нутгийн геологийн түүхүүдийг шим ертөнцийн хувьсалтай нэгтгэн харьцуулж, геологийн цаг хугацааны хуваарийг зохион олон улсад мөрддөг. Үүнийг геохронологийн хүснэгт, хроностратиграфийн ангилал ч гэж нэрлэдэг. Олон улсын геологийн цаг хугацааны хуваарийг Архей, Протерозой, фанерозой гэсэн гурван том эонд хуваадаг. Архей (археос-хамгийн эртний) 4-2,5 тэр бум жил буюу 1.5 тэрбум жил үргэлжилсэн гэдэг бөгөөд энэ үед агаар мандалд метан, амиак, нүүрс ус, хүхэрт устөрөгч асар их байсан бөгөөд энэ цаг үед мөөг, бактер, цианобиотын аймгууд зохилон амьдарч байв.

Протерозой -(анхдагч) 2.5 тэр бумаас 570 сая жил буюу 2 тэр бум жилийн турш үргэлжилсэн гэж үздэг. Энэ үед анхны нэг эст замаг, олон эст замаг, нэг болон олон эст амьтан үүссэн байна. Энэ цаг үед цианобиот ихээр тархаж фотосинтезийн урвалаараа хүчилтөрөгчийг ихээр ялгаруулж байсан тул метан, нүүрсхүчлийн хий, хүчилтөрөгчийн тэнцвэрт хэмжээ алдагдаж эхэлсэн. Протерозойн хожуу үе болох 670-570 сая жилийг Вендийн үе гэдэг бөгөөд энэ үеэс одоогийн медуз шиг ясгүй нялцгай биет амьтдын дардас их олддог байна. Дээрх хоёр эоныг хамтад нь Криптозой (крипто-далд) далд амьдралын үе гэдэг ба Дэлхий оршин тогтнож ирсэн түүхийн 80 гаруй хувийг эзэлдэг.

Үүний дараа фанерозой тодорхой амьдралын үе нь Палеозой-(палеос-эртний төрмөл), Мезозой- (мезос-дунд төрмөл), Кайнозой-(кайнос-шинэ төрмөл) гэсэн гурван том эринд хуваагддаг. Эдгээр нь 12 галавт хуваагддаг бөгөөд галавууд нь түрүү (доод), дунд (дунд), хожуу (дээд) гэсэн дэд галав (галчин)-т хуваагдаад эдгээр нь тус бүрдээ нэр бүхий Зуун(age) гэж ангилагддаг.

Улс орнууд өөрийн бүс нутгийн хэмжээнд давхарга зүйн ангиллыг зохиож, олон улсын ангилалтай дүйцүүлж ашигладаг. (Хүснэгт.2)

Палеонтологийн олдворын ангилал ба систематик

Ангилал гэдэг нь том зүйлсийг олон жижиг болгон хуваах гэсэн ойлголт гэдэг нь тодорхой юм. Ангиллын гол зарчим нь нэг нь нэгэндээ хамаарах шатлалаар хийгддэг. Амьд биетийг амьдралын нөхцлөөр нь (хуурай газрын, усны, бентос, планктон г.м.), ураг төрлийн холбоогоор нь, эсвэл идэш тэжээлийнх нь ялгаагаар ангилж болно. Гэвч орчин үед шим ертөнцийн бүх бүрдлийг зөвхөн ураг төрлийн холбоонд үндэслэн ангилахыг хүлээн зөвшөөрөх болсон байна. Шим ертөнцийн ихэнх бүлгүүдийн ангилал кладистик онол дээр тулгуурлан хийгдэх болсон бөгөөд энэ нь геологийн цаг хугацааны өөрчлөлтийг тооцолгүй удам төрлийн холбоон дээр тулгуурласан ургийн модны нэг хувилбар буюу ажиглагдаж байгаа шинж чанаруудад үндэслэсэн ангиллын олон хувилбарууд юм. Систематик гэдэг нь systematikos-эрэмбэ, дараалал гэсэн грек үгнээс гаралтай ба үндэслэгч нь Карл Линней юм. Тэрээр ангиллын дүрэм, зарчмыг боловсруулж, тухайн үед мэдэгдэж байсан орчин үеийн болон эртний чулуужсан амьтан ургамлын шатлалыг зохиосон байна. Палеонтологийн олдвор, цуглуулгыг олон улсын ангилал зүйн дүрэм журмын дагуу зөв тодорхойлсон байх ёстой. (Хүснэгт.3)

Зарим чулуужсан олдворын хадгалалтын хэлбэр нь уг организмыг ангилал зүйд ямар байр суурийг эзлэхийг тогтоох боломжгүй болгох тохиолдолыг бий болгодог. Палеонтологийн судалгааны практикт чулуужсан үлдэгдлийг яг тодорхойлж чадахгүй байгаа бол нээлттэй номенклатурыг ашиглаж, нэмэлт тэмдэглэгээнүүдийг хэрэглэдэг. Тухайлбал: Cf. (conformis)- төсөөтэй, Aff. (affinis)-ойролцоо, төрлийн холбоотой, Insertae sedis-овог ба түүнээс дээш ангилалд ямар байр суурь эзлэх нь тодорхойгүй, Insertus-мэдэгдэж байгаагүй г.м.

Хадгалалт

Ямар нэгэн амьд биет сөнөж мөхөхөд юуны түрүүн зөөлөн эд, эс нь устаж, хатуу эд эсийн нүх сүвүүдэд эрдэс хуримтлагдаж, чулуужих процесс явагддаг. Чулуужсан олдворыг яаж хадгалагдан үлдсэнээс шалтгаалан хэд хэдэн төрөлд хуваадаг.

Subfossils (Sub-дэд, доор, бараг). Энэ нь чулуужсан үлдэгдэл гадаад ясан биенээс гадна бага зэрэг өөрчлөлтөд орсон зөөлөн бие нь хадгалагдан үлдэхийг хэлнэ. Субфоссили-д дөрөвдөгчийн үеийн ургамлын үр, самар, боргоцой, ургамлын модлог зэрэг ордог. Амьтдын хувьд хожуу үеийн олдвор болох арслан заан, хирс, шувууны олдвор субфоссили-д багтана. Дөрөвдөгчөөс эртний настай хурдаснаас субфоссил харьцангүй бага тохиолддог.

Eufossils (грекээр eu-жинхэнэ, сайн) бүтэн хэлхээ яс, эсвэл бүтэн дардас, доторх цөм ядро зэргийг хэлнэ. Хадгалалтын энэ төрөлд амьтны яс, хавтас, бактери болон мөөгний бүрхүүл, навч, үр жимс, самар, үр тоосонцор орно. Ихэнх эуфоссили амьтны зөөлөн биеийн ба цусны эргэлтийн, амьдралын хэв маягийн ба биохимийн үйл ажиллагааны мэдээллийг хадгалсан байдаг.

Ichnofossils (грекээр Ichno-мөр)-чулуужсан амьтдын мөр. Үүнд үе хөлтөн, чийгийн улаан хорхой, хясаа зэрэг сээр нуруугүй амьтдын мөлхөлт, шургалтын ул мөр, сээр нуруутан амьтдын явж хөдөлсөн мөр зэргийг хэлж болно.

Coprofossils (грекээр copro-ялгадас) нь амьтны ялгадсан дотор зарим амьтан ургамлын үлдэгдэл боловсрогдож амжаагүй хадгалагдан үлдсэнийг хэлнэ.

3. **Музейд хадгалагдаж буй палеонтологийн нийтлэг олдворын тухай, түүний шинжлэх ухааны ач холбогдол**

Монгол улсын төвийн болон орон нутгийн музейнүүдэд хадгалагдаж байгаа палеонтологийн нийтлэг олдворт эртний далай тэнгисийн ул мөр болох археоциат, строматопорат, шүр, трилобит, брахиопод болон цэнгэг усны сээр нуруугүй амьтад болох дун хясаанаас эхлэн сээр нуруутан амьтны хөгжлийн сонирхол татдаг төлөөлөгчид болох үлэг гүрвэл, эртний хөхтөн, яст мэлхий, загасны олдвор, цуглуулга ихээхэн нийтлэг байдаг. Аймгийн музейд хадгалагдаж байгаа олдворуудыг мэргэжлийн хүн цуглуулаагүй, ихэнхдээ элдэв зүйл сонирхдог орон нутгийн хүмүүс олж өгсөн, сайндаа л музейн байгалийн чиглэлийн мэргэжилтэн цуглуулсан байдаг учраас палеонтологийн олдворын үнэ цэнийг илэрхийлэх мэдээ баримт маш дутуу дулимаг байдаг. Үзмэрт тавьж үзүүлэхдээ ч бүдүүлэг алдаануудыг хийсэн байдаг. Тухайлбал үлэг гүрвэлийн их биеийн араг ястай цуг эртний хөхтөн амьтны толгойн ясыг угсран үзүүлэх, эртний хүний чулуужсан тархи гээд чулууны өвөрмөц тогтоцыг үзмэрт тавьсан байх жишээтэй.

Ихэнхдээ Цэрдийн галавын үлэг гүрвэлийн олдворууд, арслан заан, савагт хирс, одос үхэр, хонин бух зэрэг Дөрөвдөгч галавын хөхтөн амьтад, зарим тохиолдолд яст мэлхийн чулуужсан хуяг зэргийг музейд цуглуулсан байдаг. Эдгээр олдворуудыг палеонтологийн олдвор цуглуулгын анхан шатны бүртгэл мэдээллийг зохих журмын дагуу хийх, анхнаасаа хийгдээгүй бол эрэн сурвалжилж, эх үүсвэрийг нь тогтоох, харьцуулах судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай. Ингэснээрээ уг олдворын шинжлэх ухааны болон танин мэдэхүйн ач холбогдол нь өсөх бөгөөд музейн үнэт үзмэр болно.

4. **Анхан шатны бүртгэл хийхэд анхаарах зүйлс**

Палеонтологийн олдворын анхан шатны бүртгэл хээрийн судалгааны явцад олж авах мэдээ баримтуудаас эхэлнэ. Эртний амьтан ургамлын олдвор цуглуулгыг байгаль дээрээ илрэх явцад нь мэргэжлийн нарийн технологи, арга барилаар малталтын ажлыг гүйцэтгэж, энэ үед олж авах бүх мэдээлэл (үе давхаргын бичиглэл, тафономын судалгааны мэдээ баримт, нас тогтооход хэрэглэгдэх мэдээ г.м.)-ийг цуглуулах ёстой.

Дараагийн үе шат болох техник боловсруулалтыг лабораторийн нөхцөлд дараах технологийн дараалын дагуу хийдэг.

Техник боловсруулалтын технологи

- Боловсруулалт хийх олдворын хадгалалт, чулуужилтын түвшин, хадгалагдсан орчин, хурдас, чулуулгийн хатуулаг, түүний бөх бат чанар зэрэгт үнэлэлт дүгнэлт өгч техник боловсруулалт хийхарга(механик арга, химийн арга г.м.)-ыг сонгоно.
- Боловсруулалт хийж эхлэхээс өмнө хээрийн судалгааны явцад цуглуулж авсан арга, олдворт газрын нэр, олдсон газрын солбицол, малталт хийсэн хүмүүсийн нэр, цуглуулгын хээрийн дугаар зэргийг боловсруулалтын ажлын дэлгэрэнгүй бичиглэлийн хуудсанд бүртгэж авсан байна.
- Тухайн олдворын чулуужилтаас шалтгаалан түүнд хэрэглэх бэхжүүлэгч уусмал, цавуу зэргийг сонгон, найруулж бэлтгэнэ. Химийн бодисыг ашиглах лабораторийн горимыг хатуу сахих шаардлагатай. Тухайлбал: Ацетон, бензол, спирт г.м. галын аюултай, дэгдэмтгий бодисыг зориулалтын саванд хадгалах, төрөл бүрийн цавууны урвалыг хурдасгагч бодисыг зөв хэрэглэх, хольж хэрэглэдэг цавууны хэрэглэх зааврыг хатуу баримтлах,
- Боловсруулалтын ажлыг гүйцэтгэхэд тухайн амьтан ургамлынхаа анатоми, морфологийн талаар тодорхой мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай бөгөөд мэдэхгүйн улмаас боловсруулалт хийх явцад эвдэж хэмхлэх аюул гардаг тул ялангуяа сээр нуруутны олдворт техник боловсруулалт хийх препаратор, лаборантууд нь харьцуулах анатомийн зохих мэдлэгтэй байх шаардлагатай.
- Боловсруулалтын ажлыг судлаач болон лабораторийн эрхлэгчийн хяналтан дор явуулах бөгөөд өдөр бүрийн техник боловсруулалтын үр дүнг дүгнэж байх ёстой.
- Техник боловсруулалтын явцад цаашдын судалгааны үр дүнд нөлөөлөх мэдээ баримтууд олноор гарч ирэх тохиолдол байдаг бөгөөд боловсруулалтын явцын гэрэл зургийг үе шат дутамд авч байх, хадгалалтын бүдүүвч зургийг тэмдэглэж үлдээх, хадгалагдсан хурдсын тэмдэглэл зэргийг боловсруулалтын ажлын дэлгэрэнгүй бичиглэлийн хуудсанд товч тодорхой, ойлгомжтой бичнэ.
- Дэлгэрэнгүй бичиглэлийн хуудсанд ямар цавуу, бэхжүүлэгч ашигласан, бэхжүүлэгчийг хэдэн удаа, хэдэн үе шаттайгаар хийсэн, цаашид судлаачид болон музейн ажилтангууд уг олдворын хадгалалтын юунд нь анхаарах талаар заавар, зөвлөмжийг бичиж үлдээнэ.

Эртний сээр нуруутан амьтдын ангилал зүйн дараалал (Үлэг гүрвэлийн жишээн дээр)

АНГИ	ДЭД АНГИ	БАГ	ДЭД БАГ	ДЭЭД БАГ	ОВОГ	ТӨРӨЛ
Pesces-загас						
Amphibia-хоёр нутагтан						
Reptilia-мөлхөгчид						
	Synapsida	Pelycosauria				
		Therapsida				
	Anapsida	Captorhinomorpha				
		Mesosauria				
		Chelonia				
	Diapsida	Araeoscelida				
		Choristodera				
		Eosuchia				
		Squamata				
		Thecodontia				
		Crocodylia				
		Pterosauria				
		Saurischia	Theropoda	Ceratosauria		
				Carnosauria	Tyrannosauridae	Tarbosaur
					Ornithomimidae	Gallimimus
				Maniraptora		
					Compsognathidae	
					Coeluridae	
					Oviraptoridae	Oviraptor
					Dromeosauridae	Velociraptor
					Troodontidae	Saurornithoides
			Sauropodomorpha	Prosauropoda		
				Sauropoda	Camarasauridae	Opisthocoelicaudia
					Brachiosauridae	
					Diplodocidae	Nemegtosaurus
					Titanosauridae	
		Ornithischia	Cerapoda	Ornithopoda	Iguanodontidae	Altirhinus
					Hadrosauridae	Saurolophus
				Pachycephalosauria		
				Ceratopsia	Psittacosauridae	Psittacosaurus
					Protoceratopsidae	Protoceratops
					Ceratopsidae	
			Thyreophora	Stegosauria		
				Ankylosauria	Nodosauridae	
					Ankylosauridae	
Aves-шувуу	Ornithurae					
	Palaeognathae					
	Neognathae					
Mammalia-хөхтөн		Monotremata				
		Triconodonta				
		Symmetrodonta				
		Docodonta				
		Multituberculata				
		Marsupialia				
		Creodonta				
		Carnivora				
		Primates				
		Condylarthra				
		Pantodonta				
		Dinocerata				
		Notoungulata				
		Perissodactyla				
		Artiodactyla				
		Proboscidea				

Хүснэгт №4

Эртний сээр нуруутан амьтны олдворын бүрэн бүтэн байдлын зэрэглэл

№	Зэрэглэл	Бүрэн бүтний бичиглэл	Таксономын ач холбогдол	Хадгалалтын түвшин	Тэмдэглэл
1	I зэрэглэл	Толгойн яс,их биеийн араг ясны 75%-иас дээших хэсгүүд нь хадгалагдсан	онцгой	Маш сайн	
2	II зэрэглэл	Толгойн яс, их биеийн араг ясны 50-75% нь хадгалагдсан	Их	Сайн	
3	III зэрэглэл	Толгойн яс, их биеийн араг ясны 30% нь хадгалагдсан	Дунд	Дунд	
4	IV зэрэглэл	Толгойн ясгүй, их биеийн араг ясны 50-75% нь хадгалагдсан	Бага	Муу	
5	V зэрэглэл	Толгойн ясгүй, их биеийн араг ясны 30% нь хадгалагдсан	Үгүй	Өгөршилд орсон	

Хүснэгт №2

Эртний сээр нуруутан амьтны олдворын насны ангилал

Галав- Period	Галчин- Epoch	Сая жилийн өмнөх	Зуун-Age (Олон улсын ангиллаар)	(Бүс нутгийн-Монголын)
Дөрөвдөгч- Quaternary Q	Голоцен-Holocene Q2			
	Плейстоцен-Pleistocene Q1	1.8	Калабр- Calabrian	
Неоген-Neogene N	Плиоцен-Pliocene N2		Геласи- Gelasian	
			Пиацензи- Piacenzian	Түйн гол (Tuyn Gol)
		5	Занкли- Zanclian	
	Миоцен-Miocene N1		Мессини- Messinian	Луу (Loh)
			Тортони- Tortonian	
			Серравалли-Serravallian	
			Ланги- Langhian	
			Бурдигали-Burdigalian	
		23	Аквитани- Aquitanian	
Палеоген- Paleogene E	Олигоцен-Oligocene E3		Чат- Chattian	Шанд гол(Hsanda Gol)
		34	Рупель- Rupelian	
	Эоцен-Eocene E2		Приабони-Priabonian	Эргилийн зоо
			Бартони- Bartonian	Хайчин
			Лютети- Lutetian	
		55	Ипри- Ypresian	
	Палеоцен-Paleocene E1		Танети- Thanetian	Наранбулаг
			Сэланди- Selandian	
		65	Дани- Danian	
		71	Маастрихт-Maastrichtian	Нэмэгт (Nm)
		84	Кампани- Campanian	Баруун гоёот (Bgt)

Цэрд- Cretaceous K	Хожуу K2	86	Сантон- Santonian	Жадохт (Djt)
		90	Коньяк- Coniacian	
		94	Турон - Turonian	Баян ширээ (Bsh)
		99	Сеноман - Cenomanian	Баруун баян (Bb)
	Түрүү K1	112	Альб - Albian	Хөх тээг (KhT)
		121	Апт - Aptian	Шинэ худаг (ShKh)
		127	Баррем - Barremian	Цагаан цав (TsTs)
		132	Готерив - Hauterivian	
		137	Валанжин-Valanginian	
		144	Берриас - Berriasian	
Юра (J)	Хожуу J3	151	Титон - Tithonian	
		154	Киммериджи-Kimmeridgian	
		160	Оксфорд - Oxfordian	
	Дунд J2	164	Келловей - Callovian	
		169	Бат - Bathonian	
		176	Байос - Bajocian	
		180	Аален - Aalenian	
	Түрүү J1	189	Тоари - Toarcian	
			Плейнсбахи-Pleinsbachian	
			Синемюри -Sinemurian	
			Геттанги -Hettangian	
Триас (Tr)	Хожуу Tr^3		Рэти -Rhaetian	
			Нори - Norian	
			Карни - Carnian	
	Дунд Tr^2		Ладини - Ladinian	
			Анизи - Anisian	
	Түрүү Tr		Оленеки - Olenekian	
			Инди - Induan	

Монголын үлэг гүрвэлийн ангилал зүйн дараалал

БАГ	ДЭД БАГ	ДЭЭД БАГ	ОВОГ	ТӨРӨЛ	МОНГОЛООС ТОГТООГДСОН ЗҮЙЛ
Saurischia	Theropoda	Ceratosauria			
		Carnosauria	Tyrannosauridae	Tarbosaurus	*Tarbosaurus bataar* Maleev, 1955
				Alioramus	*Alioramus remotus* Kurzanov, 1976
				Alectrosaurus	*Alectrosaurus olsoni* Gilmore, 1933
				Deinocheirus	*Deinocheirus mirificus* Osmolska et Roniewicz, 1970
		Ornithomimosauri	Harpymimidae	Harpymimus	*Harpymimus okladnikovi* Barsbold et Perle, 1984
			Garudimimidae	Garudimimus	*Garudimimus brevipes* Barsbold, 1981
			Ornithomimidae	Gallimimus	*Gallimimus bullatus* Osmolska, Roniewicz et Barsbold, 1972
				Anserimimus	*Anserimimus planinychus* Barsbold, 1988
		Maniraptora	Compsognathidae		
			Coeluridae		
			Oviraptoridae	Oviraptor	*Oviraptor philoceratops* Osborn, 1924
					Oviraptor mongoliensis Barsbold, 1986
				Conchoraptor	*Conchoraptor gracilis Barsbold*, 1986
				Ingenia	*Ingenia yanshini* Barsbold, 1981
				Nomingia	*Nomingia gobiensis* Barsbold, Osmolska, Tsogtbaatar,Watabe, et Currie, 2000
			Caenagnathidae	Elmisaurus	*Elmisaurus rarus* Osmolska, 1981
			Therizinosaurida	Erlikosaurus	*Erlikosaurus andrewsi* Perle, 1981
				Enigmosaurus	*Enigmosaurus mongoliensis* Barsbold et Perle, 1983
				Segnosaurus	*Segnosaurus galbinensis* Barsbold and Perle, 1980
				Therizinosaurus	*Therizinosaurus cheloniformis* Maleev, 1954
			Avimimidae	Avimimus	*Avimimus portentosus* Kurzanov, 19
			Dromeosauridae	Velociraptor	*Velociraptor mongoliensis* Osborn, 1924
				Adasaurus	*Adasaurus mongoliensis* Barsbold, 1983
				Hulsanpes	*Hulsanpes perlei* Osmolska, 1982
			Troodontidae	Saurornithoides	*Saurornithoides mongoliensis* Osborn, 1924
					Saurornithoides junior Barsbold, 1974
				Borogovia	*Borogovia gracilicrus* Osmolska, 1987
				Tochisaurus	*Tochisaurus nemegtensis* Kurzanov & Osmolska, 1991
			Avialae	Mononykus	*Mononykus olecranus* Perle, Chiappe, Barsbold, Clark et Norell, 1994
	Sauropodomorph	Prosauropoda			
		Sauropoda	Camarasauridae	Opisthocoelicau	*Opisthocoelicaudia skarzynskii* Borsuk-Bialynicka, 1977
			Brachiosauridae		
			Diplodocidae	Nemegtosaurus	*Nemegtosaurus mongoliensis* Nowinski, 1971

					Quaesitosaurus orientalis Bannikov & Kurzanov, 1983
			Titanosauridae		
Ornithischi	Cerapoda	Ornithopoda	Iguanodontidae	Iguanodon	*Iguanodon bernissartensis= I. orientalis* Rozhdestvenskii, 1952
				Altirhinus	*Altirhinus kurzanovi* Norman, 1998
			Hadrosauridae	Saurolophus	*Saurolophus angustirostris* Rozhdestvenskii, 1952
				Barsboldia	*Barsboldia sicinskii* Maryanska and Osmolska, 1981
				Gobihadros	*Gobihadros* Tsogtbaatar et al.., 2006
				Bactrosaurus	*Bactrosaurus* sp. nov., Tsogtbaatar et al., 2006
		Pachycephalosauria		Goyocephale	*Goyocephale lattimori* Perle. Maryans[a et Osmolska, 1982
				Homalocephale	*Homalocephale calathocercos* Maryanska et Osmolska, 1974
				Prenocephale	*Prenocephale prenes* Maryanska et Osmolska, 1974
				Tylocephale	*Tylocephale gilmorei* Maryanska et Osmolska, 1974
		Ceratopsia	Psittacosauridae	Psittacosaurus	*Psittacosaurus mongoliensis* Osborn, 1924
			Protoceratopsida	Protoceratops	*Udanoceratops tschizhovi* Kurzanov, 1992
				Bagaceratops	*Bagaceratops rozhdestvenski* Maryanska et Osmolska, 1975
				Protoceratops	*Protoceratops andrewsi* Granger et Gregory, 1923
				Microceratops	*Microceratops gobiensis* Maryanska et Osmolska, 1975
				Breviceratops	*Breviceratops kozlowskii* Maryanska et Osmolska, 1975
			Ceratopsidae		
	Thyreophora	Stegosauria			
		Ankylosauria	Nodosauridae		
			Ankylosauridae	Shamosaurus	*Shamosaurus scutatus* Tumanova, 1983
				Talarurus	*Talarurus plicatospineus* Maleev, 1952
				Tsagantegia	*Tsagantegia longicranialis* Tumanova, 1993
				Maleevus	*Maleevus disparoserratus* Maleev, 1952
				Amtosaurus	*Amtosaurus magnus* Kurzanov et Tumanova, 1978
				Pinacosaurus	*Pinacosaurus grangeri* Gilmore, 1933
				Saichania	*Saichania chulsanensis* Maryanska, 1977
				Tarchia	*Tarchia gigantean* Maleev, 1956

- Боловсруулалт хийж дууссан олдвор цуглуулгыг нэг бүрчлэн дугаарлаж, бүртгэх, бүрэн бүтэн байдлын бичиглэл, зэрэглэлийг фонд хариуцагчтай хамтран хийж, хүлээлгэн өгснөөр техник боловсруулалтын үе шат дууссан гэж үзнэ. Зэрэглэлийг тогтоохд олдворын бүрэн бүтэн байдлаас гадна тухайн амьтан ургамлын ангилал зүйн ач холбогдол, хадгалалтын түвшин зэргийг харгалзан үзэх ёстой. (Хүснэгт.4).

5. Палеонтологийн олдворуудын хадгалалт хамгаалалтын талаар заавар зөвлөмж

Шинэ зууны музейнүүд хэмээх номонд “Олдвор цуглуулгын хадгалалт хамгаалалт гэдэгт орчны нөлөөг хянахаас эхлээд зохих харуул хамгаалалт тавих, шаардлагатай бүртгэл каталог хөтлөх, гэмтэл эвдрэлийг засах хүртэлх бүх ажлыг

хамруулна” гэжээ. Иймд олдвор, цуглуулгыг хадгалж, хамгаална гэдэг нь харанхуй, цоожтой агуулахад хадгалаад байхыг бус тухайн олдворыг анх олдсон цаг мөчөөс нь түүнтэй холбоотой бүх баримтуудыг хөтөлж, бүртгэл, катологид оруулж, шинэ мэдээллээр байнга баяжуулж, судлаачдад аль болох нээлттэй байлгаж, судалгаа шинжилгээний амьд эргэлтэд оруулахыг хэлдэг байна. Палеонтологийн аливаа олдвор харьцуулах судалгааны тулгуур баримт болж байдаг учраас баримтжуулсан олдвор болгон судалгаа шинжилгээнд хэзээ ч хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл олон жилийн өмнө олдож, судлагдсан олдворыг ч бүрэн төгс судлагдаж дууссан гэж үздэггүй бөгөөд түүнтэй төстэй олдвор дахин олдоход тэдгээр нь харьцуулах тулгуур материал болдог.

Палеонтологийн олдворууд нь хадгалагдсан цаг хугацаа, хадгалалтын орчноос хамааран чулуужилтын түвшин нь харилцан адилгүй байдаг учир хадгалалт хамгаалалтын горим өөр өөр байдаг. Аливаа чулуужсан олдворт уур, цан, чийг маш муугаар нөлөөлдөг. Палеонтологийн олдворыг хадгалах хамгийн тохиромжтой нөхцөл агаарын температур 20-22°C, харьцангуй чийгшилт 80%-иас дээшгүй байх ёстой.

Олдворыг тодорхой давтамжтайгаар зориулалтын уусмалаар бэхжүүлэх шаардлагатай байдаг бөгөөд уусмалыг сонгохдоо анх ямар бэхжүүлэгч ашигласныг анхаарах хэрэгтэй.

Мэргэжлийн талаас манай байгууллагатай хамтарч ажиллахыг хүссэн байгууллага, хамт олон доорх хаягаар бидэнтэй харьцана уу.

Хаяг: Шинжлэх ухааны академийн Палеонтологийн төв, Палеонтологийн лаборатори, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Байгалийн түүхийн музейн баруун талд.
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Шуудангийн салбар-46, Ш/х 650
Óòàñ: 325835, 322888
e-mail: paleolab@magicnet.mn

ШУА-ийн Палеонтологийн төв
Х.Цогтбаатар

УТГА СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

“Соёлын өвийг хамгаалах тухай” монгол улсын хуулинд: “Ард түмний билиг авъяас, мэдлэг туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билиг, зан үйл, ур хийц, арга барил, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараах оюуны соёлын үнэт зүйлийг утга соёлын өвд хамааруулна. Үүнд:

1. Эх хэл, бичиг, түүний хүрээний соёл
2. Аман зохиол
3. Ардын уртын болон богино дуу, тууль, тэдгээрийг дуулах, хайлах арга барил
4. Хөдөлмөр зан үйлийн холбогдолтой уриа дуудлага
5. Хөөмий исгэрээ, аман болон тагнай ташилт зэрэг өгүүлэхийн эрхтний шүтэлцээт урлаг, тэдгээрийг илэрхийлэх арга барил:
6. Үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил
7. Ардын уламжлалт бүжиг, бий биелгээ:
8. Уран нугаралт болон циркийн үзүүлбэрийг илэрхийлэх гоц авъяастны ур чадварын арга барил
9. Ардын гар урлалын дэг сургууль
10. Ардын ёс заншил, зан үйлийн уламжлал
11. Эрдэм ухааны уламжлал
12. Ардын бэлгэдэх ёсны уламжлал хэмээн тодорхойлж өгсөн билээ.

Мөн хуулиар утга соёлын өвийг хамгаалах ажлыг төв, орон нутагт хариуцах байгууллага, албан тушаалтныг тогтоож, тэдгээрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн юм. Уг асуудлыг улсын хэмжээнд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох БСШУ-ны яам, аймаг, нийслэл, сум дүүргийн түвшинд тус тусын засаг дарга, түүний тамгын газар хариуцан дараах үүрэгтэй ажиллахыг хуулинд заасан болно. Үүнд:

а) Утга соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг тус тусын түвшинд бүрдүүлж нэгдсэн сүлжээнд хамруулах

б) Харъяа нутаг дэвсгэртээ буй утга соёлын өв ба өвлөн тээгчийн жагсаалт, судалгаа гарган, тэдгээрийг хамгаалах арга замыг тодорхойлж, хэрэгжүүлэх

в) Уг өвийг залуу үед өвлүүлэх сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг зохион байгуулах зэрэг болно.

Тэрчлэн уг хуулиар соёлын аливаа өв (түүний дотор утга соёлын өв)-ийг давтагдашгүй өвөрмөц байдал, уран сайхны үнэ цэнэ, тархсан байдлаар нь, хосгүй үнэт, үнэт, ердийн гэсэн зэрэглэл тогтоож тэдгээр тус бүрийг хамгаалах субъектийг улс, аймаг, орон нутгийн түвшинд тогтоож өгсөн юм.

Уг хууль мөрдөгдөж эхэлснээр, улсын хэмжээнд утга соёлын өвийг хамгаалах нэгдсэн тогтолцоо буй болж, хэдийгээр сайтар жигдрээгүй боловч утга соёлын өвийн ба өвлөн тээгчдийн бүртгэл жагсаалт гаргах ажил төв, орон нутагт хэрэгжиж эхлээд байгаа болно. Гэхдээ энд нэг дутагдалтай зүйл нь бүртгэл, жагсаалтад гүйцэтгэх урлаг (perpoming arts) буюу уран сайханы үзүүлбэрийн талыг голлон анхаарч, нутаг нутаг дахь ардын уламжлалт ёс заншил (customs), зан үйлийн уламжлал, ардын гар урлалын дэг сургууль, уламжлалт технологийн холбогдолтой утга соёлын өвийг төдийлөн анхаарч тусгагдаагүй тал буй болно.

Эрдэмтэн судлаачид, соёл урлагийн зүтгэлтэн, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан Утга соёлын өвийн зэрэглэл тогтоох улсын комисс байгуулж, эхний ээлжинд төв, орон нутгийн 60 гаруй ардын авъяастныг шалгаруулан “Утга соёлын үнэт өвийг өвлөн тээгч”-ийн өргөмжлөл гэрчилгээ гардуулаад байна. Хэдийгээр “Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулинд утга соёлын ховор хосгүй өвийг ур чадварын дээд түвшинд өвлөн эзэмшсэн ардын билэг авъяастнуудыг (bearers) төрийн хамгаалалтад байлгах тухай заалт орсон боловч төв, орон нутгийн төсөв хүрэлцээгүйн улмаас (хөрөнгө санхүүгийн боломжгүйгээс) энэ заалт хэрэгжиж чадахгүй байгаа юм.

Соёлын биет бус өвийг хамгаалах талаар ЮНЕСКО цуврал шийдвэр гаргасан. Тухайлбал 1989 онд гаргасан “Уламжлалт соёл, ардын билгийг хамгаалах зөвлөмж”, 2001 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Хүн төрөлхтний утга соёл, аман өвийн шилдэг дээжисийг тунхаглах” ЮНЕСКО-гийн хөтөлбөр, 2002 онд баталсан “Соёлын олон төрөл байдлын тухай түгээмэл тунхаглал”, 2003 онд баталсан “Утга соёлын өвийг хамгаалах тухай олон улсын конвенц” зэргийг нэрлэж болно.

Монгол улс 2005 онд “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-гийн конвенцид нэгдэн орсон билээ.

ЮНЕСКО 2003 онд Монгол ардын уламжлалт хөгжмийн зэмсэг Морин хуурыг, 2005 онд Монгол ардын уртын дууг Хүн төрөлхтний утга соёл, аман өвийг шилдэг дээжист тунхагласан нь өв соёлоо хүндэтгэн дээдэлдэг хүн бүхний баяр бахдалыг төрүүлсэн чухал үйл явдал болсон билээ. Морин хуур, уртын дууг хүн төрөлхтний утга соёл, аман өвийн шилдэг дээж гэж ийнхүү тунхагласнаар түүний өв уламжлалыг хамгаалан хөгжүүлэх, хойч үед залгамжлан өвлүүлэх талаар монголчууд бид хүн төрөлхтний өмнө томоохон хариуцлага хүлээж буй хэрэг юм. Эл үүргээ ухамсарлан, “Морин хуур, Уртын дууг өвлөн дэлгэрүүлэх тухай” Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн холбогдох заалтыг үндэс болгон Монгол улсын Засгийн газар 2005-2014 онд хэрэгжих “Морин хуур, уртын дуу” бие даасан хөтөлбөрийг батлан мөрдөж байгаа билээ.

Утга соёл, аман өвийг хамгаалах ажлын нэг чухал чиглэл нь түүнийг баримтжуулах асуудал юм. 1999-2002 онд ЮНЕСКО-гийн ивээл дор хэрэгжүүлсэн “Монголын аман өвийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах” төслийг хэрэгжүүлснээр Монголын олон ястны утга соёл, аман өв тэдгээрийг уламжлан тээгч 900 гаруй ардын авъяастны жагсаалт, нэгдсэн бүртгэл судалгаатай болж, тэдний урын сан, уламжлалт зан үйлийг язгуур шинжээр нь баримтжуулсан 500 цагийн видео, 210 цагийн видео бичлэгийн сан, архивтай болов. Энэ нь монголын утга соёлын уламжлалт өвийг хамгаалах, сэргээх, судлах болон үндэсний өвийн сургалт явуулах дараа дараагийн алхамуудыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол бүхий ховор нандин хэрэглэгдэхүүн юм. Аман өвийг баримтжуулах ажилд цаг хугацааны хүчин зүйл онцгой учир холбогдолтой байдаг нь түүнийг язгуур шинжээр нь уламжлан өвлөж үлдсэн авъяастнуудын тоо өдөр хоногоор цөөрсөөр байгаад оршино. Монголын утга соёл, аман өвийг хамгаалж, уламжлах өргөн хүрээтэй зорилтыг нэг удаагийн төслөөр, нэгэн далайлтаар бүрэн дүүрэн шийдэх боломжгүй тул цаашид Монголын Утга Соёлын Өвийн Үндэсний Төв өөрийн туршлагадаа тулгуурлан Монголын Олон Ястны аман өвийг дуу, дүрс, бичлэгээр баримтжуулах ажлыг үргэлжлүүлэн хийж буй болно. Мөн аман өвийн зэрэгцээ ардын ёс заншил, зан үйлийн уламжлал ардын гар урлалын дэг сургууль уламжлалт технологийн холбогдолтой баримтжуулалтын ажлыг цаг алдалгүй хийх ээлжилт зорилт бидний өмнө тавигдаж байгаа юм.

Монголчууд эх газрын эрс тэс уур амьсгалтай төв Азийн өндөрлөг бүс нутагт нүүдлийн мал аж ахуй эрхлэн аж төрж, эрин зууныг элээсээр XX зуунтай золгосон юм. Олон зууны турш гадаад ертөнцөөс тасархай (Хотлын ховыг бадарчин, аймгийн ховыг элч түгээхээс өөр мэдээлэл хомс) бөглүү хязгаарлагдмал нөхцөлд оршиж ирсэн нь хүн төрөлхтний хөгжил дэвшлээс Монгол орон гээгдэн хоцрох нэг шалтгаан болсон юм. Гэвч аливаа юмс үзэгдэл эерэг ба сөрөг талыг өөртөө агуулж байдагчлан эл хоцрогдол нь Монголын нүүдэлчдийн утга соёл, аман өвийн баялаг олон төрөл зүйл өөрийн жамаар үүсэж хөгжиж, өвөрмөц өнгө төрхөө хадгалж үлдэх боломжийг бүрдүүлж өгснөөрөө бас ч нааштай тохиолдол болсон гэж хэлж болно.

Гэхдээ энэ “давуу тал” эдүгээ нэн хурдтай алдагдаж байна. Орчин цагийн монголын нийгэмд гарч буй хамгийн том өөрчлөлт бол суурьших, хотжих, аж үйлдвэржих үйл явц эрчимжиж нүүдлийн иргэншил эргэлт буцалтгүй задарч байгаа явдал юм. Монголд XX зууны хоёрдугаар хагасаас эхэлсэн энэ үйл явц хоёр мянганы зааг дээр оргил үедээ хүрч хурдсав. 2003 оны байдлаар Монголын нийт хүн амын 2/3 хувь нь төв суурин газар, түүний дотор хүн амын талаас илүү хувь нь нийслэл хотноо оршин сууж буй статистик гарчээ.

Монгол дахь хотжих эл үйл явц өрнөдийн хотжилтоос чанарын ялгаатай. Учир нь Монголын хотжилт нь ард иргэдийн жирийн нэг шилжих хөдөлгөөн биш, амьдралын нэг хэв маягаас огт өөр хэв маягт шилжих шилжилт юм. Хотжисноор хүмүүсийн зөвхөн амьдралын орон зай өөрчлөгдөөд зогсохгүй, ахуй амьдрал, хэв заншил, уламжлалт соёлын олон үнэт зүйлс үндсээрээ өөрчлөгдөхөд хүрч байгаа билээ. Ийм тохиолдолд нүүдлийн амьдралаас урган гарч, түүний салшгүй хэсэг нь болсон оюун санааны олон үнэт зүйлс, түүний дотор мал аж ахуйн уламжлалт технологи, мал аж ахуйтай холбоотой хур мэдлэг, дадлага туршлага ашиглагдахаа больж, нүүдэлчдийн уламжлалт ёс заншил, гоо сайхны үнэлэмж, уртын дуу, үлгэр туульс, ардын бүжиг, бий биелгээ наадам, тоглоом нь хотын амьдрал, машин техникийн хэмнэлтэй төдийлөн тохирохгүй учир орчин үеийн цэнгээн, /шоу/, нийтийн /арилжааны/ соёлын зүйлсээр арга буюу солигдоход хүрч байна.

Нүүдлийн соёл иргэншлийн мөн чанар бол хүн-байгаль-мал гурвын цогц нэгдэл юм. Үүнтэй холбоотойгоор монгол ардын аман зохиол, дуу, хөгжим, үлгэр туульд сайхан хүн, сайхан мал (ялангуяа морь), онгон тансаг байгаль гурав ямагт мөнхийн сэдэв, гоо сайхны цогцолбор оногдохуй (объект) нь болж ирсэн юм. Эдүгээ Монголын хүн амын ихэнх нь хот суурин газар амьдрах болсноор байгалиас холдож, малаас хөндийрсөн шинэ үе нэгэнт бий болж, байгалтай цаг, мөч тутам харилцаж, байгальтай зохицож амьдардаг монгол уламжлал, мал сүргээ хайрлаж өсгөдөг, харж баясдаг, унаж эдлэхдээ гоёл, гоо сайхны нэгэн зүйл бахархал болгодог нүүдэлч малчдын уламжлалт сэтгэлгээ, түүнтэй холбоотой аман зохиолын баялаг өв мартагдахад хүрэв.

Залуу үеийнхний дунд өрнөджих, нийтийн гэгдэх арилжааны соёлын ололтыг шимтэх явдал нэн эрчимтэй өрнөж буй нь мэдээллийн хязгаартай орчноос нээлттэй нийгэмд шилжих нэг онцлог гэлтэй. Ийм нөхцөлд залуучуудад уламжлал хоцрогдлын бэлгэ тэмдэг мэт санагдах үе бас байдаг бололтой.

Эдгээр хүчин зүйлийн улмаас хүн төрөлхтний соёлын бүрэлдэхүүн хэсэг болсон монголын нүүдэлчдийн утга соёл, аман өвийн зарим зүйл устаж мөхөх, уламжлалт ёс заншил алдрах, бусад үндэстний соёлд уусан замхрах аюул бодитой оршиж буй юм. Ийм нөхцөлд нүүдэлчдийн уламжлалт утга соёл, аман өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх тулгамдсан зорилт бидний өмнө хэзээ хэзээнээс илүү хурцаар тавигдах болов. Энэ бол нүүдэллэн аж төрөх ёсыг мөнхлөн хадгалах тухай бус, нүүдэлчдийн олон зууны туршид бүтээн цогцлуулсан утга соёлын өвийг хамгаалах тухай асуудал гэдэг нь ойлгомжтой.

Утга соёлын өвийн үндэсний төвийн гүйцэтгэх захирал
С.Юндэнбат

Маягт №1

УТГА СОЁЛЫН ХОСГҮЙ, ХОВОР ҮНЭТ ӨВИЙГ ӨВЛӨН ТЭЭГЧИЙН СУДАЛГАА

Гэрэл зураг (9x12)

Овог ....
Нэр ....
Яс, үндэс ....
Үндсэн захиргаа ....
....
....
....
Хуучнаар аль аймаг, хошуу ....
....
....
....
Одоогийн хаяг, нутаг ус
....
....
....
....
Төрсөн он ....
Хүйс ....
Эрхэлж буй ажил ....
....
....
Мэргэжил ....
Боловсрол ....
Алдар цол, гавъяа шагнал
....

Утга соёлын өвийн нэр, төрөл зүйл ....
....

Хосгүй ба ховор үнэт зэрэглэлийн алинд хамааруулах тухай санал ....
....

Уг саналын үндэслэл (соёл, түүх, угсаатны болон уран сайхны үнэ цэнэ, онцлог шинж)
....
....
....
....
....
....
....
....

Уг өвийг хамгаалах, баримтжуулах, өвлөн уламжлуулах, судлаж сурталчлах талаар авах арга хэмжээний тухай санал
....
....
....
....
....
....
....
....

Утга соёлын өвийн тухайд:
/Судлагдсан байдал, өв залгамжлал, ямар нөхцөлд, ямар байдал, ёс журмаар гүйцэтгэдэг, энэ нь хэрхэн хувирч өөрчлөгдсөн, бусад хувилбар, тархац г.м/

Өвлөн тээгчийн тухайд:
/Овог, гарал, удам судар, хэзээ хэнээс (хуучны аль аймаг хошууны) сурсан, холбогдох түүх, намтар г.м/

Тайлбар: Дуу, дүрс бичлэг, слайд, судалгаа, тэмдэглэл зэрэг нэмэлт материалууд хавсаргаж болно.

Судалгаа гаргасан

овог нэр албан тушаал

Хаяг ....

Утас, факс ....

Хүлээн авсан

овог нэр албан тушаал

он сар өдөр

Маягт №1

<u>УТГА СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН САН</u>

Утга соёлын өвийн судалгаа

Дугаар:

Өвлөн тээгчийн овог нэр:
Улаан хуулар овогт Чулууны Чинбат

Яс үндэс: *Дархад ястан*

Төрсөн он: *1969*

Хүйс. *Эрэгтэй*

Үндсэн захиргаа: *Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум. Төгөл баг*

Хуучнаар аль аймаг, хошуу:
Богдын Дархад шавь, Хойт отог

Одоогийн хаяг, нутаг ус: *Хөвсгөл. Мөрөн сум. 3 дугаар баг*

Боловсрол мэргэжил: *Тусгай дунд, жолооч*

Эрхэлж буй ажил: *Хувиараа эрхлэх аж ахуй*

Алдар цол, гавъяа шагнал: *Үгүй*

Утга соёлын өвийн нэр, төрөл зүйл: *Дархад бөө*

<u>Өвлөн тээгчийн тухай тэмдэглэл:</u> (Удам угсаа, намтар түүхийн онцлог зүйлс, уг зүйлийг хэзээ хэнээс сурсан, хэн хэнд зааж авлуулсан, билиг авъяас, ур чадварын түвшин давтагдашгүй чанар г.м)

XVIII зууны дунд үед амьдарч байсан Увш зайрангийн удмаас нэртэй зартай бөө, удганууд удаа дараа төрж байсны 4 дэх нь XX зуны эхэн үед Дархад нутагт алдаршиж байсан Улаан хуулар овгийн Дэлдэн Мэнд зайран гэгч байжээ. Түүний хойчсоос залгаж гарсан зайран нь Чинбат ажээ.

1986-1987 онд тэрбээр бие нь муудаж, арга засал эс авч ядрахдаа мэргэч төлөгч хүнээс асуувал "хуур бариулвал (бөөгийн төмөр хуурыг хэлжээ) эдгэрэх хүүхэд байа. Урд удмынх нь онгод сахиус түүнийг оролдоод байгаа юм байна" гэснээр өөрөө хуураа хийгээд Дархадын Цагаан хуулар овогтой Цэгмэд хэмээх удган дээр бие муутай ядарч туйлдсан амьтан хүргүүлж очсон юмсанжээ. Настай удган түүнийг гэртээ 3 хонуулаад явган бөөлж арга засал хийж өгчээ. Ч.Чинбат тэр удганыд анх бөөгийн хувцас хуяг өмсөж бөөлөөд ёс төр гүйцэтгэж зайран болсон байна. Энэ нь 1989 оны намар цаг байжээ. Үүнээс хойш бие нь эрүүл болж илааршсан гэдэг.
(Намтарын энэ хэсгийг зайрангийн өөрийнх нь яринаас иш татаж бичвэй)

<u>Утга соёлын уг өвийн тухай тэмдэглэл:</u> (Судлагдсан байдал, өв залгамжлал, ямар нөхцөлд ямар журмаар гүйцэтгэдэг, энэ нь хэрхэн хувирч өөрчлөгдсөн, бусад хувилбар, тархац, түүх гарвал, домог хууч, үг, ая, холбогдох ном зүй г.м)

Сэтэр гэдэг нь магадгүй язгуур шүтлэгийн анхны шүтээн байж болох талтай ажээ. Сэтэр нь тухайн айл өрх, гэр орон, үр хүүхэд, ажил төрөл, үйл бүтээл, амь амьжиргааг нь даатгаж амьд малд шингээсэн онгод сүлд юм. Сэтэрлэсэн (онгодоо унуулсан) тэр мал хөгшрөөд үхэхийн цаг тулах үед нь уул сэтрийг нь салгаж өөр

малд шилжүүлж болдог. Өөр малд шилжүүлэх боломж үгүй бол уг малыг хэрэглэж (зурж) түүнд сэтрээ (онгодоо) шингээж шүтээн болгон хадгалдаг ёс ч байжээ. Энэ сэтрийг аль нэг шалтгаанаар (өөр төрлийн сэтэр залах, уг сэтрийг хадгалах айлын үе залгамж тасрах г.м) буцаах шаардлага гарвaас (залж болсон юм, буцааж бас болдог ажээ) уг сэтрийг хар тэнгэрт нь буцаах эл зан үйлийг гүйцэтгэдэг байна. Чинбат зайрангийн өөрийнх нь ярьснаар энэхүү мартагдсан зан үйлийг зөвхөн онгодоосоо асууж, онгодтойгоо харьцаж байж гүйцэтгэсэн байна. Зарим үед онгод нь хатуурхаж догшроод, онгоддоо алгадуулах явдал ч гардаг байна. гэвч энэ бүхэнтэй өөрөө л ноцолдож байж номхруулж авдаг гэнэ.

Энэ яриаг 2000 оны 3 дугаарын сарын 24-нд Хөвсгөл аймгийн Ринчэнлхүмбэ сумын 1 дүгээр багийн нутаг Намнантогосын ам хэмээх газар Намдагийн Баасанжавынд сонсож тэмдэглэв.

1999 оны 8 дугаар сарын 3-8 нд бөө судлалын V хурлын үеэр Бумбатын амны тахилгад бөөлсөн Сэтэр буцаах зан үйлийн дуудлага, тамлагыг дор сийрүүлэв.

Шөөг[3]
Бүргэдэйн дэвлэг минь та хоё
Хоёр хэрээ мэтээ чөөтөгөн та хоё
Хар л могойн гончиролдохуйн та хоё
Шөөг[3]
Эр л биенээ минь эздүүт та хоё
Эрдэнэ түмэн онгодууд минь та хоё
Хэргэлэг болж л ирэвтээ та хоё
Дайрлага болж л дайравтай та хоё
Тойрон тойрон луснаастаа та хоё
Төгөл төгөл модноостаан та хоё
Хальстай манхан түшлэг минь та хоё
Халиан урсгал буултал та хоё
Дархадээн цэнхэр хөрвөөлэг минь та хоё
Далайн цэнхэр түрлэг минь та хоё
Толио болгон л хоймортонгууд минь та хоё
Хар л могойн хэнгэрэгтэнгүүд минь та хоё
Харлоо
Алсээн газар залравтаа та хоё
Хар л биеэ минь манавтаа та хоё
Хойт л тайгээ л нутгаас нь та хоё
Эрдэнийн есөн мэсээ та хоё
Эрчилүүлэн шаагиулж л суунав даа та хоё
Алтан нарнаа минь цацрагаар нь та хоё
Алд л биеэ минь манана даа хоё
Мөнгөн сарнаа минь гэрэл нь дээ хоё
Зөрөө санаатанг нь зөвтгөвтээ та хоё
Буруу санаатанг нь буцаавтаа та хоё
Шөөг[3]
Хех л хөтөл хамжлага минь та хоё
Халзан согоон гутал минь дээ хоё
Буцах л буулт минь боллоо доо хоё
Эр л биенээ минь эздүүт та хоё
Эрдэнэ түмэн л онгодууд минь та хоё
Эзэн нялхасан тэнгэрүүд минь дээ хоё
Эргэлэг болж л манаарай даа хоё
Дайрлага болж л дайраарай даа хоё
Зам л жим л хоёры минь та хоё
Засалтай сайн л хийлээ дээ хоё
Бурууг нь буцааж л, зөвийг нь зөвтгөлөө хоё

МУСӨТ-ийн фондод авсан бичлэгийн товч лавлагаа

Хальс №	Зураглаач	Хугацаа	Бичлэгийн товч утга
Аудио DAT №002	С.Юндэнбат	60 минут	1999 оны 8 дугаар сарын 3-8нд Олон улсын бөө судлалын V хурлын үеэр Богд уулын зүүн тал дахь Бумбатын амны тахилгад бөөлсөн Сэтэр буцаах зан үйл
SONY BETACAM хальс Time kod:	Г.Жамсран		

Судалгаа гаргасан ажилтны овог нэр, албан тушаал

Гарын үсэг

Бүртгэл мэдээллийн санд хүлээн авсан

Гарын үсэг

(Тамга)

он сар өдөр

МОНГОЛ НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

Манай улс түүх, соёлын үл хөдлөх дурсгалаар нэн арвин бөгөөд эдгээр нь бидний өвөг дээдсийн Төв Азийн элгэнд үүсгэн хөгжүүлсэн нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц шинжийг агуулсаар иржээ. Энэхүү дурсгалууд нь түүхэн тодорхой цаг үед аж төрж байсан нүүдэлч ард түмний амьдралын хэв шинж, нийгмийн зохион байгуулалт, оюуны болон эдийн соёлын онцлог зэрэг түүх, соёлын олон мэдээллийг бидний үед тээсээр ирсэн байдаг. Монгол улсын нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг нээж бүртгэх, судалгааны эргэлтэнд оруулах ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж байгаа боловч тэр бүр бүх дурсгалаа хамарч чадахгүй байна.

Сүүлийн үед түүх, соёлын эд зүйлсээр ашиг ологч зарим нэг хүмүүс хөдөө орон нутагт хүний нүдэнд ил, далд хөшөө дурсгал, булш хиригсүүр, эртний хотын туурь, хадны зураг зэргийн түүх, соёлын ач холбогдлыг нь алдагдуулах зохисгүй үйлдэл нэлээд газар авч байгаатай холбоотойгоор хэдхэн жилийн өмнө бүрэн бүтэн байсан дурсгал устаж үгүй болсон жишээ олон байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах, нийтэд суралчилахад чухал үүрэг гүйцэтгэдэг музейн ажилтан албан хаагчид хөдөө орон нутагт байх үл хөдлөх дурсгалтай ойр дөт байдгийг түшиглэн интернетээр мэдээлэл авах өргөн боломж бидэнд байгаа билээ. Иймд бид музейн ажилтнууд та бүхэнд түүх соёлын үл хөдлөх дурсгалыг таньж мэдэх бүртгэн баримтжуулахад шаардагдах мэдээллийг хүргэж байна.

Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг ерөнхийд нь:

1. ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕИЙН ДУРСГАЛ
    1. Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар
    2. Эртний хүмүүсийн оромж, сууц, агуй
2. ХАДНЫ ЗУРАГ, БИЧГИЙН ДУРСГАЛ
    1. Хадны сийлмэл зураг
    2. Зос, бэхэн зураг
    3. Тамга, бичгийн дурсгал
3. ОРШУУЛГА, ТАХИЛ ТАЙЛГЫН БАЙГУУЛАМЖ
    1. Булш, оршуулга
    2. Тахил тайллагын байгууламж
    3. Хиргисүүр
    4. Овоо
4. БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛ
    1. Эртний хот, шивээ, хэрмийн үлдэгдэл
    2. Тахилын сүм
    3. Суврага, сүм хийд, түүний үлдэгдэл
    4. Барилга, байшин
5. ХӨШӨӨ ДУРСГАЛ
    1. Буган хөшөө
    2. Хүн хөшөө
    3. Бичигт хөшөө
    4. Амьтны дүрст чулуун дурсгал
6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УЛ МӨР БҮХИЙ ДУРСГАЛТ ГАЗАР
    1. Төмөрлөг олзворлож, боловсруулж байсан газар
    2. Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар
    3. Газар тариалан эрхэлж байсан газар……. гэж ангилан авч үзэж болно.

ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕИЙН ДУРСГАЛ

Манай улсын Баянхонгор аймгийн Баянлиг сумын Лигийн Цагаан агуйд археологийн судалгаа хийсэн гадаад дотоодын эрдэмтэн судлаачид эртний хүмүүсийн үлдээсэн 13 үе соёлт давхрагыг нээн илрүүлж манай оронд эртний хүн нутаглан аж төрж байсан цаг хугацааг 750 гаруй мянган жилийн тэртээ болохыг тогтоожээ. Энэ нь хуучин чулуун зэвгийн /палеолит/ доод үед хамаарах ажээ.

Эртний хүмүүсийн тодорхой бүс нутагт аж төрж байсан цаг хугацааг шинжлэх ухааны ололтоор нарийн тогтоох боломж хомс байдаг учир тэдгээрийн хэрэглэж байсан зэр зэвсгийн онцлог, газрын хөрсөнд үлдсэн ул мөр зэргээр тоймлон авч үздэг. Судлаачид чулуун зэвсгийн үеийг палеолит /хуучин чулуун зэвсэг/, мезолит /дунд чулуун зэвсэг/, неолит /шинэ чулуун зэвсэг/ гэж гурван хэсэг болгон авч үзээд палеолитын үеийг доод, дунд, дээд хэмээн гурав хуваадаг байна. Эдгээр үеүдийг холбогдох он цагаар нь харуулбал:

Хуучин чулуун зэвсгийн үе /палеолит/ 800000-12000 жил

Доод үе 800000 – 100000 жил
Дунд үе 100000 – 40000 жил
Дээд үе 40000 – 12000 жил

Дунд чулуун зэвсгийн үе /мезолит/ 12000 – 6000 жил
Шинэ чулуун зэвсгийн үе /неолит/ 6000 - 3000 жил

Чулуун зэвсгийн үеийг ийнхүү зааглах болсон гол шалтгаан нь байгаль, цаг уурын хэт хүйтрэлтийн нөлөөллөөс болсон ба энэ үед хүмүүс өмнө нь агнаж хоол хүнсэндээ хэрэглэж байсан болхи бүдүүлэг хөдөлгөөнт амьтад нь үгүй болж хурдан хөлтэй амьтад нь үлдсэн, нөгөөтэйгүүр түүвэрлэн олж иддэг байсан жимс жимсгэнэ нь байхгүй болсон зэргээс шалтгаалан хөдөлмөрийн багаж зэвсгийнхээ хийх арга барил, хэмжээ, хэлбэрт өөрчлөлт оруулж улам боловсронгуй болгодог байжээ. Хэдийгээр энэ нь багаж зэвсгийн өөрчлөлт боловч хүмүүсийн оюун ухаан хэрхэн яаж хөгжиж байсныг гэрчлэх баримт болдог байна.

1. **<u>Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар:</u>**

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн аж төрж байсныг гэрчлэх чулуун зэвсэг, түүнийг хийх явцад үлдсэн чулууны үлдэгдэл, хоол хүнсний үлдэгдэл болон бусад хүмүүсийн хэрэглэж байсан эд зүйлсийн ул мөр бүхий олдвортой /соёлт давхрага бүхий/ дурсгалт газрыг хамруулдаг. Чулуун зэвсгийн бууц суурин, дархны газар байх газар нутаг нь ихэвчлэн уул нуруудын ам, энгэр ээвэр газар болон чулуун зэвсэг хийхэд тохиромжтой чулуулгийн баялаг илэрц бүхий газар нутгаар тохиолддог байна. Энэ нь хүмүүсийн цаг агаарын тааламжтай цаг хугацаанд тодорхой бүс нутагт суурьшин аж төрөхдөө тухайн газрын чулуулгийг ашиглан чулуун зэвсэг үйлдэж ахуй амьдралдаа хэрэглэхээс гадна үр жимс, ан гөрөө, зэрэг байгалийн баялгийг хүртэж байсантай холбоотой юм. Зарим тохиолдолд ялангуяа хад асганы нөмөр, агуйн хонгил зэрэгт хүний хөгжлийн хэд хэдэн үед холбогдох үе давхрага бүхий ул мөр илэрч мэддэгддэг.

Чулуун зэвсгийн бууц суурингаас элдэв төрлийн чулуун зэвсэг, үр тарианы үлдэгдэл, мал амьтны яс, гал түлж байсан ор мөр зэрэг илэрч олддог бол дархны газраас чулуун зэвсэг хийх явцад үлдэж хоцорсон үлдцүүд ихээр олддог байна. Энэ төрлийн дурсгалт газраас олддог чулуун зэвсэг түүний үлдэгдлүүд нь хэдэн аваас хэдэн мянган ширхэг тоотойгоор илэрч мэдэгддэг ажээ.

Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар нь хамрах газар нутгийн хувьд хэдхэн метр талбайгаас хэдэн арван км өргөн дэлгэр газар нутгийг хамрах нь ч бий.

2. **<u>Хүмүүсийн сууж байсан оромж, сууц, агуй:</u>**

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн орогнож байсныг гэрчлэх олдвор бүхий дурсгалт агуй, нүхэн сууц зэргийг хамруулна. Чулуун зэвсгийн үеийн хүмүүс байгаль цаг уурын тааламжгүй нөлөө, болон араатан амьтдын дайралтаас биеэ хамгаалах зорилгоор хадны агуй, нөмөр нөөлөг бүхий байгалийн тогтоц бүхий газарт орж хорогддог байжээ. Энэ нь эртний хүмүүсийн оюун ухаан хөгжихийн хэрээр амьдралын нэг салшгүй хэсэг болж улмаар орон сууц үүсэхийн үндэс болсон ажээ. Байгалийн элдэв тогтоц бүхий газар хүмүүсийн хоргодон аж төрөх явдал чулуун зэвсгийн үеэр хязгаарлагдаж байсангүй. Хожмын соёлт хүн төрөлхтний элдэв шалтгаанаар тодорхой хугацаанд ийм газар оршин сууж байсан олон арван жишээг бид мэднэ. Энэ бүхэн нь бидний түүхийн нэгэн хэсэг болохынхоо хувьд анхааралгүй үлдээж үл болох дурсгалт газар болдог билээ.

Эртний хүмүүсийн болон хожуу үеийн хүний оршин сууж байсан хадны агуй хонгил, нүхэн сууц зэргийн орших байх газар нутаг нь байгалийн тогтцыг дагахаас гадна тухайн бүс нутгийн ан амьтан, үр жимсний бүрэлдэхүүн, усны хангамж, аюулгүй орчин зэрэг хүний хэрэгцээний бүх зүйлсийг харгалзан үзэж сонгосон байдаг. Хожуу үед хүмүүсийн оршин сууж байсан хадны агуй хонгилтой холбоотой олон арван үлгэр, домог, хууч яриа, хөдөө орон нутгаар элбэг байдаг бөгөөд энэ нь шашин мөргөлийн зан үйл, эрдэм чадалтай бөө, лам нарын намтар цадигтай холбоотой байх нь элбэг байдаг.

ХАДНЫ ЗУРАГ, БИЧГИЙН ДУРСГАЛ

1. <u>Хадны сийлмэл зураг:</u>

Байгалийн тогтоцоороо байгаа хад чулууны тольгор гадаргуу дээр хүн, мал, амьтан болон бусад дүрс зургийг сийлж зурсан бүх төрлийн хадны сийлмэл зургууд хамаарна. Энэ төрлийн дурсгал нь манай орны бараг бүх нутгаас олон тоогоор илэрч мэдэгддэг төдийгүй Евразийн улс орнуудаар ч тархсан тодорхой бүс нутгаар хязгаарлагддаггүй дурсгал юм. Хадны сийлмэл зураг нь зохиомж, сийлсэн арга барил зэрэг шинжүүдээсээ хамаарч өөр өөр цаг хугацаанд бүтээгдсэн байдаг. Манай орны нутаг дэвсгэр дээр энэ төрлийн дурсгалыг судалсан эрдэмтэд сийлмэл зургийн хамгийн эртний дурсгалыг палеолитийн дээд үед холбогдуулан авч үздэг.

Хадны сийлмэл зурагт янгир ямаа, аргаль угалз, буга, адуу, үхэр, тэмээ, чоно, нохой, гахай, бар, могой зэрэг араатан амьтад дүрслэхээс гадна мал адгуулж байгаа хүн, ан агнаж байгаа хүн, хоорондоо дайтаж байгаа хүмүүс, морь тэмээнд тэрэг хөсөг хэрэглэж буй хүн зэрэг хосолмол зургуудыг бодитоор болон загварчилсан санаа оруулан дүрсэлсэн байдаг. Эдгээр зургуудын ойр орчинд элдэв төрлийн тамга тэмдэг, учир нь үл ойлгогдох дүрс, үсэг бичиг сийлж үлдээсэн нь олонтаа тохиолддог. Хадны сийлмэл зургийг бүтээсэн хүмүүс тухайн зурагтаа дүрслэх амьтдынхаа бүх биеийг цоолборлож

дүрслэхээс гадна амьтны биеийн гадаад тигээр хөвөөлөн цохиж дүрсэлсэн байдаг ба энэ хоёр аргыг хослуулан бүтээсэн зураг ч цөөнгүй байдаг.

Манай оронд илэрч мэдэгдээд байгаа хадны сийлмэл зургууд нь агуйн хана туурга, томоохон уул нуруудад байх хад чулууны тольгор гадаргуу, голын хавцал дагасан хад чулуу, багавтар уул толгодын ургаа хад зэрэг газар ихэвчлэн тохиолддог. Гэхдээ дээр дурдсан хад чулууны сийлмэл зургууд нь ихэвчлэн нөмөр нөөлөг, нар дагасан энгэр газраар харьцангуй илүү байдаг.

Хадны сийлмэл зургуудыг дан ганц эрт үед бүтээгдсэн байдаг гэж ойлгож болохгүй. Дундад зууны үе болон Манжийн дарангуйллын үед зарим урлаачид хад чулуунаа элдэв зураг зурж үлдээсэн баримт нэлээд бий.

2. Зос, бэхэн зураг:

Байгалийн тогтоцоороо байгаа хад чулууны тольгор гадаргуу дээр хүн, мал, амьтан болон бусад зургийг тусгай найрлага бүхий зос, бэх, шороон будаг ашиглан зурсан бүх төрлийн хадны зургууд хамаарна. Манай оронд байгаа хадны зосон зургийг судалсан эрдэмтэд энэ дурсгалын үүслийг одоогоос хорь гаруй мянган жилийн тэртээ холбогдуулан үздэг. Зосоор зурсан зургийн зохиомж, зурсан арга барил, зурсан зос, зэргийн ялгаанаас хамаарч бүтээгдсэн он цагийн хувьд харилцан адилгүй байдаг ба энэ нь эртний хүмүүсийн оюун санааныг хөгжил ямар түвшинд байсныг харуулах баримт болдог ажээ. Харин бэхээр зурсан зураг нь ихэвчлэн харьцангуй хожуу буюу дундад зууны үед холбогддог байна.

Манай оронд илэрч мэдэгдсэн зосон зурсан зураг нь сийлмэл зургийн нэгэн адил агуйн хана туурга, томоохон уул нуруудад байх хад чулууны тольгор гадаргуу, голын хавцал дагасан хад чулуу, багавтар уул толгодын ургаа хад зэрэг газар ихэвчлэн тохиолддог бөгөөд цөөн хэдээс эхлээд хэдэн зуу мянгаар тоологдох дүрслэлтэй байдаг. Зосон зураг бүхий дурсгалт газар нь дүрслэгдсэн мал амьтныхаа тооноос хамаарч хэдэн зуун метр хүртэлх талбайг хамарах нь байдаг бол бэхээр зурсан зураг нь тооны хувьд цөөн дүрслэлтэй эзлэх талбайн хувьд харьцангуй бага талбайг эзэлдэг.

Улаан зос ашиглаж янгир, ямаа, буга, тэмээн хяруул, арслан заан, адуу, үхэр, тэмээ, шувуу, мал амьтан адгуулж байгаа хүн, ан агнуур хийж байгаа хүмүүс, тариан талбайд /зарим судлаачид энэ зургуудийн оршуулгын газар гэдэг/ ажиллаж байгаа хүмүүс, зэргийг зурсан байх бөгөөд мал амьтны биеийн гадаад хэлбэр, онцлогийг харуулахын тулд хөвөөлөн зурахаас гадна бүх биеийг нь нэлэнхүйд нь будаж дүрслэх 2 аргыг хослуулан хэрэглэсэн байдаг. Харин бэх ашиглаж зурсан зургууд нь тухайн дүрсэлж буй зургийнхаа утга агуулгад нийцүүлэн хөвөөлөн зурахаас гадна бүх биеэр нь өнгө ялган зурсан тохиолдол ч байдаг. Өнгө ялган зурсан зураг нь харьцангуй сүүлийн үед бүтээгдсэн байхаас гадна монголд 16-р зуунд нэвтэрсэн шарын шашны бурханы урлалтай нягт холбоотой байдаг.

3. Тамга, бичгийн дурсгал:

Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны тольгор гадаргуу дээр овгийн тамга, болон тодорхой үсэг бичгийг ашиглан зос, бэх болон сийлбэрлэн гаргасан бүх төрлийн тамга тэмдгийн дурсгалыг хамааруулна. Тамга тэмдгийн бүтээгдсэн он цагийг нарийн тогтоох боломж хомс байдаг ч овгийн байгуулал задарч хувийн өмч үүссэн үед бий болсон гэж ихэнх эрдэмтэд үздэг ажээ. Харин бичиг үсгийн хувьд эртний монголчуудын бичиг үсэг үүсгэн хэрэглэж байсан үүх түүхтэй холбоотой байдаг учир бичигдсэн он цагийг тогтооход элдэв бэрхшээл учрах нь бага байдаг ажээ.

Монгол нутгаар ганц нэгээр болон хэдэн арав, зуугаар тохиолдох тамга тэмдгүүд нь ихэвчлэн хад чулууны тольгор гадаргуу дээр, тал хээр тохиолдох ургаа чулуун дээр, зарим багавтар толгодын хад чулуун дээр, хавцлын ханан дээр, агуйн хана туурга дээр сийлэгдэж, зурагдсан байдаг бөгөөд дүрслэлийн хувьд геометрийн үндсэн дүрс болох дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүд түүнийг баяжуулсан олон хэлбэр дүрс байхаас гадна хожмын монголчуудын дунд үлдсэн малын тамгатай ижилсэх тамга, дүрсүүд цөөнгүй байдаг.

Хад чулуун дээрх бичиг үсгийн дурсгал нь сийлэх ба бэхээр бичих гэсэн хоёр аргаар үйлдэгдсэн байдаг байна.

Монголчууд бичиг үсэг хэрэглэж хад чулууны тольгор гадаргуу зэрэг бичиг үлдээж болох хад чулуунаа түүхэн хэрэг явдлын тухай болон элдвийн ерөөл үгс сийлсэн байх нь олонтаа тохиолдоно. Ийм бичээсүүдийг монгол бичиг, дөрвөлжин үсэг, тод үсэг, соёмбо үсэг, вангарди үсэг зэргээр үйлдсэн байдаг. Мөн монголчуудын зохиосон бичиг үсгээс гадна түүхэн тодорхой үед харилцаж байсан Хятад, Перс, Араб, Төвд, Манж зэрэг улсуудын бичгээр бичсэн бичээсүүд ч олон бий. Ялангуяа Төвд үсгээр бичигдсэн шашны холбогдолтой “Ум ма ни бад ми хум” гэх мэт тарнийн үгтэй бичээсүүд цөөнгүй газарт байдаг.

ОРШУУЛГА, ТАХИЛ ТАЙЛГЫН БАЙГУУЛАМЖ

1. Булш, оршуулга:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаачдаа тусгай зан үйлийн дагуу оршуулж мод, чулуу, шороогоор дарсан / хадны ан цав, агуйг ашиглан талийгаачийг оршуулсан хадны оршуулга мөн хамаарна/ бүх төрлийн булш, оршуулгууд хамаарна. Монгол нутагт анх шинэ чулуун зэвсгийн үед хүмүүс оршуулга үйлдэж эхэлсэн байна. Энэ цаг үеэс хойш монгол нутагт аж төрж байсан эртний нүүдэлчид, Хүннү, Түрэг, Уйгар, Кидан, Монголчууд талийгаачдаа тусгай зан үйлийн дагуу оршуулж байв. Манай оронд байгаа булш, оршуулгууд нь ихэвчлэн уул, толгодын энгэр ээвэр газар, тэгш дэвсэг, гол мөрний ай савaар тохиолддог ба хадны оршуулга нь хад чулуу ихтэй уул нуруудаар байдаг ажээ.

Булш оршуулгууд нь /хадны оршуулгыг эс тооцвол/ гадаад хэлбэр зохион байгуулалтаараа харилцан адилгүй байдаг. Монголын үеийн булш оршуулгуудын хөрсөн дээрх чулуун дараасын хэлбэр зууван дугуй байдаг бол Хүннүгийн жирийн иргэдийн булш голдоо ухагдсан гэмээр ул мөртэй дугуйран хүрээлсэн чулуун дараастай байдаг байна. Түрэгийн булш оршуулгууд нь ихэвчлэн дугуй хэлбэртэй чулуун дараастай, зүүн урд чигт босгосон олон тооны балбал чулуугаараа ялгагддаг байна. Эртний үед холбогдох булш оршуулгууд нь түүхийн тодорхой үед хүмүүсийн гараар хөндөгдөж анхны хэлбэр төрхөө алдан тоногдсон байдаг ажээ.

Зарим булш оршуулга маш том хэмжээтэй байх нь бий. Манай улсад байгаа Хүннүгийн үед холбогдох булш оршуулгийн дурсгалыг жирийн иргэдийн, язгууртны гэж 2 ангилан авч үздэг. Язгууртны булш нь газрын хөрсөн дээр дөрвөлжлөн өрсөн чулуун өрлөгтэй, урд хэсэгтээ трапец хэлбэрийн үүдэвчтэй чулуун өрлөг бүхий том байгууламж байдаг.

Хадны оршуулга нь ихэвчлэн санамсаргүй байдлаар хад чулууны завсар чөлөө, агуй хонгилоос илэрч олддог ба одоогоор манай оронд цөөн тоогоор илэрч олдоод байгаа өвөрмөц дурсгал юм.

2. Тахил тайллагын байгууламж:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаачийнхаа хойд насанд нь зориулж хийж бүтээсэн тахилын байгууламжууд хамаарна. Манай улсын нутаг дэвсгэр дээр холбогдох цаг үеийн хувьд харилцан адилгүй үед бүтээгдсэн тахилын байгууламжууд элбэг тохиолддог. Тахил тайлгын байгууламж нь манай улсын хувьд хүрэл зэвсгийн үеэс эхлэн бүтээгдсэн байдаг ба ихэвчлэн мал амьтны шатаасан болон шатаагаагүй яснууд, зарим төрлийн чулуун зэвсэг, хүрэл төмрөөр хийсэн эдлэл, сав суулганы зүйлс гардаг байна.

Тахилын байгууламж нь оршуулын зан үйлийн нэг хэсэг болох боловч гадаад дотоод зохион байгуулалтаараа булш оршуулгаас ялгаатай байдаг. Гэхдээ үүнийг гаднаас нь хараад нарийн тогтоох боломжгүй бөгөөд археологийн малтлага судалгааны үр дүнгээр баталгаажуулдаг.

Манай орны нутгаар тохиолддог тахил тайлгын байгууламжууд нь булш оршуулгын газрын ойр хавьд уул толгодын энгэр ээвэр газар, ил харагдах тэгш дэвсэг, гол мөрний ай сав зэрэг газраар ганц нэгээрээ болон хоёр гурвaараа зэрэгцсэн байдалтайгаар тохиолддог. Чулууг хэмжээний хувьд харилцан адилгүй дөрвөлжин, дугуй хэлбэрээр суулгаж үйлдсэн байдаг ба том жижиг чулуугаар голын талбайг дарсан байдаг. Тахил тайлгын байгууламжын газрын ил мэдэгдэх хэсгийг харахад голоороо доош хонхойсон хэв шинж бараг ажиглагддаггүй бол булш оршуулганд ийм зүйл ихээр тохиолддог байна.

3. Хиригсүүр:

Эртний хүмүүсийн чулуугаар том хэмжээний чулуун овоолго үйлдэж түүнийхээ гадуур хүрээ татаж олон жижиг дугуй чулуун байгууламж дагалдуулан бүтээсэн бүх төрлийн хиригсүүрийн байгууламжууд хамаарна. Төв Азийн газар нутгаар судалгаа хийсэн археологчид энэхүү дурсгалыг дөрвөлжин булш, буган чулуун хөшөөний нэгэн адилаар томоохон соёлын түвшинд авч үздэг билээ.

Манай улсын нутагт малтан шинжилсэн хиригсүүрийн цөөн хэдээс нь хүний оршуулга бүхий ул мөр илэрсэн бол бусдаас нь мал амьтны шатаасан болон шатаагаагүй яснууд, чулуун зэвсгийн үлдэгдэл, хүрэл товруу, товч, хутга, ваар савны хагархай хэсэг зэрэг эд өлгийн зүйлс илэрч мэдэгдэж байжээ.

Хиригсүүр нь ихэвчлэн нүдэнд үзэгдэх тэгш тал газар, гол мөрний ай сав, уул толгодын оройн дэвсэг газар, энгэр ээвэр газраар байх нь нэн элбэг бөгөөд ганц хоёр, хэдэн арваараа зэрэгцэн /ихэвчлэн айл саахалтын зайтай байдаг/ оршдог байна. Мөн хүрлийн үеийн дөрвөлжин булш, буган чулууны дурсгалуудтай хамт нэг газар орших байх тохиолдол нэлээд бий.

Хиригсүүр нь голдоо олон арван чулуугаар хийсэн том хэмжээний дараас овоолготой, овоолгоо тойрсон чулуун дугуй, дөрвөлжин хүрээтэй, хүрээний гадуур жижгэвтэр олон арван чулуун тахилын байгууламжаас бүрддэг цогцолбор дурсгал юм. Голдуу 2-3 метр диаметртэй багавтар чулуун дараас бүхий тахилын байгууламж нь голын том овоолгын зүүн, зүүн урд талаар байдаг. Эдгээр дагуул байгууламж дагалдсан байдаг.

4. Овоо:

Хүмүүсийн байгаль дэлхийгээ хамгаалах, газар орныхоо хилийн цэсийг тогтоох зэрэгтэй холбоотойгоор чулууг овоолон босгосон бүх төрлийн овоо хамаарна.Овоо нь ихэвчлэн уул толгодын алсаас харагдах оройн хэсэг, булаг шандны эх орчмоор ганц нэгээрээ байдаг ажээ.

Монголчуудын овоо босгох ёс нь тухайн газар нутгийнхаа уул, ус, ургамал амьтдаа хайрлан шүтэх, эрхэмлэн дээдлэх уламжлалтай салшгүй холбоотой байдаг. Мөн бурханы шашны томоохон лам нарын хойд насанд буян үйлдэх сэтгэлээр шавь нар нь овоо босгох тохиолдол цөөнгүй байжээ.

Нөгөөтэйгүүр газар нутгийнхаа хилийн цэсийг тогтоох зорилгоор уул толгодын нуруу дамнуулан овоо босгодог уламжлалтай байв. Энэ нь монголчууд Манж гүрний эрхшээлд орж газар нутгаа хэдэн хэсэг хуваалгасан тэр үеэс эхлэлтэй бөгөөд 1728 онд Орос-Манжийн хил тогтоосон гэрээ ёсоор өнөөгийн монгол улсын хойд хил дагуу ийм овоо босгож байжээ.

Овоо нь хэмжээний хувьд харилцан адилгүй агаад дунджаар 2-10 метрийн диаметртэй байдаг. Зарим тохиолдолд овоог нарийн шургааг модоор босгосон нь бий.

Манай улсын зарим аймгийн нутгаар ойр хавь нь чөлөөтэй харагдах уулын өндөр орой дээр хавтгай чулууг өрж босгосон өндөр овоо цөөнгүй тааралддаг.

БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛ

1. Эртний хот, шивээ, хэрмийн үлдэгдэл:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн оршин сууж байсан болон, цэргийн бэхлэлт болгон барьж байгуулсан барилга байшин, хэрмийн үлдэгдэл хамаарна.

Манай орны нутагт оршин аж төрж байсан эртний нүүдэлчин ард түмнүүд тодорхой цаг хугацаанд нэг газарт төвлөрөн суухдаа хот хэрэм байгуулан сууж байсан нь хөдөө орон нутгаар дайралдах хэмжээний хувьд харилцан адилгүй олон тооны эртний хотын үлдэгдлүүд гэрчилнэ. Эдгээр хот суурины үлдэгдлийн хамгийн эртнийх нь Хүннүгийн үед хамаардаг бөгөөд түүнээс хойш Түрэг, Уйгар, Кидан, Их Монгол улсуудын үед тасралтгүй баригдаж иржээ.

Манай улсын нутагт байгаа олон тооны хот хэрмийн үлдэгдлүүд нь эртний суурин соёл иргэншилт ард түмнүүдийн нөлөө ихээхэн туссан байдаг. Эртний хот хэрмийн үлдэгдлүүд нь хамрах газар нутгийн хувьд харилцан адилгүй байх бөгөөд нэг хоёр зуун метрээс хэдэн зуун метр байх нь олонтаа тохиолддог. Багахан хэмжээтэй хот хэрмийн үлдэгдэл нь ихэвчлэн эртний шинжтэй байдаг ба өндөр хэрэмтэй, эзлэх талбайн хувьд том хот нь харьцангүй хожуу үед холбогддог байна.

Эртний хот хэрмийн үлдэгдлүүд нь тодорхой цаг үед баригдаад дайн байлдааны улмаас сүйтгэгдэх устаж үгүй болох явдал цөөнгүй байсан ба түүнийг нь хожуу үед сэргээн засварлаж дахин ашиглаж байсан ул мөр манай орны нутгаас цөөнгүй олдсон байна.

Эртний хот суурины үлдэгдлүүдийн зарим нь газрын хөрсөн дээр анх барьсан байдлаа бага зэрэг алдсан ч бараг бүтнээрээ хадгалан үлдсэн байдаг бол зарим нь дөрвөлжин хүрээлсэн багахан дов төдийгөөр үлдсэн байдаг.

Төв Азийн нүүдэлчид хот байгуулахдаа юун түрүүнд хэрэм барьж хэрмийнхээ гадуур ус татах суваг шуудуу ухдаг байжээ. Хэрмийнхээ дотор гудамж гарган хоёр талаар нь байшин барилга барьдаг байв. Энэ зохион байгуулалт нь манай орны нутагт байгаа эртний хот хэрмийн ерөнхий дүр зураг юм.

Манай орны нутагт байгаа эртний хот хэрмийн үлдэгдлийг малтан шинжилэхэд барилгын тоосго, дээврийн нөмрөг, тосгуур, нүүр ваарны үлдэгдлүүд, барилгын гоёл чимэглэлийн материалууд зэрэг олон тооны барилгын хэрэглэгдэхүүн, элдэв төрлийн ваар сав суулга, хазаарын амгай, дөрөө, тэрэгний төмөр цөн, зоос зэрэг ахуйн хэрэглээний эд зүйлс, нумын наалт, сумны зэв, хутга сэлэмний хэсэг, жадны гилбэр зэрэг байлдааны багаж зэвсгийн үлдэгдэл ихээр олддог байна.

2. Тахилын сүм:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаачийн хойт насанд зориулан тодорхой цаг хугацааны давтамжтайгаар тахил тайлга хийх газар болгон барьж байгуулсан тахилын сүмүүд хамаарна. Манай улсын нутагт энэ төрлийн дурсгал төдийлөн олон биш боловч археологийн малтлага судалгааны явцад тахилга хийхээр зориуд барьж байгуулсан тахилын сүмүүд илэрч мэдэгддэг. Эдгээр дурсгалууд нь хүний нүдэнд танигдахаар хадгалагдаж үлдээгүй, ихэвчлэн нуранги байдалтай байдаг нь таньж мэдэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг. Манай улсад төр улсаа тогтоон аж тарж байсан Түрэг үндэстнүүд нэр цуутай хүмүүсийнхээ хойт насанд зориулан тахилга үйлддэг тахилын сүмүүдийг барьж байгуулан үлдээсний хамгийн алдартай нь өнөөгийн Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө Цайдам дахь Билгэ хааны тахилын сүм болно.

Тахилын сүмийн үлдэгдлээс тахилга үйлдэж байсан мал амьтны яс, гоёл чимэглэлийн эд зүйлс тэргүүтэн олдохоос гадна сүмийг барихад хэрэглэж байсан барилгын элдэв хэрэглэгдэхүүн олддог. Түрэгийн тахилын сүмүүдээс жишээ татан харахад энэ төрлийн дурсгал нь ганц дан тахилын сүм биш бүхэллэг цогцолбор дурсгал байдаг. Тахилын сүмийн гадуур шороо дагтаршуулан далан байгуулж түүнийхээ гадуур ус татах шуудуу ухаж гэрэлт хөшөө, хонины дүрс гарган урласан чулуун дурсгал, хүн хөшөө, балбал чулуу зэргээс бүрдэх энэ төрлийн дурсгал нь ихэвчлэн Түрэгийн үед хамаардаг байна. Гэхдээ тахилын сүмийн дурсгалууд Түрэгийн үед хамаарахаас гадна Хүннү, Уйгар, Кидан зэрэг эртний улсуудын үед холбогдох нь ч бий.

3. Суварга, сүм хийд, түүний үлдэгдэл:

Түүхэн тодорхой цаг үед шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан болон мөргөл, хүндэтгэлийн үүргийг гүйцэтгэж байгаад хожим нь эвдэрч сүйдсэн, эргэж сэргээн засварлагдсан томоохон суварга, сүм хийд, түүний туурь үлдэгдлүүд хамаарна. Сүм хийд, суварга нь монголчуудын сүсэг бишрэлийн илэрхийллийн томоохон жишээ болохынхоо хувьд оюуны болон эдийн соёлын үнэт дурсгал болдог. Манай улсад бурханы шашин дэлгэрсэн үеэс хойш хөдөө орон нутагт олон тооны сүм хийд барьж байгуулан хурал номын үйл ажиллагаа явуулж байсан ба сүм хийдийг даган хүмүүсийн төвлөрөл бий болж байв. Манай орны нутагт 1930-аад оны сүүлийн их хэлмэгдүүлэлтээс өмнө 1000 гаруй сүм хийд хурал номын үйл ажиллагаа явуулж байсан гэсэн албан бус тоо баримт байдаг. Гэвч эдгээр сүм хийд, томоохон суваргыг 1937-1940 оны хооронд зориудаар эвдэн сүйтгэж үгүй хийсэн бөгөөд цөөхөн хэдэн тооны сүм хийдийг зориулалтыг нь өөрчлөн ашиглахаар авч үлдсэн байдаг.

Манай орны нутагт байгаа сүм хийд, суврагын үлдэгдэл нь дан ганц бурхны шашны дэлгэрсэн үеэс хойш байдаггүй бөгөөд эртний Киданчууд болон дундад эртний монголчууд томоохон хот дотроо сүм хийд барьж байгуулж байсныг олон жишээнээс харж болно. Тухайлбал Их Монгол улсын нийслэл Хархорум хотын үлдэгдлээс томоохон сүмийн туурь олдсон, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дахь “Барс хот” хэмээгдэх Киданы хотын үлдэгдэл дэх 7 давхар суварга гэх мэтийн дурсгалаас харж болно.

Хөдөө орон нутагт байгаа сүм хийд, суваргын үлдэгдлүүдээс элдэвийн барилгын шавар болон модон материалууд, шавар бурхадын үлдэгдлүүд, ахуйн хэрэглээний сав суулга зэрэг зүйлс олдог байна.

Мөн ийм дурсгалт газруудад аж төрөх хүмүүс тухайн дурсгалтай холбоотой маш олон тооны хууч яриа, домог ярилцдаг.

4**. Барилга, байшин:** Түүхэн тодорхой цаг үед баригдаж хот байгуулалт, уран барилгын түүхийн аль нэг хэсгийг төлөөлж чадах болон түүхэн үйл хэргийн бодит дурсгал болж үлдсэн, нэрт хүмүүсийн ажиллаж амьдарч байсан бүх төрлийн барилга байшин, орон сууцны барилга хамаарна. Өнөөдөр дэлхий нийтэд барилга байшингийн түүхэн тодорхой үнэ цэнийг харгалзан үзэхээс гадна ерөнхийдөө 100 гаруй жилийн настай барилга байшинг түүх, соёлын дурсгалд хамааруулан хадгалж хамгаалдаг. Манай улсад уран барилгын дурсгал бусад суурин иргэншилт улс түмнүүдийг бодвол харьцангуй цөөхөн боловч XX зууны эхэн үеийн түүхэнд холбогдол бүхий, байшин барилга өнөөгийн Улаанбаатар, Сэлэнгэ, Улиастай, Ховд зэрэг хотуудад цөөнгүй үлдэн өнөөг хүрчээ. Эдгээр байшин барилгуудын ихэнх хэсэг нь манай оронд суурьшсан гадны иргэдийн хөрөнгөөр баригдсан байх нь олонтаа тохиолддог. Эдгээр дурсгалыг модоор бүтээгдэж шавраар өнгөлсөн байдаг тул цаг хугацааны эрхээр эвдэрч муудах нь их.

Манай улсын нутагт байгаа түүхэн үйл хэрэг, нэрт хүмүүсийн амьдралтай холбоотой барилга байшигууд нь тухайн цаг үеийнхээ барилга байшингийн нийтлэг хэв шинжийг илэрхийлэхээс гадна гадаад улс орны барилга байшингийн загварын нөлөөг ихээхэн тусгасан байдаг.

ХӨШӨӨ ДУРСГАЛ

1. Булган хөшөө:

Буган чулуун хөшөөг судалсан судлаачид уг дурсгалыг бугыг загварчилсан байдлаар дүрсэлсэн, амьтны бодит байдлаар дүрсэлсэн, амьтны дүрслэлгүй гэж ерөнхийд нь 3 ангилан авч үздэг байна. Эхний төрөлд хамаарах буган хөшөөдийн ихэнх нь Монгол болон Өвөрбайгалийн нутгаар байдаг бөгөөд бугыг дээш дүүлж байгаар загварчлан дүрсэлж сийлсэн байдаг бол 2 дахь төрөлд хамаарах хөшөөдийн гадаргуу дээр адуу, зээр, гахай, шувуу зэрэг амьтдыг бодит байдлаар дүрслэн сийлсэн байдаг ажээ. Харин 3 дахь төрлийн хөшөөд нь гадаргуу дээрээ ямар нэг амьтны дүрс байхгүй ч буган чулуун хөшөөний нийтлэг дүрслэл болох нар сар, бүс, зэр зэвсгийг сийлсэн байдаг байна. Бугыг бодит байдлаар дүрсэлсэн болон дүрслэлгүй хөшөөд нь манай улсын нутаг дэвсгэрт цөөн тоотоойгоор тохиолддог байна.

Уг дурсгалын гадаргуу дээр дүрсэлсэн нар, зарим бүсний дүрсийг ихэвчлэн хүрээлэн сийлсэн байдаг бол толь, кинжаал хутга, буга болон амьтны дүрсийг бүх биеийн хэсгээр нь цохин дүрсэлсэн байдаг.

Буган чулуун хөшөөг хэд хэдээр нь нэг дор босгосон байх ба дөрвөлжин булш, /зарим тохиолдолд буган хөшөөг булшны нүхэнд хана болгон хэрэглэсэн байдаг/ хиригсүүр, зэрэг хүрэл зэвсгийн үеийн томоохон соёлууд зэрэгцэн оршсон цогцолбор дурсгал бүхий газар манай оронд цөөнгүй тохиолддог.

2. Хүн хөшөө:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн байгалийн чулууг засч янзлан хүний биеийн төрх гарган сийлсэн бүх төрлийн хөшөө дурсгал хамаарна.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгаа хүн чулуун хөшөөдийг бүтээгдсэн он цаг, дүрслэл, онцлогоор нь Түрэгийн болон Монголын хүн хөшөөд гэж ялгаж авч үздэг. Түрэгийн хүн чулуун хөшөөд нь манай орны төвийн болон баруун аймгийн нутгаар элбэг тохиолддог бол монголын хүн чулуун хөшөөд нь ихэвчлэн зүүн бүсийн аймгуудын нутгаар тохиолддог. Хүн чулуун хөшөөдөд хүний биеийн ерөнхий хэлбэрийг гаргасан нийтлэг шинжтэй байдаг боловч тухайн хөшөөг хийж бүтээсэн ард түмний ур хийц, дүрслэлийн онцлог шинжүүдээрээ ялгаатай байдаг.

Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө: Түрэгийн хүн хөшөөдөд хүний нүүрийн хэсгийг хавтгайдуу гарган нүд хамар амыг мэдэгдэхүйцээр сийлж эрэгтэй хүнийг илтгэх сахлыг дүрсэлсэн байдаг. Баруун гартаа аяга, сав барин энгэртээ авч, зүүн гараараа бүснээс зүүсэн хутга, сэлэмний ишнээс барьсан байдалтай дүрсэлсэн байдаг. Мөн дээлийн энгэрийг ихэвчлэн буруу зөрүүлж дүрсэлсэн байхаас гадна товруун чимэг бүхий бүснээс хавтага, билүү зэргийн зүйлсийг унжуулсан байдалтайгаар дүрсэлсэн байдаг. Эдгээр нь Түрэгийн хөшөөдийн нийтлэг шинж юм.

Энэ хөшөөд нь хөдөө орон нутагт ганц хоёроор тохиолдохоос гадна томоохон тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд орсон байдалтайгаар тохиолддог байна. Зарим тохиолдолд Түрэгийн үеийн булш, тахил тайлгын байгууламжийн зүүн урд эгнүүлэн босгосон зэл чулуунд ч тааралддаг.

Монголын үеийн хүн чулуун хөшөө: Монголын хүн хөшөөд нь Түрэгийн хүн хөшөөдийг бодвол илүү бодит дүрслэл сайтай урлагдсан байхаас гадна хүнийг түшлэгтэй сандал дээр суулгасан байдлаар дүрсэлсэн байдаг байна. Монголын хүн хөшөөнд хүнийг баруун гартаа аяга, сав барьж энгэртээ аван зүүн гараараа сандлын түшлэгийг тохойлдсон зарим тохиолдолд өвдөг дээрээ тавьсан байдлаар дүрсэлсэн байдаг. Хөшөөнд дүрсэлсэн дээлийг ихэвчлэн зөв энгэртэй байдлаар дүрсэлж нэлээд хэлхэгэр том гэсэн санаа оруулсан дүрсэлсэн байдаг нь Түрэгийн хүн чулуун хөшөөнд дүрсэлсэн хувцаснаас ялгаатай байдаг. Мөн хөшөөнд хүний толгой дээр малгай өмсгөсөн байхаас гадна дээлийн хормойн доод хэсгээр гутлын дүрсийг гаргасан байдаг. Монголын үеийн хүн хөшөөдийн өөр нэг онцлог бол маш уран нарийн аргаар жижиг дүрслэлүүдийг гаргасанд оршино. Жишээлбэл түшлэгтэй сандлыг хийц хэлбэр түүнийг чимэглэсэн хээ угалз, хүний үсний хэлбэр зэргийг гайхалтай нарийн урласан байдаг.

Монголын хүн хөшөөд нь монгол орны зүүн бүс нутагт хүний нүдэнд ил мэдэгдэх газар чулуун овоолго дээр байрладаг. Зарим тохиолдолд ойр орчиндоо ямар нэг дагуул дурсгалгүй ганцаар орших нь ч бий.

Сүүлийн үеийн судалгаагаар дээр өгүүлсэн хоёр төрөл хүн хөшөөний аль нэгэнтэй нь үл ижилсэн өвөрмөц хийцийн хөшөөд монгол нутгаас цөөнгүй олдож байгаа билээ. Судлаачид эдгээр хөшөөдийн хэлбэр хийц, дүрслэгдэхүүн нь Түрэгийн хүн хөшөөдийн дараа үеийн шинжийг агуулсан гэж үзээд Уйгарын үед холбогдуулж байна. Ийм хөшөөд нь ихэвчлэн хоёр гараараа сав барьж цээжиндээ авсан байдалтай дүрслэгдсэн байх бөгөөд элдэвийн зэр зэвсгийн дүрслэлгүй байх ажээ. Мөн хөшөөний толгойд дүрсэлсэн малгай нь Түрэг, Монголын хөшөөдийн алинтай нь ч ижилсэх шинжгүй байна.

Мөн Булган аймгийн Сэлэнгэбүрэн сумын Ингэт толгойн өвөрт байх нэгэн хүн хөшөөг судлаачид Киданы үед холбогдулан үздэг. Энэ хөшөөний гол онцлог нь хувцасны дүрслэлд байх бөгөөд их хэлхэгэр дээлийг өргөн ханцуйтайгаар дүрсэлж, оройн хэсэгт үсийг овоолон боож малгайгаар дарсан байдалтай дүрсэлжээ. Энэ шинж нь Киданчуудын дунд өргөн дэлгэрсэн бомбын шашны хувцас хэрэглэлтэй адил байдаг ажээ.

3. Бичигт хөшөө:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн байгалийн чулууг засч янзлан гадаргуу дээр нь ямар нэг бичиг үсэг хэрэглэн түүхэн хэрэг явдал болон бусад зүйлсийн талаар бичиж үлдээсэн бичвэр бүхий хөшөөд хамаарна. Монгол нутагт эртнээс аж төрж ирсэн нүүдэлч түмний бичгийн соёлыг гэрчлэх олон үсэг бичгээр бичигдсэн гэрэлт хөшөөд олон бий. Эдгээр нь харилцан адилгүй цаг хугацаанд хамрагдах боловч ерөнхий хэлбэр хэмжээгээрээ ижил байдаг.

Манай орны нутагт төр улсаа төвхнүүлэн аж төрж байсан эртний Түрэг улс Орхон-Енисейн бичгийг үүсгэн хэрэглэж түүгээрээ олон түүхэн хэрэг явдлыг хөшөө чулуу босгон сийлж үлдээсэн байдаг. Түрэгийн хөшөө дурсгалууд ихэвчлэн томоохон язгууртны тахил тайлгын байгууламжид хамрагддаг учир тэрхүү язгууртны талаар ихэвчлэн өгүүлсэн байдаг. Эдгээр гэрэлт хөшөөдийн гадаргуу дээр дээр дурдсан Орхон-Енисейн үсгээр бичсэн байхаас гадна тэрхүү бичвэрийг хятад хэлээр орчуулын хятад дүрс үсгээр бичсэн байх нь тохиолддог.

Мөн манай улсын газар нутагт оршин тогтнож байсан Уйгар, Киданчууд бичгийн өндөр соёлтой ард түмэн байсан учир өөрсдийн хэрэглэж байсан үсэг бичгээр цөөнгүй гэрэлт хөшөөдийг үлдээсэн байдаг.

Монголчууд 13-р зуунаас эхлэн өөрсдийн хэрэглэж байсан уйгаржин монгол бичгээр хөшөө чулуунаа түүхэн хэрэг явдлын талаар сийлж үлдээсэн дурсгалууд цөөнгүй байдаг. Зарим хөшөөдийн монгол бичээс нь хятад бичигтэй хамт сийлсэн байдаг.

Гэрэлт хөшөөдийн чулууг дөрвөлжлөн засаж гадаргууг толийлгон бичиг үсгээ бичиж мэлхий чулуугаар суурь хийж суулгахаас гадна газрын хөрсөнд ч зоож суулгасан бий. Мөн чулууг дөрвөлжлөн засч янзлан элдэв хээ угалзаар чимж гэрэлт хөшөөдийг суулгасан тохиолдол ч байх ажээ. Гэрэлт хөшөөд нь хүний нүдэнд ил тал хээр газар босгохоос гадна эртний улсуудын хот хэрмийн орчинд босгосон тохиолдол их бий.

4. Амьтны дүрст чулуун дурсгал:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн амьтан эрхэмлэх зан үйлтэй холбоотойгоор байгалийн чулууг засч янзлан амьтны дүрс гарган урлаж хийсэн чулуун дурсгалууд хамаарна. Манай улсын нутагт энэ төрлийн дурсгал цөөнгүй тохиолддог бөгөөд харилцан адилгүй цаг хугацаанд бүтээгдсэн ч дорнын ард түмнүүдийн эрхэмлэдэг амьтнаа урлах нийтлэг шинжийг агуулсан чулуун арслан, яст мэлхий, хонь зэрэг дурсгалууд байдаг. Гэхдээ эдгээр дурсгалууд нь томоохон цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд бүтээгдсэн байдгаараа онцлогтой.

Чулуун арслангийн хувьд томоохон сүм хийд, хэрмийн хаалганы хоёр талд элдэв муу бүхнээс сэргийлэх гэсэн санааны илэрхийлэл болон байрладаг бол чулуун мэлхий нь урт удаан нас, энх амгаланлангийн илэрхийлэл болон хот суурины орчим бүтээгдсэн байдаг. Чулуун хонь нь ихэвчлэн Түрэгийн үеийн цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд багтдаг.

Чулуун хонь, мэлхий зэрэг дурсгалыг амьдчилан урлаж байсан нь хөдөө орон нутгаар тохиолдох энэ төрлийн дурсгалын гадаад төрх байдлаас харахад илэрхий байдаг. Эдгээр дурсгалыг хөлөө эвхэн хэвтэж толгойгоо өргөсөн байдалтай урласан байдаг бол чулуун арсланг сүр бараа оруулсан загварчилан суугаа байдлаар урладаг байжээ.

Манай орны нутагт байгаа энэ төрлийн дурсгалууд нь үл хөдлөх дурсгалын хүрээнд хамрагддаг боловч зарим тохиолдолд анхны байрлалаасаа зөөгдөх зэргээр түүхэн үнэ ач холбогдлоо алддаг эмзэг дурсгал болно.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УЛ МӨР БҮХИЙ ДУРСГАЛТ ГАЗАР

1. Төмөрлөг олзворлож, боловсруулж байсан газар:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн төмөрлөг олзворлож байсан уурхай болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Төв Азийн өргөн уудам нутаг дээр эдүгээгээс тав гаруй мянган жилийн тэртээ аж төрж байсан хүмүүс хүрлийг гарган авч амьдрал ахуйдаа хэрэглэж эхлэжээ. Эртний хүмүүс хүрлийн агууламжтай хүдрийг уулын салхи ихтэй онги хөтөл дээр овоолон салхин талаас нь илч ихтэй мод, нүүрсны галаар хөөлгөн гарган авдаг байв. Үүнийг монголын түүхэнд “Бух дарах арга” хэмээдэг.

Манай ард түмэн төмөрлөгийн агууламжтай орд газрын таньж мэдэн агуулагдах баялагийнх нь нэрээр нэрлэж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Тухайлбал Эрдэнэт, Оюу толгой, Төмөртэй, Зэст, Оюут, Эрдэнэхайрхан гэх мэт нэртэй газар орноос баялаг агууламжтай орд газрууд илэрдэг.

Өгүүлэн буй дурсгалт газар ихэвчлэн хөрсөн дороо төмөрлөгийн агууламжтай уулархаг газраар тохиолддог байна. Манай орны баруун, төв, өмнөд бүс нутгуудаас ийм төрлийн дурсгалт газар илэрч олдоод байгаагаас дурдвал Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгойн эртний зэсийн уурхай, гэх мэт газруудыг нэрлэж болно.

Төмөрлөг олзворлож байсан эртний уурхайн болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэн ул мөр бүхий дурсгалт газрууд нь ихэвчлэн төмөрлөгийн агууламжтай орд газруудтай давхцан оршдог учир уул, уурхайн зориулалтаар ашиглах газарт орж устгагдах аюултай байдаг.

2. Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар:

Тодорхой түүхэн цаг үед хүмүүсийн шавраар ахуйн хэрэгцээний сав суулга, барилгын хэрэглэгдэхүүн зэрэг эд зүйлс хийж байсан болон хийсэн зүйлсээ шатаан боловсруулж байсан ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Энэ төрлийн дурсгалт газар манай оронд олон биш илэрч мэдэгдээд байгаа боловч бидний өвөг дээдсийн түүх, соёл, аж ахуйн хөгжлийн талаар үнэтэй мэдээлэл агуулсан байдаг билээ.

Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар нь ихэвчлэн шатаах зуух хэлбэрээр илэрч мэдэгддэг ба тэндээс шатаасан болон түүхий барилгын дээврийн тосгуур, нөмрөг, нүүр, ваарuудын үлдэгдэл, тоосго, шавар ваар, сав суулганы хагархай хэсгүүд зэрэг олддог байна. Судлаачид хүрэл зэвсгийн түрүү үеэс буюу одоогоос 5-4 мянган жилийн тэртээгээс шавар сав суулгаа шатааж бэхжүүлэх арга технологийг Төв Азийн нүүдэлчин ард түмнүүд эзэмшсэн хэмээн тэмдэглэсэн байдаг. Шавар бүтээгдэхүүний шаварлагийн найрлага, хэлбэр хийц, бат бөх байдал зэрэг нь тухайн бүтээгдэхүүний цаг хугацааг тодруулах баримт болохоос гадна ямар ард түмний хийж бүтээсэн дурсгал болохыг гэрчлэх баримт болдог байна.

Энэ төрлийн дурсгалт газрууд нь хамрах газар нутгийн хувьд их талбай эзлэдэггүй бөгөөд ихэвчлэн хот хэрмийн ойролцоо, томоохон гол мөрний шаварлаг хөрсийг даган байрладаг. Гэхдээ энэ төрлийн дурсгалт газрууд нь ашиглалтын байдал нь цаг зуурын шинжтэй байх нь их байдаг. Их Монгол улсын нийслэл Хархорум хотын үлдэгдлийг малтан шинжлэх явцад барилгын материал шатааж байсан зуух илэрч олдсон бөгөөд энэ нь байнгын үйл ажиллагаатай байсан байна.

3. Газар тариалан эрхэлж байсан газар:

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн газар хагалж, суваг шуудуу татах зэргээр тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газар нутаг хамаарна. Манай орны газар нутаг дээр эрт цагаас аж төрж ирсэн нүүдэлчин түмэн мал аж ахуй голлон эрхлэхийн зэрэгцээ газар тариаланг томоохон гол мөрний сав дагуух үржил шит бүхий газраар тариалан эрхэлж байсан нь сурвалжийн болон археологийн хэрэглэгдэхүүнээр гэрчлэгддэг. Судлаачид Төв Азийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн үеэс буюу эдүгээгээс тав гаруй мянган жилийн тэртээгээс зээтүүт тариалангийн эх үүсвэр тавигдсан гэж үздэг байна. Гэвч эх газрын эрс тэрс уур амьсгалтай монгол нутагт газар тариалан эрчтэй хөгжиж чадаагүй ажээ.

Хүмүүсийн газар тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газрын хөрс нь тодорхой нэгэн цагт хүний гараар шулуун тууш хэдэн зуун мөр гарган хөндөгдсөн байдаг учир таньж мэдэхэд хялбар байдаг. Зарим тариан талбай руу томоохон гол мөрнөөс суваг шуудуу татаж усжуулсан байдаг. Манай оронд тохиолдож байгаа эртний хүмүүсийн тариа тарьж байсан талбайнууд нь ихэвчлэн Орхон, Сэлэнгэ, Туул, Хэрлэн, Онон, Ховд, Буянт зэрэг томоохон гол мөрний ай саваар байдаг. Гэхдээ эдгээр тариан талбайнууд нь бүгдээрээ нэг цаг үед холбогдохгүй учир хэлбэр хэмжээ, ил мэдэгдэх шинж зэргээрээ харилцан адилгүй байдаг. Жишээлбэл эртний шинж бүхий тариан талбайнууд нь хөрсөн дээрх ихэд баларсан мөрний шинжээрээ танигддаг бол хожуу үед холбогдох хагалсан тариан талбайд нь харьцангуй дээрх шинж нь тод байдаг.

Тариалан эрхлэж байсан газарт томоохон гол мөрнөөс суваг шуудуугаар дамжуулан ус татаж тариалангийн талбайгаа усжуулж байсан ул мөр их байдаг.

АРХЕОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ХАМААРАХ ҮЗМЭРИЙГ БҮРТГЭН БАРИМТЖУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Манай улсын аймаг, хотын музейнүүдэд археологийн малтлага судалгааны үр дүнд илэрч олдсон болон түүвэр байдлаар музейд цуглагдсан археологийн төрөл зүйлд хамаарах чулуун зэвсгүүд, сумны хүрэл, төмөр, ясан зэв, нумын наалт, шавар болон чулуун ваар сав суулга, хүрэл, төмөр хутга, ээмэг бөгж бүсний арал, товруу, хазаарын амгай, дөрөө зэрэг үзмэрүүд олон тоогоор хадгалагдаж байдаг. Энэхүү үзмэрүүд нь эрт цагаас монгол оронд аж төрж ирсэн нүүдэлчин овог аймаг, улс түмний түүх, соёл, зан заншил, нийгмийн хөгжлийн зангилаа асуудлуудыг нэхэн сэргээж тодруулахад асар их мэдээлэл өгөх чадвартай үнэ цэнэ бүхий дурсгалууд юм. Эдгээр үзмэрүүдийн түүхэн үнэ цэнэ, ач холбогдолыг нь алдагдуулахгүй бүртгэн баримтжуулах нь музейн эрдэм шинжилгээний ажилтан та бүгдийн гол анхаарлаа хандуулах ажлын нэг хэсэг болно.

Сүүлийн үед музейнүүд болон гадаадын жуулчид, эртний эдлэлийн дэлгүүр, сонирхон цуглуулагчид хувь хүмүүсийн гар дээрээс үзмэр худалдан авах явдал ихэссэнтэй холбоотойгоор зарим хүмүүс эртний булш хиригсүүр хөндөх байдал газар авч гарсан эд өлгийг нь гар дамжуулан худалдсанаас болж түүхийн олон мэдээллээ бид алдаж тухайн эд өлгийн үнэ цэнийг алдагдуулдаг. Иймэрхүү байдалд оруулахгүйн тулд музейн ямар ч төрлийн үзмэрийг маягтын дагуу сайтар мэдээлэлжүүлж байх нь чухал юм.

Археологийн малтлага судалгаагаар илэрч олдсон болон санамсаргүй тохиолдлоор хөдөө хээрээс олдсон археологийн малтлагаар илэрч олддог эд өлгийн нийтлэг шинжийг хадгалсан бүх төрлийн дурсгалыг археологийн гэх төрөл зүйл хамааруулан авч үздэг. Малтлага судалгааны явцад болон хөдөө хээрээс илэрч олдсон дурсгалууд нь музейн үзмэрийн танхимд дэглэгдэж нийтийн хүрээл болохоосоо өмнө “эд өлөг”-ийн шинжтэй байх ба музейн үзүүллэгт тавигдсаныхаа дараа үзмэр болдог.

Археологийн төрөл зүйлд хамаарах үзмэрийг тодорхойлохдоо юун түрүүнд нэрийг сайтар нягтлан үзэх хэрэгтэй байдаг. Манай музейнүүдэд нийтлэг ажиглагддаг жишээнээс үзэхэд “сумны зэв”, “хазаарын амгай”, “нумын гичир”, “төмөр дөрөө”, “ваар сав” гэх мэтээр нэг үзмэрийн нэрийг тодотгол үгтэй хамт хэрэглэсэн явдал их байдаг. Хэдийгээр эдгээр үгнүүдийн нийлмэл утга тухайн үзмэрийн нэрийн утгыг ямар нэг хэмжээгээр алдагдуулахгүй боловч “зэв”, “амгай”, “гичир”, “дөрөө”, “сав” гэх мэт үгс нь бие даах тухайн үзмэрийнхээ утгыг илэрхийлэх бүрэн чадвартай учир бүртгэлдээ дангаар нь авч хэрэглэн, дэлгэрэнгүй тодорхойлолт бичихдээ бусад тодотголуудыг нэмж бичих зэргээр бүртгэн баримтжуулж болно. Мөн үзмэр тус бүрийн онцлогоос хамаарч бүртгэлийн хүрээнд хэрэглэх үг хэллэгээ оновчтой зөв авч бичих нь чухал юм. Жишээлбэл төмөр зэвний тодорхойлолтыг бичих явцдаа гурван хянгат зэвийг гурван талтай зэв болгон бичих сурвалжийн бүдүүн хэсгийн төгсгөлтэй холбогдох ивийг тээглүүр болгон бичих зэрэг ташаарал зарим музейн бүртгэлд тохиолддог.

Археологийн төрөл зүйлд хамаарах энэ мэт үг хэллэгийн асуудалд хандахдаа монгол хэлний тайлбар толиуд болон эрдэмтэн судлаачдын тухайн үзмэрийн талаар явуулсан судалгааны ажлын үр дүнтэй сайтар танилцах зэргээр шийдэж болно.

Бидний өгүүлэн буй төрөл зүйлийн дурсгалын бүтээгдсэн он цагийг тогтоох асуудал нь мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын мэргэжилтнүүдийн хийх ёстой ажил боловч зарим тохиолдолд энэ үүргийг музейн ажилчид тогтоох шаардлага гардаг. Ийм тохиолдол ихэвчлэн хүний гар дамжиж ирсэн үзмэртэй холбоотой гардаг бөгөөд он цагийг үнэн зөв бодитой тогтоох нь тухайн ажилтны түүхийн мэдлэг боловсролтой шууд холбоотой байдаг. Хүний гар дамжин ирсэн үзмэрийн цаг хугацааг тогтоохдоо ижил төрлийн үзмэртэй харьцуулан үзэж анхны байдлаар бүтээгдсэн он цагийг тогтоож болох ба шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад хандан нарийвчлан тогтоолгож болно. Хэрэв музейн эрдэм шинжилгээний ажилтан өөрийн зүгээс тухайн үзмэрийн бүтээгдсэн он цагийг тогтоохоор шийдэж байгаа бол монголын түүхийн ерөнхий үечлэлээр тодорхойлбол хамрах цаг хугацааны хувьд олон зуун жилийг багтаах боловч үнэнд илүү нийцдэг байна. Жишээлбэл хүрэл хутганы тодорхойлолтыг бичих явцдаа он цагийг тогтоохдоо НТӨ /Нийтийн тооллын өмнөх/ YI зуун гэж тодорхойлбол энэ он цаг нь үнэнд үл нийцнэ. Археологийн шинжлэх ухаанд энэ мэт эд өлгийн зүйлсийг ерөнхийлсөн цаг хугацаагаар хүрэлийн үе /bronze age/ гэж тогтоодог ба зарим тохиолдолд хутганы онцогийг харгалзан үзэж НТӨ XII-YI зуун гэж тогтоох нь ч бий.

Археологийн төрөл зүйлд хамаарах үзмэрүүдийн бүтээгчийг нарийн тодорхойлох боломжгүй байдаг. Гэвч археологийн дурсгалуудыг тодорхой бүс нутагт тархсан, нэгэн цаг үед бүтээгдсэн, ур хийцийн хувьд ижил бүтээгдсэн зэрэг шинжүүдээр нь нэг соёл, нэг хийцэд хамааруулах нь байдаг. Жишээлбэл манай улсын Өмнөговь аймгийн нутгаар элбэг тохиолддог чулуун зэвсгийн дархны газраас олддог чулуун зэвсгийн үлдэгдлийг “Говийн хийц”-ийн гэж тодорхойлдог бол ишиндээ амьтны дүрс загварчлан бүтээсэн кинжаал хутгыг “Карасукийн соёл”-д хамаатуулан авч үздэг. Энэ мэтээр археологийн төрөл зүйлд хамаарах музейн үзмэрийн хийцийг тодорхойлж болдог байна.

Музейн үзмэрийн хийгдсэн материалыг тогтооход тэр бүр хүндрэл гарах нь бага байдаг. Учир нь археологийн төрөл зүйлд хамаарах дурсгал нь эртний хүмүүсийн нийгмийн хөгжлийн тодорхой үе шатад хэрэглэж хэвшсэн чулуу, мод, шавар, хүрэл, алт, мөнгө, төмөр зэрэг нийтлэг түүхий эдээр хийгдсэн байдаг. Эдгээр материалыг төвөггүйхэн тодорхойлж болох боловч зарим тохиолдолд хосолмол шинжтэй үзмэр ч цөөнгүй тохиолддогийг анхаарах хэрэгтэй. Жишээлбэл манай зарим музейнүүдэд байдаг хүрэл зэвний сурвалжийг төмрөөр бүтээсэн байдаг бол төмөр хутганы ишийг ясаар хийсэн тохиолдол бий. Эдгээр материалуудыг бүртгэлдээ нэг бүрчлэн оруулан бичих хэрэгтэй.

Археологийн төрөл зүйлд хамаарах дурсгалууд нь харилцан адилгүй хэлбэр хэмжээтэй байдаг тул тухайн хэмжилт хийж буй үзмэрийнхээ онцлогт нийцүүлэн урт, өргөн, зузаан, диаметр, жин зэргийн хэмжээг авч тодорхойлон бичдэг. Зарим үнэт болон хосгүй үнэт үзмэрийн хэмжээг нарийн тогтоохын тулд мм-ийн нарийвчлалтай шугам ашиглах хэрэгтэй. Археологийн төрөл зүйлд хамаарах ихэнх дурсгал эмтэрч гэмтсэн байдалтайгаар илэрч олддог бөгөөд түүнийг тухайн байгаа байдлаар нь хэмжилт хийж баримтжуулна. Зарим тохиолдолд ийм эмтэрсэн, хугарсан /хугарсан хэсэг нь алга болсон/ үзмэрийг бүтэн болгож хийсвэрлэн хэмжилт авсан байдал ажиглагддаг ба энэ нь тухайн бүртгэлтэй танилцаж байгаа хүнийг төөрөгдөлд оруулах нь элбэл. Ийм учир археологийн ямар ч үзмэрийн байгаа байдалд нь хэмжилт хийхээс бус хийсвэрлэн бүтэн болгож хэмжилт хийж болохгүйг анхаарах нь зүйтэй.

Археологийн зарим дурсгал иж бүрдлийнхээ хувьд олон тоотой байх нь элбэг. Ийм дурсгалыг бүртгэн баримтжуулахдаа тухайн дурсгалын бүрдэлд хамрагдах бүх хэсгийг нарийвчлан тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Ялангуяа олон тоотой иж бүрдэл бүхий үнэт хосгүй үнэт үзмэрийн бүрдлийг нарийн тодорхойлон бичихгүй бол зарим хэсэг нь алга болох явдал түгээмэл байдаг. Жишээлбэл археологийн судалгаагаар илэрч олдсон сувдан зүүлтний сувдны тоо ширхэгийг алдалгүй тоолж баримтжуулаагүйгээс музейд ирэхдээ хэд хэд нь алга болсон тохиолдол гарч болно. Гэтэл хүзүүний зүүлтэнд орсон сувдны тоо ширхэг эртний монголчуудын тоог эрхэмлэх зан үйлтэй нягт холбоотой байсныг бид тодруулж чадахгүй үлдэхэд хүрнэ. Иймд тухайн үзмэрийн иж бүрдлийг сайтар бүртгэн баримтжуулах хэрэгтэй юм.

Музейн аливаа үзмэрийн анх цуглуулсан, нээж илрүүлсэн асуудлыг тодотгож бүртгэлд оруулах нь судлаачдад их хэрэгтэй хэрэглэгдэхүүн болдог байна. Өгүүлэн буй төрөл зүйлийн дурсгалуудын гарал үүслийн тодруулахад тухайн үзмэрийг археологийн малтлага судалгаагаар илрүүлэн олж тодорхой хугацааны дараа музейд шилжүүлэн өгч байгаа бол илрүүлэн олсон экспедицийн тайлантай танилцаж хангалттай мэдээллийг авах нь чухал. Хэрэв хувь хүний гараас худалдан авч байгаа бол хэзээ, хэрхэн ямар замаар тухайн хүний гар дээр ирсэн болох, хаа нэгтээ газраас олсон бол тухайн газар нутгийн талаарх бүрэн мэдээллийг авах зэргээр бүртгэлжүүлэх хэрэгтэй. Сүүлийн үед БНХАУ-д өнгийг нь хуучруулж хийсэн янз бүрийн эдлэлүүд Монголд маш ихээр орж ирж байгаа бөгөөд үүнийг нь манай музейнүүд худалдан авсан тохиолдол цөөнгүй байгаа нь тухайн худалдан авах гэж буй үзмэрийнхээ гарал үүсэлтэй сайтар танилцаагүйтэй холбоотой. Ийм анхаарал болгоомжгүй байдлаас болж тэрхүү музей биш нийт монголчуудын эрх ашиг хөнддөгддөг учир үзмэрийн гарал үүслийг сайтар тодруулж байх шаардлагтай.

Археологийн төрөл зүйлд хамаарах үзмэрийг сэргээн засварласан, хуулбар хийсэн, хөдөлгөөнд орсон байдлыг тухай бүр карт хөтлөх замаар мэдээлжүүлж бүртгэн баримтжуулах ажилдаа тусгаж байх нь чухал.

Музейн үзмэрийн тодорхойлолт, товч түүхийг маш сайн бичих хэрэгтэй. Тухайн үзмэрийн гадаад байдал онцлог зэргийг харж байгаад тодорхойлон бичихийн зэрэгцээ түүхийн аль үед ямар зорилгоор ашиглагдаж байсан, хэдий үеэс хүний гар дээр ирсэн, тэр хүн нь ямар байдлаар ашиглаж байсан гэх мэт олон зангилаа асуудлуудыг тухайн үзмэртэйгээ холбоотой хууч яриа, үлгэр домог, түүхийн баримтаар баяжуулж өгөх хэрэгтэй. Жишээлбэл Хүннүгийн булшнаас гарсан хүрэл тогоог “цөгцөн ёроолтой, дэрэвгэр амсартай, амсат нь 2 сэнж гагнаж тогтоосон, хүрэн өнгөтэй, зэвэрсэн….” гэх мэтээр тодорхойлж болно. Гэхдээ “Хүннү нар энэ төрлийн тогоог хол газар аян дайнд явахдаа ганзагалан явдаг байв” гэх мэт түүхэн мэдээг орхигдуулахгүй байх нь чухал юм.

Аливаа дурсгалын бүртгэл нь тухайн дурсгалыг сэргээхэд шаардлагатай бүрэн мэдээлэлийг агуулж байх учиртай. Иймд үзмэрийг бүртгэн баримтжуулахдаа цөөн хэдэн үгээр хязгаарлалгүй асуулгын утгын хүрээнд аль болох дэлгэрэнгүй мэдээллийг бичиж байх нь чухал юм. Олон улсын хил дамнан худалдаалагдаж байгаа үндэстэн угсаатны үнэт эд өлгийн зүйлсийг сурвалжлан олох, хосгүй үнэт үзмэрийг санамсаргүй байдлаар эвдэх, алга болоход түүнийг сэргээх, тухайн нэг үзмэрийн талаар эрдэм шинжилгээний ажил хийж байгаа судлаач зэрэгт та бидний хийсэн үзмэрийн бүртгэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд та бүхэн музейн үзмэрийг бүртгэн баримтжуулахдаа цөөн хэдэн үгээр оновчтой тодорхойлолт бичихэд шүтэлгүй аль болох дэлгэрэнгүй үнэн зөв мэдээллийг агуулсан бүртгэл хийхэд гол анхаарлаа хандуулан ажиллах хэрэгтэй.

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн
Б.Даваацэрэн

МАЯГТ № 2

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 56 дугаар тушаалаар батлав.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМСангийн дугаар: 1110МЦМ50001

Зэрэглэл: Ердийн **шийдвэр:** МЦМ-н захирлын 22 тоот тушаалаар 2006/6/14

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: БХЯ-ний харьяа Монголын цэргийн музей	**РД:** 9121927
Дурсгалын орших байгаа хаяг: Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг. Ж.Лхагвасүрэнгийн гудамж 12 Монгол цэргийн музей	

Дурсгалын нэр: Зэв	
Орон нутаг, олон улс (шинжлэх ухаан) –ын нэр: Хайбүр зэв	
Бүртгэлийн дугаар: Y-06-36	**Хувийн дугаар:** 255
Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл	
Ашиглалтын байдал: Монгол цэргийн музейн эртний үзвэрийн танхимд	
Төрөл зүйл: Зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл	
Он цаг: Монголын эзэнт гүрний үе / XIII, XIV зуун /	
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Бүтээлчийн нэр тодорхойгүй, цутгаж хийсэн	
Материал: Төмөр	

Хэмжээ	өндөр	өргөн (зузаан)	урт	диаметр	жин
		3.2 см	13.7 см		63 гр

Гэрэл зураг: 4 ширхэг зурагтай

			
өмнө тал	ар тал	хажуу тал	бусад

Иж бүрдэл: Зэв

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: Уг зэвийг 1999 онд Булган аймгийн Могод сумын малчин Р.Гомбосүрэн малынхаа бэлчээрээс олсноо багийн дарга Э.Баасандоржид өгчээ. 2006 онд уг зэвийг Э.Баасандоржийн хүү Б.Энхбаатар Монгол цэргийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Одонтуяад үзүүлэн худалдах санал тавьсан.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: МЦМ-н "Үзмэр худалдан авах зөвлөл"-ийн саналыг үндэслэн тус музейн захирал 2006 оны 6-р сарын 14-ний өдрийн 22 тоот тушаалаар музейн сан хөмрөгт худалдан авсан.

Сэргээн засварласан байдал: Уг зэв нь анх ирэхдээ нэлээд зэвэрсэн, сурвалж нь хугарсан байсан бөгөөд тус музейн сэргээн засварлагч мужаан С.Баасандорж цэвэрлэн цавуугаар нааж бэхжүүлсэн. Дараа нь СӨТ-д сэргээн засварлуулсан.

СЗБ № 03

Хуулбар хийгдсэн байдал: Уг зэвэнд Соёлын Өвийн төвөөр 2 хувь хуулбар хийлгэсэн. Энэхүү хоёр хуулбар зэв нь эхийн хамт тус музейн эртний үзвэрийн танхимд дэглэгдсэн.

Тодорхойлолт: Уг зэвийг цутгуурын аргаар хийсэн ба Дундад эртний монголчуудын дунд өргөн хэрэглэгдэж байсан "Хайбүр" төрлийн зэв юм. Он удаан жил газрын хөрсөн дээр ил байснаас зэвэрч улаан хүрэн өнгөтэй болсон байв.
Зэвний ерөнхий бүтэц нь сурвалж, ив буюу ээз, хүзүү, мөтөгөөс бүрдэх ажээ. Сурвалжийн урт 4 см, диаметр нь ив орчмын бүдүүн хэсгээрээ 0,7 см, нарийн үзүүр орчмоороо 0,2 см, зэвний их биеийн зузаан голдоо 0,3 см мөтөг орчмоороо 0,1 см.
Төв Азийн нүүдэлчид эрт үеэс чулуу, яс, хүрэл, төмрөөр олон хэлбэрийн үүрэг зориулалтаараа харилцан адилгүй зэв хийж хэрэглэж байжээ. Судлаачдын тэмдэглэснээр монголчууд ан авд хэрэглэдэг харвуурыг "сум" дайн байлдааны аливаа ажиллагаанд хэрэглэдэг харвуурыг "зэв" гэж нэрлэдэг байжээ. Энэхүү хайбүр зэв нь дайн байлдааны үеэр хэрэглэдэг зэв болно.

Гэмтэл өө сэв: Зэв нь ив буюу ээз орчмоороо хоёр хэсэг болон хугарсан байдалтай байх ба мөтөг нь хожмын механик үйлдлээс болж ихэд эмтэрсэн. Мөн зэвний гадаргуу зэвэнд идэгдсэнээс анхны тольгор байдлаа алдаж барзгар болсон. Зэвний сурвалж нь элдэв гэмтэлгүй анхны хийцээрээ сайн хадгалагсан байна.

Зориулалт: Дундад эртний монголчуудын морьт болон явган цэргүүд аливаа байг онилолгүй хаймсуулан харвахдаа ийм төрлийн зэвтэй сумыг хэрэглэдэг байжээ.

Ховор, түгээмэл байдал: Ийм төрлийн зэв нь хөдөө орон нутгаас түүвэр байдлаар болон булшны малтлага судалгааны үр дүнд нэлээдгүй илэрч олддог түгээмэл дурсгал бөгөөд хөрш зэргэлдээ БНХАУ, ОХУ-ны нутгаас ч цөөнгүй олджээ.

Товч түүх: Энэ зэв нь Булган аймгийн Могод сумын нутаг "Уртын адаг" хэмээх газраас олдсон байна. Энэхүү газраас урьд өмнө нь төмөр зэв нэлээдгүй олдсон ажээ. Нутгийхан энэхүү зэв олдсон газрын талаар "Цогт хун тайжийн цэрэг Хайрхан уулын араар давж ирэхээд энд байсан Манжийн цөөхөн цэргүүдтэй байлдаж ялсан газар..." хэмээн ярьдаг. Энэхүү зэв нь Монголын эзэнт гүрний үед цэргүүд сумныхаа зэвийг цутгаж хийгээд дараа нь өө сэвийг нь хуурайдан засдаг байсан тэрхүү арга технологийн дагуу хийгдсэн байна.

Гарал үүсэл:

Шилжилт хөдөлгөөн: Энэхүү зэв нь Баруун Европын орнуудаар зохиогдсон "Их Монгол" үзэсгэлэнд хамрагдаж 2006 оны 5 сараас 11 сар хүртэл явсан. Мөн Үндэсний Түүхийн Музейгээс 2006 оны 12-р сард зохион байгуулсан "Нүүдэлчдийн зэр зэвсэг" сэдэвт үзэсгэлэнд 3 хоногийн хугацаатай оролцсон.

Судлагдсан байдал: 1, Ж.Базарсүрэн. "Чингис хааны цэргийн зэр зэвсэг" Уб., 2000
2, А.Дамдинсүрэн. "Монголын зэвсгийн түүх" Уб., 1990
3, Ю.С.Худяков. "Вооружение средневековых кочевников Южной Сибири и Центральной Азии" Новосибирск., 1986

Хавсралт материалын тэмдэглэл: Судалгааны ном бүтээлд хэвлэгдсэн ижил төрлийн зэвүүдийн хувилж авсан 7 зурагт хуудас, зэвтэй холбоотой хэвлэгдсэн бүтээлээс бичиж авсан материал 5 хуудас байгаа болно. Мөн гар болон гэрэл зураг 9 ширхэг байгаа.

Эзэмшигч /өмчлөгч/-д хадгалагдаж байгаа
Негатив № 7 слайд № 0 CD № 0 дүрс бичлэгийн хуурцаг № 0
УНБМСанд хадгалагдаж байгаа
Негатив № ____ слайд № ____ CD № ____ дүрс бичлэгийн хуурцаг № ____
Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: Б.Даваацэрэн, Мэргэжилтэн 2007 он 6 сар 5 өдөр
УНБМСанд хүлээн авсан: Б.Даваацэрэн, Мэргэжилтэн ____ он ____ сар ____ өдөр

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН ДУРСГАЛЫН БҮРТГЭЛ

Солирын тухай ерөнхий ойлголт

Бага гараг хэмээн нэрлэгддэг, хөндлөн огтлолоороо 1-1000 км орчим байх тэнгэрийн жижиг биес нарны аймгийн тогтолцоонд өөрийн тойрог замаар эргэлдэн оршдог. Одоогоор 2000 орчим бага гараг мэдэгдээд байгаа ба бага гарагууд тодорхой хэлбэр дүрсгүй, ямар нэг том биеийн хэлтэрхий мэт сэтгэгдэл төрүүлнэ. Судлаачид энэхүү сансрын биеийг Улаан нүдэн ба Бархасбадь гаргийн хооронд байсан ямар нэг том гараг тодорхой нэгэн учир шалтгаанаар задран бутархад үүссэн гэдэг бол зарим нь Нарны аймгаас их хол, уудам орчлонгийн хаа нэгтээ үүссэн цэвдэг хүйтэн гариг орчих хөдөлгөөнийхөө явцад нарны гэрэлд хайлан бутран салсны нэгээхэн хэсэг хэмээн өөр өөрөөр тайлбарладаг. Энэхүү бага гарагууд солир төрүүлэх эх гэж үздэг. Тэнгэрийн ийм жижиг бие дэлхийн агаар мандалд зүсэн орж ирээд агаартай үрэлдэн бүрмөсөн шатаж амжилгүй газар унасныг солир, тэнгэрт гэрэлтэн зүсч явааг нь толир хэмээн нэрлэнэ.

Дэлхийд унасан солируудын хэмжээ янз бүр байх ба 1927 онд Өмнөд Африкаас олдсон 70 тонн солир хамгийн томд тооцогддог. Монгол нутагт хүмүүст харагдаж унасан хийгээд нутаг дээрээс олдсон солирууд цөөнгүй бий. ХХовд аймгийн Булган сумын нутагт байх “Мөнгөн Дөш” солирыг 20 тонн орчим жинтэй гэж үздэг ба энэ нь дэлхийд дээгүүрт орох том солир юм.

Солирыг ихэвчлэн унасан газар нутгийн нэрээр нэрлэх нь элбэг. Жишээлбэл: Ажбогд-I, Ажбогд-II, Манлай, Матад, Ноёнбогд, Хэрлэн, Тугалын бүлээн г.м.

Солирын ангилал

Манай орон төдийгүй энэ дэлхий дээр унасан солируудыг химийн бүтэц бүрэлдэхүүнээр нь:

- төмөр
- чулуун
- төмөр-чулуун гэж үндсэн гурав ангилна. Манай дэлхий дээр унасан солируудын ихэнх нь төмөр солир байх ба аль ч солироос дэлхийд байдаггүй химийн найрлага, элемент олдоогүй байна.

Солирын химийн найрлага гол үзүүлэлт болно. Жишээлбэл: төмөр солирт төмөр-91%, диц-8,5%, кобальт-0,6%; чулуун солирт хүчилтөрөгч-36%, төмөр-26%, цахиур-18%, магни-14% орчим хувийг тус тус эзэлдэг. Мөн солирын бүрэлдэхүүнд цацраг идэвхит бодис, тугалга байх тул түүнийг ашиглан цөмийн физикийн аргаар насыг тогтоох боломж олддог.

Чулуун солирын хувьд хүчилтөрөгч болоод цахиурынхаа агуулгаар дэлхийн хөрстэй ойролцоо байдаг бол төмөр солирт энэ хэмжээ мэдэгдэхүйц их байдаг онцлогтой.

Солир тэнгэрийн биетийн хувьд орчлонгийн гарал үүслийг тогтоох, шинэ бодис, элемент хайх зэрэгт онц сонирхолтой судлагдахуун болдгоороо ихээхэн үнэ цэнэтэй юм. Нөгөө талаас хүмүүс харж байхад унасан солирын үнэ цэнэ бүр ч илүү байдаг.

Хэрлэн хэмээн нэрлэгдсэн шиллэг солир 1950 оны III сарын 22-ны 01 цагт Хэрлэн голоос урагш 80 км орших “Энгэр шанд” гэдэг газар их дуу чимээ гарган унахыг хүмүүс харжээ. Ийм шиллэг солир анх 1787 онд Чехословакаас, сүүлд АНУ, ЗХУ, Зааны ясан эрэг, Австралиас олдсон боловч тэдгээрийн унахыг хүн хараагүй тул солирын бие мөн эсэхэд эргэлзсээр ирсэн юм. Тэгвэл Хэрлэн солир чухамдаа тэдгээрийг “тэнгэрийн бие” болгож чадсанаараа ихээхэн ач холбогдолтой гэж үздэг.

Солир бол шинжлэх ухаан, танин мэдэхүйн асар их ач холбогдол бүхий дэлхий нийтийн үнэт сан хөмрөгт багтдаг ховор биет тул өөрийн нутаг дэвсгэрээс олсон улс орнууд дэлхийн солирын хороонд бүртгүүлэн судалгаа шинжилгээний үнэт материал болгон ашигладаг. Түүнийг олсон хувь хүмүүс эвдэх, хэлбэр дүрсийг нь өөрчлөх, хувьдаа өмчлөхийг хориглодог.

Монгол Улс солирын ховор олдворуудаараа дэлхийд үзэсгэлэн гаргах боломж бүхий орнуудын тоонд зүй ёсоор багтдаг.

Монгол орноос олдсон солирууд:

- “МӨНГӨН ДӨШ” 20 тн, Ховд аймаг, Булган сум
- “АЖ БОГД II” 582.2 кг, Говь-Алтай аймаг, Алтай сум
- “МАНЛАЙ” 166.8 кг, Өмнөговь аймаг, Манлай сум
- “НОЁН БОГД” Өмнөговь аймаг, Ноён сум
- “АЖ БОГД I” Говь-Алтай аймаг, Алтай сум
- “МАТАД” Дорнод аймаг, Матад сум
- “ТАМИР-ЦЭЦЭРЛЭГ” 172 кг, Архангай аймаг, Тамир сум
- “НОЁН УУЛ” 103.0 кг, Өмнөговь аймаг, Ноён сум
- “ХЭРЛЭН” Дорнод аймаг, Хэрлэн сум (1950.03.22)
- “ТУГАЛЫН БҮЛЭЭН” Дундговь аймаг, Хулд сум (1967.02.03)

Амьд биетийн тухай ерөнхий ойлголт

Музейд хадгалагдаж буй байгалийн олдвор, цуглуулгийн тухай ярихын өмнө амьд биет, тэдгээрийн үндсэн шинж, ангилал г.м. суурь ойлголтуудтай танилцах шаардлагатай юм. Хүн өөрөө байгалийн бүтээгдэхүүн тиймээс ч амьд байгалийн тухай мэдлэг төсөөлөл хүн бүхэнд тодорхой хэмжээгээр байдаг. Амьдралын, амьд биесийн тухай шинжлэх ухааныг Биологи (bio- амьд, амин logos-ухаан) гэнэ. Биологийн шинжлэх ухаан нь амьтан ургамал бичил биетэн гэх мэт олон салбар шинжлэх ухаанаар энэ дэлхий ертөнц дээрх амьд биетийн бие бүтэц, өсөлт хөгжилт, удамшил, өөр хоорондоо хэрхэн нөлөөлж холбогдож буй тухай нарийвчлан судалдаг.

Амьтан ба ургамал судлалын шинжлэх ухаанууд цэцэглэн хөгжих, зүйлүүдийг шинээр нээх, шинжлэх ухааны оноосон нэршил өгөх, тэдгээрийн удам зүйн холбоог тогтоосны үндсэн дээр ангилалын системийг зохиох ажлуудын судалгааны суурь материалууд үе үеийн байгалийн түүхийн музейнүүдийн цуглуулгын санд хадгалагдан, хуримтлагдаж байсан.

Түүхэн уламжлалаас харахад музей нь шинжлэх ухааны томоохон байгууллага, нэртэй их дээд сургуулиудын дэргэд байгуулагдаж байсан байна.

Байгалийн музей бол тухайн улсын байгалийн баялаг, амьтан ургамал, эрдэс баялагийн зонхилох ховор үнэт цуглуулгыг хадгалж байдгаараа ард түмний оюун мэдрэхүйг шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдээллээр ханган цэнэглэж байх төв болдог. Ийм байх үндэс нь тухайн музейд хадгалагдаж байгаа амьтан ургамлын зүйлүүд, эрдэм баялагийн дээжүүд нь шинжлэх ухааны үүднээс зөв тодорхойлогдож, байгаль болон хүний нийгэмд үзүүлэх эерэг сөрөг холбогдол, нөөцийн байдал, хамгаалагдаж байгаа статусаараа хүмүүст танин мэдэхүйн үнэн зөв ойлголт өгдөг байхад оршино. Энэхүү үнэн зөв мэдээллийг гагцхүү эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнд гаргасан бодит материалууд дээр л тулгуурлан дэлгэрүүлэх, цуглуулах боломжтой.

Амьд биетийн ангилал

Биологийн ангилал бол амьтан ургамлын зүйлүүдийн тухай, зүйлийн доторхи хувьслийн тухай, зүйлүүдийг ангилалын янз бүрийн хэмжээний хуваарьт нэгтгэн бүлэглэх тухай шинжлэх ухаан юм.

Ангилал нь эрт цагаас одоо үе хүртэл амьд биет бүдүүлэг доод хэлбэрээс боловсронгуй дээд хэлбэр лүү ахисан түүхэн хөгжлийн дагуу тэдгээрийн үүслийн дэс дараалал, цусан төрлийн холбооны хол ойрыг тусгасан жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй хуваарь бөгөөд судлахад хялбар болгох зорилгоор санаанаасаа хуваасан зохиомол зүйл биш юм.

Орчин үеийн биологийн шинжлэх ухаанд зүйлийн үүслийн тухай онолыг үндэслэгч нь Ж.Ламарк, Ч.Дарвин нар бөгөөд энэ асуудал одоо хүртэл бүрэн шийдэгдээгүй, биологийн ухааны хамгийн маргаантай нарийн асуудлын нэг юм.

Амьтан ургамлын ангилалын үндсэн нэгж нь ЗҮЙЛ (species) юм. Гарал үүсэл, гадаад дотоод бүтцээрээ адил төсөөтэй амьтан ургамлын бодгалиудыг зүйл гэнэ. Жишээлбэл: манай оронд тархсан урт сүүлт, дагуурын, гозоорой, бозлог зэрэг зурамнууд гадаад байдал, гарал үүслээрээ төсөөтэй боловч бас хоорондоо ялгарах шинжүүдтэй учир тус бүр бие даасан зүйл болно. Зүйл бүр заавал тодорхой тархсан нутаг (ареал)-тай байна. Зүйл бүхний тархсан нутаг тус тусдаа байхаас гадна давхардсан байж болно.

Ангилалын дараагийн хуваарийг ТӨРӨЛ (genus) гэнэ. Гарал үүсэл, гадаад дотоод бүтэц зэргээрээ ойролцоо төстэй зүйлүүд нэгдэж төрөл болно. Дээр дурьдсан олон зурамнууд нийлж зурамны төрөлд хамааргадана. Ойролцоо төрлүүд ОВОГ (familia), овгууд БАГ(ordo), багууд АНГИ (class), ангиуд ХҮРЭЭ (phylum), хүрээнүүд АЙМАГ (regnum) -т тус тус нэгдэнэ. Үүнийг тоймлон харуулбал:

АЙМАГ (regnum)
- ХҮРЭЭ (phylum)
  - Анги (classis)
    - Баг (ordo)
      - Овог (familia)
        - Төрөл (genus)
          - Зүйл (species)

Энэхүү үндсэн ангилалын нэгжийн хуваариудаас гадна зүйлийн түүхэн хөгжлийн үүднээс тэдгээрийн үүсэл гарал, төстэй ба ялгаатай талыг улам тод болгохын тулд завсрын хуваариуд байдаг. Үүнд: салбар зүйл (subspecies), салбар овог (subfamilia), дээд овог (superfamilia), бага анги (infraclass) гэх мэт. Амьтан ургамлын зүйл бүр тодорхой нэг төрөл, овог, баг, анги, хүрээнд хамаарна. Жишээ нь: Саарал чоно (Canis lupus L., 1758) зүйл нь амьтны аймгийн хөвчтөний хүрээ, хөхтний анги, махчдын баг, нохдын овог нохойн төрөлд хамааргадана.

Амьтан ургамлын ангилалын одоогийн нэр томьёог үндэслэгч нь Шведийн нэрт эрдэмтэн Карл Линней юм. Тэрээр ургамал амьтны төрөл зүйлийг тэмдэглэсэн хос латин нэрийг анх удаа нарийн журамтай хэрэглэсэн. Дэлхийн улс бүхэн одоо ургамал амьтны зүйлийг нэрлэхдээ энэхүү хос нэршлийг зарчмыг хэрэглэж байна. Амьтан ургамлын ангилалын нэр томьёоны олон улсын дүрэм ерөнхий агуулга зарчмынхаа хувьд адил боловч нэр томьёоны хувьд нэг нэгэндээ хамаарахгүй өөр өөрсдийн дүрэм горимтой байна.

Энэ нь амьтны аймагт гарсан зүйлийн нэр ургамлын аймагт тохиолдож болно гэсэн үг юм. Харин амьтны аймаг дотроо зүйлийн хос нэр хэзээ ч дахин давтагдах ёсгүй өөрөөр хэлбэл нэг амьтан олон нэртэй байхгүй, олон амьтан нэг нэртэй байхгүй гэдэг зарчимтай тул дэлхийн шинжлэх ухаанд хичнээн зүйл амьтан, ургамал мэдэгдэж байна мөн тийм тооны хос латин нэр томьёо байна гэсэн үг болно. Ангилал, ангилалын нэр томьёоны зарчим нь дэлхий дээр одоо байгаа амьтан ургамлыг хамраад зогсохгүй эртний сөнөж мөхсөн амьтан ургамалд ч мөн хэрэглэгддэг. Ангилалын олон улсын дүрэм ёсоор төрөл түүнээс дээших хуваариудын нэрийг том үсгээр, зүйл салбар зүйлийн нэрийг жижиг үсгээр эхлэн бичнэ.

Хос нэршлийн ард тухайн зүйлийг шинжлэх ухаанд анх бичсэн хүний нэр, оныг бичдэг боловч голчилон эрдэм шинжилгээний бүтээлд хэрэглэдэг.

Түүнээс гадна шинжлэх ухаанд нутгийн нэр гэгддэг нэр томьёо улс бүхэнд байдаг ба энэ нь зүйлийн шинжлэх ухааны хос нэршлийн зарчимтай заавал тохирох шаардлага байхгүй юм.

Монгол орны амьтан, ургамлын тухай

Монгол орон 1,567 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай ба экологийн янз бүрийн шилжилтийн бүсийг тухайлбал Сибирийн тайга, Төв Азийн тал хээрийн бүс нутаг, мөн Алтайн нуруу, Говийн бүсийг эзлэн оршдог. Өргөн уудам нутгийн экосистемийн энэхүү байршил дэлхийд ховордож байгаа амьтан ургамлын олон төрөл зүйл тархах боломжийг олгосон.

Монгол орны амьд организмын үндсэн хэсгийн зүйлийн бүрдэл

№	Бүлэг	Зүйл	Төрөл	Овог
1	Цоргот ургамал	2823	662	128
2	Хаг	1000	133	57
3	Хөвд	414	162	38
4	Замаг	1200	168	59
5	Мөөг	875	136	28
6	Хөхтөн	136	22	8
7	Шувуу	469	203	60
8	Хэвлээр явагч	22	14	7
9	Хоёр нутагтан	8	4	4
10	Загас	74	39	12
11	Нялцгай биетэн	36	---	---
12	Шавьж	12000	3200	350

Зарим нутгийн ургамлын нарийвчилсан судалгаа гүйцэд хийгдээгүй хэдий боловч урьдчилсан тооцоогоор 3000 гаруй цэцэгт ургамал байна гэж үздэг. Мөн монгол орны сээр нуруугүйтэн амьтдын судалгаа бүрэн гүйцэд хийгдээгүй тул зарим тоо баримт дутуу байна.

Хөхтөн амьтад

Үр зулзгаа сүүгээрээ тэжээн бойжуулдаг дээд зэргийн хөгжилт нугалмайт амьтныг хөхтөн гэнэ.

Хөхтөн амьтныг тодорхойлон танихад хагас чихмэл юмуу бүтэн мөчидтэй арьс, бүх шүдтэйгээ байгаа нас гүйцсэн амьтны толгойн бүтэн яс хэрэгтэй болно. Толгойн ясны хэмжээ шүдний бүтэц шинж тэмдэг нь залуу буюу нялх амьтанд бүрэн тодорхой бус байх учир заавал бие гүйцсэн амьтны толгойн яс ашиглагддаг.

Монгол орны амьтны аймаг өөрийн зүйлийн бүрэлдэхүүний хувьд арвин олон боловч тэдний дундаас хөхтөн амьтан онцгой ач холбогдолтой. Амьтан судлалын ухаанд хэдийгээр хөхтөн, шувуу, гүрвэл, мэлхий , шавьж тэргүүтнийг цөмийг амьтан гэх боловч хэн хүний ойлгодгоор амьтан гэхэд хөхтнийг л төсөөлөн бодох нь элбэг. Амьтан амьтны дотроос хүнд ямагт үзэгдэх нь хөхтөн бөгөөд агнан махыг хүнсэнд хэрэглэх, арьс үсийг эдлэл хэрэглэлийн үйлдвэрлэлд түүхий эд болгон ашиглах зэрэгт хөхтөн амьтад бусдаас түлхүү байдаг. Хөхтөн амьтдын олонхи, тухайлбал мэрэгчид нь олон зүйлийн үслэг махчин амьтны идэш тэжээлийн гол хэсгийг эзлэх учир тэд үгүй бол ашигт амьтдыг ховордуулахад хүргэх дам нөлөөтэй.

Мөн хөхтөн амьтдын дотор малын бэлчээрийг “өрсөн” иддэг бэлчээрийн хортон, тариа буудай, хүнсний ногооны үндэс, иш, үрийг идэж хороох хорлогчид, олны дээр зүйл зүйлийн тахал өвчин, шимэгч хорхой, шавьжийг биедээ тээж явах ба бусдад тараан түгээгчид олон бий зэргээс харахад хөхтөн амьтад нь амьд байгаль болон хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөө маш их болно.

Монголчууд эртнээс наашан амьтнаар элбэг баян газар нутагт оршин амьдарч, амьтны бие бүтэц, амьдралын төлөв байдал, зан төрхийн талаар гүн мэдлэг туршлагатай болсон. Амьтны тухай мэдлэг голдуу аман яриа, сургаал, зан заншлаар хойч үедээ уламжлагдан ирсэн юм.

Шувуу:Монголд бүртгэгдсэн 60 овог, 203 төрлийн 469 зүйл шувуудаас тус орныг дайрч өнгөрдөг 108 зүйл, суурин амьдардаг 74 зүйл, халуун дулаан орноос ирж өндөглөдөг 231 зүйл, Сибирийн их цаснаас дайжин ирж өвөлждөг 13 зүйл шувуу бий.

Шувуу нь сээр нуруутан амьтдын дотроос нисэх чадвар бүрэн эзэмшсэн анги болно. Нисэх чадвартай холбогдон бие бүтцэд ихээхэн өөрчлөлт гарчээ. Биеийн гадуур өвч өдөн бүрхүүлээр бүрхэгдсэн, биеийн зарим эрхтэн хэмжээ жижигрэх, устах замаар биеийн жин хөнгөрсөн, араг яс, булчингын бүтэц нисэхэд бүрэн зохилдсон г.м. нисэх чадвартай холбогдон дэлхийд маш өргөн дэлгэр нутагт, экологийн янз бүрийн орчинд дасан зохицсон юм.

<u>Загас:</u>Загас нь усанд амьдарч заламгайгаар амьсгалдаг, мөчдийн оронд хос ба хос бус сэлүүрүүдтэй байдгаараа хуурай газрын сээртэн амьтдаас ялгаатай юм. Усан дахь орчин зүйн онцлогоос шалтгаалан биеийн хэлбэр, зүс, хэмжээ харилцан адилгүй, маш олон янз болсон. Загасны бие бөөрөнхий, хавтгай, урт, өргөн, утас шиг нарийхан, ороомог маягийн болон ээрүүл хэлбэрийн биетэй. Зарим нь зөөлөн нялцгай биетэй байхад зарим нь битүү хайрс, хатуу арьсархаг, хуягархаг эдээр, гуравдах нь хурц шүдэрхэг, өргөсөөр хучигдсан байдаг. Энэхүү биеийн галбир, гадаад төрх, тэрхний байршил, тоо хэмжээ, өнгө зүсний ялгаа зэрэг өвөрмөц шинжийг жишин харьцуулж тодорхойлдог.

Манай орны усны гурван ай савын гол, мөрөн, нуурт 2 анги, 8 багийн, 13 овог, 44 төрөлд хамааргдах 74 зүйл загас оршин амьдарна.

Загасны гадаад бие бүтцэд янз бүрийн хэмжилт хийж эдгээр хэмжээсний дундажийг тооцоолсон тоон үзүүлэлтийн харьцуулалтыг загасны баг, овог, төрөл, зүйлийг танин тодорхойлоход ашигладаг.

<u>Хоён нутагтан:</u>Дэлхий дээр 3 баг, 29 овогт хамаарах 3000 гаруй зүйлийн хоёр нутагтан бий. Манай монгол оронд 2 баг, 4 овог, 4 төрөлд хамааргдах 6-8 зүйлийн 2 нутагтан тэмдэглэгдсэн. Гүлмэр бах, мэлхийнүүдийн хөгжлийн үе шатандаа ус болон хуурай газар ээлжилэн амьдарч өсөж хөгждөг учир хоёр нутагтан хэмээн нэрлэх болсон.

<u>Мөлхөгчид:</u>Дэлхий дээр 4 баг, 7000 гаруй зүйл мөлхөгчид байдгаас монгол оронд 2 салбар баг, 7 овог, 14 төрөл, 22 зүйл мөлхөгч тэмдэглэгдсэн. Могой, гүрвэлүүд хамаарагдана. Гүрвэлийн бие хайрсаар бүрхэгдсэн бөгөөд энэхүү хайрсны хэлбэр, хэмжээ, тоо нь ангилалзүйн үндсэн гол шинж болно. Зарим овгин могойд үлдэгдэл төдийн мөч байх боловч ихэнх могой хөлгүй. Нүдний зовхи, чихний хэнгэрэг хальс хөгжөөгүй. Могойг тодорхойлоход биеийн гадаад төрх, толгой ба их биеийн хайрс, бамбайн хэлбэр дүрс, тоо хэмжээ их чухал.

<u>Шавьж :</u>Шавьжийн ангийн амьтдаас өмнө сээр нуруугүйтэн гэсэн асар том бүлгийн тухай товч өгүүлье.

Энэ дэлхий дээр үүсэн бий болж тархсан бүх амьтан ургамлын 90 гаруй хувийг сээр нуруугүйтэн амьтад эзэлдэг. Энэ утгаараа байгаль дахь бодисын эргэлт, амьд биесийн зүй тогтол, амьдралын хэлбэр, оршин байх эсэх зэрэгт хамгийн өндөр нөлөө, үүрэгтэй юм. Орчин үеийн амьтан судлалын шинжлэх ухааны байгалийн ангилалзүйн түүхэн тогтолцоог бүхэлд нь авч үзвэл амьтны аймгийг эгэл биетэн (Protozoa-5 хүрээ) олон эстэн (Metazoa - 18 хүрээ) болгон хоёр том бүлэгт хуваан судалж байна.

Шавьж дэлхий дээр хамгийн өргөн тархсан амьтан юм. Эдүгээ үед 1500 мянга гаруй зүйлтэй байгаа бөгөөд тоо хэмжээний тухайд бусад бүх амьтан ургамлын тоо хэмжээнээс хэд дахин илүү. Жил бүр хэдэн мянган шинэ зүйл дэлхийн өнцөг булан бүрээс олддог ба 1,5-2 сая орчим зүйл шавьж байх бүрэн боломжтой юм.

Шавьжууд цэнгэг ус, газрын хөрсний дээд хэсгийн амьдрал байж болох бараг бүх экологийн орчинд өргөн тархсан байна. Байгаль, хүний амьдралд шавьжийн үзүүлэх нөлөө холбогдол их бөгөөд олон талтай. Ургамлын тоос хүртээж өндөр ургац авах, хөрсний бүтэц сайжруулах, хөрсөнд агаар ус нэвтрэх чадварыг дээшлүүлэх, хагдарч унасан ургамал, үхсэн амьтдын үлдэгдэлийг задлан байгаль цэвэрлэх, хор хөнөөлт амьтдаар хооллон цөөрүүлэх, эмийн ба хүнсний чанартай түүхий эд, бүтээгдэхүүн өгөх г.м. ашиг тус үзүүлдэг шавьжнууд олон юм.

Мөн амьд ургамлын эд эрхтнээр хооллох, паразитлан өсөлтийг саатуулах, элдэв өвчин халдвар тараах, амьтан хүний биед өвчин үүсгэх, мод модон материал, хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл болон ноосон эдлэлийг гэмтээх зэрэг сөрөг муу тал ч бий.

Энэ утгаараа сонирхолтой, танин мэдэхүйн холбогдол асар өндөр. Иймд шавьжийн бие бүтэц, хөгжил, амьдралын онцлог, ашиг, тус, хор хөнөөлийг мэдэж шаардлагатай юм.

Бие гүйцсэн шавьж

- толгой
- цээж
- хэвлий

гэсэн биеийн үндсэн гурван хэсэгт хуваагдана. Шавьжийг бусад аалз, хачиг зэргээс ялгах гол шинж нь 3 хос буюу зургаан хөл юм. Зарим тохиолдолд шавьжийг Hexapoda буюу зургаан хөлтөн ч гэж нэрлэдэг. Бүх шавьжууд хөгжлийн бүрэн ба бүрэн бус хувиралыг дамжин хөгжинө.

Хадгалалт, хамгаалалт

Загасыг бэхжүүлэн хадгалах арга

Загасыг бэхжүүлэн удаан хадгалах бол загасны том жижгээс шалтгаалан 2-5 хувийн формалин, 70° -ын спиртийн уусмалд хийх шаардлагатай. Загас том биетэй бол хэвэл хэсэгт тариураар уусмалаа шахах буюу живэр, өехийн сэлүүрийн хооронд хутгаа зүсч өгвөл дотор эрхтэн мууддаггүй.
Шинжилгээ судалгааны цуглуулга, музейн үзмэр болгон удаан хугацаагаар хадгалахад дан формалинд загасны өнгө хувираад жигд бараан болдог. Иймд загасыг уян хатан, өөрийнх нь өнгөтэй хадгалахын тулд тусгай уусмал бэлтгэн хэрэглэж болно. Үүнд: 100 мл халуун усанд 20 гразот хүчлийн кали, 10 гр цууны хүчлийн натри, 10 гр хүхрийн хүчлийн давсыг хольж уусгаад хөрсөн хойно нь 30 мл формалин, 20 мл глицерин хольж хутгаад тунгаан шүүсэн уусмалд загасаа хийж хадгална. Загасыг нойтон байдлаар хадгалахад зузаан цилиндр шил сав ашиглах ба загастай уусмалаа ууршуулахгүйн тулд савны тагийг сайтар битүүмжлэн агаар оруулахгүй болгоно. Мөн шинэ гэмтэлгүй загасны арьсыг өвчин авч боловсруулан чихмэл хийж болно.

Бусад амьтад хадгалах

Ихэнх амьтдыг үзмэр бэлтгэхэд зориудаар барьж агнаж цуглуулсан байдаг. Жижиг мэрэгч амьтдыг занга, хавх хэрэглэн цуглуулдаг. Зангыг ихэвчлэн өгөөштэй тавина. Арай томоохон мэрэгчдийг занга болон хавх ашиглан барина. Хярс үнэгнээс дээш дунд зэргийн махчдыг томоохон төмөр хавх, буугаар агнана. Агнасан амьтдаа штангенциркуль болон туузан метрээр нарийвчлан хэмжинэ. Хөхтөн амьтныг өвчих нь тэдгээрийн хэмжээ, хадгалах арга зэргээс шалтгаалан битүү, тулам, задгай 3 янз байна. Дан ганц арьснаас гадна биеийн яс ялангуяа толгойн ясыг заавал цуглуулдаг. Цуглуулсан амьтан нэг бүрд тусгай бэлтгэсэн хуудсан дээр 1. цуглуулгийн дугаар, 2. зүйлийн нэр, 3. хүйс, 4. нас, 5. агнасан он, сар, өдөр, 6. агнасан газар, аймаг, сум, газрын нэр, 7. орших нутгийн онцлог, 8. жин, 9. биеийн үндсэн хэмжээс, 10. тухайн амьтны биеийн онцлог байдал (тарга, тэвээрэг, өвчин, хээлтэй эсэх г.м.)11. цуглуулагчийн нэр эдгээрийг заавал бичнэ.

Хоёр нутагтаны цуглуулгийг голчилон 70° спиртийн уусмал, 3-4% формалины уусмалд хадгална. Мөлхөгчид (могой, гүрвэлүүд)-ийг мөн уусмалд бас арьсийг өвчин хуурайгаар хадгалж болно.

Шавьж хадгалах

Шавьж цуглуулсаны дараа тэдний хуурайгаар үхүүлж хадгалах, уусмалд хийж хадгалах гэсэн 2 үндсэн арга байна. Үхүүлэхэд хлороформ, эфир зэрэг унтуулагч бодис ашигладаг. Хуурайгаар хадгалахдаа үхүүлсэн шавьжаа том жижигээр нь ялган хэвлий том, биеийн зөөлөн эд ихтэй шавьжийг дотор эрхтэнг цэвэрлэн авч хөвөн хийж хадгална. Голдуу бие гүйцсэн, биеийн гадаад бүрхүүл хатуу шавьжнуудыг хуурайгаар хадгална.

Уусмалд хадгалахад голдуу 70° спиртийн уусмал хэрэглэнэ. Мөн 3-4%-н формалины уусмал хэрэглэж болно. Шавьжийн авгалдай, хүүхэлдэй, аалз, чийгийн улаан хорхой зэргийг уусмалд хадгалдаг.
Үхүүлсэн шавьжийг тодорхойлон шинжлэх ухааны нэрийг оноох хүртэл хөвөн зулж бэлтгэсэн мартацан дээр тавьж хатааж хайрцганд хийнэ. Энэхүү хээрийн анхдагч материалын анхны хаяг тайлбарыг маш тодорхой, үнэн зөв бичсэн байх шаардлагатай. Цуглуулсан шавьжийг тодорхойлон үзмэр бэлтгэхийн тулд шавьж хатгахад зориулсан тусгай зүү ашиглана. Шавьжийн баг тус бүрд зүүгээр хатгах, дэлгэмэл үзмэр материал бэлтгэх харилцан адилгүй өөр өөр байдаг.

Ургамал

Дээд ургамлын гадаад бүтэц

Ургамал таньж тодорхойлохын тулд ургамлын гадаад бүтцийн тухай мэдлэгтэй байх хэрэгтэй. Ургамлын биеийн бүр эрхтнийг үржлийн эрхтэн (цэцэг, жимс), ургал эрхтэн (иш, навч, үндэс) хэмээн хуваана. Эдгээр эрхтнүүдийн хэлбэр, хэмжээ, байрлал зэрэг нь ургамал бүрд харилцан адилгүй ба ямар зүйл болохыг нь тодорхойлдог юм. Монголын ургамлын аймаг нь хуурай эрс тэрс уур амьсгалын нөлөөгөө зүйлийн бүрдэл харьцангуй ядмаг боловч нутаг дэвсгэр уужим, газрын гадарга өвөрмөц зэрэг олон шалтгаанаас сонирхолтой ургамлууд цөөнгүй юм.

Ургамлын аймагт одоогоор 128 овгийн 662 төрлийн 2823 зүйл дээд гуурст ургамал, 38 овгийн 162 төрлийн 417 зүйл хөвд, 30 овог, 57 овог 133 төрөл 1000 зүйлийн хаг, 28 овог 136 төрлийн 875 зүйлийн мөөг, 9 хүрээний 59 овгийн 168 төрлийн 1200 зүйлийн замаг бүртгэгдээд байна. Үүнээс дээд гуурст ургамлын ихэнх зүйлийг багтаасан 20 томоохон овог байна. Мөн үлдвэр (реликт), унаган (эндемик) завсрын унаган (субэндемик) зэрэг зүйлүүд манай ургамлын аймагт тодорхой хувийг эзэлдэг.

Монгол оронд өргөн уудам газар нутагтай эх газрын эрс тэрс уур амьсгалтай учир ургамалжилтын хувьд нилээд онцлог юм. Ургамалжилт нь далайн түвшнээс дээшлэх тутам өөрчлөгдөх ба нам дор газраас өндөр уул хүртэл ургамалжилтын янз бүрийн хэвшинжүүд харилцан солигдож байдаг. Иймээс монгол оронд газрын гадаргын онцлогтой холбоотой ургамалжилтын 6 бүс бүслүүр бий.

- Өндөр уулын (тагийн) бүслүүр (3,0%)
- Уулын тайгын бүслүүр (4,1%)
- Уулын хээрийн буюу уулын ойт хээрийн бүслүүр (25,1%)
- Хээрийн бүс (26,1%)
- Заримдаг цөл буюу цөлөрхөг хээрийн бүс (27,2%)
- Цөлийн бүс (14,5%)

Мөн монгол орны ургамлын аймгийг ургамал газарзүйн 16 тойрог болгон хувааж үздэг. Энэхүү байгалийн бүс бүслүүр болон ургамал газарзүйн тойрог бүрт өвөрмөц онцлогтой болон өөр хоорондоо ялгаатай ургамлан хэвшинж, бүлгэмдэлүүд тархан ургах бөгөөд тухайн орон нутаг аль бүс бүслүүр болон тойрогт хамаарахыг мэдвэл цуглуулга хийсэн ургамлаа таньж тодорхойлоход хялбар байх болно.

Цуглуулга хийх

Байгалийн нөхцөлд цуглуулгийн зорилгоор өдрийн турш ургамал цуглуулж болох боловч цаг агаар хуурай бол хамгийн зохимжтой юм. Чийг ихтэй үед авсан ургамал муудаж гэмтэмтгий байдаг. Хатаадас хийхээр авсан ургамлын бүх эрхтэн бүтэн, өвчин, хорлогчдод идэгдэж гэмтээгүй байх хэрэгтэй. Үндэс, иш, навч, цэцэг бүгдийг салгалгүй цуглуулж байгаа төрхөөр нь хадгална.

Цуглуулсан ургамал бүхэнд анхан шатны хаяг заавал бичиж хийсэн байх хэрэгтэй. Хаяг этикетка гэдэг нь тухайн ургамлыг цуглуулсан орон нутгийн нэр, ургах орчин, авсан он, сар, өдөр, цуглуулсан хүний нэрийг хэлнэ.

Хатаадас цуглуулах, бэлтгэх явцад зөв хийсэн хаяг нь эрдэм шинжилгээний чухал баримт мөн. Хаяггүй гербари /хатаадас/ хичнээн сайн хийгдсэн байлаа ч сургалт болон судалгааны ямар ч ач холбогдолгүй байдаг. Иймд хаягыг зөв, нягт нямбай бичиж хавсаргах хэрэгтэй.

Ургамлын амьдралын хэлбэрүүд

Олон зүйл ургамал адилхан нөхцөлд өөр өөр замаар зохицох, үүний зэрэгцээ өөр өөр овог, төрөл, зүйл ургамлууд нэг янз орчинд адилхан байдлаар амьдрах тал бий. Амьдралын хэлбэр үүсэхэд гадаад орчин чухал нөлөөтэй.

- Модлог ургамлууд
- Сөөгөнцрүүд
- Заримдаг сөөгөнцрүүд
- Өвслөг ургамлууд

ургамал бүхэн олон хүчин зүйлийн нөлөөнд оршин байх ба тэдгээрээс нэг нөхцөл нь давамгайлж байдаг. Үүнд ургамал бүр зохицож гадаад дотоод бүтэц, үйл ажиллагаагаараа ойролцоо болсон байдаг. Тэдгээрийг экологийн бүлгүүд гэнэ.

- Гидрофитүүд: бүхлээрээ юмуу доод хэсэг нь усанд ургадаг цэцэгт ургамлуудыг хэлнэ.
- Гигрофитүүд: гол горхины эрэг, намаг мөн усанд үе үе автдаг нугын их чийгтэй орчинд ургана.
- Мезофитүүд: чийгийн хангамж сайтай газар ургана. Нугын ургамлууд
- Ксерофитүүд: хуурайвтар гандуу нутагт зохицон ургах ба хөрс, агаарын ганы үед усны дутагдалыг тэсвэрлэх чадвартай бүлэг ургамал юм.

Мэргэжлийн талаас туслалцаа авч хамтран ажиллахыг хүссэн байгууллага, иргэд доорх хаягаар бидэнтэй харьцана уу.

Хаяг: Монголын Байгалийн Түүхийн Музейн эрдэм шинжилгээ, аргазүй сан хөмрөгийн тасаг
Шуудангийн хаяг: Улаанбаатар -46, Хувьсгалчдийн өргөн чөлөө, Самбуугийн гудамж
Утас: 324543, 318179
e-mail: beetle_msg@yahoo.com

Байгалийн түүхийн музейн эрдэм шинжилгээний тасгийн эрхлэгч
Н.Жавзмаа
Байгалийн түүхийн музейн эрдэм шинжилгээний ажилтан
Б.Алтантуяа

Хэмжилт хийх

Сүүлтэй хоёр нутагтаны биеийн хэмжээг авах

Товчилсон тэмдэг	Хэмжих зүйл	Хэмжих арга
L.	Биеийн урт	Хоншоорын үзүүрээс клоакийн /хойд сүв/ -ийн дунд хүртэл
L.c.	Толгойн урт	Хоншоороос дагз хүртэл
L.cd.	Сүүлийн урт	Клоакийн өмнөөс сүүлийг шувтартал
P.a.	Урд хөлийн урт	Урд мөчний их биетэй нийлэх үеэс хамгийн урт хурууны үзүүр хүртэл
P.p.	Хойд хөлийн урт	Хойд мөчний их биетэй нийлэх үеэс хамгийн урт хурууны үзүүр хүртэл

Сүүлгүй хоёр нутагтаны биеийн хэмжээг авах арга

Товчилсон тэмдэг	Хэмжих зүйл	Хэмжих арга
L.	Биеийн урт	Хоншоороос клоакийн дунд хүртэл /нуруугаар нь тавьж дарж байгаад хэмжинэ/
L.c.	Толгойн урт	Хоншоорийн үзүүрээс дагзны сүв хүртэл
D.r.o.	Нүднээс хоншоор хүртлэх зай	Хоншоороос нүдний өмнөд үзүүр хүртэл
Sp.c.r.	Хоншоорийн өргөн	Нүдний өмнөд талаар хамрын бараан зурвасны дотоод захын хоорондын зай
L.o.	Нүдний урт	Нүдний хамгийн их уртыг хоолой дээр хуруугаар арж байгаад хэмжинэ
Lt.p	Зовхины өргөн	Дээд зовхины их өргөн
L.tym.	Хэнгэрэгийн урт	Хэнгэрэгийн хамгийн их урт
F.	Гуяны урт	Клоакийн дундаас өвдөгний үе хүртэл хөлийг нугалсан байдлаар хэмжинэ
T.	Шилбэний урт	Шилбийг мөн нугалсан байдалд хэмжинэ
D.p.	1-р хурууны урт	Ходй хөлийн сарвууны дотоод төвгөрөөс 1-р хуруу хүртэл
C.int.	Дотоод төвгөр	Хойд хөлийн сарвууны дотоод төвгөрийн хамгийн урт

Хөхтөн амьтны биеийн үндсэн хэмжээс авах арга

Товчилсон тэмдэг	Хэмжих зүйл	Хэмжих арга
L.	Биеийн урт	Хамрын үзүүрээс сүүлний уг хүртэл /нурууны хотгор гүдгэрийг дагуулан туузан метрээр/
C.	Сүүлний урт	Сүүлний угаас үзүүр хүртэл /үс оруулахгүй/
P.	Тавхайн урт	Өсгийний хойд захаас хамгийн урт хурууны үзүүр хүртэл /хумс орохгүй/
A.	Чихний урт	Доод сэтэрхийгээс торгон үзүүр хүртэл /үс орохгүй/
G.	Биеийн жин	Амьдын жин

Шувууны биеийн үндсэн хэмжээс авах арга

Товчилсон тэмдэг	Хэмжих зүйл	Хэмжих арга
L.	Биеийн урт	Хушууны үзүүрээс сүүлний үзүүр хүртэл
A.	Далавчны урт	Мөрнөөс далавчны хамгийн урт өдний үзүүр хүртэл
K.	Хушууны урт	Хушууны угаас шулуунаас хянга дагуулан үзүүр хүртэл
C.	Сүүлний урт	Сүүлний уугаас хамгийн урт өдний үзүүр

		хүртэл
T.	Тарсны урт	Улнаас өсгий хүртэл
P.	Биеийн жин	Амьдын жин / том шувуу кг-аар, жижгийг граммаар

Загасны биеийн үндсэн хэмжээс авах арга

Товчилсон тэмдэг	Хэмжих зүйл	Хэмжих арга
L.	Биеийн урт	Загасны овгоор өөр өөр хэмждэг. Хошуунаас сүүлний далбангын үзүүр хүртлэх зай
H.	Биеийн өндөр	Нурууны сэлүүрийн өмнүүр хэмжсэнийг их өндөр (H), сүүлний нарийн хэсгээр хэмжсэнийг бага өндөр (h) гэнэ.
A.	Далбаа	Ялгаруулах сүвний ард байрладаг хос бус сэлүүр. Энэ сэлүүрийн гуурсны тоо ангилалзүйн холбогдолтой.
f.	Дух	Хоёр нүдний хоорондын зай, заримдаа духны өргөн гэж нэрлэдэг.
pl.	Сүүл	Ялгаруулах сүвээс сүүлний далбангын зах хүртлэх биеийн хэсэг.
D.	Сэрвээний сэлүүр	Нуруун талд ургасан цувраа буюу өрөөсөн сэлүүр
C.	Толгойн урт	Хошуунаас заламгайн хавхагын хамгийн алсалсан зах хүртлэх зай.
ll	Хажуугийн журам	Биеийн хоёр хажууг даган байрласан нарийхан сүвээр холбоотой эгнээ хайрсан шугам

Хавсралт

Монгол орны улаан номонд бүртгэгдсэн амьтан, ургамал

Хөхтөн амьтад (MAMMALIA)

1. *Erinaceus dauricus* - Дагуур зараа
2. *Talpa altaica* -Алтайн чацуулин
3. *Vespertilio superans* – Дорнодын сармаахай
4. *Citellus alaschanicus*– Гозоорой зурам
5. *Castor fiber birulai* – Төв азийн минж
6. *Dryomys nitedula*– Ойн унтаахай
7. *Meriones tamariscinus*– Сухайн чичүүл
8. *Salpingotus kozlovi* – Элсний атигдаахай
9. *Salpingotus crassicaudata* - Өөхлөг атигдаахай
10. *Euchoreutus naso*– Соотон алагдаага
11. *Cardiocranius paradoxus*– Таванхуруут атигдаахай
12. *Felis lybica (silvestris)* – Цоохондой
13. *Uncia uncia* - Ирвэс
14. *Ursus arctos gobiensis* – Мазаалай
15. *Cuon alpinus* – Цөөвөр чоно
16. *Lutra lutra* – Голын халиу
17. *Vormela peregusna* – Эрээн хүрэн
18. *Equus hemionus hemionus* – Монгол хулан
19. *Equus przewalskii* - Тахь
20. *Camelus bactrianus ferus* – Хавтгай
21. *Sus scrofa nigripes* – Зэгсний гахай
22. *Moschus moschiferus* – Хүдэр
23. *Alces alces pfizenmayeri* – Шивэр хандгай
24. *Alces alces cameloides* – Хар мөрний хандгай
25. *Rangifer tarandus* – Цаа буга
26. *Saiga tatarica tatarica* – Соргог бөхөн
27. *Saiga tatarica mongolica* – Монгол бөхөн
28. *Gazella subgutturosa*– Хар сүүлт зээр
29. *Capra sibirica*– Янгир
30. *Ovis ammon* – Алтайн аргаль

Шувууд (AVES)

1. *Pelecanus crispus* - Борцгор хотон
2. *Egretta alba* - Цасч дэглий
3. *Platalea leucorodia* - Халбаган хушуут
4. *Ciconia boyciana* - Хар хушуут өрөвтас
5. *Ciconia nigra* - Хар өрөвтас
6. *Anser indica* - Хээрийн галуу
7. *Anser cygnoides* - Хошуу галуу
8. *Cygnus cygnus* - Гангар хун
9. *Cygnus olor* - Хуруут хун
10. *Anas formosa* - Байгалийн нугас
11. *Aix galericulata* - Халзан ангир
12. *Aythya baeri* - Ухаа шумбуур
13. *Oxyura leucocephala* - Ямаан сүүлт нугас
14. *Pandion haliaetus* - Явлаг сар
15. *Haliaeetus albicilla* - Усны цагаан сүүлт бүргэд
16. *Gyps himalayensis* - Цастны хажир бүргэд
17. *Tetraogallus altaicus* - Алтайн хойлог
18. *Phasianus colchicus* - Гургуул
19. *Grus leucogeranus* - Цагаан тогоруу
20. *Grus vipio* - Цэн тогоруу
21. *Grus monacha* - Хар тогоруу
22. *Otis tarda* - Тоодог

23. *Chlamydotis undulata* - Жороо тоодог
24. *Limnodromus semipalmatus* - Азийн цууцаль
25. *Larus ichthyaetus* - Итэлгэн цахлай
26. *Larus relictus* - Реликт цахлай
27. *Podoces hendersoni* - Хулан жороо
28. *Saxicola insignis* - Өгөөлэй шулганаа
29. *Paradoxornis heudei* - Хургач бор
30. *Remiz pendulinus* - Уран шувуу

Хоёр нутагтан (AMPHIBIA)

1. *Salamandrella keyserlingii Dyb., 1870* - Шивэр гүлмэр
2. *Bufo danatensis Pisanetz, 1978*- Дундад азийн бах
3. *Hyla japonica Gunh., 1859*- Модны мэлхий
4. *Rana chensinensis David, 1875*- Дорнодын мэлхий

Мөлхөгчид (REPTILIA)

1. *Cyrtopodion elongatus Blanf., 1875*- Говийн махир хуруут гекKон
2. *Phrynocephalus helioscopus Pall., 1771*- Тойрмын хонин гүрвэл
3. *Eremias arguta Pall., 1773*- Толбот гүрвэл
4. *Eryx tataricus Licht., 1823*-Тэмээн сүүл могой
5. *Coluber spinalis Peters., 1866*- Нарийн могой

Дугариг амтан (AGNATHA)

1. *Lampetra japonica* –Шивэр жарас

Загас (PISCES)

1. *Acipenser baeri baicalensis* - Шивэр хилим
2. *Acipenser schrencki* – Хар мөрний хилим
3. *Hucho taimen*- Тул
4. *Coregonus autumnalis migratorius* – Монгол омоль
5. *Tinca tinca* – Үхэрдэй
6. *Mesocottus haitej* – Зантахай загас

Шавьж (INSECTA)

1. *Aeshna juncea mongolica* – Дамнуурга цэнхэр соно
2. *Scarabaeus typhoon* – Шүтээн цох
3. *Aromia moshata orientalis* – Дорнын заарт эвэрт цох
4. *Parnassius Apollo* – Аполлон дэвүүр
5. *Parnassius eversmanni* - Эверсманны дэвүүр
6. *Parnassius stubbendorfi* – Штуббендорфийн дэвүүр
7. *Parnassius pheobus* – Фэб дэвүүр
8. *Parnassius tenedius* – Зүүн Сибирийн дэвүүр
9. *Papilio machaon* – Махаон дэвүүр
10. *Eudia pavonia* – Бага тогосон одот
11. *Macroglossum stellatarum* – Эгэл хошуулаг шумбуур
12. *Deiliphila elpenor* – Инжирийн шумбуур
13. *Hemaris tityus* – Бэр цэцэгч шумбуур
14. *Sphinx ligustri* – Голтборын шумбуур
15. *Bombus muscorum* – Хөвдний үхэр хэдгэнэ
16. *Bombus modestus* – Модестус үхэр хэдгэнэ
17. *Bombus sporadicus* – Спорадикус үхэр хэдгэнэ
18. *Bombus subbaicalensis* - Байгалийн үхэр хэдгэнэ
19. *Satanus gigas* - Их эрлэг ялаа

Хавч хэлбэртэн (CRUSTACEA)

1. *Leander modestus* – Хар мөрний хавч
2. *Cambaroides dauricus* – Голын хавч

Зөөлөн биетэн (MOLLUSCA)

1. *Dahurinaia dahurica* – Дагуурын сувдан хясаа

2. *Cristaria plicata* – Дэлт танан хясаа
3. *Anodonta sedakovi* – Сэлэнгийн танан хясаа
4. *Middendorffinaia mongolica* – Монгол танан хясаа

Ургамал (PLANT)

1. *Botruchium lanceolatum* – Юлдэн шүүдэр ойм
2. *Lycopodium alpinum* – Тагийн шивэрс
3. *Lycopodium clavatum* – Балуун шивэрс
4. *Lycopodium complanatum* – Хавчгар шивэрс
5. *Abies sibirica* – Сибирь жодоо
6. *Larix dahurica* – Дагуур шинэс
7. *Pinus pumila* – Одой нарс
8. *Ephedra equisetina* – Морин зээргэнэ
9. *Juniperus pseudosabina* – Хуурамч хонин арц
10. *Juniperus sabina* – Хонин арц
11. *Populus diversifolia* – Элдэв навчит улиас
12. *Iljinia regelii* – Регелийн будраа
13. *Stellaria dichotoma* - Ацан ажигана
14. *Gymnocarpos przewalskii* – Улаан түлээ
15. *Nympaea candida* - Цав цагаан бөлбөө
16. *Nympaea tetragona* – Дөрвөлжин бөлбөө
17. *Nuphar pumila* – Бяцхан саахуу цэцэг
18. *Adonis mongolica* – Монгол хундгана
19. *Adonis sibirica* – Сибирь хундгана
20. *Paeonia anomala* – Ягаан цээнэ
21. *Paeonia lactiflora* – Цагаан цээнэ
22. *Mitella nuda* – Нүцгэн товьцэцэг
23. *Saxifraga hirculus* – Ямаан сэрдэг
24. *Rhodiola rosea* - Алтан гагнуур
25. *Drosera anglica* – Англи үстхиг
26. *Drosera rotundifolia* – Төгрөгнавчит үстхиг
27. *Amydgalus mongolica* – Монгол бүйлэс
28. *Potaninia mongolica* – Хулан хойрго
29. *Sorbaria sorbifolia* - Тэснавчит тэсмэг
30. *Ammopiptanthus mongolicus* – Монгол мөнххаргана
31. *Astragalus dschimensis* – Жинийн хунчир
32. *Caragana brachypoda* – Хойрог харгана
33. *Caragana gobica* – Говийн харгана
34. *Gueldenstaedtia monophylla* – Ганц навчит сальжир
35. *Halimodendron halodendron* – Мөнгөлөг хонхот харгана
36. *Hedysarum sangilense* – Цэнгэлийн шимэрс
37. *Oxytropis acanthacea* – Шивүүрт ортууз
38. *Oxytropis fragalifolia* – Хэврэгнавчит ортууз
39. *Oxytropis mongolica* – Монгол ортууз
40. *Oxytropis grubovii* – Грубовын ортууз
41. *Saphora flavescens* – Шаравтар лидэр
42. *Vicia tsydenii* – Цэдэнгийн гиш
43. *Peganum harmala* – Эгэл өмхий өвс
44. *Dictamnus dasycarpus* – Бавгарүрт агчаахай
45. *Elaeagnus moocroftii* – Мукрофтын жигд
46. *Cynomorium songaricum* – Зүүнгарын гоёо
47. *Ferula ferulaeoides* – Залаархаг хавраг
48. *Rhododendron adamsii* – Адамсын тэрэлж
49. *Rhododendron aureum* – Алтан тэрэлж
50. *Rhododendron dauuricum* – Дагуур тэрэлж
51. *Rhododendron ledebourii* – Ледебурын тэрэлж
52. *Rhododendron parvifolium* – Жижигнавчит тэрэлж
53. *Vaccinium myrtillus* – Хар нэрс
54. *Androsace longifolia* – Уртнавчит далантовч
55. *Gentiana algida* – Цагаан дэгд

56. *Caryopteris mongolica* – Монгол догар
57. *Physochlaina albiflora* – Цагаан хүнхорс
58. *Lancea tibetica* – Төвд баягзаваа
59. *Incarvillea potaninii* – Потанины улаантулам
60. *Cistanche deserticola* – Цөлийн аргамжин цэцэг
61. *Sambucus manshurica* – Манж гандигар
62. *Viburnum mongolicum* – Монгол бүрэлгэнэ
63. *Viburnum sargentii* – Саржентийн бүрэлгэнэ
64. *Valeriana officinalis* – Эмийн бамбай
65. *Artemisia lithophila* - Чулуусаг шарилж
66. *Brachanthemum gobicum* – Говийн тост
67. *Brachanthemum mongolorum* – Монгол тост
68. *Chrysanthemum sinuatum* – Оньт тонхуу
69. *Jurinea mongolica* – Монгол чоногоно
70. *Krylovia eremophila* – Цөлийн өнчинцэрэв
71. *Leuzea carthamoides* – Мөгөөрсхэй хонхорцгоно
72. *Olgaea leucophylla* – Цагааннавчит хасзул
73. *Olgaea lomonosowii* – Ломоносовын хасзул
74. *Saussurea dorogostaiskii* – Дорогостайскийн банздоо
75. *Saussurea involucrata* – Нөмрөгт банздоо /Вансэрбэрүү/
76. *Tugarinovia mongolica* – Монгол шардалан
77. *Allium altaicum* – Алтайн сонгино
78. *Allium macrostemon* – Томдохиурт сонгино
79. *Allium obliquum* – Сармисан сонгино
80. *Anemarrhena asphodeloides* – Тансаг номилгоно
81. *Convallaria keiskei* – Кейскийн хонхонцор
82. *Lilium dahuricum* – Дагуур сараана
83. *Tulipa uniflora* – Ганццэцэгт алтанзул
84. *Zygadenus sibiricus* – Сибирь адаргана
85. *Calypso bulbosa* – Булцуут түвдэнхавх
86. *Corrallorhyza trifida* – Гурвалсан шүрэнүндэс
87. *Cypripedium calceolus* – Шар саадганцэцэг
88. *Cypripedium macranthon* – Их саадганцэцэг
89. *Epipogium aphyllum* – Навчгүй оочгоно
90. *Neottia camtschatea* – Камчатын хүнхүй
91. *Neottianthe cucullata* – Хөхөө цүнхрэг
92. *Orchis fuchsia* – Фуксийн цахирам
93. *Orchis militari* – Дуулгавчин цахирам
94. *Platanthera bifolia* – Хоснавчит шөнийн нил
95. *Acorus calamus* – Эгэл годил өвс
96. *Carex parva* – Бага улалж
97. *Carex selengensis* – Сэлэнгийн улалж
98. *Kobresia robusta* – Их бушилз
99. *Festuca komarovii* – Комаровын ботууль
100. *Melica nutans* – Бөхөгөр шогшрого

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн нэрийн товч толь

AMPHIBIA -Хоёр нутагтаны анги

Caudata -Сүүлтэй хоёрнутагтаны баг
Hynobiidae -Гүлмэрийн овог
1. *Salamandrella keyserlingii Dyb., 1870* - Шивэр гүлмэр

Anura -Сүүлгүй хоёрнутагтаны баг
Bufonidae - Бахын овог
2. *Bufo bufo L., 1758*- Бор бах
3. *Bufo danatensis Pisanetz, 1978*- Дундад азийн бах
4. *Bufo raddei Str., 1876*- Монгол бах

Hylidae -Модны мэлхийн овог

5. *Hyla japonica Gunh., 1859*- Модны мэлхий

Ranidae -Мэлхийн овог

6. *Rana amurensis Boul., 1886*- Шивэр мэлхий
7. *Rana arvalis Nils., 1842*- Шөвгөр мэлхий
8. *Rana chensinensis David, 1875*- Дорнодын мэлхий
9. *Rana nigromaculata Hallo., 1860*- Хар толбот мэлхий

REPTILIA -Мөлхөгчидийн анги

Lacertilia-Гүрвэлийн салбар овог

Gekkonidae -Геккон гүрвэлийн овог

1. *Alsophylax pipiens Pall., 1813*- Төмөр гүрвэл
2. *Cyrtopodion elongatus Blanf., 1875*- Говийн махир хуруут геккон
3. *Terastocincus przewalskii Str., 1877*- Нохой гүрвэл

Agamidae -Замба гүрвэлийн овог

4. *Stellio stoliczkanus Blanf., 1875*- Замба гүрвэл
5. *Phrynocephalus helioscopus Pall., 1771*- Тойрмын хонин гүрвэл
6. *Phrynocephalus versicolor Str., 1876*- Цоохор хонин гүрвэл

Lacertidae -Жинхэнэ гүрвэлийн овог

7. *Eremias argus Peters., 1869*- Монгол гүрвэл
8. *Eremias arguta Pall., 1773*- Толбот гүрвэл
9. *Eremias multiocellata Gunth., 1872*- Могой гүрвэл
10. *Eremias przewalskii Str., 1876*- Говийн гүрвэл
11. *Eremias vermiculata Blanf., 1875*- Загалт гүрвэл
12. *Lacerta agilis L., 1758*- Гавшгай гүрвэл
13. *Lacerta vivipara Jacquin, 1787*- Зулзагалагч гүрвэл

Serpentes-Могойн салбар баг

Boidae-Аврага могойн овог

1. *Eryx tataricus Licht., 1823*-Тэмээн сүүл могой

Colubridae -Хар могойн овог

2. *Coluber spinalis Peters., 1866*- Нарийн могой
3. *Elaphe dione Pall., 1773*- Рашааны могой
4. *Elaphe schrencki Str., 1873*-Хар мөрний цариг могой
5. *Natrix natrix l., 1758*- Усны могой
6. *Psammophis lineolatus Brandt., 1838*- Суман могой

Crotalidae -Хоржигнуурт могойн овог

7. *Agkistrodon halys Pall., 1776*- Бамбай хоншоорт могой

Viperidae -Загалмайт могойн овог

8. *Vipera berus L., 1758*- Энгэл загалмайт могой
9. *Vipera ursini Bonap., 1835*- Хээрийн загалмайт могой

Монгол орны загасны нэрийн товч толь

MARSIPOBRANCHII-ДУГАРИГ АМТНЫ АНГИ

Hyperoartia –Жарастаны баг

Petromyzonidae – Жарасынханы овог

1. *Lampetra reissneri* –Могой жарас
2. *Lampetra japonica* –Шивэр жарас

TELEOSTEI –ХАГАДАСТ ЗАГАСНЫ АНГИ

Glaniostomi –Хилэмтэний баг

Acipenseridae – Хилэмийнхэний овог

3. *Huso dauricus* - Аврага загас
4. *Acipenser baeri* - Шивэр хилэм
5. *Acipenser schrencki* – Ононы хилэм

Isospondyli – Цагаалжтаны баг

Salmonidae – Хулдынханы овог

6. *Hucho taimen*- Тул
7. *Brachymystax lenok* – Зэвэг

Coregonidae – Цагаагасынханы овог

8. *Coregonus autumnalis migratorius* – Байгалын омоль
9. *Coregonus chadary*- Цагаан хадир
10. *Prosopium cylindraceum* – Булуусгай
11. *Coregonus lavaretus pidschian* – Цагаан загас
12. *Coregonus peled* - Жарга
13. *Coregonus sardinella* – Зарам

Thymallidae – Хадрангийнханы овог

14. *Thymallis arcticus* – Шивэр хадран
15. *Thymallis brevirostris* – Монгол хадран
16. *Thymallis grubei* – Ононы хадран
17. *Thymallis nigrescens* – Хөвсгөлийн хадран

Haplomi – Цурхайтаны баг

Esocidae – Цурхайнханы овог

18. *Esox lucius* – Ердийн цурхай
19. *Esox reicherti* – Амарын цурхай

Eventognathi – Мөрөгтөний баг

Cyprinidae – Мөрөгийнхэний овог

20. *Rutilus lacustris* – Улаан нүдэн
21. *Oreoleuciscus potanin* – Алтайн сугас
22. *Oreoleuciscus pewzowi* – Нохой сугас
23. *Oreoleuciscus humilis* – Давжаа сугас
24. *Leuciscus baicalensis* –Шивэр сугас
25. *Leuciscus idus* – Бух сугас
26. *Leuciscus waleskii* – Амарын сугас
27. *Phoxinus czekanowskii* – Чекановын варлан
28. *Phoxinus lagowskii* – Лаговскийн варлан
29. *Phoxinus phoxinus* – Ердийн варлан
30. *Phoxinus percnurus* – Нуурын варлан
31. *Ctenopharyngodon idella* – Цагаан амар
32. *Pseudaspius leptocephalus* – Улаан живэрт
33. *Tinca tinca* – Шаргал үхэрдэз
34. *Pseudorosbora parva* – Амарын хөөленхэй
35. *Gobio albipinatus* – Сахалт гүрц
36. *Gobio gobio cynocephalus* – Шивэр гүрц
37. *Gobio gobio* – Ердийн гүрц
38. *Gobio soldatovi* – Солдатовийн гүрц
39. *Gobio soldatovi tungussicus* – Түнгүсийн гүрц
40. *Gnathopodon chankaensis* – Ханхын гүрц
41. *Sarcocheilichthys nigripinnus* – Хар гүрц
42. *Ladislavia taczanowskii* – Тачановын гүрц
43. *Saurogobio dabryi* - Хадаасан гүрц
44. *Microphysogobio amurensis* – Монхор гүрц
45. *Paraleucogobio stringatus* – Сугасан гүрц
46. *Hemibarbus labeo* – Морин тавхрал
47. *Hemibarbus maculatus* – Морин харвал

48. *Erythroculter erytropterus* – Цагаан догтор
49. *Erythroculter mongolicus* – Улаан далбаат
50. *Culter alburnus* - Өлгөр цагаан
51. *Hemiculter leucisculus* – Ердийн хавчигас
52. *Hemiculter warpachowskii* – Амарын хавчигас
53. *Rhodeus sericeus* – Халбаган жараа
54. *Acanthorhodeus asmussi* - Харваа
55. *Carassius carassius* – Алтлаг хэлтэг
56. *Carassius auratus* –Мөнгөлөг хэлтэг
57. *Cyprinus carpio haematopterus* – Булуу цагаан
58. *Hypophthalmichthys molitrix* - Дух давхаа

Cobitidae – Яралжийнханы овог
59. *Noemacheilus barbatulus* – Сахалт эрээлж
60. *Noemacheilus stolichkai* – Тангад эрээлж
61. *Noemacheilus strauchi* – Толбот эрээлж
62. *Cobitis taenia sibirica* – Шивэр яралж
63. *Cobitis taenia* – Чимхүүр загас
64. *Misgurnus anguillicaudatus* – Ердийн моголзой
65. *Lefua costata* – Наймас эрээлж

Siluridae – Цулбууртныханы овог
66. *Parasilurus asotus* – Ердийн цулбуурт
67. *Silurus soldatovi* – Амарын лах

Anacanthini – Сагамхайтаны баг
Gadidae – Хутарынханы овог
68. *Lota lota* – Ердийн хутар
Percomorphi – Алганатаны баг
Percidae – Алганыханы овог
69. *Perca fluviatilis* – Алгана
Cottidae – Живэртийнхэний овог
70. *Cottus poecilopus* – Эрээн живэрт
71. *Cottus sibiricus* – Шивэр эрээн живэрт
72. *Mesocottus haitej* – Зантгар загас
73. *Paracottus kessleri* – Элсний эрээн живэрт
Gobiyidea – Цоохлойтоны баг
Eleotridae – Цоохлойнхоны овог
74. *Eleotris glehni* – Тогтмолын цоохлой

Монгол орны хөхтөн амьтдын нэрийн товч толь

INSECTIVORA – ШАВЬЖ ИДЭШТЭНИЙ БАГ
Erinaceidae - Зараанызханы овог
1. *Erinaceus dauricus Sundevella..1841-* Дагуурын зараа
2. *Erinaceus auritus Gmelin.,1770* - Дэлдэн зараа

Talpidae Gray,1821- Чацуулиныханы овог
3. *Talpa altaica Nik.,1883* -Алтайн чацуулин

Soricidae Gray,1821 – Жөвүүгийнхэний овог
4. *Sorex daphaenodon Thomas.,1907* - Бэсрэг атаахай
5. *Sorex vir Gl.Allen.,1914* - Тавшгай атаахай
6. *Sorex caecutiens Lax.,1788* - Дааган атаахай
7. *Sorex minutissimus Zim.,1780* - Өөдсөн атаахай
8. *Sorex tundrensis Mer.,1900* - Цармын атаахай
9. *Sîrex araneus.,L.,1758* - Хэвлүүн атаахай
10. *Sorex isodon Turov, 1924* - Тэгш Шүдэт атаахай
11. *Sorex minutus L .,1766* - Хонин атаахай
12. *Neomys fodiens Pen.,1771* - Усч гэрэлзгэнэ

13. *Crocidura sauveolens Pall.,1811* - Хонин малтаахай
14. *Crocidura Leucodom Nerm.,1780* - Цагаан хэвлийт малтаахай

CHIROPTERA – ГАР ДАЛАВЧТАНЫ БАГ

Vespertilionidae

15. *Myotis mystacinus Kuhl, 1819* – Сахалт багваахай
16. *Myotis daubentoni Kuhl, 1819* – Усны багваахай
17. *Myotis brandtii Ever., 1845* – Брандтын багваахай
18. *Myotis ikonnikovi Ogn., 1911* – Иконниковын багваахай
19. *Plecotus auritus L., 1758* – Жижиг соотон багваахай
20. *Plecotus austriacus Fisch., 1829* – Том соотон багваахай
21. *Nyctalis noctula Schreber, 1774* – Бүрэнхин хонгор багваахай
22. *Pipistrellus savii Bon., 1837* – Турсган сармаахай
23. *Eptesicus nilssoni Keys. Et Blas., 1839* – Умардын сармаахай
24. *Eptesicus gobiensis Bobr., 1926* – Говийн сармаахай
25. *Vespertilio murinus L., 1758* – Буурал сармаахай
26. *Vespertilio superans Thom., 1898* – Дорнодын сармаахай

LAGOMORPHA – ТУУЛАЙ ХЭЛБЭРТЭНИЙН БАГ

Ochotonidae

27. *Ochotona daurica Pall., 1776* – Дагуур огдой
28. *Ochotona pallasi Gray, 1867* – Монгол огдой
29. *Ochotona alpina Pall., 1773* – Тагийн огдой
30. *Ochotona hyperborea Pall., 1811* – Асганы огдой

Leporidae

31. *Lepus tolai Pall.,1778* – Бор туулай
32. *Lepus timidus L., 1758* – Чандага
33. *Lepus tibetanus Water., 1841* – Түвд туулай

RODENTIA – МЭРЭГЧДИЙН БАГ

Scuiridae

34. *Sciurus vulgaris L., 1758* – Бараан хэрэм
35. *Tamias sibiricus Lax., 1769* – Жирх
36. *Citellus alaschanicus Buch., 1888* – Гозоорой зурам
37. *Citellus dauricus Brandt, 1844* – Дагуурын зурам
38. *Citellus undulatus Pall., 1888* – Урт сүүлт зурам
39. *Citellus erythrogenus Brandt, 1841* – Бозлог
40. *Marmota sibirica Rad., 1862* – Монгол тарвага
41. *Marmota baibacina Kast., 1899* – Алтайн тарвага

Pteromidae

42. *Pteromys volans L., 1758* – Олби

Castoridae

43. *Castor fiber L., 1758* – Минж

Gliridae

44. *Dryomys nitedula Pall., 1778* – Ойн унтаахай

Cricetidae

45. *Phodopus sungorus Pall., 1773* – Орог зусаг
46. *Phodopus roborovskii Satu., 1903* – Элсний зусаг
47. *Cricetulus migratorius Pall., 1773* – Бор шишүүхэй
48. *Cricetulus longicaudatus Mil.-Ed., 1868-1874* – Урт сүүлт шишүүхэй
49. *Cricetulus barabensis Pall., 1773* – Хөх шишүүхэй
50. *Cricetulus pseudogriceus Orl. et Iskh., 1975* – Байгалийн шишүүхэй
51. *Cricetulus obscurus Milne-Ed., 1868-1874* – Говийн шишүүхэй
52. *Allocricetulus curtatus Allen., 1925* – Цомч шишүүхэй
53. *Myospalax aspalax Pall., 1778* – Дагуур номин
54. *Myospalax psilurus Milne.-Ed., 1868-1874* – Манжуур номин
55. *Ellobius talpinus Pall., 1770* – Сохдой оготно
56. *Ondatra zibethica L., 1766* - Ондоотор
57. *Alticola argentatus Sev., 1879* – Хадны барагчин

58. *Alticola barakshin Ban., 1949* – Говьалтайн барагчин
59. *Alticola macrotus Rad., 1861* – Соёоны барагчин
60. *Alticola strelzovi Kast., 1899* – Тавшгар барагчин
61. *Cletrionomys rutilus Pall., 1779* – Ойн улаан оготно
62. *Cletrionomys rufocanus Sund., 1846-1847* – Ойн хүрэн оготно
63. *Lagurus lagurus Pall., 1773* – Хөх ов
64. *Eolagurus luteus Evers., 1840* – Шар ов
65. *Eolagurus przewalskii Buch., 1888* – Түвд ов
66. *Arvicola terrestris L., 1758* – Усч оготно
67. *Myopus schisticolor Lillj., 1844* – Ойн хөвхөлжин
68. *Microtus arvalis Pall., 1778* – Бараан оготно
69. *Microtus mongolicus Rad., 1861* – Монгол оготно
70. *Microtus maximowiczii Schr., 1858* – Ширгийн оготно
71. *Microtus fortis Buch., 1889* - Өргөөнч оготно
72. *Microtus oeconomus Pall., 1776* – Мэхээрч оготно
73. *Microtus limnophilus Buch., 1889* – Зүлгийн оготно
74. *Microtus gregalis Pall., 1779* – Хэргэлзий оготно
75. *Lasiopodomys brandtii Rad., 1861* – Үлийн цагаан оготно
76. *Lasiopodomys mandarinus Milne-ed.,1867* – Үлийн бор оготно
77. *Meriones meridianus Pall., 1773* – Шар чичүүл
78. *Meriones unguiculatus Milne.-Ed., 1867* – Монгол чичүүл
79. *Meriones tamariscinus Pall., 1773* – Сухайн чичүүл
80. *Rhombomys opimus Licht., 1823* – Морин чичүүл

Muridae

81. *Micromys minutus Pall., 1771* – Чигчий хулгана
82. *Mus musculus L., 1758* – Гэрийн хулгана
83. *Apodemus agrarius Pall., 1771* - Хээрийн хулгана
84. *Apodemus peninsulae Thom., 1906* – Азийн хулгана
85. *Rattus norvegicus berk., 1769* – Бор харх

Zapodidae

86. *Sicista subtilis Pall., 1773* – Хээрийн хулганцар

Dipodidae

87. *Alactagulus pygmaeum Pall.,1779* – Алагдааганцар
88. *Allactaga sibirica For., 1778* – Сибир алагдаага
89. *Allactaga elator Licht., 1825* – Давжаа алагдаага
90. *Allactaga bullata Allen., 1925* – Говийн алагдаага
91. *Allactaga nataliae sok., 1981* - Өмнөговийн алагдаага
92. *Dipus sagitta Pall., 1773* – Савагдаахай
93. *Salpingotus kozlovi Vin., 1922* – Козловын атигдаахай
94. *Salpingotus crassicaudata vin., 1924* - Өөхөн сүүлт атигдаахай
95. *Euchoreutus naso Sklat., 1890* – Соотон алагдаага
96. *Cardiocranius paradoxus Sat., 1902* – Таванхуруут атигдаахай
97. *Stylodipus andrewsi Allen., 1925* – Монгол даахай
98. *Stylodipus sungorus Sok. et Shen., 1987* – Зүүнгарын даахай

CARNIVORA – МАХЧДЫН БАГ

Felidae

99. *Lynx lynx L., 1758* – Шилүүс
100. *Felis manul Pall., 1776* – Мануул
101. *Felis silvestris Schr., 1777* – Цоохондой
102. *Panthera uncia Schr., 1775* - Ирвэс

Ursidae

103. *Ursus arctos L., 1758* – Хүрэн баавгай
104. Ursus arctos gobiensis – Мазаалай

Canidae

105. *Canis lupus L., 1758* – Саарал чоно
106. *Vulpes vulpes L., 1758* – Шар үнэг
107. *Vulpes corsax L., 1758* – Хярс
108. *Nyctereutes procyonoides Gray, 1834* – Нохой элбэнх
109. *Cuon alpinus Pall., 1811* – Цөөвөр чоно

Mustelidae

110. *Lutra lutra l., 1758* – Голын халиу
111. *Meles meles L., 1758* – Дорго
112. *Gulo gulo l., 1758* – Нохой зээх
113. *Martes foina erxl., 1777* – Хадны суусар
114. *Martes zibellina L., 1758* – Ойн булга
115. *Mustela altaica Pall., 1811* – Солонго
116. *Mustela erminae L., 1758* – Цагаан үен
117. *Mustela eversmanni Les., 1827* - Өмхий хүрэн
118. *Mustela nivalis L., 1766* – Хотны үен
119. *Mustela sibirica Pall., 1773* – Ойн солонго
120. *Mustela vison Schr., 1777* – Усны булга
121. *Vormela peregusna Guld., 1770* – Эрээн хүрэн

PERISSODACTYLA – БИТҮҮ ТУУРАЙТНЫ БАГ

Equidae

122. *Equus hemionus Pall., 1775* – Хулан
123. *Equus przewalskii Polj., 1883* - Тахь

TYLOPODA – ТАВХАЙТНЫ БАГ

Camelidae

124. *Camelus ferus Prz.,* 1883 – Хавтгай

ARTIODACTYLA – АЦ ТУРУУТНЫ БАГ

Suidae

125. *Sus scrofa L., 1758* – Зэрлэг гахай

Cervidae

126. *Moschus moschiferus L., 1758* – Хүдэр
127. *Cervus elaphus L., 1758* – Халиун буга
128. *Alces alces L., 1758* – Хандгай
129. *Capreolus pygargus L., 1758* – Бор гөрөөс
130. *Rangifer tarandus L., 1758* – Цаа буга

Bovidae

131. *Procapra gutturosa Pall., 1777* – Цагаан зээр
132. *Saiga tatarica L., 1766* – Бөхөн
133. *Gazella subgutturosa Guld., 1780* – Хар сүүлт
134. *Capra sibirica Pall., 1776* - Янгир
135. *Ovis ammon L., 1758* - Аргаль

Ашигласан ном

1. Баасанжав Г., Цэнд-Аюуш Я., 2001 он Монгол орны загас
2. Байгалийн түүхийн музейн шинжлэх ухаан, танин мэдэхүйн холбогдол эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл 2006 он
3. Бей-Биенко Г.Я., Общая энтомология 1966 г.
4. Бүгд найрамдах монгол ард улсын амьтны аймаг 1-р боть Шавьжийн анги 1987 он
5. Губанов И. А. 1996 он Монгол орны цоргот дээд ургамлын конспект
6. Дуламцэрэн С. 1970 он Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг
7. Жизнь животных Том 1 1965 г
8. Цэндээхүү Ц., Улыкпан К., 1989 он Биологийн хээрийн дадлага
9. Монгол улсын улаан ном 1997 он
10. Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь Улсын нэр томьёоны бичиг №2 (150) 2007 он
11. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр 1996 он
12. Мөнхбаяр Х., Тэрбиш Х., 1997 он Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийг тодорхойлох бичиг
13. Фомин В.Е., Болд А., Каталог птиц МНР 1991 г.

ГУРВАН ХЭМЖЭЭСТ БҮТЭЭЛ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ

(Уран баримал)

Уран баримлын хөгжлийн түүхэн тойм

Дүрслэх урлагийн нэгэн томоохон төрөл уран баримал үүсэл хөгжлийн хувьд нэн эрт үеэс эхлэлтэй бөгөөд монголын түүхийн бүхийл үед үндэсний уран сайхны сэтгэлгээний онцлогийг хадгалан хөгжиж иржээ. Эртний хүмүүс чулууг эмтэлж, зорж, цуулж ахуй амьдралдаа хэрэглэж байсан чулуун эд зүйлээс эхлээд амьтны загварт хүрлийн үеийн дурсгал, манай орны хөдөө хээр элбэг тохиолддог цоолборлон сийлсэн хүн чулуу, буган чулуун хөшөө зэрэг нь уран баримлын эхэн үеийн дурсгалд хамаарна. Түүнчлэн онго шүтээн, бурхан тахил, бэлэг дурсгал төдийгүй барилга, сүм хийдийн гадаад, дотоод чимэглэлийн товгор хотгор ингэмэл, орчин үеийн монументаль урлагийн бүтээл нь бүгд баримлын урлаг юм. Европын суурь уран баримлын хувьд манай оронд 1950 оноос хөгжиж эхлэсэн бөгөөд тухай он оны уран бүтээлийн дээжүүд Монголын уран зургийн галерейд хадгалагдаж байдаг.

Ийнхүү уран баримал нь агуулга хэлбэр, төрөл зүйлийн хувьд маш өргөн цар хүрээтэй урлаг юм.

Манай музейнүүдэд уран баримлын олон төрөл зүйлийн үзмэрүүд байдгийн ихэнх хувийг бурханы шашны хөрөг баримлууд эзэлдэг. Энэ нь монголчуудын урлагийн түүхэнд бурханы шашны урлаг томоохон байр суурь эзлэж байсантай холбоотой.

Буддын шашин Монголд эрт үеэс дэлгэрсэн байна. Түүхэн сурвалжид Монголчуудын өвөг Хүннүгийн Модун Шаньюй (МЭӨ 20-174) үед 3м гаруй өндөр “Бурханы алтан хөрөг” баримлыг шүтэж байсан тухай тэмдэглэсэн байдаг.

XVI зууны хоёрдугаар хагасаас Богд Зонховын шар малгайтны буюу гэлүгван шашин Монголд өргөн дэлгэрснээр дүрслэх урлагийн хөгжилд нэн шинэ үе эхэлсэн юм. Энэ үеэс буддын урлагийн олон төрөл зүйл цэцэглэн хөгжиж байсны дотор уран баримал нь бусдаа тэргүүлэн хөгжсөн. Энэ үеийн гол төлөөлөгч бол Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Г.Занабазар Лувсандамбийжанцан (1635-1724) юм. Тэрбээр гүн ухаантан, хэл шинжээч, улс төр, шашны томоохон зүтгэлтэн төдийгүй уран баримлын урлагт томоохон дэвшил гаргасан хүн билээ. Занабазар бурхан дүрслэлийн хатуу тигийг хүний биеийн сонгодог харьцаатай хослуулан, баяжуулж, бурхан дүрслэлийн үндэсний дэг сургууль бий болгон, хүрэл цутгамлын цоо шинэ аргыг боловсруулжээ. Түүний зүйдэлгүй цул цутгамлын аргаар бүтээсэн сонгодог тиг харьцаа бүхий хосгүй бүтээл болох Язгуурын таван бурхан, 21 Дара эх, Цагаан, Ногоон дара эх, Очирдара, Аюуш зэрэг бүтээлийд Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Гандантэгчинлэн хийд зэрэг газруудад бий. Эдгээр бүтээлүүд монгол төдийгүй дорно дахины уран баримлын урлагт хүндтэй байр суурь эзэлдэг.

XVIII зууны хоёрдугаар хагасаас Монгол оронд газар сайгүй олон тооны сүм хийд баригдаж тахил шүтээний зориулалтаар олон тооны бурхад шаардлагатай болжээ. Энэ үед монгол урчуудын бүтээлүүдээс гадна Хятадаас олон тооны хямд бурхадыг авчирч байжээ. Эдгээр бурхад музейнүүдэд одоо мэр сэр байдаг бөгөөд ур хийц, уран сайхны хувьд монгол урчуудын бүтээлүүдийг гүйцэхгүйгээр барахгүй харьцаа тигийн хувьд алдаатай гэхэд хилсдэхгүй. Тэр үед сүм хийд, сүсэгтэн олонд зориулан том, жижиг хэмжээний шавар баримлыг олноор хэвлэн бүтээж байсан.

XX зууны эхэн үеийн уран баримлын өвөрмөц төрөл зүйл бол цамын баг юм. Цам нь томоохон сүм хийдүүдэд гаргадаг байснаас хамгийн сүрлэг нь 108 цам харайдаг Их хүрээний Жахар цам байлаа. Цамын багийг урлах явдал Монголд ихээхэн өндөр хөгжснийг Чойжин ламын сүм музей, Дүрслэх урлагийн музейд байдаг нэрт шуумалч Пунцаг-Осорын бүтээлүүдээс харж болно. Түүнчлэн сүмийн гадна талын чимэглэлүүд, дотор ханыг товгор ингэмэл, том хэмжээний шуумал, жижиг шавар баримал зэрэг XVIII-XX зууны уран баримлын хосгүй нандин бүтээлүүд цогцоороо Чойжин ламын сүм музейд бий.

Уран баримлын төрөл зүйл, материал, арга ажиллагаа

Уран баримлыг шавар, гууль, хүрэл, зэс, мөнгө, мод, яс, чулуу, цаас зэрэг олон төрлийн материал ашиглан урладаг онцлогтой.

- Шавар. Шавар бол баримлын үндсэн материал юм. Жижиг шавар урлалыг хийхдээ монгол элбэг байдаг улаан, шар шавар ашигладаг ба шавраа хэвэнд хэвлээд шороон будгаар өнгө ялган будаж урладаг байжээ.
- Гууль. Гууль бол зэс, цайрын хайлш, хатуулаг ихтэй металл юм. Иймээс түүгээр урлал хийхдээ цутгах аргыг хэрэглэдэг. Түүний найрлагын 60-90%-ийг зэс эзэлдэг учир зэсний хэмжээнээс хамаарч өнгө нь цайвар шар, алтан шар, улаан хүрэл болдог байна.
- Хүрэл. Хүрэл бол зэс цагаан тугалганы хайлш юм. Энэ нь мөн хатуулаг ихтэй хайлш учир цутгах аргаар урлал хийдэг. Хүрэл хэмээх мателлын мөн чанарыг монгол урчууд XVII зуунаас мэдэрч, олон хосгүй бүтээл урлаж байсан талаар бид мэднэ. Тэр үеийн хүрэл цутгуурын жор, арга ажиллагааны нууцыг одоо ч бүрэн тайлагдаагүй гэж үздэг.
- Зэс. Зэс бол байгал дээр цэврээрээ оршдог, уян зөөлөн металл. Түүгээр хөөлгөж давтаж урлал хийдэг. Зэсийг монгол урчууд аль эрт хүрлийн үеэс ашиглаж иржээ.

· Мөнгө. Мөнгө бол мөн байгал дээр цэврээрээ байдаг, уян зөөлөн давталт сайн авдаг металл бөгөөд хөөмөлдөх аргаар урлал хийдэг. Мөнгийг дархны урлалд эрт үеэс ашиглаж ирсэн ба мөнгөөр урласан баримлын бүтээлүүд манай музейдүүдэд цөөнгүй байдгийн нэг цалин цагаан мөнгөөр хөөмөлдөн урладаг мянгат малчны дурсгалын цом юм.

- Мод. Модон сийлбэр манай музейн үзмэрүүдэд өөрийн гэсэн орон зайг зүй ёсоор эзэлдэг. Хус, хуш, хар мод зэрэг бүх төрлийн модоор сийлбэр хийж болдог байна. Хуш модоор ихэвчлэн авдар, эд зүйлсийн чимэглэл хээ угалз, сийлдэг бол хус модоор шавар, ахуйн хэрэглээний шанага, хутгуур зэргийг урладаг байна. Богд хааны ордон музейд Их хүрээний нэрт сийлбэрч Балганы бүтээл, Чойжин ламын сүм музейд уран Сүрэнгийн урласан Жамсран бурханыг хоруудын хамт бүтээсэн гайхамшигтай модон сийлбэр бий.

- Яс. Ясан сийлбэр бол баримлын урлагийн нэгэн гол төрөл юм. Монгол урчууд тэмээний ясаар цамын хувцасны чимэглэлийг урладаг байсан гэдэг бол зааны ясан сийлбэр мөн бий. Тухайлбал: Монголын уран зургийн галерейд урлагийн гавъяат зүтгэлтэн, сийлбэрч М.Чуваамэдийн зааны соёогоор урласан алдартай сийлбэр бий.

- Чулуу. Монголчууд чулуун урлалын эртний уламжлалтай. Чулуун баримлыг хийсэн аргаар нь чулуугаар урлах, чулуун дээр урлах гэж 2 ангилж болох юм. Манай музейнүүдэд говь нутгаар элбэг байдаг баргилт хэмээх зөөлөн чулуугаар хийсэн сийлбэр болон цагаан, ногоон хаш, шүрэн сийлбэр ч байдаг.

- Шүр. Шүр бол тослог цагаан, ягаан, улаан зэрэг өнгөтэй байдаг далайн гялгар чулуулаг юм. Шүрийг монголчууд гоёл чимэглэлийн урлагт маш өргөн ашиглаж иржээ. Богд хааны ордон музейд VIII Богдын хэрэглэж байсан улаан шүрэн сийлбэртэй хөөрөг, Завхан аймгийн музейд хумсны толионоос томгүй шүрээр сийлсэн бурхан зэрэг ховор бүтээлүүд бий.

- Цаас. Цаасан шуумал нь нимгэн, хөнгөн, ямарч нарийн дүрслэл гаргаж болдог зэргээс гадна овор хэмжээ томтой бүтээл хийж болдог байна. Цаасан шуумлын гол бүтээл бол цамын баг юм.

Баримлыг ихэвчлэн нэг материал, арга ажиллагаараар урладаг бол цамын багийг урлахад олон төрлийн материал, арга ажиллагаа ордог онцлоготой. Жамсран бурханы цамын багийг цаасан шуумлын аргаар урлаж, нүүрэнд нь улаан шүр битүү шигтгэж, мэлмийд нь лүнтэн хэмээх хар чулуу суулгасан байдаг. Дуулгыг зэс хөөмлөөр, хохимой толгойн титмийг мөнгөөр хийж, хохимойнуудын хооронд төрөл бүрийн үнэт чулуу хэлхсэн унжлага чимэгтэй. Түүнчлэн ээмгийг модоор, үсийг морины сүүлээр хийдэг ба багийн арын жавдар хатгамал, зээгт наамал бүхий давуу байдаг. Цамын хувцсыг хавтгай, товгор хэлбэр гарган зээгт наамлын аргаар урлаж яс төрөл бүрийн үнэт чулуугаар чимэглэдэг.

Уран баримлыг материалаар нь ангилахаас гадна хийсэн арга техникээр нь ангилж болдог.

1. Хөөмөл
2. Цутгамал
3. Сийлбэр
4. Барламал, хэвлэмэл
5. Шуумал гэж ангилж болно.

Хөөмөл, цутгамал, барламал, шуумлыг хэв авч урладаг учир олон хувилж болдог талтай. Харин сийлбэрийн бүтээлийг олон хувь хийхэд хүч хөдөлмөр, цаг хугацаа их зардаг учир голдуу ганц хувь бүтээдэг онцлогтой.

Уламжлалт уран баримлын төрөлд:

Балингийн урлал (Бурханы шашны тахилын зүйл хийдэг)

Зүмбэрийн урлал (Уран барилга, ахуйн хэрэглээний зүйлийг

чимэглэдэг) мөн багтдаг бөгөөд Европоос гаралтай кирамик, шил шаазан урлаг ч манайд тодорхой түвшинд хөгжсөн.

Уран баримлын бүртгэл хийхэд анхаарах зүйл

· Уг шүтээн баримал тигийн дагуу бүрэн бүтэн байгаа эсэх. Жигжид, Цагаан шүхэрт зэрэг олон гар, хөлтэй бурханыг тодорхойлохдоо гар хөлийн тоог заавал дурьдахаас гадна аль мутарт ямар барьц байгааг нэг бүрчлэн нягтлан тэмдэглэнэ. Барьцыг бичихдээ эхлээд урд хоёр мутрын барьцыг, дараа нь тойрсон мутрын барьцыг зүүн дээрээс нь, баруун дээрээс гэж зааж өгөөд доош цувуулан тоочно. Хэрэв дутуу байгаа бол аль хэсэг ямар барьц, зэвсэг дутууг тодорхой бичиж өгнө.

- Тодорхойлолтонд тухайн үзмэрийн онцлог шинж, бусад ижил үзмэрээс юугаараа ялгагдаж байгааг бичнэ. Уг бурхан шүншигтэй эсэх мөн ямар нэгэн дүрс зураг, тэмдэг, бичээстэй байгаа зэргийг тодорхой тэмдэглэнэ.

- Бурхан хэдэн хэсгээс бүрдэж байгаа болон салдаг хэсгийг бүгдийг бичнэ. Тухайлбал бурханы суурь, шактий, барьц салдаг эсвэл эх биетэйгээ хамт цутгагдсан г.м.

- Бүтээлийн ямар аргаар хийгдсэнийг зөв таньж, тодорхойлох. Олон арга ажиллагаа орсон бол тэр бүгдийг тоочин бичнэ. Тухайлбал, бурханы эх бие гууль цутгамал, суурийн хэсэг зэс хөөмөл г.м.

- Хэрэв ур бурханы хийцийг таниж байгаа бол “Долнуур хийц, монгол хийц, Занабазарын хийц” гэж бичих хэрэгтэй.

- Бүтээлийг өнгөөр ялгаж будсан бол ямар ямар өнгөөр, чулуун шигтгээ чимэг байгаа эсэх. Эдгээр нь бүрэн, эсвэл дутуу байгаа бол хэдэн ширхэг дутуу байгааг заавал зааж бичиж өгнө.
- Тодорхойлолт хийхэд бүтээлийн материалыг зөв таньж бичих явдал чухал. Тухайлбал мод бол ямар мод, хэрэв чулуу бол ямар төрлийг чулуу болохыг зааж өгөх. Харин таниагүй материалын өнгийг харагдаж буй байдлаар нь тодорхой бичих ба адил төрлийн материалтай харьцуулан бичиж болно.
- Тухайн үзмэр ямар шилжилт хөдөлгөөнд орсон, үзэсгэлэнд хамрагдсан талаар заавал бичсэн байвал зохино.

Бүтээлийн тодорхойлолтыг бичилтийг маш ойлгомжтой, тодорхой, тоочих маягаар хийх нь зүйтэй байдаг.

Хэмжилтийн тухай

Уран баримлын үндсэн хэмжилтийг дараах байдлаар хийнэ.

- Сууринаас орой хүртэлх нийт өндөр
- Суурийн урт, өргөн, зузаан, дугуй бол диаметрыг
- Олон гар хөлтэй бурханы хэмжээг хамгийн урт, өргөн хэсгийг нь авбал зохино.
- Юүм буюу дагинаа тэвэрсэн (шактитай) бурхадын хэмжээг авахдаа хамгийн өндөр, өргөн ерөнхий хэмжээг авахаас гадна гол бурхан, юүм хоёрын хэмжээг дээр дурьдсаны дагуу тус тусад нь авна.
- Хагас товгор шавар баримлын хэмжээг хамгийн өндөр, өргөн болон зузааныг авч болно.

Эдгээрээс гадна зөвхөн бурханы /суурьгүй/ өндөр, өргөн, тэргүүн, титэмний хэмжээ зэрэг шаардлагатай бүх хэмжээсийг авч болно. Хэмжээг олон улсын музейн стандартын дагуу сантиметрээр хэмжинэ. Хэмжээс нь аливаа эд зүйлс, дурсгалыг тодорхойлоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг чухал маш нямбай, нарийн гүйцэтгэх ёстой. Хэмжилтийг стандартын биш шугамаар хийсэн тохиолдолд хэмжээ нь эх бүтээлтэйгээ зөрж ижил төрлийн бусад



олон бүтээлүүдтэй андуурагдах зэрэг олон таагүй сөрөг нөлөөг дагуулдгийг анхаарах нь зүйтэй.

Уран баримлын хадгалалт хамгаалалт

Цуглуулгыг хадгалж, хамгаалах үйл ажиллагаа үзмэр музейн хаалгаар орж ирсэн үеэс эхлэдэг бөгөөд үзмэртэй харьцах ажиллагаа бүр үзмэрийн насыг аль болох уртасгахад чиглэгдсэн байх ёстой. Музейн орчинг аль болох үзмэр, эд зүйлс гэмтэж муудахаас хамгаалсан байдлаар зохион байгуулах ёстойг музейн ажилтанууд байнга анхаарч байвал зохино.

Үзмэрийн урт удаан насалж, оршин тогтноход сөрөг нөлөө үзүүлдэг гол хүчин зүйлүүд бол гэрэл, чийг, дулаан, агаарын хэлбэлзэл, биологийн сүйтгэл, гэнтийн аюул, хүний буруу үйл ажиллагаа байдаг. Эдгээр үзүүлэлтийг байх ёстой хэм хэмжээ аль нэг байдлаар зөрчигдөхөд үзмэрт мэдэгдэхүйц өөрчлөлт гарч муудаж эхэлдэг.

Гэрэл. Гэрэл үзмэрийг муутгах гол шалтгааны нэг. Гэрлийн нөлөөгөөр явагддаг өөрчлөлтийг фотохимийн урвал гэдэг. фотохимийн урвалын нөлөөгөөр үзмэрийн өнгө хувирч харалж, цайрах зэрэг физик шинж чанар өөрчлөгдсөнөөр үзмэр хугарамтгай, үйрэмтгий болдог.

Металл, чулуу болон шавар уран барималд гэрэл харьцангуй бага нөлөөтэй байдаг бол цаасан шуумал, модоор хийгдсэн баримал гэрэлд их өртөмтгий бөгөөд гэрэлд удаан байвал гандаж өнгөө алдаж, хатаж хуурайшин хугарамтгай болдог. Яс, зааны соёогоор хийсэн сийлбэр бол хагарч, харладаг. Ийм учраас музейд гэрлийг аль болох бага байлгах, музейн үзүүллэгийн танхимын

гэрлийг шаардлагагүй үед заавал унтрааж байх хэрэгтэй.

Чийг ба дулаан. Музейн үзмэрт байнга агаарын чийг нөлөөлж байдаг. Агаарын чийгээс үзмэрийг хамгаалах тийм ч амар биш байдаг. Учир нь агаарын чийг нь дулаанаас хамаарч байнга өөрчлөгддөг. Агаарын чийг, дулааныг хамт хэмждэг термогидрограф гэдэг багаж байдаг ба үүнийг музейн үзүүллэгийн танхим бүрд байлгах нь зүйтэй.

Хүрээлэн байгаа агаарын чийг ихэсэх, багасах үед чийгийг хүлээн авч, алдаж чаддаг материалуудыг гидроскопены шинж чанартай материалууд гэж нэрлэдэг. Ийм материалд цаас, мод, даавуу, яс, арьс, шир зэрэг орно. Эдгээр нь дотоод бүтэцдээ байнга зохих хэмжээний чийгийг агуулж байдаг ба агаарын чийгийг хүлээж авснаар эдгээр материалын эзэлхүүний хэмжээ ихсэж хөөж тэлдэг бол хуурайших үед чийгээ алдаж агшиж багасдаг. Гидроскопены шинж чанартай материалуудыг хадгалж, хамгаалахад тодорхой чийгтэй орчин зайлшгүй шаардлагатай.

Хэрвээ үзмэр нь байнга агших, тэлэх орчинд байвал хагарч гэмтэх, өнгө будаг нь ховхрох, чийг нь ихсвэл мөөгөнцөртөж хөгцрөх, ялзрах явдал гардаг. Агаарын чийгийн хэт холбилзолд модон болон цаасан шуумал баримлууд их мэдрэмтгий байдаг. Модон сийлбэрийн өнгө будаг ховхорч, хагарал үүсдэг. Агаарын чийг хэт ихэсвэл цаасан шуумал зөөлөрч хэлбэрээ алддаг бол хэт хуурайшсанаас болж хагарал үүсч үйрэмтгий болдог байна.

Металл баримлын хувьд аль болох хуурай орчинд байх нь тохиромжтой. Металл баримал темпратурын хэт хэлбэлзэлд орвол цан цохиж, усан толбо үүсэж энэ нь аажимдаа хар толбо болдог. Иймээс хүйтэн орчноос шууд дулаан орчинд оруулж болдоггүй.

Чулуун баримал түүний дотор хаш чулуун баримал нь хэт хүйтнээс болж бутрамхай эмзэг болдог тул хаш чулуун баримлыг тусгай шүүгээ саванд хадгалавал зохионо.

Утаа тортог. Утаа нь өөртөө хатуу биетүүдийн өчүүхэн жижиг хэсгүүд болон тоосонцор хөөг агуулдаг ба нүүрсхүчил, хүхэр хүчлийн хийнүүд дагалдан оршдог. Утаа тортог үзмэрийн гадна талыг бохирдуулан харлуулж гэмтээдэг.

Тоос нь төрөл бүрийн эд зүйлсийн үйрч жижгэрсэн өчүүхэн хэсгээс бүрддэг. Тоос нь сул хуурай учир агаарын урсгалаар байнга хөдөлж үзмэрийг бүрхэн бохирдуулдаг. Ялангуяа Монголд хаврын улиралд хуурайшил ихтэй үед тоос улам ихэсдэг. Үзмэр дээр тогтсон тоосыг цэвэрлэхгүй бол үзмэрийн гадаргууд хортон үржих, нүх, хонхор хэсгийг хирээр дүүргэж гэмтээхэд хүргэнэ. Иймээс үзмэрийг аль болох цэвэрхэн байлгах хэрэгтэй. Үзмэрт цэвэрлэгээ хийхдээ маш болгоомжтой нямбай хандах нь чухал.

Хүний буруу ажиллагаа. Байгалийн нөлөөллөөр үзмэр, эд зүйлс хөгширч муудан устддаг хэдий ч хүний буруу үйл ажиллагаанаас болж үзмэр гэмтэж бүр устаж үгүй болох ч явдал байдаг. Судлаачдын гаргасан дүнгээр хүн өөрийн бүтээсэн зүйлийнхээ 70%-ийг өөрөө устгадаг байна. Хүний үйл ажиллагааг санаатай болон санамсаргүй гэж хоёр ангилж болно. Санаатай устгах тодорхой шалтгаантай байдаг бол санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас үзмэр гэмтэх нь элбэг. Наад зах нь үзмэрийг бээлийгүй гараар барьснаас болж тэр нь бохирдох, металл эдлэл бол исэлдэж гэмтдэг байна. Үзмэртэй харьцахдаа тогтмол бээлийн өмсөж занших хэрэгтэй. Ингэснээр бид үзмэрээ гарын хөлс, бохирдолоос хамгаална.

Шашны урлагийн бүтээлүүд хадгалж байдаг Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Эрдэнэ-Зуу музейн барилга байгууламж сүм дуганы зориулалтаар ашиглагдаж байсан, музейн зориулалтын барилга биш учир ихэнхдээ дулааны системгүй байдаг. Өвлийн хүйтэнд халаалгүй сүмүүдийн доторх үзмэрүүд хөлддөг. Тиймээс манай музейн хувьд нөхцөл байдалдаа тохируулан сөрөг нөлөөг саармагжуулах механик арга хэмжээнүүдийг авдаг. Тухайлбал: Хэт хүйтнээс дулаан байр руу үзмэрийг шууд оруулж ирдэггүй. Сан хөмрөгийн байрны өрөөнд хэсэг хугацаанд байлгасны дараа зөөж оруулдаг. Мөн хавар намрын завсарын улиралд шөнө хүйтэн өдөртөө дулаан байдгаас сүмүүдэд байгаа металл бурхад хөлрөх явдал гардаг. Ингэсэн тохиолдолд өдрийн цагаар сүм дотор халаагуур тавьж гаднах доторх агаарын температурын хэлбэлзлийг багасгах арга хэмжээ авдаг. Металл бурхад хөлөрсөн тохиолдолд тухай бүрд нь зөөлөн салфеткаар дарах маягаар чийгийг шингээж авахгүй бол харлах явдал байдаг.

Үзмэрийг тоос шороо, механик гэмтэл, хулгай зэргээс хамгаалж хорго саванд байрлуулах шаардлагатай.

Модон болон цаасан шуумал, ясаар хийсэн баримлыг үзмэр үзүүллэгийн танхимд гэрлийн шууд тусгалаас хамгаалж цонхонд нарны гэрэл нэвтэрдэггүй наалт, хөшиг татдаг.

Сан хөмрөгийн байранд баримлыг төрөл зүйл, материалаар нь ангилж тусгай сейф, тавиурт хадгална. Төмөр сейфэнд байрладаг металл бурхадыг урвал явахаас сэргийлж тавиур бүр дээр хөөсөнцөр зөөлөвч дэвсэж, дээгүүр нь тоос шорооноос хамгаалан даавуун бүтээлгээр бүтээдэг. Модон болон цаасан шуумал, ясан сийлбэрийг сан хөмрөгийн байранд мөн шкаф, сейфд хадгалдаг.

Хавар, зуны хуурай улиралд сан хөмрөгийн өрөөнд савтай ус тавих зэргээр бололцоогоо ашиглан чийгийг тогтмолжуулж байх нь зүйтэй.

Сан хөмрөгийн байрыг хэт их халаахгүй, цэвэрлэгээг тогтмол хийж, хортон мэрэгчдээс хамгаалсан ариутгалыг мэргэжлийн байгууллагаар хаврын улиралд хийлгэж байвал зохино.

Богд хааны ордон музейн Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Алтаннавч
Соёлын өвийн төвийн мэргэжилтэн
Ш.Энхтуяа

МАЯГТ № 2

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 56 дугаар тушаалаар батлав.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМСангийн дугаар: 1125ДҮМ00001

Зэрэглэл: Хосгүй үнэт **шийдвэр:** Засгийн газрын 241-р тогтоол 1995/12/23

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей	**РД:** 9081542
Дурсгалын оршин байгаа хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. Барилгачдын талбай. Дүрслэх урлагийн музей	

Дурсгалын нэр: Үл хөдлөгч

Орон нутаг, олон улс (шинжлэх ухаан) –ын нэр: т: Минтүг, с:Aksobhya

Бүртгэлийн дугаар: 11-111 **Хувийн дугаар:** 00-00-00

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл

Ашиглалтын байдал: Дүрслэх урлагийн музейн Занабазарын танхимын үзүүллэгт

Төрөл зүйл: Цутгамал

Он цаг: XVII зуун - сүүл үе

Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Өндөр гэгээн Занабазар /1635-1724/

Материал: Хүрэл, алт шармал

орлон (Хүрэл) зузаан

Хэмжээ	өндөр	өргөн (зузаан)	урт	диаметр	жин
	71.4 см			44.6 см	7500 гр

Бурханы өндөр /суургүй/-61 см, Тэргүүний өндөр /үстэйгээ/ - 22 см, Өвдөр хоорондын зай - 40 см,

Гэрэл зураг: 3 ширхэг зурагтай

			
өмнө тал	ар тал	хажуу тал	бусад

Иж бүрдэл: 1 ширхэг

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1930-аад оны сүүлчээр Дэчингалавын хийдээс анх Цэндийн Дамдинсүрэн ачаалан авчирч Чойжин ламын сүмд буулгасан байна.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1966 онд Дүрслэх урлагийн музейн бүртгэлд орсон.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлагдаж байгаагүй

Хуулбар хийгдсэн байдал: Хуулбар хийгдэж байгаагүй.

СЗБ №

Тодорхойлолт: Үл хөдлөгч бурхан амирлангуй дүрээр орших идэр залуу, төгс сайхан залуу хүүгийн дүртэй бөгөөд баруун мутраараа "нотлох мутарлага", зүүнээрээ "баясалгалын мутарлага" үйлдэн, бүтэн очир завилгаагаар бадам цэцгийн дугуй суурин дээр заларна.
Нүүрний төрх: Магнай дээрээ 1,5 см-ийн диаметртэй "үр-на" хэмээх товгортой, дээш дугуйрсан саран мэт хар өнгийн хөмсөгтэй. Мэлмий нь арвай нуман хэлбэртэй, зовхио ялимгүй буулгаж бясалган буй дүртэй. Нүдний дээд зовхийг хараар, доод зовхийг улаанаар будсан. Эгц шулуун хамартай, бомбогор улаан уруултай. Чих нь 8 см урт, омог нь 4 см бөгөөд 5 см-ийн диаметртэй цэцгэн хэлбэрийн ээмэг зүүсэн.
Үл хөдлөгч бурхан ихэнх үсээ дээрээ шомбойлгон боож, үлдсэн хэсгийг нь хоёр мөрөө дагуулан унжуулсан. Овоолсон үс нь орой дээрээ 10 см өндөртэй эрдэнийн чимэгтэй хойно урдаа багана, хоёр бүслүүр чимэглэлтэй.
Тэргүүндээ эрдэнийн титэмтэй. Титэмний суурь нь голоороо товгор 3 см-ийн өргөнтэй. Голын хэсэг нь 10 см өндөртэй, хоёр том, хоёр жижиг цэцгэн чимэгтэй. Түүний хоёр талд 6 см-ийн өндөртэй хос эрдэнийн чимэгтэй.
Хүзүүндээ урт, богино дөрвөн давхар цэцгэн чимэгтэй эрих зүүлт зүүсэн. Эхний богино зүүлт 2,5 см-ийн диаметр цэцгэн чимэгтэй ба хоёр талдаа дараалан жижгэрсэн хос чимэглэлтэй. Дараагийн зүүлт 8 см-ийн диаметртэй том, түүнийг тойроод 6 ширхэг цэцгэн чимэгтэй...

Үргэлжлэл хуудас-1

Гэмтэл өө сэв: Үл хөдлөгч бурханы зүүн талын хөмсөгний дээд талд 1,2 см газар цохиж хонхойлгосон. Хоёр мөр тохойн хойт талд тус бүр 2 см диа-тэй цутгуурийн бололтой нөхөөстэй. Баруун гарын шуун дээр 2x2 см нөхөөс түүний өмнө 6 мм урт хонхорхойтой. Суурийн ирмэгнээс дотогш 3 см-ийн зайд цутгуурын үед хагарч цуурсан байж болзошгүй гагнаасны оромтой. 1976 онд музей гарсан галын утааны улмаас биеийн алт шармал нь исэлдэж үл мэдэг цайрсан байна.

Зориулалт: Анх шүтээний зориулалтаар бүтээгдээд, одоо музейд үзмэрийн зориулалтаар ашиглагдаж байна.

Ховор, түгээмэл байдал: Энэ бүтээл цорын ганц байдаг онцлогтой.

Товч түүх: Өндөр гэгээний дэргэд олон жил шавиласан Заябандид Лувсанпэрэнлэйн бичсэн "Өндөр гэгээний намтар оршивой" хэмээх судварт Занабазар өөрийн мутраар "Язгуурын таван бурхан"-г бүтээсэн тухай тэмдэглэсэн байдаг.
Өндөр гэгээн Язгуурын таван бурханаа Төвхөн хийдийн Урлагийн сүмд бүтээгээд Эрдэнэ-зуу хийдэд анх залсан байна. 1724 онд Өндөр гэгээн Занабазарыг жанч халахад уг бурханыг Эрдэнэ-зуу хийдээс Амарбаясгалант хийдэд аваачаад тэнд 1930 он хүртэл байсан байна....

Үргэлжлэл хуудас-1

Гарал үүсэл: Монгол

Шилжилт хөдөлгөөн: 1994-1995 онд Парисийн Азийн Урлагийн ГИМЕЙ музейд нээгдсэн "Монголын урлагийн эрдэнэс" үзэсгэлэнд
1996 оны 1-р сард Солонгосын Сөүл хотын захиргааны музейд нээгдсэн "Чингэс хаан ба Их монгол" үзэсгэлэнд тус тус тавигдсан болно.

Судлагдсан байдал: 1. Заябандид Лувсанпэрэнлэй. Өндөр гэгээний намтар оршивой.
2, Н.Цүлтэм. Монголын гарамгай баримлач Г.Занабазар. Токио 1982 он
3, Д.Дашбалдан. Өндөр гэгээн Занабазар УБ., 1985 он
4, Жийл Бегин, Д.Дашбалдан. Монголын урлагийн эрдэнэс. Парис 1994 он...

Үргэлжлэл хуудас-1

Хавсралт материалын тэмдэглэл:

Эзэмшигч /өмчлөгч/-д хадгалагдаж байгаа
Негатив № №35 слайд № 0 CD № 0 дүрс бичлэгийн хуурцаг № №2
УНБМСанд хадгалагдаж байгаа
Негатив № ________ слайд № ________ CD № ________ дүрс бичлэгийн хуурцаг № ________
Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: Ш.Энхтуяа, СӨТ-д мэргэжилтэн 2007 он 6 сар 7 өдөр
УНБМСанд хүлээн авсан: ________ ____ он ____ сар ____ өдөр

Товч түүх:

Дурсгалын нэр: Үл хөдлөгч

УНБМСангийн дугаар: 1125ДҮМ00001

Хувийн дугаар: *Үргэлжлэл хуудас-1*

Өндөр гэгээний дэргэд олон жил шавиласан Заябандид Лувсанпэрэнлэйн бичсэн "Өндөр гэгээний намтар оршивой" хэмээх сударт Занабазар өөрийн мутраар "Язгуурын таван бурхан"-г бүтээсэн тухай тэмдэглэсэн байдаг.

Өндөр гэгээн Язгуурын таван бурханаа Төвхөн хийдийн Урлагийн сүмд бүтээгээд Эрдэнэ-зуу хийдэд анх залсан байна. 1724 онд Өндөр гэгээн Занабазарыг жанч халахад уг бурханыг Эрдэнэ-зуу хийдээс Амарбаясгалант хийдэд аваачаад тэнд 1930 он хүртэл байсан байна.

1930 оны сүүлээр бурхадыг Армарбаясгалант хийдээс ардын аман зохиолч Ц.Дамдинсүрэн морин тэргээр ачаалан Чойжин ламын сүмд буулгасан байна.

Үл хөдлөгч бурханыг 1965 онд анх "Монгол дүрслэх урлаг" үзэсгэлэнд оролцуулж, улмаар Дүрслэх урлагийн музей байгуулагдахад тус музейд үлдээжээ.

1976 онд Дүрслэх урлагийн музейд гал түймэр гарснаас Үл хөдлөгч бурхан галд өртөн нилэхүйдээ харлаж, хөө тортог болсон байсныг тэр үед музейд үйлчлэгч байсан Дэнсмаа гэдэг хүн воктой усаар угаасны улмаас алт нь хамт угаагдаж алаг цоог цайрсан байна.

ДЭЛГЭМЭЛ БҮТЭЭЛ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ

Дүрслэх урлагийн бүтээлийн дийлэнх хэсгийг дэлгэмэл буюу хоёр хэмжээст хавтгай бүтээл эзэлдэг. Монголд байгаа дэлгэмэл бүтээлүүдийг дараах төрөлд хамруулж болно. Үүнд:

- Танка буюу шүтээн зураг,
- Монгол зураг,
- Уран зураг,
- Зураасан зураг,
- Хатгамал,
- Зээгт наамал

Эдгээр төрөл зүйлийн талаар тодорхой мэдлэгтэй байж тухайн урлагийн бүтээлийг бүртгэж тодорхойлох улмаар хадгалж хамгаалах асуудлыг онолын үндэслэлтэй хэрэгжүүлэх гол нөхцөл болно.
Иймээс дүрслэх урлагийн дэлгэмэл бүтээл танка зураг, уран зураг болон зээгт наамал, монгол зураг, зураасан зургийн түүхэн хөгжил, уламжлалт материал, арга ажиллагаа, онцлог, төрөл ангилал болон хадгалалт хамгаалалтын талаар тайлбарлах болно.

<u>Танка зураг, зээгт наамал:</u>

Танка буюу шүтээн зураг нь тиг харьцаа, өнгө дүрслэлийн тогтсон онолтой, гүн гүнзгий утга, бэлгэдэл бүхий буддын шашны урлахуй ухааны үндсэн төрөл зүйл юм.
Бурханы шашин дэлгэрсэн Энэтхэг, Төвд, Балба, Хятад, Солонгос, Япон зэрэг бүх оронд танка зураг өөрийн дүр төрхтэй хөгжиж ирсний дотор манай оронд ч мөн адил бурханы шашны урлахуйн ухаан үндэсний сэтгэхүй, уламжлалт урлагтай уялдан хөгжсөн юм.
Монгол оронд дэлгэрсэн бурханы шашны түүхийг 3 үед хувааж үздэг. Хамгийн сүүлийн дэлгэрэлтийн үед буюу 1578 онд “Арван буянт номын цааз” хэмээх цаазын бичиг гарч, бөөгийн тахилга үйлдэх хоцрогдсон ёсыг халж, буддын шашны зургаан мутарт Гомбо бурханы хөргийг айл бүхэн шүтэж байхыг хатуу зарлигласан байдаг.
Ийнхүү шүтээн зураг нь бурханы шашны хөгжилтэй уялдан хөгжсөөр XIX-XX зууны үед олон арван давтагдашгүй сонгодог бүтээлүүд төрөн гарсан нь эдүгээ манай Дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей зэрэг газруудад хадгалагдаж байна. Эдгээр сонгодог бүтээлүүдийг ихэвчлэн VIII Богд Жавзандамбын лүндэнгээр Их хүрээнд урчууд бүтээсэн байдаг. Их хүрээнд Умзад Гэндэндамба, Тойсүмлин аймгийн Цэнд, Зоогой аймгийн Жүгдэр, Бизьяагийн аймгийн Шарав, Чойнхорын аймгийн зураач Дорж, Зоогой аймгийн Хасгомбо зэрэг олон алдартай урчууд байсан бөгөөд эдгээр урчууд шүтээн зургийн хажуугаар Богдын хааны ордны үйлчин бүсгүйчүүдтэй хамтран Сангайн аймгийн модон гэрт зээгт наамлын олон сонгодог бүтээл урласан байна.
Бурханы зээгт наамал нь шүтээн зурагтай салшгүй шүтэлцээтэй урлаг юм. Хэдийгээр зээгт наамал, шүтээн зураг хоёр материал, арга ажиллагааны хувьд өөр өөр урлаг боловч нэгэн үндсэн эх зураг (тиг)-ын дагуу бурханы дүрийг бүтээдэг. Зээгт наамлын урлагийн түүхийг МЭӨ III зууны үед бүтээгдсэн Хүннүгийн ширмэл ширдэгнээс эхлэн авч үздэг. Эхэн үедээ ахуйн хэрэглээний, гоёл чимэглэлийн зүйлс урлаж байгаад бурханы шашны урлаг хүчтэй хөгжих болсон үеэс бурханы хөрөг бүтээл хийх болсноор бие даасан урлагийн төрөл болон хөгжсөн. XIX зууны дунд үеэс дүрслэх урлагийн бусад төрлөө тэргүүлэх хандлагатай болсон ба Төвдийг эс тооцвол Монголоос өөр оронд ийм өндөр хөгжөөгүй хэмээн манай зарим урлаг судлаачид үздэг. Энэ үед бүтээгдсэн хосгүй нандин бүтээлд Богд хааны ордон музейн “Улаан сахиус”,” Гонгор”, Дүрслэх урлагийн музейн “Цагийн хүрдийн хот мандал” зэрэг олон бүтээлийг нэрлэж болно. Торго, хоргой, есөн эрдэнээр урладаг тансаг өвөрмөц энэ урлаг нүүдэлчний соёлын онцлогийг хадгалсан дэлгэж хураах, зөөж тээвэрлэхэд хялбар төдийгүй ямар ч том хэмжээтэй бүтээл хийж болдог онцлогтой. Ийнхүү нүсэр том овроор бүтээсэн 10-16 метр өндөр “Цагаан дара эх”, “Очирваань”, “Жалбу сэнгийн ара”, “Аюуш” бурханы зээгт наамал хөрөг Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Эдгээр бүтээлийн гэрэл зургийг анх удаа 2003 онд Төвдийн сантай хамтарсан төслийн хүрээнд Соёлын өвийн төвөөс авсан юм. Ер нь зээгт наамал олон үйл ажиллагаа, шат дамжлагатай, хүн хүч, цаг хугацаа шаардсан нүсэр урлал байдаг учир их олон тоогоор байдаггүй гэж болно. /Хавсралт.1/
Социализмын үед зээгт наамал нийгмийнхээ чиг хандлагатай зохицон реалист чиг хандлагатай хөгжиж энх тайван, бүтээн байгуулалт, найрамдал, нөхөрлөлийн сэдэвтэй бүтээл хийгдэж байсан нь эдүгээ Уран зургийн галерей болон орон нутгийн музейнүүдэд байдаг.
Шүтээн зураг, зээгт наамлын бүтээлүүд нь манай музейнүүдийн сан хөмрөгт гол байр суурь эзэлж, хамгийн үнэ цэнэтэй үзмэрийн тоонд зүй ёсоор багтдаг. 2007 оны байдлаар улсын хэмжээнд түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан 274 үзмэр байдгийн 87 нь Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Эрдэнэ-зуу музейд хадгалагдаж байгаа танка, зээгт наамлын бүтээлүүд байдаг. Эдгээр музейнүүдэд манай орны танка, зээгт наамлын гол өв сан төвлөрөн хадгалагддаг гэж болох боловч орон нутгийн музейнүүдэд ч шүтээн зургийн цөөнгүй бүтээл бий. Орон нутгийн музейн хувьд танка зургийг ач холбогдол, үнэ цэнийг сайн мэддэггүйгээс тэр үү ихэнхдээ бөөнд нь хуйлж, шороо тоосонд даруулсан байдгаас ихэнх нь гэмтэлтэй, зарим нь бүр үзмэрийн шаардлага хангахгүй болсон байдаг төдийгүй солигдсон байдалч ажиглагддаг.

Материал, арга ажиллагаа:Уламжлалт танка, зээгт наамлын бүтээлийг бүтээж ирсэн материал, арга ажиллагааны талаар авч үзье.Тэр үеийн шүтээн зураг урлаач нь зургийн суурь дэвсгэр, будаг, бийр бүх зүйлээ өөрийн гараар хийдэг байжээ. Монгол уламжлалт танка зургийг төрөл бүрийн байгалийн зос, үнэт чулуу, шүр, оюу, номин, сувд, тана болон алт, мөнгө зэргээс гаргаж авсан шороон болон чулуун будгаар бүтээсэн байдаг. Будгаа бэлтгэхдээ: Чулуугаа хурууны өндгөнд мэдрэгдэх ширхэггүй болтол нухаад, ургамал, амьтны гаралтай цавуу хольж найруулдаг байжээ.Танка зургийг суурь дэвсгэр ихэвчлэн тусгай цардсан торго, хөвөн даавуу байдаг. Зургийн суурь дэвсгэрийг бэлтгэхдээ: Сонгосон даавууныхаа дөрвөн талд нарийн хулс мод барьж оёод, угсардаг жааз хэлбэрийн “тэлүүр” хэмээх модонд бэлтгэсэн даавуугаа хөвөрдөн хэрж бэхлээд, дараа нь цардлага (грунт) тавина. Цардлагыг бэлтгэхдээ: “Пайтуу” гэдэг цагаан шохойнд амьтан, ургамлын гаралтай цавууны ус холиод, дээр нь малын тархи, нугас, сүү зэргийг хийж зөөлрүүлдэг байна.Бэлэн болсон дэвсгэр даавуун дээрээ бурханаа бүтээхдээ анхлан тигээ татна. Бурханы нүд хөмсөг, ам хамар, нүүр, гар, хөл зэрэг биеийн бүх хэсэг бага, их хувь хэмжээстэй босоо, хэвтээ, өнцөг, тойрог шугамуудаар тогтоосон тигтэй. Тиг гэдэг нь бурханы биеийн хамгийн зөв харьцаа, хэмжээ юм.
Тиг зургаа гаргасны дараа өнгөө тавина. Бурхан бүр өөрийн тогтсон өнгөтэй. Тухайлбал, Очирваань, Гомбо бурхан- хар хөх, Жамсран бурхан- улаан, Цагаан дара эх- цагаан, Ногоон дара эх- ногоон гэх мэт. Өнгийг тавихдаа уусгах замхруулах, шаглах, шавших зэрэг аргыг ашигладаг байна. Өнгө тавилт дуусаад, дүрсэндээ хүрээлбэр (контур) хийж, дагнаас, самнаас гаргана. Энэ нь урлаачийн авьяас, чадварыг илтгэсэн, шүтээн зургийн гол хэсэг юм.
Танка зургийг бүтээж дуусаад хамгийн сүүлд “алт өргөдөг”. Тухайн үед “Хорголжин”, “Хуудсан” алт хэмээх хоёр төрлийн цэвэр алт хэрэглэдэг байсан нь хичнээн цаг хугацаа өнгөрсөнч өнгөө алддагүй онцлогтой.
Ийнхүү шүтээн зургийг бүтээх явц, зургийн өнгө, тиг бүгд өөрийн онол, арга зүйтэй байдаг төдийгүй шүтээн урлаач хүн болон түүнд сүжиглэгч хүмүүн ямар байвал зохиолтойг сударт тодорхой заасан байдаг аж. Шүтээнийг урлаач хүн ухаан, мэлмий, гарын ур тэгш, сүжиг төгс, номхон дөлгөөн, атгаг санаа үгүй, урлалд төгс мэргэжсэн, номонд мэргэн, энэрэлтэй, эрдэм бэлгэ ихтэй байна хэмээсний дотроос хамгийн гол нь гурван ур тэгш, түүн дотроо ухааны урыг голчлон үздэг байна. Зээгт наамал буюу торгон зурагт төрөл бүрийн торго хоргой, өнгийн зээг, алт, мөнгөн утас ашиглахын сацуу алт, мөнгө, үнэт чулуугаар чимэглэл хийдэг байж. Зээгт наамлыг бүтээхдээ: Зургийн дагуу бүх деталь хэсгийг нэг бүрчлэн өнгийн торгон дээр цаваг нааж, эргүүлэн нугалж бэлтгэнэ. Дараа нь дүрсээ “зээг” хэмээх эрчилж, томсон өнгийн утас болон алтан утас дараулан, хүрээлж оёно. Ийнхүү бурханы бүх хэсгүүд нүүр нүд, ам, хамар, гар хөл, хувцас чимгийг нэг бүрчлэн бүтээж дуусаад, зургийн дагуу угсарч оёсноор бүтээл дуусдаг байна.

Төрөл ангилал:Буддын шашинд гурван төрлийн шүтээн урлал байдаг байна.

1. Лагшны шүтээн урлал – бурханы хөрөг, дүр, хот мандал
2. Зарлигийг шүтээн урлал – судар, ном шашдар
3. Тааллын шүтээн урлал – суварга

Бидний үзэж байгаа танка зураг, зээгт наамлын урлаг нь лагшны шүтээн урлалын төрөлд багтана.
Бурханы шашин нь бусад бүх шашнаас хамгийн олон бурхантай шашин бөгөөд тэднийг олон ангилалд хувааж болдог байна. Хамгийн ерөнхий ангилалын нэг болох бурхадын гадаад ерөнхий төрх байдлаар нь:

- Амирлангуй,
- Хагас хилэнт,
- Хилэнт буюу догшин бурхан гэж хуваадаг бол бурхадыг хувцас, чимэглэлээр нь чимэгтэй бурхан, чимэггүй бурхан гэж хуваадаг байна.
- Чимэггүй бурханд – Бурхан багш, Богд Зонхов, Богд, Банчин богдууд, Далай ламууд зэрэг бодит бурхад багтана. Эдгээр нь чимэг сэлтгүй, номын хувцас соёрхосон байдаг. Номын хувцасанд- Орхимж, цээжний өмсгөл, хормойн өмсгөл, бандида малгай зэрэг багтдаг.
- Чимэгтэй бурханд- Өөр өөрийн чимэг сэлттэй амирлангуй, хагас хилэнт, хилэнт бурхад багтана. Төгс жаргалангийн лагшинт амирлангуй болон хагас хилэнт бурхад нь их эрдэнийн найман чимэг – титэм, ээмэг, урт, богино энгэрийн чимэг, бугуй, бугалаг, шагайвч чимэг, манжлагат бүс болон торгон хувцас тэргүүтэнг соёрхсон байдаг. Хилэнт буюу догшин бурхад оройн ясан чимэг, хүзүүн ясан чимэг, бугуйн ясан чимэг, чихний ясан чимэг, ясан суга зангиа гэсэн таван зүйлийн ясан чимэг, барын арьсан шамтав, хүний болон зааны арьсан нөмрөг тэргүүтнийг соёрхсон байдаг.

Дээрх ангилалаас гадна бурхадыг дараах дөрвөн ангилалд хуваах нь хамгийн түгээмэл байдаг.

- Бодит бурхад буюу лам, багш нар
- Ядам бурхад- Бавуу хандмаа буюу дагинас
- Чойжин сүрмаа хамгаалагч бурхад

Ядам бурхадад амирлангуй, догшин дүртэй тарнийн үндэсний, баясалгалын олон бурхад хамаардаг бөгөөд дотор нь жажүд, жоджүд, налжоржүд, ламиджүд гэсэн дөрөв хуваана. Шүтээн зургийн хувьд бүтээсэн байдлаар нь дараах ангилалд хамруулна. Үүнд:

- Тиг зураг - Бурханы дүрийг өнгө тавилгүй уран таталбар хүрээлбэр буюу контур зураасаар бүтээсэн бүтээл юм.

- Хэвлэмэл буюу бар зураг - Бараар хэвлэх маягаар олон тоогоор бүтээдэг бүтээл.
- Гартан – Цагаан дэвсгэр дээр уран таталбар хүрээлбэр зураасаар дагнааслан бүтээдэг.
· Нагтан - Хар дэвсгэр дээр уран таталбар өнгийн зураасаар дагнааслан бүтээсэн бүтээл.
· Мартан – Улаан дэвсгэр дээр уран таталбар өнгийн зураасаар дагнааслан бүтээсэн бүтээл.
· Сэртэн - Алтаар бүтээсэн бүтээл

Танка, зээгт наамлыг бүртгэж тодорхойлоход анхаарах зүйл

Үзмэрийн тодорхойлолт бол тухайн бүтээлийн шинж чанар, онцлог, гадаад төрх байдал зэргийг бүрэн илэрхийлж чадсан баримт байх үүднээс бүтээл устаж гэмтсэн тохиолдолд сэргээн засварлах, алдагдаж үрэгдсэн тохиолдолт сурвалжлан олоход шаардлагатай бүх мэдээллийг агуулсан байвал зохино.

Нэр. Бүртгэлийн үндсэн гол өгөгдлийн нэг бол бүтээлийн нэр юм. Бүртгэлийн маягтанд тавигдах бүтээлийн нэр музейн үндсэн бүртгэлийн нэртэй таарч байх ёстой. Гэхдээ музейн бүртгэлд бурхадын нэрийг буруу бичсэн байх нь олонтой учир бурханы зөв нэрийг олсон бол үндсэн бүртгэлийн нэрийн ард хаалтан дотор бичиж өгнө. Харин бурхадын төвд, сансакрит нэрийг мэдэж байвал " Орон нутаг, олон улс (шинжлэх ухааны)-ны нэр" гэсэн өгөгдөлд тэмдэглэнэ. Ер нь буруу нэрлэгдсэн бурхадын нэрийг мэргэжлийн байгууллагад хандан залруулан бичих нь зүйтэй юм.

Хэмжээ. Танка, зээгт наамлын бүтээлд хоёр хэмжээ авна. 1. Үндсэн зургийн хэмжээ буюу үзэгдэх хэмжээ 2. Хүрээ торгоны хэмжээ - үүнийг хэмжээний өгөгдлийн доор хүснэгтэнд бичиж өгнө.

Дүрслэл. Танка зургийн дүрслэлийг дараах байдлаар бичих нь тохиромжтой. Эхлээд бүтээлийн гол (төв)-д байгаа бурханы төрх байдал, мутрын хөдөлгөөн, барьц, хувцас чимэглэл, өнгө, суудал байрлал зэргийг тоочин бичээд, дараа нь бүтээлийн төв дээр байгаа бурхан болон дээгүүр байгаа бурхадыг бичнэ. Дээгүүр байгаа бурхад нь ихэвчлэн гол бурханыг бясалгасан бүтээлчин, ихэс дээдэс эсвэл багш нар байдаг. Тэднийг зөв таниж нэрлэх, танигдахгүй бол дүрслэн бичиж болно. Бүтээлийн дээд хэсгээр олон бурхад байрлаж байгаа бол төв дээр байгаа бурханаа нарийн дүрслэн бичээд, бусад бурхадыг ерөнхийлөн бичиж болно. Тухайлбал "Төв дээр баруун мутартаа гүц барьж, зүүн мутраа энгэртээ авч ном хэлэлцэх мутарлага үйлдсэн амирлангуй дүртэй цагаан лагшинтай бурхан бадам цэцгэн суудал дээр очир суудлаар оршино. Түүний хоёр талд хоёр дүвчин, тэдний цаана баруун талд нинмава ёсны хоёр лам, зүүн талд гэлүгван ёсны хоёр лам тус тус заларна" гэх зэргээр дүрсэлж болно. Үүний дараа бүтээлийн хажуу болон доод талын бурхадыг бичнэ. Хажуу талын бурхад ихэвчлэн голын бурханы нөхөр сэлт байдаг бол доод хэсгээр шавь, дагуул бурхад болон хамгаалагч бурхад байдаг. Дүрслэн бичихдээ байрлалыг нь зааж нэрлэж болно, мөн дүрслэн бичиж болно. Тухайлбал "Бүтээлийн доод хэсэгт байгаа таван бурханыг баруун талаас нь дурьдвал: Очирваань, Гомбо, Гонгор г.м" эсвэл "Бүтээлийн баруун доод хөх дүртэй … " гэж дүрслэж болно. Хамгийн сүүлд бурхадын цаад хэсэг буюу бүтээлийн дэвсгэр хэсгийг дүрслэн бичнэ. Бүтээлийн бүх хэсгийг дүрслэж бичсэний дараа эмжээр хүрээ торго нь ямар өнгөтэй, хээтэй, хуучин, шинэ болох зэргийг нь тодорхой бичнэ.

Ийнхүү тодорхойлолт нь хатуу тогтсон зарчим биш гэдгийг санах хэрэгтэй бөгөөд бүтээл бүрд өөр өөрөөр бичигдэх нь ойлгомжтой боловч танка зургийн дүрслэл нь бүх хэсгийг багтаасан, хамгийн ойлгомжтой, тодорхой бичигдсэн байвал зохино.

Маягтны "гэмтэл" гэсэн өгөгдөл бүтээлийн гэмтлийг нарийн тодорхой зааж хаана, ямар хэмжээтэй, ямар гэмтэлтэй байгааг бичиж өгнө.

Музейнүүдэд байгаа ихэнх танка зураг, зээгт наамлын бүтээсэн он цаг буюу бүтээгч тодорхойгүй эсвэл тойм төдийгүй, нэр нь буруу байх явдал нийтлэг байдаг. Энэ нь 1. Судалгааны ажил дутмаг 2. Бүтээл дээрээ ямар нэгэн он сар, урлаачийн нэрийг тавьдаггүй дорно дахины сэтгэхүйтэй холбоо гэж болно.

Танка, зээгт наамлын бүтээлийг хадгалж хамгаалалт

Аливаа бүтээл урт удаан орших тогтнох гол үндэс бол зөв харьцаж, зөв хадгалах явдал бөгөөд энэ нь өөрийн гэсэн арга зүйтэй, практик мэдлэг, туршлага шаардсан нарийн ажил байдаг. Энэ зааварт музейн ажилтнууд зайлшгүй мэдэж байх ёстой үзмэртэй харьцах, хадгалах хамгийн энгийн зарчмыг толилуулж байна.

Үзмэрийг юуны түрүүнд зориулалтын байр, саванд хадгалах хэрэгтэй. Музейн байр бол зориулалтын эсвэл зориулалтын болгон тохижуулсан байж болно.

Музейн сан сөмрөг. Музейн сан хөмрөгийн байр хамгийн эмх цэгцтэй байх шаардлагатай байдаг. Сан хөмрөгийн өрөөнд үзмэрийг төрөлжүүлэн, модон тавиур, шүүгээ саванд байрлуулна. Модон тавиуруудад үзмэрийг тоос шорооноос хамгаалсан хаалт хөшиг хийх хэрэгтэй. Энэхүү энгийн тохижилтыг ямар ч музей өөрсдийн бололцоогоор хийх бүрэн боломжтой юм. Сан хөмрөгийн өрөөнд үзмэрийн байршил, үзмэр гарсан орсон хөдөлгөөнийг тэмдэглэдэг бүртгэлийн дэвтэр заавал хөтлөх хэрэгтэй. Эмх цэгцгүй сан хөмрөгийн өрөөнөөс үзмэрийг зөөвөрлөх, хайх, үзмэрт хяналт тавих, цэвэрлэгээ хийх зэрэгт бэрхшээлтэй нь дээр үзмэр гэмтэх, муудах нэг нөхцөл болдог.

Үзмэртэй харьцах. Ер нь үзмэрийг дэлгэх, хуулих, зөөх зэрэг хөдөлгөөнд орох бүрд үзмэр элэгдэж муудаж байдаг гэдгийг байнга санаж үзмэртэй харьцахдаа дараах наад захын зарчмыг музейн бүх ажилтан мэдсэн байвал зохионо. Үүнд:

- Үзмэртэй харьцахдаа цэвэр, даавуун бээлий өмсөж занших,
- Үзмэртэй ганц ганцаар нь харьцах, (Үзмэрийг хэд хэдээр нь барьж хэрхэвч болохгүй)
- Зөөхдөө маш болгоомжтой байх (Үзмэрээ хаанаас хаана аваачихаа бодож, замаа чөлөөтэй байлгах),

Үзмэрийг хадгалах. Үзмэрийг хадгалахад гэрэл, чийг, дулаан хамгийн их нөлөөлдөг гол хүчин зүйл бөгөөд үүнийг тогтоосон (стандарт) горимонд нь байлгах нь хадгалалтын хамгийн гол зарчим юм. Танка зураг, зээгт наамлын бүтээл зөөлөн материалтай учир эвхэж хуулихад тохиромжтой байдгаас бүтээлийг ихэвчлэн хуулиж хадгалдаг. Энэ бол хадгалалтын сайн арга биш. Танка, зээгт наамлыг хадгалах хамгийн тохиромжтой арга бол хавтгай зүйл дээр дэлгэж, дээр нь тоос, шорооноос хамгаалсан хүчилгүй цаас, хөвөн даавуугаар хучиж, хооронд нь бага зэрэг зайтай байхаар бодож хадгалах хамгийн тохиромтой юм. Үзмэр цөөнтэй байр сайтай музейн хувьд ийнхүү хадгалах боломцоотой. Харин эдгээр үзмэр байр сав муутай, олон үзмэртэй музейн хувьд танка, зээгт наамлыг зайлшгүй хуулиж хадгалах шаардлагатай болдог.
Үзмэрийг хуулиж хадгалахдаа бүдүүн тусгай цаасан голонд хэт чанга биш, сул биш ороож, гадна талаар нь хүчилгүй цаас, хөвөн даавуугаар бооно. Үзмэрийг ороосон гол нь үзмэрийн өргөнөөс бага зэрэг илүү байх шаардлагатай бөгөөд түүнээс нь барьж зөөвөрлөхөд тохиромжтой. Ихэнх хуучны танка, зээгт наамлын урдуур "шалхавч" хэмээх нимгэн самбаа унжуулсан байдаг нь хамгаалалтын нэгэн хэлбэр бөгөөд ийнхүү шалхавчтай үзмэрийг ороохдоо шалхавчийг тэнийлгэн хавчуулснаар зөөлөвч хамгаалалт болгодог. Харин шалхавчгүй үзмэрийн дээр хүчилгүй цаас, хөвөн даавуу тавиж хуйлдах шаардлагатай.

Үзүүллэг. Музейн үзүүллэгийн танхимд танка, зээгт наамлаа байрлуулахдаа дараах зүйлийг анхаарах нь чухал юм. Үүнд:

- Гэрэл багатай
- Чийг, дулааны тогтмол хэмтэй, халаалтын системнээс хол
- Агаарын бохирдол, тоос шороогүй - агааржуулалт салхивчнаас хол
- Боломжтой бол үзмэрийг сайжруулсан циллоед бүхий жаазанд хийх нь хамгийн тохиромжтой бөгөөд жаазны шил бүтээлээс бага зэрэг зайтай байх шаардлагатай байдаг.

· Үзүүллэгт байрлуулсан үзмэр сан хөмрөгт байгаа үзмэрээс илүү мууддаг учир үзмэрийг үзүүллэгт дээд тал нь 3-6 сар байлгаад, 3 жилээс доошгүй хугацаагаар завсарлах хэрэгтэй гэж үздэг байна.

· Үзмэрийн тоосыг тогтмол зөв цэвэрлэх, үзмэрээ байнга ажиглан муу нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг олж тогтоон, тухай бүрд нь боломцоотой арга хэмжээг авч байх нь зүйтэй юм.

Монгол зураг: Төв азийн орнуудад нийтлэг дэлгэрсэн зураг урлал нь буддын шашны сонгодог танка зурагтай харилцан нөлөөлөх явцад эртний уламжлалтай язгуур Монгол зураг тодрон гарч иржээ. Буддын шашин хүчтэй дэлгэрч, бурхан дүрслэлийн хатуу тиг хэмжээтэй танка зураг давамгайлж байсан үед ч монголын язгуур уран зураг 400-аад жилийн туршид байсаар байжээ. Харийн түрэмгийлэгчдийн эсрэг эрх чөлөөний тэмцэл, үндэсний ухамсар өрнөж байсан XX зууны эхэн үеэс жинхэнэ монголчуудын санаа бодлыг илэрхийлж, байгаль, нийгмийн үзэгдлийг дүрслэн реалист хандлагатай хөгжсөн байна.
Монгол зурагт уул ус, утаа зэрэг байгалийн бүх юмс үзэгдэл, хүмүүсийн ахуй амьдрал, зан үйлийг бодит байдлаар тусгадаг ба нэг хавтгай дээр олон үйл явдлыг хураан багтаасан байдгаараа онцлог юм. Монгол зураг нь монголчуудын дүрслэхүйн сэтгэлгээг илэрхийлсэн уран сайхны өвөрмөц хэллэгтэй бөгөөд хүн амьтныг дүрслэхдээ донж намбыг нь тохируулсан, ардын ёгт хошин санаагаар баян байдаг. Манай язгуур монгол зургийн сонгодог төлөөлөл бол Б.Шаравын 1911-1919 онд бүтээсэн "Монголын нэг өдөр" цуврал бүтээл юм. Энэ бүтээлд XIX зууны үеийн Монголчуудын амьдралын бүхийл үйл явдлыг багтаан харуулсан байдгаараа уран сайхны төлөөгүй түүхэн ач холбогдолтой гэж үздэг. Түүнчлэн Цагаан Жамба, Д.Манибадар, Д.Дамдинсүрэнгийн бүтээсэн олон сайхан монгол зураг Дүрсгэх урлагийн музейд байдгаас гадна 1970-1980 оны олон монгол зургийн бүтээлүүд Монголын уран зургийн Галерейд байдаг. Үүнд: Ц.Даваахүүгийн "Нэгдлийн баяр", "Сүргийн мэнд", Л.Дарьсүрэнгийн "Урт наст зургаа", МУ-ын төрийн соёрхолт, Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн "Өрх гэрийн эзэн", Ц.Жамсрангийн "Үлэмжийн чанар", Б.Аварзэдийн "Ард Аюуш" зэргийг нэрлэж болно.
Монгол зураг нь материал, арга ажиллагааны хувьд танка зурагтай ижил юм.

Зураасан зураг

Зураасан зураг нь дотроо маш олон төрөл, техникт хуваагддаг ба маш эртний уламжлалтай болохыг хад агуйд зосоор зурсан зураг, хүн ба буган чулуун хөшөөний дурсгалаас харж болно.
Монголын орчин үеийн зураасан зураг нь Б.Шарав тэргүүтэй ахмад зураачидтай салшгүй холбоотой. Ардын хувьсгал ялахаас өмнө ба дараа хүмүүс бичиг үсэг тайлагдаагүй байсан үед ард түмнийг уриалан дуудахад гол зэвсэг нь ухуулах хуудас, ном хэвлэлийн зурагт хуудаснууд байжээ.
Зураасан зураг дотроо зурагт хуудас, номын чимэглэл зураг, сонин сэтгүүлийн зураасан зураг, суурь зураасан зураг гэсэн үндсэн төрөл зүйлүүдэд хуваагдан түүхэн хөгжлийн он цагийн дараалалаар эдүгээ хүртэл хөгжсөөр байна.
XYI-XX зууны эхэн үед Монгол оронд мод, чулуу, зэс барын урлаг өндөр хөгжсөн байна. Үүний тод жишээ бол барламал номын хосгүй гайхамшигт туурвил Ганжуур, Данжуур билээ. Эртний үеийн барын урлагийн гол бүтээлүүдэд ном, судар бичгүүд ордог.
Барлах урлагийг хулдаасан бар, модон бар, төмөр бар, чулуун бар, өндгөн бар гэсэн ерөнхий төрлүүдээс гадна өнгөт бар гэж байдаг.
Эрт үеийн баялаг уламжлалтай монгол барын урлаг хэсэг хугацаанд зогсонги байдалд орж байсан ч орчин үеийн зураасан зураг 50-иад оны үеэс эрчимтэй хөгжиж иржээ.
Манай зураасан зураг, тэр дундаа бар зургийн томоохон төлөөлөгчид хуучнаар ЗХУ-ын Москва хотын Суриковын нэрэмжит Уран зургийн Академи, Ленинград хотын   Репиний   нэрэмжит Уран зургийн Академи, Польш, Герман, Чех, Болгар зэрэг Европын орнуудын дэлхийд алдартай нэр хүнд бүхий Уран зургийн сургуулиудад суралцаж энэ чиглэлээр олон арван авьяаслаг багш, сурган хүмүүжүүлэгчдийн шавь болсноороо манай уран зураг, зураасан зураг, тэр дундаа бар зураг, барлах хэмээх авьяас тэвчээр шаардсан агуу урлагийг орчин үеийн дүрслэх урлагийн нэгэн томоохон төрөл болгон хөгжүүлж чадсан билээ.
Монгол Улсын Төрийн шагналт, Ардын зураач Д.Амгалан, МУЭ-ийн шагналт С.Нацагдорж, зураач О.Нямсүрэн,Б. Балдан зэрэг зураач урчууд манай бар зургийн 50-80-аад оны үеийн томоохон төлөөлөгчид ба сүүлийн үеийн зураачдаас Ж.Болд, Д.Гунгаа, Л.Бумандорж, Ц.Нармандах, Д.Хажидмаа, Ө.Гандулам, Б.Шатарсайхан, Я.Оюунчимэг зэрэг зураач урчуудыг нэрлэж болно.
Монголын Уран Зургийн Галерейд Төрийн шагналт, Ардын Зураач Д.Амгалангийн “Уулзалт”, “Айлын гадаа”, МУЭ-ийн шагналт С.Нацагдоржийн “Адуун сүрэг”, “Малчин”, “Лимбэчин”, Ц.Дагванямын “Наадам”, “Цагаан сар”, Д.Гунгаагийн “Төрийн багана” зэрэг Монголын бар зургийн урлагийн хөгжлийг харуулсан олон сонирхолтой бүтээлүүд хадгалагдсаар байдаг ба Цэндсүрэнгийн Нарангэрэлийн “Хатан” монотип, Ц.Доржпаламын “Хөргүүд”, Ядамсүрэнгийн Оюунчимэгийн “Охины хөрөг” зэрэг усан будгийн бүтээлүүд, Мижидийн Бүтэмжийн “Таван эрдэнэ” харандаан зураг, Ц.Бүдбазарын “Хүүгийн хөрөг” харандаан зураг зэрэг зураасан зургийн олон бүтээлүүдийг харж болно.

Уран зураг

Уран зураг нь байгал, юмс үзэгдэл, оюун санаанаас урган гарсан зүйсээ зургийн хавтгайд гурван хэмжигдэхүүнээр харьцуулан илэрхийлж гэрэл сүүдэр, орон зай агаарлаг байдлыг өнгө гэрлийн харилцан нөлөөлөл, алслалтын хууль, бусад дүрслэлийн ухааны үндэслэлийн дагуу илэрхийлэн гаргадаг байна.
Уран зураг нь дотроо а. Суурь уран зураг, б. Монументаль уран зураг гэж хуваагдана.

<u>Суурь уран зураг.</u> Мольберт гэдэг үгнээс гаралтай. Уран зураг нь хүн төрөлхтөний түүхийн бүхий л үе шатанд сонгодог уран зургаас, импресионизм, оп арт, поп арт гэх мэт маш олон урсгал, -измээр хөгжиж иржээ. Сэдвийн хувьд натюрморт, анималист, байгалийн, аж байдлын гэх мэт маш өргөн хүрээтэй.

<u>Монументаль уран зураг.</u> Энэ нь сүрлэг том гэдэг үгнээс гаралтай. Уран барилгатай нягт холбоотой урлаг бөгөөд барилгынхаа утга агуулга, зорилгыг илэрхийлэхийн зэрэгцээ чимэглэлийн үүрэг гүйцэтгэдэг. Монутенталь уран зургийг хийсэн арга техникээр нь 4 хуваадаг.
- фреска зураг: Шууд ханан дээр зурдаг.
- Мозайка: Эвлүүлэг гэсэн үгнээс гаралтай бөгөөд барилгын бүх төрлийн ханан
- дээр шил, чулуугаар шигтгэмэл хийдэг. - Витраж: Шилэн дээр зурсан зураг.
- Панно: Тусгай материал дээр хийгдсэн хана таазанд бэхлэхэд зориулсан зургийг хэлнэ. Жишээ нь: Сүмийн бурхдыг даавуун дээр зураад хананд бэхэлдэг.

Европын уран зураг Монголд Оросоор дамжин орж ирсэн ба 1950-иад оноос уран зургийн мэргэжлийн зураачидтай болсноос уран зургийн ур чадварын түвшин, бүтээлийн цар хүрээ тэлэн нэмэгдсэн гэж болно.
Европ уран зургийн аргаар туурвисан анхны бүтээлүүдэд БНМАУ-ын Төрийн хошой шагналт, Ардын зураач О.Цэвэгжавын “Гүүн зэлэн дээр”, УГЗүтгэлтэн Д.Дамдинсүрэнгийн “Жинчин”, Төрийн шагналт, Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн “Д.Сүхбаатар”, Д.Чойдогийн “Партизан Мельников” зэрэг бүтээлүүд ордог бөгөөд эдгээрийг монгол зургийн дүрслэн илэрхийлэх онцлогийг европын уран зургийн арга барилтай хослуулан бүтээсэн байна.
Монголын ард түмний шинэ амьдрал, хөдөлмөрчин ардын дүрийг чадварлаг гаргасан БНМАУ-ын төрийн шагналт, ардын зураач Г.Одонгийн “Ажлын дараа”, “Улзын малчин”, “Монгол эмэгтэй”, “Туульч” зэрэг бүтээлүүд Уран зургийн галерейн үзүүллэгт хүндтэй байр суурь эзэлдэг. БНМАУ-ын төрийн хошой шагналт,ардын зураач О.Цэвэгжав бол эгэл жирийн хүний амьдрал, эрэмгий зоригт хүмүүс, мал амьтдын хүч сорих өрсөлдөөнийг харуулсан бүтээлүүд туурвидаг “анималист” зураач ба түүний “Азарганы ноцолдоон”, “Бухын мөргөлдөөн”, “Эмнэг сургалт”, “Гүү саалт”, “Ууланд” зэрэг бүтээлүүдийг дурьдаж болно.
Монголын шинэ цагийн театр-кино,тайз дэлгэцийн засал чимэглэлийн урлагийн үндсийг тавьсан хүн бол Төрийн шагналт, ардын зураач Л.Гаваа юм. Тэрээр 1938 онд Д.Намдагийн “Сүрэг чоно” жүжгээр уран бүтээлийнхээ гарааг эхэлж олон арван жүжгийн тайз чимэглэлийг бүтээсэн билээ. Түүнд зураагүй төрөл жанр, хөндөөгүй сэдэв үгүй байсан бөгөөд Уран зургийн галерейд түүний “Киномеханикч”, байгалийн сэдэвт “Алтайн уулс”, “Өвөл”, “Нутгийн бараа” бүтээлүүд хүндтэй байр суурь эзэлж байдаг.
Байгалийн уянгын зургаар дагнан ажилладаг уран бүтээлч бол МУ-ын УГЗ, зураач М.Цэмбэлдорж билээ. Түүний бүтээлүүд галерейн үзүүллэгт чухал байр суурь эзэлдэг ба галерейн үзмэрт түүний “Өвөл”, “Чулуутын цуурай”, “Шуудан хүргэгч”, “Монгол Алтайн дуулал” зэрэг бүтээлүүд тавигдсан байдаг.
Хот барилгын чимэглэх урлагт мэдлэг чадвараа зориулсан хүн бол төрийн шагналт, УГЗ, зураач Д.Чойдог билээ. Түүний туурвисан “Г.Бумцэндийн хөрөг” зэрэг бүтээлүүдийг дурдаж болно.
1960-аад онд манай олон нэрт зураачид шинээр сургууль төгсч уран бүтээлээ туурвих болсон ба тэдгээрийн дотроос С.Дондог, Г.Баяр, М.Бүтэмж, Г.Дунбүрээ, До.Болд, Р.Дүйнхоржав нарыг нэрлэж болно.
1980-аад оноос шинэ залуу уран бүтээлчид ахмад үеийнхнийхээ уламжлалт арга барилыг үргэлжлүүлэн уран бүтээлээ туурвиж байв. Тэдгээрийн дотроос До.Болдын “Алтайн дуулал”, Б.Пүрэвсүхийн “Талын ээзд”, Ц.Энхжаргалын “Өвөөгийн булаг”, Ш.Тэнгисболдын “Их хүлгэн туульс”, Ч.Хүрэлбаатарын “Зээргэнтийн өндөр ууланд”, Л.Бавуудоржийн “Эх” зэрэг бүтээлүүд орно.
Монголын зураачид 1990-ээд оноос модернист шинэ урлагийн урсгал чиглэлийг үндэс болгон өөрийн арга сэтгэлгээгээр баяжуулсан өвөрмөц бүтээлүүдийг туурвих болсноор уламжлалт реалист уран зургийн өнгө төрхийг улам гүнзгийрүүлсээр байна. Монгол оронд Ардчилсан хувьсгал ялснаар уран бүтээлчид баригдмал арга барилаас салж өөрсдийн ур чадвараа улам сайжруулж, уран бүтээлийн эрэл хайгуул хийх болсон ба дүрслэх урлагийн орчин үеийн хэллэг, арга барил, чөлөөт сэтгэлгээгээр бүтээлээ туурвих болжээ. Тэдгээрийн тоонд Б.Чогсомын “Зохиомж”, Ш.Чимэддоржийн “Үдэлт”, Ж.Мөнхцэцэгийн “Бүсгүй”, Ц.Энхжаргалын “Мөнхөд оршихуй”, Төрийн соёрхолт, зураач До.Болдын “Одот тэнгэр орчиж”, М.Бүтэмжийн “Ботгон цагаан үүлс”, Н.Адъяабазарын “Адуучид” зэрэг олон бүтээлийг дурдаж болно.

Уран зургийг бүртгэхэд анхаарах зүйл
Уран зургийн бүтээлд бүртгэл хийхдээ дараах онцлог нөхцөлүүд харгалзана.

<u>Материал, арга ажиллагаа.</u> Уран зургийг хуучрах шинж чанарт орчин их нөлөөтэй байдаг боловч зураачийн сонгосон материал, арга техник мөн томоохон хүчин зүйл болдог. Уран зургийг бүтээхэд ашигласан материал цаг хугацаа өнгөрөх тусам мууддаг. Иймээс материал, арга техникийг нарийн тодорхой бичих хэрэгтэй.

А

Б

Уран зургийг олон янзын материалаар хийж болох боловч голчлон будаг, дэвсгэрээс бүрдэнэ. “Дэвсгэр” бол уран зургийн хөрс буюу будгийн хальсыг агуулж байдаг биет бүтцийг тодорхойлоход хэрэглэгдэх ба уран зургийг модон хавтан, картон, зотон, металл, болон зураг зурж болох бүх хавтгай зүйл дээр бүтээж болдог.
Уламжлалт монгол зураг, төрөл бүрийн бар зураг, усан будгийн зургууд нь зураасан зургийн төрөлд хамаарах ба ихэвчлэн цаас, даавуун дээр хийгдсэн байдаг.

Хэмжээ. Уран зураг болон зураасан зургийн хэмжээг см-ээр авах ба зургийн босоо талын хэмжээг эхэлж тэмдэглэнэ. Жаазны хэмжээг /хэмжээний үндсэн хүснэгтний доод зайнд/ тусад нь тэмдэглэнэ.

Гэмтэл, өө сэв. Бүтээлийн хаана, ямар гэмтэлтэйг тодорхой бичнэ. Урагдсан, цуурсан, хагарсан гэмтлийн хэмжээсийг бичнэ. Туршлагаас харахад бүтээлийн гэмтлийг түүний хэвлэсэн зураг дээр зааж тэмдэглэх нь илүү тохиромжтой байдаг.

Тодорхойлолт. Бүтээлд тодорхойлолт бичих нь зураачдын зохиомжийн сэдэв, шийдэл, арга барил, чиглэл урсгалтай нягт холбоотой ба дараах үндсэн зарчмыг мөрдлөг болгоход тохиромжтой. Үүнд:
- Зургийн хавтгайд дүрс хэлбэр /дүр/-ийг баруун, зүүн, дээд, доод тал эсвэл төвд хэрхэн байрлуулсаныг нарийн тодорхой бичнэ. Зургийн ерөнхий форматыг босоо, хэвтээ авсан эсэх ч үүнд хамаатай.
- Дүрс хэлбэр /дүр/-ийн үндсэн хэлбэр, ерөнхий хэмжээг тодорхойлон дүрслэх
- Дүрс хэлбэр /дүр/-ийн ерөнхий байрлалыг зургийн талбайд багтаасан байдал, хэрааны төвшний дээр, доор алслалт г.м
- Дүрс хэлбэр /дүр/-ийн үндсэн гэрэл сүүдэр, өнгө харьцаа, хөдөлгөөн донжийг тодорхой гаргах,
- Туслах дүрс, хэсгүүдийн гэрэл сүүдэр, өнгийн тусгалыг гаргах

Хийсвэр зурган дээр цэг, зураас, хавтгай, хэлбэр, гэрэл, тусгал, өнгийг хэрхэн суурь болгосон байдлыг дүрслэн бичих бол бодит зурган дээр дүрүүдийн харьцаа хаана ямар дүрийг хэрхэн байрлуулсан байдал, сэдэв /байгаль, ан амьтан, натюрморт г.м/, зургийн үйл хөдлөл хаана, хэзээ, ямар цаг үед хэрхэн өрнөж байгаа гэх мэтийг тодорхой бичнэ.

<u>Уран зураг болон зураасан зурагтай харьцах, хадгалах горим</u>

Уран зургийг хадгалах
Зургийг цохигдож урагдаж, хиртэж, хөгцөрч магадгүй сан хөмрөгт байлгаснаас хананд өлгөх нь аюулгүй.

<u>Зургийг шалнаас хөндий байлгах.</u> Үүний гол зорилго нь усны аюулаас сэргийлж байгаа явдал юм. Зургийг байнга хадгалахдаа тавиур, шургуулганд буюу дэлгэцэн дээр хадгалах бөгөөд түр хугацаагаар хадгалахдаа зөөлөвчтэй блокууд дээр хадгална. Зөөлөвчтэй блокууд нь жааз буюу зургийн суурийг хамгаалж, гулгуулахгүй барьж байдаг. Эдгээрийг зөвхөн хөөсөөр хийж болно. Эсвэл модон дээр хөөсөөр хийж даавуугаар бүрж болно.

<u>Зургийг давхарлах.</u> Зургийг давхарлан тавихдаа маш болгоожтой байх хэрэгтэй. Учир нь ингэж хадгалахад урлагийн бүтээл буюу жаазанд гэмтэл гарах нь олонтаа байдаг.
Зургууд хоорондоо шууд шүргэлцэж болохгүй бөгөөд долгиотсон гадартай картон зэрэг хатуу материалаар тусгаарлана. Зотон зургийн нүүр буюу арыг түшүүлж юу ч тавьж болохгүй. Учир нь ингэвэл зургийн хэлбэрийг алдуулж, урагдаж, хагарахад хүргэнэ. Эмзэг зөөлөн гадаргатай жаазлаагүй зурагтай онцгой болгоомжтой харьцах хэрэгтэй. Ингэхгүй бол картон зургийн гэмтээж болно. Тиймээс гадаргаас нь бүх зүйлийг хөндий байлгахын тулд зөөврийн жааз хэрэглэж болно. Зургийг нүүрээр нь түшүүлж тавьж хэрхэвч болохгүй.
Зургуудыг нүүр нүүрээр нь ар араар нь харуулж, босоогоор нь давхарлаж, дунд нь долгиотсон гадартай картон хавчуулна. Ингэснээр жаазны товойсон хээ угалз болон өлгүүр хажуудах зургийн нүүрийг гэмтээхээс хамгаална. Ойролцоо хэмжээтэй бүтээлүүдийг нэг дор хураа. Хамгийн том бүтээлийг ард нь тавьж, хамгийн жижиг бүтээлийн нүүрэнд нь тавь. Арын зураг нь урдахаасаа илүү гарч байхаар том байх ёстой. Хэврэг будгийн давхрагатай зургийг бүү давхарла. Ийм зургийг хэвтээгээр нь байлгах ёстой бөгөөд хадгалалт хамгаалалтын мэргэжилтнээс зөвлөгөө авах нь зүйтэй.

Зургийг жаазтай нь хадгалах ёстой. Жааз нь зургийг үрэлтээс хамгаалдаг. Зөөврийн жаазанд хадгалаагүй бол зургийг цэвэр зөөлөн цаасанд (хүчилгүй байвал сайн) боох хэрэгтэй.

Хуйлж хадгалах. Зураг нь зузаан буюу хэврэг будган үе, наамал элемент, эмзэг дэвсгэртэй бол хуйлж болохгүй. Зурганд нугалаас үүсгэхгүйн тулд том голчтой хоолойнд хуйлна. Хуйлахдаа зурагтай талыг нь гадагш харуулж чанга хуйлах ёстой. Будгийн давхаргыг хумьж улмаар ан цан гаргахгүйн тулд зурагтай талыг гадагш харуулж хуйлна. Зургийг том голчтой хоолойны гадуур хуйлснаар будгийн давхаргад бага даралт учруулж, гадаргад гэмтэл учруулах магадлал багасна. Хоолойн голч нь зургийн хэмжээнээс хамаарах боловч 200 мм-ээс багагүй байх ёстой бөгөөд том зургийн хувьд 400 мм-ээс том голчтой байх ёстой. Хоолойг зөөлөн цаасаар бүрж, үеүдийн хооронд нь тусгаарлахын тулд зурагтай хамт хуйлна. Хоолойны хоёр үзүүрт зөөлөвчтэй блок хийж хадгалж болно эсвэл хоолойн голоор гинж буюу саваа оруулж өлгөнө.

Уран зурагтай харьцах

· Обьект, уран зураг, жаазыг хөдөлгөхөөсөө өмнө гэмтэл байгаа эсэхийг үзэж шалга. Гэмтэл байгаа бол өчүүхэн гэсэн хэлтэрхий, үйрмэгийг болгоомжтой цуглуулж, хадгал. Ингэснээр сүүлд хадгалалт хамгаалалтын мэргэжилтэний ажилд маш их тус нэмэр болдог.

- Уран зураг жаазандаа бат бэх суусан байх ёстой. Хэрэв сул байвал бэхэлж чангалтал нь хөдөлгөх оролдож болохгүй. Уран зургийг өлгөхөөсөө өмнө өлгүүр нь бат бөх байгаа эсэхийг шалга.
- Зураг зургийг нэг нэгээр нь барьж хөдөлгөнө. Том зураг байвал жингээс хамааралгүй хоёроос доошгүй хүн зөөх ёстой.
- Зургийн нүүрэн талд гар, даавуу, бусад зүйлийг шууд хүргэхээс зайлсхий. Харьцаж байхдаа үргэлж цагаан хөвөн даавуун бээлий өмсөх нь зүйтэй. Гарын хөлс уран зураг, жааз болон даавуун дэвсгэрийг гэмтээдэг.
- Жаазлаагүй бүтээлийг ихээр нь овоолж болохгүй. Босгож өрсөн бүтээлийг дундаас нь татаж авч болохгүй. Дэвсгэр урагдаж, цуурч, механик гэмтэл учирч болно.
- Гараа дотуур рам ба зотонгийн хооронд хэзээ ч бүү хий. Энэ нь зотонг сулруулж будгийн давхаргад ноцтой гэмтэл учруулж болно.
- Уран зургийн нүүрэн тал буюу жаазны үзэгдэх хэсэгт наалддаг тууз буюу цавуу хэзээ ч бүү хэрэглэ. Зотон дээр зурсан уран зургийн ард шошго наах буюу бичиж болохгүй.
- Урлагийн бүтээлийг аль болох бага хөдөлгөөнд оруулах хэрэгтэй.
- Хайхрамжгүй харьцсанаас болж үүссэн гэмтэл нэлээд хугацаанд ил гардаггүй. Зургийн гадаргуug цохиход будгийн гадарга хагарна, энэ нь мэдрэгдтэлээ олон сар жил өнгөрч болно.

Жаазлалт

- Анхны жааз нь урлагийн бүтээлийн нэг чухал хэсэг байж болно. Зураач жаазыг сонгохдоо зурагтаа ямар нэг зүйл нэмэх буюу тодруулахаар сонгосон байж болно. Хэрэв тийм бол та ийм жаазыг салгаж авсанаар зураачийн хүсэл эрмэлзлийг өөрчилж болох юм. Мөн жааз нь бүтээлийн насыг илэрхийлж, түүхтэй холбож өгч болно. Тийм учраас анхны жаазыг аль болох дахин ашиглах нь зүйтэй.
- Зураасан зураг болон монгол зургийг шилний цаана жаазалбал хамгийн сайн. Учир нь будгийн онцлогоос шалтгаалан хүний гар хүрэхэд амархан арилдаг.
- Уран зургийг үзмэрт тавихдаа жаазалдаг. Энэ нь үзэмж нэмэхээс гадна хамгаалалт болдог. Гэхдээ хамгаалах нь чимэглэлийн үүргээсээ өмнө тавигдах ёстой. Тэгэхгүй бол жааз нь зургаа гэмтээж болно.
- Жааз нь зургийг барьж байхаар бахим, биетэй байх ба зургийн гадаргаас илүү гарч харагдах ёстой. Ингэвээс нүүрээр нь доош харуулж тавихад зургийн гадарга ширээнд хүрэхгүй, үрэлт, тоосноос хамгаална.
- Зургийг жаазнаас нь өлгөнө. Ялангуяа том зургийг найдвартай өлгөхийн тулд ханад хоёр цэгээс өлгөх нь зүйтэй. Зургийн утас зотон даавуун зургийн ар уруу цохиж хэлбэрийг нь алдуулж, цав гаргаж гэмтээж болохыг анхаарах нь зүйтэй.

Ном зүй:

1. Д.Дамдинсүрэн. Их хүрээний нэрт урчууд, УБ., 1995 он
2. Лавайн эгшиг. Сэтгүүл, Гандантэгчинлэн хийд, УБ., 1996 он
3. Ардын урлагийн тухай тэмдэглэл. МУЭХороо, УБ., 1988 он
4. Буддын шашин, соёлын тайлбар толь. МУИС, I,II боть. УБ., 2000 он
5. Бурханы шашны сүм, дуганы урлал, чимэглэлийг сэргээн амирлуулах монгол уламжлалт арга ухааны гарын авлага. ЮНЕСКО, Хархорин, УБ., 2006 он
6. Музейн цуглуулгын хадгалалт, хамгаалалт. Семинарын материал, 1998 он
7. Д. Энхдаваа. Зохиомж. УБ., 2002 он
8. Урлагийн бүтээлийн арчилгаа. Шинэ Зеланд дахь урлагийн бүтээл, түүхийн дурсгалт зүйлсийн арчилгаа

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн
Ш.Энхтуяа
Уран зургийн галерейн Эрдэм шинжилгээний ажилтан
Ц.Баттөр

14м 85см



16м 38см



14м 16см

15м 40см

СУДАР НОМ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ

Европ тивд хамгийн анхны хэвлэмэл номыг Германы Иоганн Гуттенберг XV зууны I хагаст буюу 1445 онд хэвлэсэн байдаг бол 1564 онд Иван Федеровын хэвлэсэн христосын шашны "Апостол" судрыг Оросын хамгийн анхны хэвлэмэл ном гэж үздэг. Эдгээр номын аль нь ч манай үед уламжлан үлдээгүй байна.

Монгол номын түүх эртний хад чулуун дээрх бичээснээс эхтэй гэж үздэг. Монголчууд түүхэндээ хятан, монгол, дөрвөлжин, төвд, тод, соёмбо, манж, вагиндра, нангиад, ланз үсгээр ном зохиол хэвлэж байсны дотроос төвд, монгол бичгээр хамгийн олон ном бүтээл хэвлэсэн байдаг. Тухайлбал: Их Ляо буюу Хятан гүрний /916-1125/ үеийн монголчууд дорно дахинд нилээд түгээмэл байсан "Ачлалт ном", "Шүлэглэлт ном", "Засагт ном", "Зурхайт ном", "Шашинт ном", "Их суртахуй бичиг", "Шүүмжлэл өгүүлэл", "Мэнзи бичиг" зэрэг болно. Эндээс үзэхэд монголчуудын ном хэвлэж байсан түүх Европд ном хэвлэсэн түүхээс бараг 500 шахам жилийн өмнө байгаа юм.

Монгол номыг хэлбэрээр нь дараах байдлаар ангилдаг.

1. Сударчилсан ном
2. Хуйлмал ном
3. Нугалбар ном
4. Дэвтэрчилсэн ном
5. Чулуун ном

Сударчилсан ном. Энэ нь хоёр янз байна.

а) Эртний сударчилсан номын хуудсыг хос нүх гарган утсаар холбосон байдаг ба хуудсаа гүйлгэн уншдаг ба гадна талаараа модон хавтастай байдаг. Монгол улсын үндэсний номын сангийн "Үнэт ховор номын музей"-д хадгалагдаж буй эртний Энэтхэгийн алдарт эрдэмтэн Нагаржуна (Манай эриний I зуун) зохиосон гэх домогтой дал модны навчин дээр эртний ланз үсгээр бичсэн "Жадамба" буюу "Билгийн чанад хязгаараа хүрсэн найман мянгат" хэмээх их хөлгөн судар үүний тод жишээ болно. Уг ном нь 31,5 х 5,2 см хэмжээтэй бөгөөд гадна талаараа модон хавтастай.

б) Дийлэнх сударчилсан номын хуудас нь тус тусдаа наалт үдээгүй урт гонзгой хуудастай байдаг бөгөөд хуудас бүр нь хос шугамтай дөрвөлжин хөвөө хүрээтэй. Хүрээний гадна талын шугам өргөн, дотор талынх нь нарийн байна.

<u>Сударчилсан номыг хэд хэдэн янзаар дугаарладаг</u>. Үүнд:

а/ Судрын хуудасны өвөр ар хоёрт ижил дугаар тавих. Жишээлбэл:
- Хуудасны өврийг тавь дээд, арыг тавь доод,
- Хуудасны өврийг тавь гээд арыг дэд тавь,
- Хуудасны өврийг тавь гэж бичгээр дугаарласан бол арыг тоогоор "50" гэнэ,
- Хуудасны өврийг тавь гээд арыг дугаарлалгүй цулгуй орхих зэргээр дугаарладаг.

Ингэж янз бүрээр дугаарласны улмаас хуудасны өвөр арын мөрийн тоо харилцан адилгүй болдог.

б/ Их хөлгөн судартбүлэг бүрийг тус тусад нь дугаарладаг,

в/ Зарим судартномын нийт дугаараас гадна, бүлэг бүрийн хуудасны дугаарыг давхар тавьдаг байв.

<u>Сударчилсан номыг бүтээсэн аргаар нь:</u> Барын судар, бичмэл судар хэмээн ангилдаг.

Барын судрыг дотор нь:
- Модон бар
- Зэс бар
- Хорголжин бар
- Чулуун барын гэж ангилдаг.

Бичмэл судрыг дотор нь:
- модон үзгийн бичмэл
- хулсан үзгийн бичмэл
- бийрийн бичмэл
- алт эрдэнээр бичсэн бичмэл судар хэмээн ангилна.

Сударчилсан номыг бүртгэхэд анхаарах зүйлс:
- Хуудасны дугаар болон талыг тэмдэглэхдээ тухайн судрыг яаж дугаарласныг нь анхаарах,
- Сударчилсан номын гол онцлог нь төгсгөлийн үг байдаг. Төгсгөлийн үгээс
- Зорилго
- Эзэн (зохиогч, орчуулагч, хуулагч)
- Он цаг, хаана бүтээсэн

- Дурьдсан зүйл зэрэг багтдаг.

Жишээ нь: "Мялын бум дуулал" гэсэн зохиолын "Мял" гэдэг нь шүлэгч хүнийг хэлж байгаа юм. Мөн "Дурдсан" гэдэг нь өнөөгийн бидний ойголтоор "Захиалагч" гэсэн үг юм. Зарим төгсгөлийн үгэнд "Самардсан хүн" гэж бий. Энэ нь самбар дээр бичсэн хүн гэсэн үг. Эдгээр судрын хэлийг мэдэхгүйгээс тухайн номын зохиогч хийгээд дурьдсан хүн болон номын нэрийг үнэн зөв тодруулахад хэцүү юм.

- Мөн он цагийг тодруулахад анхаарах хэрэгтэй. Үүний тулд он тооллын талаар мэдэж байх шаардлагатай.

- Аргын тоолол
- Билгийн тоолол
- Европын он тоолол /христосын/
- Хятадын он тоолол
- Лалын он тоолол
- Хаадын он гэх мэт. Жишээ нь: Хаадын он дээр гэхэд Жи Юаны анхдугаар

он гэдэг нь Хубилай хааны суусан эхний он буюу 1264 он байх жишээтэй. Эндээс яаж мэдэх вэ гэвэл, Юан гэдэг нь Хубилай хааны оны цол юм.

Олноо өргөгдсөний 1-р он- 1911 он

Олноо өргөгдсөний 10-р он- 1921 он

Олноо өргөгдсөний 30-р он- 1941 он гэх мэт зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Хуйлмал ном. Хуудсуудаа дэс дараагаар нь угсруулан залгаж наагаад, хоёр талын үзүүрт нь номынхоо хуудаснаас арай урт нарийн бөөрөнхий мод тогтоож хуйлсан номыг хуйлмал ном гэнэ. Хуйлмал ном нь бичих, авч явах, хадгалах зэрэгт хамгийн тохиромжтой байдаг.

Бага хэмжээтэй цаасан номыг ихэвчлэн даавуун дээр бичсэн байдаг бол том хэмжээтэйг цаасан дээр бичдэг байжээ. Жишээ нь: Монгол улсын үндэсний номын сангийн "Үнэт ховор номын музей"-д хамгийн урт хуйлмал ном болох Саган сэцэний 1662 онд зохиосон "Эрдэнийн товч" хэмээх муутуу цаасан дээр хар бэхээр уйгаржин бичгээр бичсэн 71,1 м урт ном нандигнан хадгалагдаж байна.

<u>Хуйлмал номыг бүртгэхэд анхаарах зүйл:</u> Хуудасны дугаар гэж тавихгүй харин номын уртын хэмжээг бичнэ.

Нугалбар ном. Нугалбар ном нь сударчилсан номын нөлөөгөөр үүссэн гэж үздэг. Нугалбар ном нь ямар ч газар дэлгэж уншиж болох давуу талтай юм.

Нугалбар номын хуудсыг хуйлмал номын адил залгаж наагаад, тодорхой хэмжээгээр нугалаж эвхсэн байдаг. Доторх бичвэрт 5–7 мөр бүрд нэг юм уу эсвэл хагас мөрний хэмжээтэй хоосон зай үлдээдэг ба энэ нь нугалбар гаргах зай болдог.

Эхний болоод сүүлчийн хуудас нь хавтас болж, зузаан цаасыг хоёр талд нь нэмж наасан байдаг байна.

Нугалбар номын хуудсыг хоёр янзаар дугаарладаг байжээ.

- Хавтсаа дугаарлаад хуудсаа дугаарладаггүй
- Хуудас бүрд дугаар тавьдаг.

Үндэсний номын сангийн "Үнэт ховор номын музей"-д хадгалагдаж байгаа "Жамбалцанжид" хэмээх 25х9 см хэмжээтэй модон барын судар нь нугалбар номын нэгэн тод жишээ юм.

Дэвтэрчилсэн ном. Хуудасны зүүн талын ирмэгүүдийг нийлүүлэн үдэж, хуудас бүрийг эргүүлэн унших боломжтой болгон хийсэн номыг дэвтэрчилсэн ном гэнэ. Жишээ нь: "Элдэв зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг" хэмээх XVIII зуунд буюу 1847 онд бичигдсэн ном нь дэвтэрчилсэн номын нэгэн жишээ юм. Дэвтэрчилсэн номын хуудсыг дэс дараалан дугаарладаг. Орчин цагийн бидний хэрэглэдэг ном бол дэвтэрчилсэн номын төрөлд орно.

Чулуун ном. Хад чулуун дээр сийлбэрлэн бичсэн хөшөө чулууг чулуун ном гэнэ. Жишээлбэл: "Чингисийн чулууны бичиг", "Мөнх хааны хөшөөний бичээс" /1257/, "Куль-Тегиний гэрэлт хөшөөний бичээс" /МЭ VII-VIII/, "Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээс", "Данжуурын гэрэлт хөшөө" зэрэг олон чулуунын номын дурсгал манайд байдаг. "Данжуурын гэрэлт хөшөө"-г Монгол Данжуурын 226 ботийг 1925 онд улсын нийслэлд залж авч ирсний дурсгалд зориулан 1929 онд Дэндэв гуай (1891-1960) урлан бүтээжээ. Энэ хөшөө нь номонд зориулагдаж бүтээгдсэнээрээ нэн ховорт тооцогддог юм.

<u>Чулуун номыг бүртгэхэд анхаарах зүйл:</u> Хөшөөний бүрдэл хэсгүүдийг сайн тодорхойлох хэрэгтэй. Жишээ нь: "Данжуурын гэрэлт хөшөө" гэхэд суурь, титэм, бичээс бүхий гол самбар гэсэн 3 хэсгээс бүрддэг. Эдгээр нь хоорондоо чулуун углуургаар холбогддог. Бүрдэл хэсгүүдээ гаргасны дараагаар тус тусынх нь хэмжээг тавих шаардлагтай. Мөн хөшөөн дээрх бичээсээс гадна ямар нэгэн амьтны дүрс тэмдэглэгээ байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.

<u>Монгол улсын үндэсний номын сангийн "Монгол судлал, гар бичмэл номын фонд"-д хадгалагдаж буй номын бүртгэл дараах өгөгдөлтэй байдаг.</u> Үүнд:

1. Дансны дугаар
2. Анги, зохиогчийн тэмдэгт
3. Хуучин дансны дугаар
4. Зохиогч
5. Бичсэн он
6. Номын нэр, латин галиг
7. Номын эхлэл, латин галиг
8. Номын агуулга
9. Номын төгсгөл, латин галиг
10. Номын хэлбэр
11. Номын хавтас
12. Номын үдээс
13. Номын хэмжээ
14. Номыг бичсэн цаас
15. Бэх, бичгийн хэрэгсэл
16. Мөрийн тоо
17. Хуудас, тал
18. Бичгийн хэв
19. Засварлагдсан эсэх
20. Тамга/ тэмдэг
21. Үнэ
22. Номын хадгалагдсан байдал зэрэг болно.

Эдгээр өгөгдлүүд нь батлагдсан Маягт №2-той үндсэндээ таарч байдаг.

Номын бүртгэл хийхэд анхаарах зүйл

- Номын нэр. Тухайн номонд оноон өгсөн нэрийг л бичнэ. Жишээ нь: "Ганжуур", "Алтангэрэл", "Жадамба", "Гэсэр" гэх мэт.
- Төрөл зүйл. Тухайн номоо дараах таван ангилалд хамруулна.
  - Сударчилсан ном,
  - Хуйлмал ном,
  - Нугалбар ном,
  - Дэвтэрчилсэн ном,
  - Чулуун ном,
- Эдгээр ангилал програмын өгөгдөлд байхгүй бол программын өгөгдөлд орсон "ном судар" гэсэн ерөнхий ангиллыг сонгоод, тодорхойлолтондоо дээрх таван ангилалаа бичиж өгнө.
- Он цаг. Ном сударт он цагийг тэр үеийнхээ он тооллоор тэмдэглэсэн нь элбэг байдаг. Жишээ нь: Энх-Амгалангийн 30-р он, Олноо өргөгдсөний 1-р он гэх мэт. Програмын он цагийн өгөгдөлд ийм он тоолол байхгүй бол энэ он тоолол нь одоогийн тооллын хэдэн он болохыг мэдээд програмын бэлэн өгөгдлөөс сонгон оруулна. Судар дээр байгаа дээрх он тооллоо тодорхойлолтын хэсэгт давхар бичиж өгнө.
- Хэмжээ. Судрын хэмжээг авахдаа хуудасны гаднах урт, өргөний хэмжээг авахаас гадна доторх бичвэрийн хэмжээг заавал авна. Түүнчлэн нийт зузаан, жинг мөн авч болно.
- Иж бүрдэл. Тухайн номын хуудасны тоо, ямар баринтиг, шоголтой байгаа зэрэг бүх бүрдийг тэмдсэглэнэ.



- Тодорхойлолт. Тухайн номын хавтас, эхний болон сүүлийн хуудас, онцлог хуудасыг тодорхой бичих бөгөөд хуудасны дугаар болон тоо ширхгийг тэмдэглэнэ. Мөн тухайн номыг гараар бичсэн эсвэл хэвлэж үйлдвэрлэсэн болох эсэх. Гараар бичсэн бол: Ямар цаасан дээр юугаар бичсэн. Алт мөнгө, эрдэнийн чулуу орсон эсэх талаар бичнэ.

- Гэмтэл.Тухайн номын хуудас бүрийг нэг бүрчлэн шалгаж, гэмтэлтэй хуудсыг тэмдэглэх. Жишээ нь: Хөгцөрсөн, шарласан, урагдсан, норсон, бичвэр баларсан зэргийг тэмдэглэнэ. Тодорхой хугацаанд уг гэмтлийг шалгаж яаж өөрчлөгдөж байгааг байнга тэмдэглэж, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагт хандах хэрэгтэй.

Монгол улсын үндэсний номын сангийн хадгалалт хамгаалалтын байдал

Монголын ард түмэн ном соёлын асар баялаг өвтэй юм. Монгол Улсын Үндэсний номын сан нь 3 сая гаруй ном хэвлэлтэй бөгөөд үүнээс нэг сая гаруй нь монгол, төвд, манж, гар бичмэл болон модон барын ном байна. Эдгээр номын дотор VIII зуунаас эхэлсэн "Чингисийн угийн бичиг", дэлхийд ганц "Есөн эрдэнийн Ганжуур" /142 боть/, "Монгол Данжуур" /226 боть/, монголын нэрт дархан Дагва тэргүүтэй урчууд XIX зууны сүүлчээр цэвэр мөнгөн хуудсан дээр үсгийг хөөлгөн алтаар шарсан, эхлэл төгсгөлийн өгүүлбэрийг цул шижир алтаар шигтгэн урласан "Сандуйн жүд" буюу "Нууцын хураангуйн үндэс", "Монголын нууц товчоо"-ны 282 зүйлээс 233 зүйлийг бараг тэр хэвээр нь агуулсан "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой" /"Лу. Алтан товч"/ гэх мэт монголд төдийгүй Төв азийн соёл иргэншлийн түүхэнд онцгой байр суурь эзлэх соёлын үнэт их өвүүд хадгалагдаж байна.

Эдгээр дахин давтагдашгүй соёлын өвийг устаж үгүй болохоос сэргийлж, технологийн дагуу хадгалж хамгаалах, бүрдүүлэх, судлах, хадгалж хамгаалах орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр хангах, сэлбэн засах, сэргээн засварлах боловсон хүчнийг бэлтгэх нь тулгамдсан асуудал болоод байгаа юм.

Манай номын сангийн үнэт ховор ном судар нь хэвлэлийн болон чулуун барын будаг, тусгай технологоор бэлтгэж бэхжүүлсэн цаас, даавуу, арьс, илэг зэрэг органик гаралтай материалаас бүрддэг бөгөөд удаан хугацааны хадгалалтын технологийн горим алдагдсанаас хэвийн байдал нь өөрчлөгдөж, цаас нь үйрэх, номын бичиг зураг баларч арилах, мөөгөнцөртөх, хорхой шавьжид идэгдэх, нугалаасаараа урагдах зэргээр гэмтэж муудсаар байна. Жишээ нь: "Монгол Данжуур" судрын хадгалалтын байдлыг шалгахад:

- Гэмтэл сэвгүй- 18.488 /28 боть/
- Гэмтсэн- 94341 хуудас
- Ноцтой элэгдэлтэй- 88 боть
- Мөрүүдийн хооронд тэмдэглэж эрээчсэн- 4 боть
- Шавьжинд идүүлсэн- 4 боть

"Монгол Данжуур"-ын 226 ботийн 198 боть буюу 89% нь гэмтэлтэй, сэргээн засварлах шаардлагатай байгаа бөгөөд дээрх байдлаас дүгнэлт хийхэд өвөг дээдсийн маань уламжлан үлдээсэн монгол ард түмний оюуны үнэт өв хадгалалт хамгаалалтын наад захын шаардлагыг хангахгүй орчинд хадгалагдаж байгаа нь харагдаж байна.

Ном судрыг хэрхэн хадгалах талаар

Ном судрын хадгалалт, хамгаалалтанд ном судрыг бүртгэх, үнэлэх, хуулбарлах, микро хальс болон кино хальсанд буулгах, дүрс эсвэл дуу авианы бичлэг хийж кассет, дискэнд буулгаж хувийг хадгалах, эхийг тусгай зориулалтын байранд хадгалах, ялзрах гэмтэж муудах, хулгай дээрмээс сэргийлэх (хавтаслах, хайрцаглах, чийгшилт, агааржуулалт, температурыг тохируулах, хүчиллэгээс сэргийлэх, гал түймэр, хулгайлахаас хамгаалах дохиоллын хамгаалалт хийх гэх мэт) зэрэг олон арга ажиллагаанаас бүтдэг байна.

"Монгол улс дахь баримтат өвийг хадгалж хамаалах нь "Үндэсний семинарт /2006.05.02-200605.05/ тавьсан Жон юн жэгийн "Цаасан баримтат өв элэгдэхэд орчны нөлөөллийн судалгаа" илтгэлийн материал ашиглан ном судрыг хамгийн ихээр гэмтээж болох хүчин зүйлүүдийн талаар тайрбарлая.

Гэрэл: Гэрэл туссанаар номын цаас халж, хэрэгцээт чийгээ алдаж өөрийн уян хатан бөх бат чанараа алдахад хүрдэг байна. Бүх гэрэл хэт ягаан туяа гаргадаг. Нарны болон өдрийн гэрэл нь их өндөр хэт ягаан туяа, дулааныг ялгаруулдаг тул номыг гэмтээдэг хамгийн аюултай гэрлүүд юм. Хэр зэрэг хурц гэрэлд хэдий хэр удаан байсан зэргээс гэмтэл элэгдлийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Жишээ нь: Хүчтэй гэрэлд богино хугацаанд байсан, сул гэрэлд удаан байсан цаасны элэгдлийн хэмжээ адилхан байдаг байна. Гэрэл цаасны өнгийг алдуулан харлуулдаг ба удвал үйрч унадаг. Дараах аргууд нь нарны, өдрийн гэрлээс номыг хамгаалан элэгдлийг багасгахад тустай юм.

Гэрлээс болж элэгдсэн цаасанд үзэгдэх шинж тэмдэг. Цаас нимгэрч биегүй болон үйрч унан шар, бор өнгөтэй болно.

Хадгалах арга техник.

- Нарны гэрэл шууд тусахаас сэргийлж хөшиг, жалюзан хөшиг тавих
- Хэт ягаан туяаг багасгахын тулд цонх, өдрийн гэрэлд хамгаалах (фильтр) суурилуулах
- Боломжтой бол бага ваттын (60 watt) жирийн гэрэл ашиглах. Жирийн гэрэл өдрийн гэрлээс бага хэт ягаан туяа ялгаруулдаг байна. Гэрлийг номоос дор хаяж 30 см-ийн зайтай байлгах хэрэгтэй.
- Номыг саармаг шинжтэй цаасан саванд хадгалах
- Нийтэд үзүүлж буй номын гэрэлд ил байх хугацааг хязгаарлах

Дулаан ба чийг. Цаас агаар дахь чийгийг байнга өөртөө шингээж мөн гадагшлуулж байдаг тул цаасыг амьд бие хэмээн ярьдаг. Чийг дулааны огцом өөрчлөлт нь цаасыг гэмтээдэг. Мөн илүүдэл чийг нь механик гэмтэл үүсгэхээс гадна хорхой шавьж үүрлэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Эсвэл их хуурай нөхцөлд цаас хатаж хэв нь өөрчлөгдөнө. Дулаан, чийгийг тогтмол таарсан хэмжээнд байлгах нь ном судрыг хадгалахад хамгийн чухал. Чийгийн хэмжээ 55-65%-ийн хооронд байлгавал цаасны өөрийнх нь чийг хүлээн авах хэмжээнд байна гэсэн үг. 65%-иас ихэдвэл хөгц үүсэх магадлалтай юм. Чийглэг байдал үргэлжилбэл чийгний эсрэг бэлдмэл (силикагел) хэрэглэх хэрэгтэй.

Чийг, дулаанаас болж цаас элэгдэхэд бий болдог шинж тэмдэг

- Цаас хэврэгшин бутарч өнгө нь өөрчлөгдөнө.
- Ус гүйсэн мөр илэрч өнгө алдана.
- Цаас хумигдан үрчийж хоорондоо нааладана.

Хөгц, шавьж, мэрэгчид. Цаас гэрэлгүй, чийглэг дулаан, агаарын солилцоогүй орчинд удаан тодорхой нэг температурт байх нөхцөлд хөгц түргэн үржиж эхэлдэг. Орчны харьцангуй чийгшил 65%-иас дээш, цаасны чийгшил 10%-аас дээш байхад бичил биет өсөж үржих таатай боломж бүрддэг байна. Номын санд хөгц хана, номын тавиур, мөн ном бичгийн завсар, дусаал гоожиж байгаа газруудад үүсдэг бөгөөд цаас нороод хатах явцад ихэнхдээ үүсдэг.

Цаас идэж, бохирдуулдаг 70 гаруй төрлийн хортон шавьж бүртгэгдээд байна.

Ном судрыг хортон шавьжаас хамгаалахын тулд чийг дулааныг тааруулах, хадгалах болон үзүүлэх байрыг тоос шороогүй цэвэр байлгах, үе үе шалган хорт шавьжийг эрт илрүүлэх хэрэгтэй.

Мөн хөгцнөөс хамгаалахын тулд чийг ихтэй хадгалах газар чийггүйжүүлэх төхөөрөмж, өрөөний агаарыг сольж байхын тулд салхивч сэнс тавих нь зүйтэй юм. Нэгэнт хөгц үүссэн номыг бусад номоос тусгаарлаж, хөгцтэй хэсгийг зөөлөн үстэй бийрээр цэвэрлэж 70%-ийн этилийн спиртийг хөвөнд шингээх юмуу тос шингээгч хөвөнд түрхэн арчиж үгүй хийж болно. Хамгийн аюултай зүйл бол хөгцтэй чигээр нь удаан байлгах юм.

Амьд биетээс болж ном гэмтэхэд илрэх шинж тэмдэг

- Цаасны гадаргуу дээр хүрэн, шороон, улаан өнгөтэй толбууд үүснэ.
- Цаасанд хүрэхэд салж унан үйрнэ.
- Цаасны гадаргуу дээр жижиг хар толбо үүснэ.

Хадгалах арга

- Чийг дулааныг байвал зохих төвшинд байлгана.
- Хадгалах байранд хоол ундны зүйл байлгахыг хориглоно.
- Байнга агаар сольж байхын тулд сэнс, агааржуулагч тавих.
- Цаасанд хөгц үүссэн тохиолдолд бусад номоос тусгаарлан зөөлөн бийрээр арчих
- Хортон шавь, мэрэгчдээс болж ном судар гэмтсэн эсэхийг тогтмол шалгаж, гэмтэл илэрвэл хортон шавьж устгах бодис, хавх, урхи ашиглан устгах

Хортон шавьж устгах бодисыг номонд хүргэлгүйгээр хэрэглэх хэрэгтэй бөгөөд боломжтой бол энэ ажлыг хортон шавьж устгах мэргэжлийн байгууллагад даатгаарай.

Ус. Чийгнээс хамгаалахын тулд дараах арга хэмжээг авах хэрэгтэй.

- Норсон номыг хөгцрөхөөс сэргийлж 18^{0}С-аас бага температурт агаар тохируулагчтай байр луу шилжүүлнэ.
- Байнга агаар солин, хатаах явцыг хурдасгахын тулд сэнс хэрэглэх.
- Норсон номын хуудсыг нэг нэгээр нь салгаж шингээх чадвар сайтай цаас, даавууны завсар хавчуулна.
- Хатаж байгаа номын дээрээс хавтгай зүйл тавин хуйларч нугаларахаас сэргийлнэ.
- Усанд автан гэмтсэн номыг мэргэжлийн хүнээр сэргээн засуулах

Ус, чийгнээс болж гэмтэхэд үүсдэг шинж тэмдэгүүд

- Номын гадаргуу дээр ус тарсан тэмдэг харагдана.

- Ном нугаларан үрчийж хоорондоо наалдана.

Хадгалах арга техник

- Номыг ус дамжуулах хоолой, радиатор, агааржуулагч машин, нарны гэрэл, гаднах ханаас хол зайтай газар хадгална.
- Ус алдан ном гэмтэхээс сэргийлж шалнаас 30 см-ийн өндөр тавиурт хадгална.
- Нугларч үрчийсэн хэсгийг тэнийлгэхдээ төмөр металл хэрэгслийг ашиглахгүй байх.

Номын механик гэмтэл, буруу сэргээн засварлах. Ном урагдаж гэмтэхэд засах гэж хавчаар, үдээс, скоч, цавуу, резин зэргийг хэрэглэхгүй байх. Жирийн скоч, цавуунд хүчиллэг чанартай бодис агуулагдаж байдаг ба эдгээр нь номын элэгдлийг хурдасгадаг. Яваандаа гадаргууг гэмтээж бохирдуулдаг.

Гал. Галын аюулаас дараах байдлаар сэргийлж болно.

- Номын сан, фондонд галын дохиолол байрлуулах нь галын аюулыг эрт илрүүлнэ
- Галд тэсвэртэй сейф, хайрцаганд хадгалах
- Гал гарсан тохиолдолд ойролцоо гал унтраах ангид яаралтай мэдэгдэнэ.

Ном судрыг хадгалж хамгаалахад тэдгээрийг хадгалах байр, зөв харж хандах нь чухал юм. Номыг хадгалах зориулалтын саармаг цаасан хайрцаг, дугтуй зэрэг нь орчны муу нөлөөнөөс хамгаалж, элдэв гэмтэл элэгдлээс сэргийлэхэд тустай.

Ном зүй

1. Оюунбилэг. Д. “Ном хэвлэлийг хадгалах хамгаалах” Номын санч. УБ. 1994. №1-2, 19-27 тал
2. Шагдарсүрэн. Ц. “Монголчуудын үсэг бичгийн товчоон” УБ. 2001
3. Шагдарсүрэн. Ц. “Монголчуудын утга соёлын товчоон” УБ. 1991
4. Шүгэр.Ц. “Монгол модон барын ном” УБ. 1991
5. Шүгэр.Ц. “Монголчуудын ном хэвлэдэг арга” УБ. 1976
6. Сэржээ.Ж. “Монголчуудын номын өв” УБ. 2001
7. Цэзэн.Ж. “Монгол ном” УБ. 1999
8. Чой чан ху (БНСУ-ын Үндэсний архив)”Цаасан дээрх баримтыг хадгалах арга” /Монгол улс дахь баримтат өвийг хадгалж хамгаалах нь/ Үндэсний семинар
9. Жон юн жэ (Соёлын өвийн судалгааны төвийн хадгалах хамгаалах тасаг) “Цаасан баримтат өв элэгдэхэд орчны нөлөөллийн судалгаа”

Үндэсний номын сангийн Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Алтанзаяа
Соёлын өвийн төвийн мэргэжилтэн
Ш.Энхтуяа

ГЭРЭЛ ЗУРГААР ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ БАРИМТЖУУЛАХ НЬ

Ерөнхий зүйл

Түүх, соёлын дурсгалт зүйлийг (ТСДЗ) бүртгэн баримтжуулах ажлын үндсэн баримт хэрэглэгдэхүүнд гэрэл зураг авах, түүнийг цаасан болон дижитал хэлбэрээр хадгалах ажил байдаг.

Хэдийгээр гэрэл зураг авах нь хүмүүст амар, хялбар хэн ч хийж чадах ажил мэт харагдавч, энэ нь тухайн хүнээс тодорхой мэдлэг, ур чадвар, цэвэрч нямбай байдал, асар их үүрэг хариуцлагыг шаардаж байдаг юм. Аппарат бариад шагайвч, дэлгэцээр нь хараад таарсан бүхнээ бодлогогүй авахад, дараа нь авсан зурагнаас чинь ашиглах, шаардлага хангасан тохирох зураг олдохгүй байдал үүсдэг. Тийм учраас дэлгэцийн хувиарлалт, гэрэл сүүдрийн зохицол, дүрсний гажуудал зэрэг олон зүйлийг цогц нэг дор төвлөрүүлж бий болгосноор гэрэл зураг авах ажил эхэлнэ.

Сүүлийн үеийн гэрэл зургийн аппаратны технологийн хөгжилд дижитал систем хүчтэй нэвтэрч автоматаар гэрлийн хурд өнгөний тохиргоог хийх болсон нь гэрэл зураг авахад асар их хөнгөлөлт хялбаршуулалт бий болгожээ.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг баримтжуулах зорилгоор авч буй гэрэл зураг нь уран сайхны, байгалийн болон хөдөлгөөнт гэрэл зураг авахаас өөр орчин тусгай нөхцөл байдлыг шаардаж байдгаараа онцлог. 1960-аад оноос эхлэж музейн үзмэрийг баримтжуулах зорилгоор гэрэл зураг авч эхэлсэн ба өдгөө музейд хадгалагдаж буй гэрэл зураг нь тухайн үзмэрийг тодорхойлох баримт, хэрэглэгдэхүүн болж огт чадахгүй байна.

Музейн үзмэрийг гэрэл зургаар баримтжуулах ажлын ач холбогдол, гэрэл зурагжуулалт, тэдгээрийг архивлан хадгалах тогтолцоо одоог болтол манай музейнүүдэд төлөвшөөгүй байна. Урьд өмнө авсан хар цагаан, өнгөт гэрэл зургууд нь тухайн үзмэрийн үнэн бодит өнгө, онцлог шинж байдал зэргийг харуулах нь бүү хэл дүрс нь бүдэг бадаг харагдах төдий л байдаг.

Музейн үзмэрийг хулгайд алдагдах, устаж алга болох тохиолдолд хамгийн түрүүнд түүний гэрэл зураг шаардагдаж байдаг ба ийм тохиолдолд тухайн үзмэрийн гэрэл зураг шаардлагын түвшинд хүрч чадахгүй буюу огт гэрэл зураг авагдаагүй зэрэг хүндрэлүүд гардаг.

Бүртгэн баримтжуулах гэрэл зургийг аливаа үүсэж болох эрсдэл хохирлоос өмнө хийгдсэн байх ёстойн дээр зөвхөн гэрэл зурагжуулалт гэдэг ерөнхий нэрийн дор ганц удаагийн ёс төдий гэрэл зураг авалт биш шинжлэх ухааны үндэслэлтэй, баримтжуулах ажлын үндсэн нөхцөл шаардлагыг хангасан цогц мэдээлэл өгөх баримт болдог гэдгийг гэрэл зураг авахдаа цаг ямагт анхаарч байх хэрэгтэй юм.

Одоо бид энэ хөтөлбөрийн хүрээнд улс аймгийн музейг нэг төрлийн аппарат хэрэгслэлээр тоноглон, ТСДЗ-ийг бүртгэн баримтжуулах зорилготой гэрэл зураг ямар түвшинд байх ёстойг стандарт хэмжээнд жигдлэн, гэрэл зургийг хэрхэн авах, түүнийг хэрхэн хадгалах тухай нэгдсэн ойлголт, хэв маягт орох болно.

Аппарат хэрэгслэлийг зөв зохистой ашиглах нь

Гэрэл зураг авч буй хүн нь өөрийн хэрэглэж буй аппарат хэрэгслэл, тоног төхөөрөмжийг цаг ямагт үүсэж бий болох гэмтэл, эрсдэлээс хамгаалж байх үүргийг хүлээнэ. Ялангуяа албан байгууллага, музейд байх тоног төхөөрөмж нь хэдийгээр нийтийн хэрэгцээнд ашиглах болов ч түүнийг голлох нэг хүн нь хариуцан ажиллаж бусдад аль болох (ялангуяа аппарат, техник хэрэгслэлтэй харьцаж сураагүй хүнд) дамжуулахыг хориглоно. Олон хүний гар дамжигдан хэрэглэгдэх тусам аппарат хэрэгслэлийн ашиглалт, зөв зохистой хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлдэг.

Аппарат хэрэгслэлийг тоос шороо, тосны бохирдлооос хамгаалах нь чухал. Хөдөө гадаа, өрөө тасалгаан дотор гэрэл зураг авах үед ч тоос шорооноос хамгаалж байх хэрэгтэй. Ялангуяа хээр хөдөө гэрэл зураг авах үед нарийн ширхэгтэй тоос, шороо аппаратанд шигж наалдан, зарим тохиолдолд автомат ажиллагаатай дуран болон зарим эд ангийг гэмтээдэг. Тиймээс аппарат болон дагалдах хэрэгслэлийг тус бүрд нь битүү ороож хамгаалах зөөлөвчтэй гялгар уут бэлдэн хэрэглэж дадах хэрэгтэй. Аппарат, дагалдах хэрэгслэл (дуран, зай цэнэглэгч, спичик г.м)-ийг тусад нь уутанд хийгээгүйгээс бие биен дээрээсээ дарж дурангийн бие болон линз шил сэвтэх, үрэгдэж холгогдох, өнгө үзэмж муудах, хагарах зэргээр хэвийн ажиллагаанд муугаар нөлөөлнө.

Хүний гар нь элдэв зүйлд хүрч байнга бохирдсон байдаг. Гарны алганаас ялгарсан хөлс, тос нь хоол хүнсний үлдэгдэл тостой холилдон бохирдсон байдаг тул гэрэл зураг авах хүн аппарат хэрэгслэлтэй ажиллахын өмнө гараа сайтар угааж цэвэрлэсэн байх ёстой. Гарыг цэвэрлээгүйн улмаас аппаратны биед тос хуримтлагдан бохирдох, дурангийн шил линзэнд бохирдуулан авч буй гэрэл зурагны дүрсэнд гарын хээ давхар авагдаж бохир гэрэл зураг авагддаг болохыг анхаарах хэрэгтэй.

Аппарат, хэрэгслэлийг гэрэл зураг авахын өмнө болон гэрэл зураг авсны дараа, дараачийн ажилд зориулж хөнгөн чанарын цэвэрлэгээ хийнэ. Энэ цэвэрлэгээг тоос шороог үлээж цэвэрлэх зориулалтын зөөлөн үстэй багстай бургуй үлээгч ашиглахаас гадна зөөлөн хиймэл илгэн материал ашиглан хийнэ. Гэрэл зураг авах аппаратны дурангийн линз шилний орчим ханиах, найтаах, шүлсээ үсчүүлэн ярих зэрэгт шилэн гадаргуу дээр шүлсний толбо үүсэж бохирддог. Энэ тохиолдолд хөвөн, зөөлөн цаас, ширүүн гадартай даавуу материалыг огт ашиглаж болохгүй бөгөөд зөвхөн хиймэл илгэн материал ашиглаж хөнгөн дарж арчина.

Аппарат, техник хэрэгслэлийг бохирдол, тоос шороонoос хамгаалахаас гадна механик гэмтлээс хамгаалах нь хамгийн чухал. Гэрэл зургийн аппаратны эвдрэл гэмтлийн 80% нь хүний өөрийн буруутай үйл ажиллагаанаас болдог.

Үүнд:

- Анх удаа гэрэл зураг авч буй хүн гэрэл зургийн аппаратны ажиллагааг бүрэн таниагүйгээс байнга оролдож товчлуурын даралтыг гэмтээх
- Аппаратны зүүлт оосрыг хэрэглэж дадахгүй байх
- Ширээ сандал, хана, хад чулуу зэрэг хатуу биетийг аппаратны аль нэг хэсгээр цохих
- Сайн тулгууртай ширээ, сандал, тавцан дээр тавиагүйгээс унагаах
- Хүүхэд багачуул, сонирхогч хэн дуртай хүн бүхэнд өгч оролдуулах, сонирхуулах
- Гадаа хэт халуун, хүйтэн үед удаан хугацаагаар байлгах, ажиллуулах зэрэг олон хүчин зүйлс нөлөөлнө.

Дээрх хүчин зүйлээс хамгаалахын тулд тухайн хүнээс хянуур, нямбай ажиллагааг байнга шаардана. Санаатай болон санамсаргүй үйлдлээс болж аппарат хэрэгслэлээ эвдэх тохиолдолд төлбөрт орох, төлөвлөгөөт ажил тасалдах зэрэг олон хүчин зүйлийн эрсдэл, сөрөг үр дагавар дагуулж байдгийг анхаарч ажиллах хэрэгтэй.

Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, аппарат хэрэгслэл ажиллах зай багтаамж орон зайг бий болгон, олон хүн хөлхүүлэхгүй байх, аппаратны оосор зүүлтийг хэрэглэж сурах, найдвартай бат бөх хөлтэй ширээ, тавиур дээр тавих зэргийг өдөр тутам үйл ажиллагаанд хэвшүүлэн заншиж, гэрэл зургийн аппаратны зөв зохистой хэрэглээг удаан ашиглаж, үр дүнг нь үздэг.

Үзмэрийн гэрэл зураг авч байх үед аппаратыг хэрхэн аюулгүй орчинд байлгах вэ?

- Үзмэрийн зураг авсны дараа аппаратыг заавал биенээсээ салгаж тусад нь тавцан ширээн дээр тавьж байх хэрэгтэй. Ингээгүйгээс дараагийн үзмэрийн гэрэл зургийг авахад бэлдэх ажиллагааны үед гар болон хүзүүнээс зүүж байсан аппарат жингээрээ савагдаж хатуу биетэд цохигдон гэмтэх магадлалтай
- Аппаратыг зориулалтын тулгуур хөл (tripod) дээр зоож гэрэл зураг авах үед тулгуур хөлний өмнө зогсож зургийг нь авах гэж буй үзмэр эд өлгийн зүйлдээ анхаарал хандуулан ухрах үед тулгуур хөлийг хөдөлгөж аппарат унаж эвдрэх тохиолдол гарахаас сэргийлэх
- Гэрэлтүүлгийн студи болон дагалдах хэрэгслэлийг нэг дор бөөгнөрүүлэн гэрэл зураг авах үед олон сүлжээ кабель утасны орчмоор үзмэр зөөж буй хүн болон тэнд ажиллаж буй хүмүүс санамсаргүй утсанд орооцолдон тээглэж тоног төхөөрөмж болон үзмэр, аппарат хэрэгслэл дээр унагаах тохиолдол гарахаас сэргийлэх
- Гэрэл зургийн аппаратыг шал дэвсгэр болон газар шороон дээр тавихыг эрс хориглож, амрах, түр завсарлах тохиолдолд аппаратны дээгүүр гялгар уут нөмөргөх хэрэгтэй.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулах зорилгоор гэрэл зураг авахад шаардагдах ерөнхий зарчим

Музейн үзмэр, түүх, соёлын дурсгалт зүйлийг баримтжуулах гэрэл зураг нь тухайн дурсгалыг бодит байгаа байдлаар нь үнэн зөв мэдээллийг агуулсан байх ба өнгө гэрлийн илүүдэл, уран сайхан, гоёл чимэглэлийн төрлийн зураг авалтын хэлбэрээс зайлсхийсэн байх ёстой.

Бүртгэн баримтжуулах гэрэл зургийг:

- Зориулалтын дэвсгэр (хар, цагаан) дээр дурсгалын гэрэл зургийг авахдаа түүний хажууд 5-8 см-ийн зайнд тухайн үзмэрийн сан хөмрөгийн болон хувийн дугаарыг бичиж тавина. (зураг.1)
- Дурсгалын гэрэл зургийг авахдаа гэрэлтүүлгийг (мини студи, шүхрэн гэрэл) тохируулж, хэт гялайлгахгүй, гэрлийн бөөгнөрлийг нэг дор биш жигд тархсан байдлаар тохируулна. (зураг.2)
- Дурсгалыг үнэн зөв хэмжээсээр харуулахын тулд хэт дүрсний гажуудал үүсэхээс аль болох зайлсхийх (зураг.3)
- 3 хэмжээст үзмэрийн гэрэл зураг авахад тухайн үзмэрийн доод суурийг төв цэг гэж үзэн 60-80 градусын хажуу өнцөг буюу өндрөөс аппаратыг байрлуулан зураг авахад тохиромжтой байдаг бол дэлгэмэл бүтээлийн гэрэл зураг авахад үзмэр бүтээлийн гол төв цэгийг олж аппаратны дуранг байрлуулан 90 градусын тэгш хэмээр зураг авахад тохиромжтой байдаг. (гар зураг.5)
- 3 хэмжээст үзмэрийн гэрэл зураг авахдаа үзмэрийг арын дэлгэцнээс (фонноос) 30-80 см зайнд хөндий тавьж зураг авах ба энэ нь гэрлийн бөөгнөрлөөс зайлсхийх зорилготой.

- Зүүлт унжуурга, хэт хутга зэрэг хавтгай хэлбэр дүрслэлтэй дурсгалын зураг авахад зориулж хагас налуу тавцан тавиурыг хийх ашиглах хэрэгтэй.
- Үзмэр, эд өлгийн зүйлсийн гэрэл зураг авахад макро 60 mm дуранг нийтлэг хэрэглэхэд зохих болов ч үзмэрийн хэмжээнээс хамаарч том хэмжээний дурсгалд өөр төрлийн дуран хэрэглэнэ.
- Металл эдлэл, тосон будгийн зураг, маажиндсан (лакдсан) үзмэр, дурсгалыг гэрэлтүүлэг хэрэглэн гэрэл зураг авахад үзмэрийн гадаргуун дээр гялайлт үүсдэг. Ийм нөхцөлд гэрэл зургийн аппаратыг зориулалтын хөл дээр зоож байрлуулан, аппаратыг гэрэлтүүлэггүй хуваарь ажиллагаан дээр тохируулж гэрэл зургийг авч үзэх хэрэгтэй.
- Гэрэл зураг авах үед дэлгэцэн дээр үзмэрийн багтах харьцааг зөв хувиарлаж, аль болох дэлгэцийг дүүргэж авна. Гэхдээ дэлгэцийг хэт дүүргэж авсан тохиолдолд гэрэл зургийг угаалгахад лаборатори зургийн хүрээ орчмыг хасаж танан угаадаг тул дэлгэцний гадна хүрээнээс дотогш 5 мм-ээс 1 см-ын зай үлдээн гэрэл зураг авах хэрэгтэй.
- Том хэмжээний дурсгалыг дурангийн буруу сонголт, дэлгэцийн буруу хувиарлалтаас жижигрүүлэн авахаас зайлсхийх. (зураг.4)
- Гэрэл зургийг аль болох зориулалтын тулгуур хөл дээр зоож бэхэлсэн аппаратаар авч занших
- Дурсгалын овор хэмжээнээс шалтгаалж гэрэлтүүлгийг (студийн гэрэл) өөрчилөх ба дурангийн хүчин чадалд тулгуурлан гэрэл зургийг авах орон зайг зурагчин өөрийн мэдрэмж дээр тулгуурлан зохих өөрчлөлтийг хийх ёстой.
- Баримтжуулах зорилготой ТСДЗ-ийн гэрэл зураг авах зурагны хэмжээг компьютер дээр хадгалахад 2 MB буюу 1500x1500 пикселээс дээш хэмжээтэй байхаар нягтаршил хэмжээг тохируулна. Заагдсан хэмжээнээс бага болон том хэмжээгээр авахыг хориглоно.
- 3 хэмжээст үзмэрийг нүүр, 2 хажуу тал, ар тал, орой дээрээс болон ёроолыг доороос нь гэсэн үндсэн хэд хэдэн талаас авах зарчмыг баримтлах ба содон онцлог дүрслэл, хийц болон гэмтэл согог, эвдэрсэн байдлыг хэсэгчилэн баримтжуулж заавал авах ёстой.

Аппарат хэрэгслэлийн ажиллагаа, гэрэл зураг авах тухай, авсан гэрэл зурагт дүн шинжилгээ хийж асуух шаардлага гарвал Соёлын өвийн төвийн УНБМСангийн интернет хаяг болох cch_fund@monheritage.mn -ээр харилцаж болно.

Соёлын өвийн төвийн захирал
Г.Энхбат

ЗУРАГ №1

ЗУРАГ №2

ЗУРАГ №3

ЗУРАГ №4



ЗУРАГ №5.1

Гэрэлтүүлгийн ерөнхий байдал



ЗУРАГ №5.2